Ц. Шагдарсүрэн



Монголчуудын утга соёлын товчоон

Ц. ШАГДАРСҮРЭН

МОНГОЛЧУУДЫН УТГА СОЁЛЫН ТОВЧООН

Эрхилэж нийтлүүлсэн Д. Гантуяа

УЛААНБААТАР
1991

Монголын судлалд шинэ дэг үүсгэж хөгжүүлсэн Польшийн монголч эрдэмтэн ДЫНОВСКИ ВИТОЛЬД профессорын гэгээн дурсгалд энэ номоо зориулаю.

Ц. Шагдарсүрэн

ОРШИЛ

Хувь ерөөлөөр монгол ардынхаа далай их соёл боловсролын зах зухаас сонсож, үзэх завшаан багаас минь тохиолдож, бас Монгол Улсын Их сургуулийн монгол хэл, утга зохиолын ангид элсэн орсон анхныхаа хавраас буюу 1963 оноос Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгээс орон нутагт явсан, академич Йөнөөбуу Бямбын Ринчен профессорын удирдсан шинжээний ангийн бүрэлдэхүүнд орж монгол хэл аялгуу, угсаатны зүйн хэрэглэгдэхүүнийг сурвалжлан цуглуулах ажилд удаа дараа оролцсон минь монголчуудын утга соёлыг шимтэн судлах урмыг тэтгэн хөгжөөж өгсөн гэж бат итгэж явдаг.

Их сургуулиа дүүргэсний дараа хувь завшаанаар академич Ринчен профессорын гарынх нь шавь болж нийтдээ 15 жил ойр дотно байж дагалдан сурч, судлагаа шинжилгээний ажлын учир холбогдол, наад цаадыг ойлгож эхлэхдээ эрдэм шинжилгээний ажилтан тодийгүй, ер хүн хэн боловч заалгаж олсон мэргэжлээрээ хязгаарлалгүй ардынхаа хэв ёс, зан заншил, утга соёлыг сайтар мэдэж түүгээрээ бахархаж явах нь соёлт хүмүүн төрөлхтөний хувьд заавал ч үгүй нийтлэг байх зүйл ажээ гэж ухаарах болсон билээ. Ингээд «бүдүүлэг харанхуй, соёл боловсролгүй байсан» гэгдэж олон жил гүтгүүлж ирсэн ардынхаа утга соёлд холбогдох баримт сэлтийг үзсэн ном, уулсан өтгөс өвгөдийн амнаас сурвалжлан тэмдэглэж хураасаар байсан маань нэг мэдэхэд овоо ном цуглачихсан, нэг ном болгоё гэвэл хүрэхээр болчихсон байлаа.

Толилуулан буй энэ номын гол үндэс нь 1977 онд Польш Улсын Шинжлэх Ухааны Академийн Эдийн боловсролын түүхийн хүрээлэнд эрдмийн зэрэг хамгаалан хүртсэн «Монголчуудын утга соёл» гэдэг зохиол бөгөөд түүнийгээ монголоор хэвлүүлэе гэтэл сэдэвээс болоод ч юм уу хэвлэлийн төлөвлөгөө гэгч нь олдоогүй тул монгол ардынхаа боловсрол мэдлэгийг зах зухаас нь ч гэсэн танилцуулахсан гэж бодсоор уул ажлынхаа гол төлөвий нь Польш, Франц, ЗХУ, Германд гардаг Төв Азийн судлалд зориулсан эрдэм шинжилгээний цуврал бичиг, сэтгүүлд нийтлүүлсэн бөлгөө. Үүндээ монголчуудын соёл, мэдлэг боловсролын тухай тодийгүй, тэрхүү өвөрмөц утга соёлыг маань буй болголцож хөгжүүлэхэд нэг нас, бие сэтгэлээ эргэлтгүй зориулсан Өндөр гэгээн Занабазар, Зая бандида Огторгуйн далай, Чин сүзэгт номун хан Лувсанноровшийрав, мэргэн бандида Цэвэлванчугбавуудорж зэрэг, одоо бол өргөн дэлгэр ярьдаг болоод байгаа, тэр цагт бол манайд нэрий нь ч дурдахад хориотой байсан. монголын шашны зүтгэлтэн, эрдэмтэн, соён гэгээрүүлэгч, зүрхайч, эмч оточ нарыг үйл амьдрал, бүтээл туурвилтай нь танилцуулан гаргахыг хичээж байлааб.

Ингээд 13 жилийн дараа тэрхүү зохиолоо монголоор хэвлэн гаргах боломж олдож, нэг талаас түрүүн бичиж нийтлүүлсэн зүйл дээрээ энэ завсар гадаад дотоодод гарсан шинэ сэрэг судлагааг хир чинээгээрээ нэмж тусган, нөгөө талаас олон нийтэд ойлгомжтой болгохын үүднээс шинжилгээний байдлы нь хариулан хялбарчлаж уншигч, олондоо толилуулан барих өлзий учрал сая нэг бүрдэж байна.

Монголын судлалын тухай тухайн сэдвээр цааш нь нарийсган яргааж үзэе гэсэн хүнд хэрэг болууЖин хэмээж энэ номынхоо хэсэг бөлөг бүрийн сүүлд лавшруулан үзүүштэй ном зохиолын жагсаалтыг хэвлэгдсэн он цагийн дараалаар хавсаргасан болно. Бас овойж оцойтол хийсэн их зүйлгүй боловч, эрдэм шинжилгээний ажилтан гэгдэж, монгол хэл зохиол, үсэг бичиг, утга соёлын судлалд 20 гаруй жил гар бие оролцож ирсэний хувьд монголын судлалын буянтай үйлсэд нэгэн үзүүр сэтгэлээр шимтэн орж байгаа хүмүүст санаа сэдэлгэ авуулах зорилгоор судлах эзнээ хүлээж буй зарим ажлын сэдвийг чухалчлан дурдсаныг минь зөв ойлгож, хоосоор мэдэмхийрхэлээ хэмээж зэмлэхгүй буй заа гэж итгэж байна.

Бас энэхүү номын дотор кирилл үсгээр дадаж хэвшсэнээс арай өөрөөр бичсэн зарим үг буй. Энэ бичилгэ нь монгол хэлний үг бүтэх ёстой аль болохуйц ойртуулах гэсэн зорилготой бөгөөд номын холбогдох хэсэгт учир начрыг нь тайлбарласан зүйл байгааг анхаарах ажааму.

МОНГОЛ НОМ ЭРДЭМ АРВИТАХ БОЛТУГАЙ!

Ц. Шагдарсүрэн

XVII жарны Маш соггонги хэмээх цагаан морин жилийн намрын сүүл сарын 12-ын өлзийт сайн өдөр.

1990 оны 10-р сарын 31.
Улаанбаатар хот.

ХҮМҮҮНИЙ ХАРИЛЦААГ НАРИЙСГАН ХӨГЖҮҮЛСЭН МОНГОЛ УХААНААС

ХЭМЭЭХ
НЭГДҮГЭЭР БӨЛӨГ

МОНГОЛ ГЭДЭГ НЭР ХИЙГЭЭД МОНГОЛЧУУДЫН УУХ ТҮҮХИЙН ТУХАЙД

Монгол гэдэг нэр түүхэнд анх, хэдийд гарч ирсэн хийгээд монголчуудын өндөр өвөг дээдэс гэж ямархуухан хүмүүс байсан талаар дурдалгүйгээр монгол гэдэг үгийн тухай ярих нь учир дутагдалтай болно гэдэгт эргэлзэх хүмүүн гарахгүй буй заа.

Одоогоор лавтайяа болсон баримт сэлтээс үзэхүл *монгол* гэдэг нэр тухайн нэгэн аймгийн нэр болж манай эриний VII зууны үеэс түүхэнд тэмдэглэгдэн орсон ажээ. Чингэвч энэ үг аймгийн тусгай нэгэн нэр болохоосоо өмнө түүхийн тодорхой хугацаанд байсаар байсан гэдэг нь эргэлзээгүй билээ. Үүний баримт гэвэл XIV зууны үед түүхч Рашид-эд Дин, Болод чинсан нар «*Сударын чуулган*» хэмээх зохиолдоо тэр үеийнхээ итгэмж бүхий хүмүүсийн амнаас сонссон, 2000 жилийн өмнөхи үйл явдлын тухай өгүүлсэн нэн сонин домог яриаг оруулсан жишээ ажгуу.

Уг домогт өгүүлснээр, манай эриний өмнөхи VII—III зууны үеэс *монгол* хэмээн нэрлүүлж байсан овог аймгууд түрэг угсааны овог аймагтай айлсан нутаглаж, бас заримдаа дайтан тулалддаг байжээ. Нэгэн удаагийн их хямрал тэмцэлд монголчууд ихэд дарагдаж *Нукуз*, *Хийан* гэдэг хоёрхон өрхийн төдий хүн үлдэж арга буюу унаган нутаг, уугуул уснаасаа дайжин явсаар өндөр өндөр уулаар хүрээлүүлсэн *Эргунэ-кун* гэдэг, хүрэхэд нэн бэрх боловч хүрсэн хойноо өвс ус тэгш, өгөөж шимтэй сайхан газар хүрч нутаглан сууж өсөн үржсээр тэндээ багталцахгүй болсон тул арга сүвэгчлэж төмөрлөгийн хүдэр бүхий нэгэн их уулыг бух хөөргөөр хөөргөдөн хайлуулж гарах зав нээгээд хуучин суугуул нутаг орноо зорин тэмцэж *Онон*, *Хэрлэн*, *Туул* хэмээх *гурван голынхоо* эхэнд хүрч аж төрөх болсон байна.

Эл домгийн зарим хэсгий нь үлэмжхэн тодруулсан баримт хожуугийн түүхч Хондемир, Абуль-гази нарын зохиолд гардаг нь саяхи дурдсан үйл явдал оргүй хоосон зүйл биш байсныг нутлах баримт буюу заа.

Үүнээс гадна түүхийг улариулан үзэхэд манай эриний IV-VIII зууны үеийн монголчуудын тухай мэдээ занги харьцангуй

их л хомс байдаг бөгөөд түүхийн тэрхүү балархай цагийн үйл явдлыг дээр дурдсан домгийн өгүүлэл нөхөж «Монголын нууц товчоон» хийгээд түүхийн бусад хэрэглэгдэхүүнтэй холбож өгдөг нь уул домог үндэстэй, үнэн байсны давхар баталгаа гэж хэлэх бололцоог бидэнд олгож байгаа хэрэг билээ.

Ийнхүү түүхийн хуудаснаа нэн эртнээс тэмдэглэгдэж ирсэн *гурван голын монголчууд* нь одоогоос 800 гаруй жилийн тэртээ буюу 1189 онд Тэмүжин «Чингис хаан» гэдэг цол өргөмжлүүлж Хамаг монголын хаан болоод Монголын нэгдсэн төр улс байгуулахын үүсгэлийг тавихад үндсэн цөм мөхлөг нь болж өгсөнийг түүхийн холбогдох бүх баримт ямар ч эргэлзээгүй бат нут гэрчилдэг билээ л.

Үүнтэй холбогдуулан нэгэн зүйлийг дурдахад, хожуу үеийн зарим түүхийн сурвалжид монголчуудын уг гарлыг энэдхэг, төвөдтэй холбож тайлбарлах явдал уламжлал мэт болсны талаар товч боловч ярилгүй өнгөрөхийн аргагүй гэж бодож байна. Цаг хугацааны хувьд ийм сурвалжаас хамаагүй түрүү үед буй болж, тухайн үйл явдалдаа илүүтэй ойр цагт зохиогдсон найдвартай түүхийн зохиолд тэр мэт баримт сэлт огт байдаггүй нь уламжлал мэт болсон уг зүйл монгол газар сүүлийн удаа шашин ном хүчтэй дэлгэрсэнтэй холбоотой гарч ирсэн зохиомол зүйл болох нь тодорхой бөгөөд энэ талаар ч олон эрдэмтэн мэргэд сэтгэл хуваарилалгүй нэгэн дуугаар зөвшөөрөн хүлээдэгийг энд хэлэхэд яав ч илүүдэхгүй буй заа.

Ийнхүү *монгол* гэдэг нэр буй болсоор хэдэн мянган жилийн нүүр үзсэн боловч чухам ямар үгнээс хэрхэн үүссэн, ямар утгатай болох нь одоо хүртэл учир битүүлэг байсаар байгаа билээ. Ингэж утга учир нь битүүлэг бүгт байгаа нь ч гэсэн уул уг нэн эртнийх болохыг давхар гэрчлэж байгаа хэрэг биз ээ.

Монголын бичиг номын олон хүн — В. Инжаннаши, Дарма гүүш, Ш. Дамдин, Раши-пунцаг нар *монгол* гэдэг үгийн гарал, утгыг тайлах гэж оролдож байлаа. Банзарын Дорж, Г. Рамстедт, Г. Цыбыков, А. Ш. Кичиков, Хаттори Широ, Намжилцэвээн, А. Амар, Ч. Хасдорж зэрэг гадаад дотоодын олон монголч эрдэмтэн *монгол* гэдэг үгийн уугуул утга, гарлыг нэхэн хөөж судлаад ном бүтээлдээ санал дүгнэлтээ тэмдэглэн үлдээжээ. Дээр дурдсан олон эрдэмтний судалгааг ерөнхийд нь авч үзвэл нэгэн хэсэг нь *голлох, ерөнхийлөх,* эвсэл *агуу их* буюу *нэгдмэл цул* гэсэн утгатай үгээс, нөгөө хэсэг нь газар усны нийлмэл хоёр нэрээс үүссэн бололтой хэмээж үзсэн байдаг билээ

Монголын ШУА-ийн сурвалжлагч гишүүн Х. Пэрлээ агсан дээрхи олон эрдэмтний саналыг дүгнэж, бас Рашид-эд Дин, Болод чинсан нарын тайлбар хийгээд «Цагаан түүх», «Эрдэнийн товч» зэрэг монголын эртний түүхийн гол гол сурвалж бичигт байдаг мэдээ баримтад тулгуурлаж «...*монгол* нэрийг газрын

нэрээс үүссэн гэдэг саналыг залруулан, нийгэм олны амьдралын үзэгдлээс үүдэн гарсан гэж үзэх нь үнэнийн хувьд их л дөхөж очно гэж бодлоо. Ингэж тайлбарлавал *монгол* гэдэг нэрийн гарал утга хоёр нь урьдахи таамнал, тайлбаруудыг бодвол харилцан холбогдож болохын хувьд их л шадар дөт болно...» хэмээн тэмдэглэжүхүй.

Сүүлийн үед ч олон эрдэмтэн нөхөд *монгол* гэдэг үгийн гарал, утгыг судлахад хүч анхаарлаа зарж сонирхолтой санал дүгнэлт гаргасаар байна. Үүнээс зарим тоймтойг нь дурдваас сэтгүүлч С. Жамбалдорж *монгол* гэдэг үгийн утга, гарлыг «хүн, хүмүүн» гэдэгтэй холбож үзсэн байх бөгөөд Х. Силам түрэг хэлний үүднээс «мин-гол» гэсэн цийлмэл үг бөгөөд «мянган гар» хэмээсэн утгатай гэж үзжээ.

Иймд *монгол* гэдэг нэрийн үүсэл, чухам юу гэсэн утга санаатай байсан тухай эрдэм шинжилгээний үүднээс хөдлөшгүй нэгэн мөр болгож шийдсэн зүйл одоо хир үгүй байна гэж хэлэх бүрэн үндэстэй юм.

Хэдийгээр *монгол* гэдэг нэрийн гарал, уугуул утга нь одоогоор тов тодорхой мэдэгдэхгүй байгаа боловч энэ нэр манай эрийн өмнөхи үеэс судар түүхнээ тэмдэглэгдэн үлдэж, Эргүнэкун'д дайжин очсон аймаг хүмүүсийг нийтээр нь заасан үг болж улмаар тэр аймаг улс хуучин уугуул нутаг ус-Гурван голын эх буюу Онон, Хэрлэн, Туулын эх хавьдаа эгэн ирж нутаглан суугаад язгуурын монгол аймгийг бүрдүүлсэн нь тодорхой байгаа билээ.

Сая бид *монгол* гэдэг нэрийн талаар тун товчхон ярилаа. Харин Монголчуудын гарал үүслийн тухайд, ялангуяа түрүүхэн үеийн судлагчдын ном бүтээлд монголчуудыг нангиадаас, энэдхэг төвөдөөс, мөн түрэг угсаатнаас гаралтай байж магадгүй гэсэн таамаг бодолго дайралддаг байлаа. Тэгээд ч монгол гэдэг нэрийг хятад, түрэг зүгийн хэлний үүднээс тайлах гэсэн оролдолго ч цөөн бус гарчээ. Гэлээ ч монгол хэл аялгуу, зан заншил, эд өлөгийн зүйл, аж төрөхийн ухаан, мөн түүнчлэн хүн судлалын үүднээс монгол хүний бие галбирын онцлог хийгээд түүхийн шинжлэх ухааны сүүлийн үеийн нээлт дүгнэлт зэргээс үүдэж монголчуудыг нангиадаас ч юм уу, энэдхэг төвөдөөс эсбөгөөс түрэг зүгийнхэнээс гаралтай байж магадгүй гэдэг таамаглал шинжлэх ухааны хувьд үндэсгүй болох нь хэдийнээ илэрхий болсон бөлгөө.

ЛАВШРУУЛАН ҮЗҮҮШТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Бичурин П. Я, Собрание сведений о народах, обитавших в средней **Азии в древние времена,** I—III, II издание, М.-Л, 1950—1953.

Рашид-Ад Дин, **Сборник летописей,** I—III, М.-Л, 1952, 1960, 1966.

Амар А, **Монголын товч түүх,** тэргүүн дэвтэр, УБ, 24 (1934).

Доржи Банзаров, **О происхождении имени «монгол»,** Собрание сочинений, М. 1955, стр. 167—176.

Доржи Банзаров, **О названии Эргэнэ-хон,** Собрание сочинений, М, 1955, 178—179.

Намжилцэвээн, **Монгол гэдэг нэрийн тухай,** УБ, 1959.

Хасдорж Ч, **Монгол гэдэг нэрийн тухай,** УБ, 1960.

Нэрлээ Х, **Гурван мөрний монголчуудын аман түүхийн мөрийг мөшгисөн нь,** Түүхийн судлал, 8-р боть, 1—12-р дэвтэр, УБ, 1969, 81-152.

Гонгор Д, **Халх товчоон,** тэргүүн дэвтэр, УБ, 1970.

Бира Ш, **Монгольская историография XIII—XVII вв,** М, 1978.

Жаранэг Ж. Данзан, **Монгол гэдэг үгийн учир,** Нийгмийн шинжлэх ухаан, 1986, № 4, Хөххот, 86—101.

БИДНИЙ МОНГОЛЧУУД ЭРТНЭЭС ИНТЕРНАЦИОНАЛЬЧ БАЙВ ШҮҮ

ЮНЕСКО-гийн ивгээл дор 1973 онд Улаанбаатар хотноо хуралдсан «Төв Азийн соёл иргэншилд нүүдэлчдийн оруулсан хувь нэмэр» гэдэг хам илтгэлт хуралд тавьж сонордуулсан илтгэлдээ академич Ринчен профессор «...монголчуудын соёл боловсролын тухай мэдэх мэдэхгүй амьтнаар элдэвлүүлэн бичүүлсэн түүхтэй улс энэ дэлхий дээр монголчуудаас өөр байхгүй гэж санагдаж байна...» гэж тэмдэглэн хэлж байж билээ. Монгол орон хийгээд монгол хүнийг бараг мэдэхгүй шахам хирнээ муучлаж дорд үзэх гаргц зорилго бүхий гадаадын нэлээд хүн чухамхүү ингэсээр ирснийг нүдэн балай аялдан дагаж өөрөө өөрсдийгөө гүтгэн доромжилж «эрдэмтэн» болсон монгол хүн тийм ч цөөнгүй байсаар өнөөдрийг хүрчээ. Тэгээд ч энэ бүхнийг бодолцож академич Ринчен профессор багш маань «Монголчийн андагаар» гэдэг шүлгээ 1969 онд бичсэн болович зүдэг цагийн эрхээр нийтлэгдэж олны хүртээл болоогүй ажээ. Иймхүү монголчууд бид мэдэх мэдэхгүй хүнээр элдэвлүүлэн бичүүлсээр хэдэн үеийн нүүр үзэж газар авсаар монгол туургатны чухамхүү уугуул утга соёл, эрдэм боловсрол, зан заншил, үнэн түүх олон нийтийн дунд мартагдахад хүрч «наашгай» гэгдмээр бүхий л зүйл XX зууны хорин нэгэн оноос үүсэн буй болчихсон мэт ухаарал буй болж билээ. Үүний нэг нь сүүлийн 40—50 жилийн турш дэн их ярьдаг болсон интернациональч гэдэг ойлголт болой. Латин гаралтай энэхүү нэр томьёо монгол хэлэнд хожуу орж ирсэнээс монголчуудын хувьд урьд өмнө нь огт байгаагүй цоо шинэ ойлголт гэж боддог хүн ч бий, ярьдаг хүн ч байсаар байна. Гэтэл монгол ардынхаа зан заншил, үзэл бодролыг уламжилан нэхэж үзэхүл тиймэрхүү бодол үндэсгүй болох нь аяндаа мэдэгдээд ирдэг. Энэ талаар тэд гурван зүйл дээр түшиж товч ярия гэж санаж байна.

Аливаа ном бичгийг тэгш хүндэтгэх ёсон манай ардуудын дунд нийтлэг байдаг байлаа. Монгол хүн зөвхөн монгол буюу төвөд номыг төдийгүй мэдэх мэдэхгүй бичиг үсэгтэй аливаа нэгэн номын ганц хуудас байхад ч *«номын үсэгтэй* (зарим нутагт *номын үзүгтэй* гэдэг) *юм, дор бүү оруул! эс тэгвээс номын алдас болно»* гээд хүндтэй газар тавихаас биш, одоогийнх

шиг сонин сэтгүүл, ном хуудас цаасыг морь харахдаа хэрэглэх бүү хэл, газар орхих, дээр нь гишгэх суухыг цээрлэдэг байсан асан. Тэгээд ч эгэл жирийн өдий төдий хүн шажин номыг устгасан хилинцэт бэрх цагт ч амь нас, хувь заяагаараа дэнчин тавьж ном судар, аль нандин гэсэн бүхнээ хайрлаж, зориглон хадгалсаар энэ үед хүргэж ирсэн нь утга соёлын их уламжлалаа таслахгүй гэсэн уужим ухаан, буянтай эрмэлзлийн бие бодтой жишээ мөн буй заа.

Монголчууд түүхэн хөгжлийнхөө туршид үсэг бичгийн арав гаруй төгтөлцөөг хэрэглэж ирсэн бөгөөд бараг тэр болгоны нийтлэг нэгэн онцлог нь гэвэл төвөд, самгард, хятад, түрэг, орос зэрэг олон хэлний нэр томьёо болон бусад шаардлагатай хэрэглэгдэхүүнийг тухайн хэлээр нь тэмдэглэж чаддаг галиг үсгийн тусгай хэсэгтэй байсан билээ. Энэ нь эрт цагаас манай монголчууд олон хэлийн ард түмний соёл боловсролыг эрх тэгш хүндэтгэж, монголчуудын хэрэглэж ирсэн бичиг үсэг нь ч олон ард түмний бие биесээ баяжуулах соёлын өвөрмөц зууч болсоор байсны нутлагаа буюу.

Дээр дурдсанчлан монгол хүний хувьд аливаа ном бол хамгийн нандин эрхэм зүйл байсан бөгөөд энэ тухай яруу найрагч Т. Галсан «Монгол заншил» хэмээх дөрвөн мөртдөө тунч уран өгүүлж дээ гэж боддог. Үүнд:

Өөрсдөө даалимба хөдөс өмсдөг,
Үр ачаа нэхийд өлгийддөг,
Номыг харин торгоор баринтаглаж дээдлэдэг
Монгол түмний минь заншил даан ч өөдрөг! гэжээ.

Харин хэт хувьсгалч нар л монголын ард түмний утга соёлын үнэт дурсгал болсоор ирсэн өдий төдий ном дэвтрийг шашных гэж, үзэл сурталд харш гэж, дарга нарын санаанд тохирохгүй гэж урж тасчин, усанд урсгаж, галд шатааж, бас ардын дуунд:

...ташаан дээрээ дарсан тамга нь хөө
таван номын үсэгтэй дээ хөө... гэж байсныг
...ташаан дээрээ дарсан тамга нь хөө
таван хошуу хэлбэртэй дээ хөө... болгуулан

«засч» ирсэн нь яав ч нэгэн жаранаас илүү настай болжухуй. Гэвч цаг цагаараа байдаггүй гэж...

Ер хүнийг, харийн хүнийг, бусад улс үндэстнийг тэгш хүндлэх ёсон монголчуудын дунд хэв журам болж байсан тухай түүхийн баримт сэлтэд дулдуйдаж эрдэмтдийн тэмдэглэсэн нь тийм ч цөөнгүй. «Монголын нууц товчоон» хэмээх алдарт дурсгалаас үүний жишээ нутлагаат хялбархан олж болно заа. Үүнд: аливаа хэн хүнийг гадна, дотнын гэлгүй тэгш үздэг байсан явдал бөгөөд хүнийг үнэлэх гол үнэлүүр нь шударгуу зан, эзэндээ үнэнч зүттэх зүтгэл, ажилсаг хичээнгүй байдал эдгээр гу-

рав болой. Тэр цагт эзэндээ үнэнч байна гэдэг бол одоогийн ухаарлаар эх орон, ард түмэндээ хайртай байна гэдэгтэй адил зүйл байжээ гэж санагддаг. Эзэн нь ч гэсэн доорхи түшмэл, зарсан элч, албат иргэнээ бусдын халдалга, элдэв доромжлолоос «эзэн шиг» хамгаалж чаддаг, тэр нь ч албат иргэдийнхээ хайр хүндэтгэлийг хүлээх хөрс нь болж өгдөг байжээ. Ер хүний зан шулуун шударгуу, эзэндээ үнэнч бөгөөс дайсан байсан хүнээ ч авч хэрэглэдэг ёсон монголын хаад ноёдын дунд нийтлэг байсан аж.

Монголчуудыг зочломхой сайхан зантай, цагаалхай тусархаг сэтгэлтэй ард түмэн хэмээж гадаадынхан тэмдэглэсэн нь эртнээс инагш тун ч олон. Энэ бол харийн хүний сэтгэлд монголчуудын хүрсээр ирсний нэгэн баримт буюу. Хэрхэн ямар учраас монголчууд харийн хүний сэтгэл зүрхэнд хүрдэг байв гэдэг талаар ерөнхийлөлгүй ганц нэг боловч бодтой жишээгээр тайлбарлавал зохино. Үүнд баримт болгож монголчуудын ариун бузрын тухай ойлголтыг авч үзэж болно. Ах дүү, нутаг усныхан, эсбөгөөс танил тал улсаас, нэн ялангуяа үдэш оройн цагаар амсуулахаар өгсөн юмыг шууд иддэггүй, хонуулж байгаад эхлээд хангай дэлхий, тэнгэр бурхандаа дээж, галдаа хувь өргөөд дараа нь нас ахмад нь ам хүрч байгаад сая хүүхэд багачуудаа өгдөг заншил байсан билээ. Харин харийн хүний өгсөн зүйл хиншүү хярвастай байсан ч, үдэш орой байсан ч «хэл буруутнаас бузартдаггүй» гээд тахил тавиг өргөөд шууд ам хүрцгээдэг байсан асан. Энд нэгэн зүйлийг тэмдэглэхэд *хэл буруутан* гэдэг нь энэ тохиолдолд гадуурхаж муучлан дорд үзсэн утга огт байжгүй, зөвхөн өөр бусад хэмээсэн санаа болой. Өөрөөр хэлбэл харь буюу өөр хэлтэн л гэсэн үг! Энэ мэтчилэнгээр харь гадаад хүнийг хүншээн хүндлэж үздэг монголчуудын үзэл заншил нь бусад улс үндэстэнд тэгш хандах уламжлалыг буй болгосон ч байж магадгүй гэж санагддаг.

Үүнээс гадна ер хүний ухаан билиг, сэцэн цэлмүүн үзэл бодлыг угсаа гарал, шашин суртлыг ялгаварлалгүй жигд анхааран хэрэгсэн үздэг байсны жишээ гэвэл их эзэн Чингис хаантан Елуй Цуцайг төрийн албанд хэрэглэж, Чан чүн бумбыг урин авчирч төр ёсны явдлыг хэлэлцсэн түүх даруй мөн ажгуу.

Бусад улсын ёс заншил, шашин номыг тэгш хүндэтгэх ёсон монголчуудын хувьд их л хүчтэй байсныг баруун европын олон түүхчид тэмдэглэсээр ирсэн бөгөөд Сталины үеэс эхлэн Зөвлөлтийн бараг бүх түүхчид, тэднийг дагалдаж манай монголын түүхчид бараг цөмөөрөө тэрхүү «харш» үзлийг бутцохицгоосоор өнөөг хүрсэн билээ. Үүнд нэгэн зүйлийг тэмдэглэхэд Зөвлөлтөд Сталины дэглэм ноёрхохоос өмнө түүхч Н. М. Карамзин, академич В. В. Бартольд, Б. Я. Владимирцов, түүхч Н. Н. Костомаров, Ф. И. Леонтьев зэрэг олон эрдэмтэн түүхийг

бодтой үнэлэн дүгнэж байсныг, мөн Сталины дэглэмийн үед ч нэрт түүхч, монголч эрдэмтэн Л. Н. Гумилев Зөвлөлтийн бусад түүхчдээс өөр үзэл бодолтой байж, түүнээсээ болж ажуумшигт хэлмэгдлийг амсаж, хоёр орны олонхи түүхчдийн зүрхэнд шар ус хуруулсаар байж арай гэж өөрчлөн байгуулалттай золгосныг хэлэлгүй орхиж болмооргүй санагдлаа.

Хаана ч гэсэн монгол хүний чанд баримталдаг нэгэн үзэл бол «усы нь уувал, ёсы нь дагадаг», «ёс ёмбогор, төр төмбөгөр» гэдэг мэргэн үгэнд найрсаж шингэсэн байдаг билээ. Энэхүү *ёс, төр* гэдэг ойлголтод тухайн ард түмний зан заншил, уламжлал ёс, аж төрөл цөм багтана. Дээр өгүүлсэн хоёр мэргэн үг нь хэн ч болов байж байгаа бүхэн очсон газар орныхоо хүн ардын ёс төрийг хүндэтгэн дагана гэсэн санаа. Гэтэл бас хэн ч болов бусад улс үндэстний элдэв нарийн ёс төрийг тэр бүр мэдэхгүй байх явдал ч тохиолдох нь мэдээж. Тийм зүйл гарахад монголчууд уг хүнийг үл зөмлэн «ёс мэдэхгүй хүнд ёр халддаггүй» гэж сэтгэл санааны эмзэглэлий нь тайлан хариулж тухайн ёс төрийг тайлбарлан өгдөг байжээ. Дээрхи хэдэн мэргэн сайхан үгэнд туссан монголчуудын уламжлал заншил бол олон хэлийн ард түмний ёс төр, зан заншил, шашин шүтэлгийг эрх тэгш хүндэтгэх сэтгэл нийтлэг, хэн хүнд хүртээмжтэй байсны илрэл ажгуу. Энэ бол эгэл жирийн ард түмний дундхи явдал болой. Монголын төрийн бодлогын хувьд ямар байв аа?

Энэ сонирхолтой асуулт судлагчдын, тэр дундаа гол төлөв баруун европ дахины эрдэмтдийн анхаарлыг татахгүй байж чадаагүй юм. Польш, Франц, Баруун германы монголч эрдэмтэд энэ асуудлыг судлан эрдэм шинжилгээний олон өгүүлэл, ном товхимол цөөн бусыг нийтлүүлж улмаар «монголын энх төр», «монголын хүлцэмж» гэдэг тусгай нэр томьёог ч буй болгосон билээ.

Монголын эзэнт улсын төрийн байгууллын үйл ажиллагааг түүхэн баримт сэлтэд тулгуурлаж судлаад «монголын ноёрхол уу?», эсбөгөөс «монголын энх төр үү?» гэж асуугаад «монголын энх төр» байжээ гэдэг хариултыг өгч байгааг анхаарахгүй байхын аргагүй. Бас Судар бичгийн хүрээлэнгийн хүндэт гишүүн, Польшийн монголч эрдэмтэн В. Котвич Ил хаан Өлзийтөөс 1305 онд Францын гео Филипп ванд илгээсэн албан захидлыг нарийвчлан судлаад «...XIII зуунд монголчууд *дэлхий нийтийн энх тайван*гийн асуудлыг сэдэж үүсгэжээ...» гэдэг дүгнэлтийг гаргаж билээ. Тэгээд ч «монголын энх төр»-ийн гол бодлого болсон «дэлхий нийтийн энх тайвангийн» дүнд олон улс үндэстний хооронд эрс тэс дайсагналцаж байсан шашин суртлын янз бүрийн урсгал эедэн зохилдож, мөн эрс заагтай байсан өрнө, дорно дахиныг улс төр, арилжаа худалдаа, соёл боловсролын хувьд эрх тэгш холбож өгсөн анхны төр улсыг Монголчуудтогтоожээ гэж дүгнэсээр, бичсээр байгааг ойрмогхо-

үоос л монгол үншигчдадаа ил хэлж танилцуулах нөхцөл бүрэлдэж байна шүү.

Монголын хүлцэмж гэдэг нь нэгдсэн улсын дотоодод ч гэсэн мөн гадаадад ч гэсэн аливаа улс, аймаг үндэстний шашин суртал, зан заншил, хэв ёсыг хүндэтгэж эрх тэгш үзэх үзэл байснаас биш бусдын юм бүхнийг дорд тавьж, буруу номтон гэж ялгаварлан гадуурхах буюу хуга нуга дарж байгаагүй гэсэн үг болой. Түүхийн зарим нэгэн баримтыг дурдвал: Зэв, Сүвээдэй нарыг Хотонгийн тал руу дайлуулахаар илгээхдээ аливаа хүссэн шашныг нь чөлөөтэй шүтүүлнэ хэмээн зар тархаалгаж байсан байна. Тэгээд бас ам, ажил хөёр нь зөрдөггүй байсан баримт одоо л тодорхой болсоор байна. Тухайлбал: толгойтой бүхнийг алж, товойсон бүхнийг тэгшлэж байсан гэж түүхийн олон номд «тэмдэглэгдсэн» Бат хааны их цэрэг Оросын сүм хийдэд огт гар хүрч байсангүй гэдгийг саяханаас л Зөвлөлтийн зарим эрдэмтэн хүн ч, бас сэтгүүлч хүн ч батлан бичих боллоо. XIII зууны үед монголчуудаас гадагшаа хийсэн аян дайны түүхийг үзвэл голдуу л дайтах аян шалтагийг цаад талаас гаргасан баримт гарч ирдэг. Дайн тулааны үед эсэргүүцэл этгээдийн хоорондхи шашин шүтлэгийн тэмцэл зөрөлдөөнийг монголчууд авхаалжтай ашиглаж байсан тул монголчуудын эрхшээлд орсон бусад улс аймаг үүнийг давын өмнө сайтар ухан ойлгож байснаас гадна шашин суртлын дайсагналд туйлдан зүдэрсэн тэдгээр ард олны тухайд монголчуудын хүлцэмжит бодолгын нөлөөгөөр өөр өөрийнхөө эрхэмлэн итгэж шүтдэг шашин номын чөлөөтэй бишрэх боломлоог ямар ч атугай нэгэн хэсэгтээ олж авсан гэж түүхчид бичсээр байна.

Үүний дээр бас нэгэн зүйлийг нэмж өгүүлэх нь зүйтэй гэж бодлооб. Юу хэмээвээс монголчууд гэр бүлийнхээ харилцаанд бусад олон шашинтантай адилгүй байсан ажээ. Үүнд: гэр бүл болохдоо шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхдаггүй байсан явдал болой. Үүнийг батлах баримтыг түүхээс ч, түүхэн зохиолоос ч амархан гарган нутлаж болно. Энэ бол бас л *монголын хүлцэмжийн* нэгэн жишээ ажгуу.

Энэ бүхнээс үзэхүл монголчууд эрт цагаас бүх аймаг, улс, үндэстнийг шашин суртлын хувьд ч, угсаа гарлын хувьд ч, хэл соёлын хувьд ч, үсэг бичгийн хувьд ч, зан заншлын хувьд ч, аж төрөх ухааны хувьд ч эрх тэгш хэмээн хүндэтгэн үздэг байсан нь тодорхой харагдах бөгөөд, бидний монголчууд маань өртнөөс жинхэнэ интернациональч байж шүү дээ гэдэг бодлыг эрхгүй төрүүлнэ зээ.

ЛАВШРУУЛАН УЗУУШТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Kotwicz W, **Les Mongols, promoteurs de l'idée de paix universelle au début du XIII siécle,** -La Pologne au VI Congrés International des Sciences Historiques, I, Warszawa, 1933, pp. 199—204; -RO, Tom. XVI, Warszawa, 1950,

Монгол орчуулга: Котвич В, **XIII зууны эхин үед Монголчууд дэлхий нийтийн энх тайвангийн санааг сэдэж үүсгэсэн болох нь,** (орчуулсан Ц. Шагдарсүрэн) -ХЗС, IX боть, 20-р дэвтэр, УБ, 1972, 205—214.

Seidler G. L, **The Political Doctrine of the Mongols,** -Annales Universitatis Marie Curie-Sklodowska, Lublin-Polonia, Vol. VI. 7, 1959, pp. 249—277.

Chantal Lemercier-Quelquejay, **La paix mongole,** Joug tatar ou paix mongole? Flammarion, 1970.

Гумилев Л. Н, **Поиски вымышленного царства,** М, 1970.

МОНГОЛЧУУДЫН ХҮН ЭМНЭЛГИЙН УЛАМЖЛАЛ

Түүхэнд тэмдэглэгдэж үлдсэн баримт сэлтийг нэхэн сонирхоцгооё. Манай эриний өмнөхи II зууны үед бидний монголчуудын дээд өвөг Ухуани нар «...хүн өвдвөөс агь шатааж буюу чулуу халааж төөнөдөг. Бас өвстэй газар шатаагаад өвчтэй хүнээ хэвтүүлдэг. Хүний өвчин эмгэгтэй газры нь ханаж цус гаргадаг...» гэсэн мэдээ эртний нангиадын түүхнээ тэмдэглэгдэн үлджээ. Энэ нь бидний өнөөдрийн мэдлэгийн хэрээр монголчуудын дээд өвгийн хүн эмнэлэгт холбогдож буй хамгийн эртний баримт бэлгөө. Харин үүнээс хожуу үед хамаарах цөөн бус мэдээ буй. Тоймтойхоноос эшлэн дурдсу. Ираны их түүхч Рашид-эд Дин «*Судрын чуулган*» хэмээх зохиолдоо «...Урасуд, тэлэнгэд, куштэм аймгийнхан монголчуудтай нэгэн адил эмийн зүйлийг сайн мэддэг бөгөөд монгол аргаар сайн эмнэдэг...», бас «...нэлээд хэдэн сайн монгол эм байдаг. Хуучин тэр эмийг кадыр хэмээн нэрлэж байлаа. Одоо бол кажир гэж нэрлэдэг амуй...» гэх зэргээр тэмдэглэсэн нь бий.

Энэ бүгдээс үзэхүл, бидний монголчууд болон манай өвөг дээдэс маань хүн эмнэлгийн өвөрмөц тодорхой арга, уламжлалтай байсан ажгуу. Монгол хэлний үгсийн санд *эмч*, *оточ*, *бариач*, *домч*, *шархач* гэх зэрэг эмнэх анагаах мэргэшлийн олон нэр томьёо байсаар ирсэн бөгөөд дотроо нарийн учир ялгавартай байсан авач он цагийн саалтад зарим үгийнх нь уугуул утга санаа өөрчлөгдсөн явдал харагддаг билээ. Үүнд: үгийн гарлын талаас нь авч үзвэл, тусгай бэлдсэн эмийн зүйлээр өвчин эмгэгийг анагаадаг хүнийг *эмч*, өвс ургамлын зүйлээр анагаадаг хүнийг *оточ* (от гэдэг нь алтай овгийн олон хэлнээ өвс, ургамал гэсэн утгатай үг), илж барих аргаар анагаадат хүнийг *бариач*, элдэв дом хийгээд үгийн шидээр анагаадаг хүнийг *домч*, цэрэг дайны цагт олсон янз янзын шарх гэмтлийг анагаадаг хүнийг *шархач* хэмээн учир ялгавартай нэрлэж байсан байдал харагддаг. Цаг хугацааны эрхээр үгийн уугуул утга хувирах явдал аливаа хэл бүрт байдагчлан сүүлийнх үест нэгэн хэсэгтэр оточ гэдэг нэрийг эмч гэдэгтэй адил утгаар хэрэглэж байв. Бас *эмч* гэдэг монгол үг төвөд хэлний үгийн санд нэвтрэн орж монгол хэлнийхтэйгээ адилхан утгаар хэрэглэгдэж байсан нь монголчуудын хүн эмнэлгийн уламжлал Төвөдөд ихээхэн нө-

лөөтэй байсны нэгэн гэрч буй заа. Дээр дурдсанаас гадна, эмч оточ нар гэхэд л дотроо ханууруч, төөнүүрч гэх зэрэг нарийн мэргэшлийг эзэмшсэн хүмүүс цөөн бус байсныг энд тэмдэглэхэд илүүдэх нь юун билээ.

Монгол газар Бурханы шашин ном гутгаар удаагаа хүчтэй дэлгэрэхэд эртний Энэдхэгийн анагаах ухаанд үндэслэсэн төвөд эмнэлгийн нөлөө хүчтэй болж ирсэн ажээ. Гэхдээ монгол эмч нар төвөд эмнэлгийн гол үндсийг багтаасан ном бүтээлийг судлаж, цөөн бус зүйлий нь шүүмжлэн залруулах, тодруулан дэлгэрэнгүй болгож байсны зэргэцээ монгол хүнд тохиолддог өвчнийг анагаах талаар монгол орны байгаль цаг уур, хүмүүсийн аж төрөл, монгол хүний бие махбодын онцлогт тохируулан эмчлэх арга, зохимжтой эмийн жорыг нарийсган боловсруулсаар ирсэн байна. Энэ далимд нэгэн зүйлийг онцлон дурдахад төвөд бичгийн хэлний хөгжил хийгээд их бага таван ухааны салбарт монголчуудын оруулсан бодтой хувь нэмэр их байсан гэдгийг төвөд, энэдхэгийн бичгийн их хүмүүс хүлээн зөвшөөрсөөр ирснийг хэлэх нь зүй ёсны доторхи зүйл гэж бодож байна. Энэ бүхний жишээнд, тэжээхүй ухааны хүрээнд гэхэд л 1—4 боть зохиолтой, Сайн ноён хан аймгийн Лувсандэнзанжанцан (1639—1704), Ёндон (XIX зуун), Дандар (XIX зууны эцэс—XX зууны эхин), Сэцэн хан аймгийн Лувсанчоймбол (XIX зуун) мөн Сүмбэ хамбо Ишбалжир (1704—1788), найман тойн хэмээх Жамбалдорж (XVIII зууны эцэс—XIX зууны эхин) нарын өдий тэдий алдартай эмч, оточ, маарамба нар байсныг дурдаж болно. Ийнхүү монгол эмч нар онол туршлагаараа олж мэдсэн зүйлээрээ монгол төдийгүй төвөд эмнэлгийн ухааныг нарийсган хөгжүүлсэн билээ. Тэгээд ч доктор Ц. Хайдав нарын зэрэг нарийн судалсан нөхдүүд, мөн европ зүгийн хэлээр гарсан нэлээд ном бүтээлд монголчуудын анагаах ухааныг төвөдийнхитэй адилтгаж хутгадаг нь бүдүүлэг алдаа юм гэж тэмдэглэсэн байдаг нь цаанаа нарийн учир үндэстэй зүйл бөлгөө.

Тийм ч учраас монголд хүн эмнэлгийн биеэ даасан дэг сургууль байсан ажээ гэж хэлэх бүрэн үндэстэй юм. «Юан улсын судар»-ын 81-р бүлэгт «...Хубилай хаан Жун тунгийн 2-р оны 5-р сард... эмчийн сургууль байгуулав...» гэсэн мэдээ байдаг. Жун тунгийн 2-р он гэдэг нь аргын 1261 он болно. Үүнээс гадна Монголд байсан бараг бүх хүрээ хийдэд *манба дацан* монгол эмч нарыг туслайлан бэлтгэдэг сургуулийн газар болж байсан билээ. Их эмч, төвөдөч Н. Дашзэвэг авгайн бичсэнээр монголд байсан сүм хийдийн 70—80 орчим хувьд нь уул дацан байсан хэмээжүхүй. Тэгэхдээ монголын өргөн уудам нутаг дэвсгэрт байсан манба дацан бүр нэгэн хэвд цутгасан мэт байсангүй, анагаах ухааны аль нэгэн чиглэлийг газар орны байр байдал, хүн ардын аж төрөл болон бас бус онцлогтой уялдуулан

түлхүү анхаарсаар яваандаа тэр нь уламжлал болсон байдал бэлхэнээ харагддаг. Тухайлбал: Йогийн талаар Егүзэрийн хийд, ханаж хатгах талаар Яруу, Улиастайн хүрээ монгол даяар нэртэй байсан ажээ.

Монгол эмч нар маань төвөдийн анагаах ухаанаас гадна дорно, өрнийн бусад зарим орны анагаах ухааны тухайн цагийн ололтыг зохих хэмжээгээр анхааран үзэж хэрэгсдэг байсан байна. Үүний бодтой баримт гэхэд хятад хэлнээс орчуулж тод бичгээр бичсэн «Хатгах, төөнө тэргүүтнийг хураасан нэм»-ын IV, VI дэвтрийг жаран хэдэн оны дундуур ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн ажилтан, нэрт эрдэмтэн Х. Лувсанбалдан Баруун монголчуудын дундаас олж гэрэл зураг татаж хэвлүүлэн нийтийн хүртээл болгосон билээ. Бас XVIII зууны үед латин хэлнээс орчуулсан 6 боть «Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг» хэмээх хүний биеийн огтлолзүйн ном уг эхээрээ манай Улсын Нийтийн номын санд хадгалагдаж байсныг акад. Йөнтөөбү Бямбын Ринчен санаачлан үүсгэж буй болгосон «Монголын дурсгалт бичгийн чуулган» хэмээх цуврал дээ гэрэл зургийн аргаар хэвлүүлэн нийтэлсэн нь 1968, 1971, 1972 онд тус тус хошоод хэлмэлиэр гарч эрдэм шинжилгээний гүйлгээнд орсон билээ. Тэр үед монголчуудын хүн эмчлэгийн түүхэн уламжлалын талаар тус улсад ам ангайх чадуулгай байсан цаг тул мэргэжлийн эмч нарын ч хараанд өртөж нэмд нь тэмдэглэгдсэн явдал үгүй байсаар энэ үед иржээ.

Монгол эмч нарын хувьд, эрүүл хүний бие цогцосын *хий, шар, балгам* гурвын зохицлын тухай, мөн тэр гурав хэрхээс эдлэв өвчин эмгэг үүсдэг тухай өвөрмөц сонин ойлголт байсан талаар цухас дурдахаас бус нарийвчлан тайлбарлана гэдэг бол монгол эмнэлгийн уламжлалыг нарийн судалсан мэргэжлийн эмчийн чадах ажил тул дэмий олныг нуршихаас түгэлзлээ.

Монгол эмч нар эдлэв өвчин эмгэгийг эмээр анагаахын хажуугаар ханах хатгах, самнах, зүү түрмэ төөнүүр тавих, рашаан ус шавраар эмчилэх, хоолоор засах зэрэг олон аргыг мэддэг гэр бүх аргаа зүй зохисоор зэргэцүүлэн хэрэглэдэг байсныг тэмдэглэх нь яав ч илүүц болохгүй буй заа.

Харин монгол эмч нарын хувьд нийтлэг байсан зарим онцлогийн талаар ярихад эмч бүр анагаах ухааныхаа онол бодрол хийгээд практикийн бүхий л салбарыг тэгс эзэмшиж сурсан байдал бэлхэнээ харагддаг. Үүнд: эмч хүн өвчтөнийг үзэж оношлох, дээр дурдсан олон зүйл аргаар өвчнийг анагаахын сацуу эмд ордог бүх зүйлийг бүрдүүлдэг, эм тангаа өөрөө талхлан найруулж бэлтгэдэг, эмээ өөрөө барьдаг байсан болохоор уургамалсудлал, амьтансудлал, эрдэссудлал хийгээд эмзүйн нарийн мэдлэгтэй байсан ажээ. Үүнээс гадна монгол эмч нар оношлын хүрээнд хүний эрүүл биеийн тогтоц, элдэв өвчний үүсэх шалтгаан, өвчний шинж тэмдэг, анагаах арга болон өвчнөөс

сэргийлэх арга зам, эмийн найрлага, эм бэлтгэх арга ухаан зэрэг өргөн асуудлыг судлан шинжлэж ном бүтээлээ тухайн цагт Төв Азийн олон орны хувьд Lingua Franca болж байсан төвөд хэлээр бичдэг, бас эмчилгээний бүх арга барилд биеэрээ үлгэрлэн дагуулж шавь нараа сурган бэлтгэдэг уламжлалтай байсан билээ. Энэ ташрамд тэмдэглэхэд тэр цагт төвөд хэл бичиг нь дундад зууны үед Европ дахинаа латин хэл ном судрын хэл болж байсантай нэгэн адил Төв Азийн олон орны хувьд ном бичгийн хэл болж байсан тул монголын бичгийн хүмүүс эх хэлнийхээ хажуугаар төвөд хэлээр их бага таван ухааны номыг өдий тодий ботиор зохиож монголдоо тодийгүй төвөд, энэдхэгт гайхагдаж ирснийг үл нуршин гол сэдэв рүүгээ эргэж орсу. Монгол хүний төвөд хэлээр бичсэн анагаах ухааны олон боть ном зохиолын дотроос нэгийг сонирхуулан дурдахад Найман тойн гэж алдаршсан Жамбалдоржийн «mDzes mTshar mig rgyan» гэж товч нэрээрээ олон нийтэд танил болсон бөгөөд 1971 онд Шинэ Дели хотноо гэрэл зургийн аргаар дахин хэвлэгдсэн бүтээлд л гэхэд ургамлын гаралтай 323, эрдэсийн гаралтай 135, амьтны гаралтай 124 зүйлийн эмд ордог хэрэглэгдэхүүнийг зураг тай нь тодорхойлж, бас монгол эмнэлэгт хэрэглэж ирсэн шинжилгээний болон мэс заслын 63 багажийн зургийг тайлбарын хамт, мөн хүний биеийн огтлолзуйн байдлыг зургаар үзүүлсэн байгаа нь нэн сонирхолтой төдийгүй үнэтэй ховор сурвалж бичиг мөн болой. Энэчлэн дээр дурдсан олон монгол эмчийн гол гол бүтээл нь төвөд хэлээр бард гарсан байна.

Бариач нарын талаар цухас боловч дурдалгүй орхиж хэрхэвч болохгүй буй заа гэж санаж байна. Монголын өргөн уудам нутагт таван хошуу мал адгуулан өсгөж, сүү шимээр нь цагаан идээний үйлэтхэл хийж аж төрдөг нүүдэл амьдралын эрхээр монголчууд төв суурин газраас алслан сууж, хээрлэн явах шаардалга захаас аван гардаг нь нийтлэг байсан бөгөөд эрхлэх үйлдвэрийн улмаас унаа малаас ойчих, бэртэх зэрэг нь аль олон тохиолдохыг хэлэх нь юун. Үүнээс үүдэж яс хугарах, мах тасрах, тархи толгой хөдлөх, үе мөч булгарах, цул эрхтэн хийгээд сав суулга доргин гажих зэрэг эмгэг согог олох явдал бага бус гардаг байсан нь хэн бүхэнд мэдээж билээ. Энэ мэтийн гэмтэл согогийг анагаан засдаг *бариач* гэдэг тусгайлан мэргэжсэн хүмүүс аж төрөхийн шаардалгаар их л эрт цагаас буй болж уламжилсаар өнөөг хүрчээ. Монголчуудын дунд жинхэнэ сайн бариач ихэнхидээ удам дагадаг гэдэг яриа байдаг нь үндэстэй боловч адуу малынхаа бэртэнгэ гэмтлийг барьж зассаар яваандаа гартаа дүйтэй болсон мэргэжлийн бариач нар гардаг байсныг ч үгүйсгэх аргагүй. Бариач хүн хэн боловч эхээс гармагцаа бариач байдаггүй болохоор тодорхой дадал, гар хурууны мэдрэмжтэй болох гэж ахмад сайн бариачид шавь орж гол ёсыг нь хэлүүлж, дараа нь устай буюу элстэй тулманд хуга цохисон

чомөт зэрэг ясыг хийгээд илж барьж эвд нь оруулдаг болоод улмаар бага малын бэртэнгэ сотогийг засч эхэлдэг байжээ. Ийнхүү яв явсаар хүн барьдаг хэмжээнд хүрдэг байсан уламжлалтай байв. Бариач нарын мэдвээс зохилтой нэгэн гол зүйл бол хүн малын биеийн бүтэц мөн бөгөөд үүнд таван хошуу малыг адгуулан өсгөж үржүүлэх ажил онцгой хэрэг болдог байлаа. Үүнээс гадна бариач болохын гол ёсыг заасан тусгай ном зохиол ч байдаг байж шүү. Жишээ гэхүл, Сайн ноён хан аймгийн Арвай хээрийн хошууны Бишрэлт бандида Цэвэлванчуг, бавуудорж гэдэг, 15 боть ном зохиосон их бичгийн хүний «Монгол ёсны бариач хэмээгч заслын ёсон сэлт» гэдэг төвөдөөр бичсэн бүтээл байсан ажээ. Энэ хүний 15 боть зохиол нь Арвайхээрийн хүрээнд бард гарчээ. Энэ 15 ботид нь хүн эмнэлэг, мал эмнэлэг, судар тарнийн ухааны зохиол ордог юм. Энэ бүхнээс үзэхүл монгол бариачийн засал, анагаах арга нь цаанаа нарийн үндэс, ёс дэгтэй байжээ гэж хэлэх бүрэн үндэстэй ажгуу.

Малчин монголчуудын дунд «эмээс дом», «жор үзсэн ламаас зовлон үзсэн чавганц дээр» гэдэг үг байдаг. Мал сүргээ адгуулан алс хээр аж төрөх явцад мэргэжсэн эмч нараас хол өвдөж зовох, хүүхэд нялхас нолцойж айлгах явдал аль олон гардаг байсан бөгөөд энэ үед чухамхүү сая өгүүлсэн дом, хар бор арга, «зовлон үзсэн чавганц»-ын хэрэг гардаг байж дээ гэж эрхгүй санагддаг. Үүнд: хүүхдийн ам тэмтвэл нагацын моринд халуун амгай зуулгах буюу толгойгоор нь хүйтэн усанд дүрэх, хүүхэд хөлсөж уйлвал тугалга цутгах зэрэг зан үйлийг хийх, өвдөг гарахад дотоод хормойгоо долоо нугасхийж тахилзуур доогуураа гаргаад «гарвал долоо гар, гарахгүй бол дороо хат» гэж домнодог, эсбөгөөс нүцгэн өвдөгөөрөө домнож дурдсан хэллэгийг хэлдэг зэрэг нутаг нутагт түгээмэл тархсан домын арга байснаас гадна тухайн нутагийн өвөрмөц арга ч байсныг үгүйсгэж болохгүй. Домын арга нь их төлөв шившилгэтэй байдаг нь мөн эрт цагт хүмүүс үгийн шидэд итгэдэг байсан үеийн үлдэгдэл, үр хөврөл нь мөн буй заа. Ерийн нэг санахад гэнэн зүйл мөт боловч ард түмэн маань олон үеийнхээ туршиж хэрэгсэн үзсээр байсныг үгүйсгэх аргагүйгээс гадна тухайн зан үйлтэй холбогдсон үйл хөдөлгөөн, юм хүм нь тэр өвчин эмгэгт зохих нөлөө үзүүлдэг байсан байж бүрэн болох билээ. Домын зүйлийг ерөнхийд нь үзэхэд сэтгэл санааны хувьд тухайн өвчтөнд өдгөө сайжрана гэдэг итгэл төрүүлэх дэвсгэрийг буй болгохын сацуу эмнэлгийн анхны тусламжийн маягтай байсан байдал харагддаг. Нийт монголчуудын дунд «Домын судар» гэдэг нэртэй гар бичмэл ном өргөн тархмал байсан бөгөөд зарим нь их л олон домын арга чарга багтаасан том ном ч байсан ажээ. Ийм номын нэг жишээ дурдахад Улсын Нийтийн Номын сангийн монгол номын хөмрөгт хадгалагдан буй «Эриндуа нацуг

домын судар орошибай» гэдэг монгол гар бичмэл номыг нэрлэж болно.

Монголын уламжлалт хүн эмнэлгийн талаар ярихад, нийт хүн ам хийгээд малчдын өнө удаан цагийн ажиглалт туршлгаар хэрэг тустай нь шалгаран боловсорсон *ардын эмнэлгийн* тухай дурдалгүй өнгөрвөөс бидний ярьж буй энэ сэдэв маань учир дутагдалтай болох нь лáв буй заа. Монгол ардын эмнэлгийн арга барилыг ерөнхийд нь авч үзэхэд: өвс ургамал болон бас бусад зүйлийг эмийн маягаар хэрэглэх, хоол ундаар засах, домын арга хэрэглэх гэсэн гурван зүйл харагддаг бөгөөд домын аргын талаар дээр товч өгүүлсэн билээ.

Өвс ургамал болон бусад зүйлийг эмийн маягаар хэрэглэж ирснээс зарим нэгэн жишээг дурдсу.

— Ходоодны гал буурч, идэш хоолны шингэц муудахад улаан чинжүүг харууц хэмээх улаан давстай хоолондоо хольж идвэл ходоодны гал сэргэнэ гэдэг. Энэ далимд дурдахад харууц давс заримдаа олдохуйяа бэрх байдаг тул эмч нар маань тусгай жорсор харууц давс найруулан хийдэг байсан нь хими хэмээх хувилахуй ухааны хувьд ямархуу мэдлэгтэй байсны нэг гэрч буюу гэж санагддаг.

— Ханиалга, ханиад зэрэгт хөх дэгд, банжингарбо, царван зэрэг өвс ургамлыг хандлаж уудаг.


— Гахай хавдарт хятадын заартай хар бэхийг түрхвэл сайн гэлцэж хэрэглэдэг.

— Шээс задгайрахад цулхир буюу цулхирын гурилыг цайндаа орхиж уувал тустай гэдэг.

— Шар дүүрэх, элэг дотрын элдэв гэмд ширгээсэн ус уувал сайн. Тэгээд ч ардуудын дунд «шинэ эмчээс ширгээсэн ус» гэдэг үг байдаг нь дэмий хэрэг бус болой.

— Халуунд цагаан мөөгний шөлийг сайн хэмээж өргөн хэрэглэнэ. Ялангуяа дотор шунасан халуунд нэн сайн гэлцдэг. Хүүхдийн халууны тухайд эхийнх нь усыг өгдөг явдал байсан бөгөөд «эхтэй хүн халуунаар үхдэггүй» гэж ярьдаг. Заримдаа алс хол явах зэрэгтээ эхийнхээ усыг арвайн гурилд шингээж авч явдаг явдал ч байсан аж.

— Манай малчид од харж нүдний хараагаа шалгадаг байсан билээ. Үүнд: Долоон бурханы б-р од буюу зуч (бас нэхэх арга од ч гэдэг, европ дахинаа их төлөв мицар хэмээх) одны дэргэдэх *жирэглэх од* (европ зүгийн олон хэлнээ алькор) хэмээх бяцхан дагуул одыг хараад хэрэвээ үзэж байхул хараа сайн



Долоон бурхан буюу Долоон өвгөн одны дэргэд байдаг Жирэглэх одны байршил

байна гэж, үзэхээ байчихсан бол нүд мууджээ хэмээн залуу адууны цус ханаж тусгай зааврааp хэсэг уугаад дахин шалгадаг ёсон байжээ.

— Хүүхдийн хүй сайн цөглөхгүй бол эхийнх нь гээгийн үүүрээс авч түлээд нүүрсий нь нарийн талхлаж үрдэг зэрэг маш олон арга монголчуудын дунд байж билээ.

Монголчуудын хоол хүнсний тухайд, мах цагаан идээнээс өөр зүйл идэж хэрэглэж мэддэггүй байсан гэдэг ташаа ойлголт цилээд олон хүний тархи толгойд эргэлдсээр, түүнийгээ хэлж бичсээр байгаа явдал ч буй. 1990 онд зохиосны нь 750 жилийн ойг дэлхий даяар тэмдэглэсэн «Монголын нууц товчоон»-д гэхэд л энэ ташаарлыг зассан бодтой баримт бийгээс гадна судалгааны ном зохиол зэргээс үзэхүл монголчууд наад зах нь 20 гаруй жимс жимсгэнэ, арваад үр тарианы зүйл, арав шахам сонгинын төрөл хийгээд шанцайн ургамал, гуч шахам цайны ургамал өвс, бас бус мөөг, самар, халуун ногоо тэргүүтнийг хоол тэжээлдээ хэрэглэсээр байсныг бэлхэнээ мэдэж болно. Энэ бүхэн бол хүний биед хэрэг тустай ургамлын гаралтай махбодыг хоол хүнсэндээ хэрэглэж ирсний баримт буюу.

Монголчуудын хоолоор засах аргын тухайд нэгэн зүйлийг онцлон тэмдэглэх хэрэгтэй гэж бодном. Юу хэмээвээс аль нэгэн эрхтэний өвчин эмгэгт мал, ан гөрөөс, жигүүртэн шувуудын тухайнх нь эрхтэн тустай гэдэг нэгэн сонин зарчим байсныг хэлвэл зохино. Жишээлбэл: ходоодны эмгэгт ёл, сар буюу чоныи ходоод, шөлийг тустай гэж тусгай аргаар хэрэглэдэг байсан билээ.

Монгол ардын эмнэлэгт хэрэглэж ирсэн, дээр өгүүлсэн зүйлийг тэр хэвээр нь хэрэглээрэй гэсэн зөвлөгөө огт биш, харин нарийн мэргэжлийн хүмүүс монгол ардын эмнэлгийн гүнд бүрэлдэн буй болсон арга, зарчим хийгээд түүний учир холбогдлыг орчин цагийн холбогдох холбогдох ухааны үүднээс судлан үзэж учир начры нь гаргах, шинжлэх ухааны үндэслэлий нь тодорхойлох, улмаар ашиг тустай үр хөврөлий нь нарийсган боловсруулж эмчилгээ сувилгааны үйл ажилдаа хэрэгсэн анхаарамсай гэсэн бодлоор энд дурдсанаа онцлон тэмдэглэх нь зүйтэй буй заа.

Монголчуудын хүн эмнэлгийн уламжлалд мал сүргээ адгуулан маллаж нүүдэллэн аж төрөх үйл ажиллагаатай салшгүй шүтэлт бариддсан, элдэв өвчин эмгэгээс сэргийлэх арга буй болсон байдал илэрхий харагддаг. Монголчуудын аж төрөх нэгэн гол нөхцөл бол жилийн дөрвөн улиралд цаг ямагт цэнгэг ариухан салхинд усны тунгалаг, өвсний сорыг даган нүүдэллэж явж, өрхлөн хөтөлдөг ажил төрөл нь биеийн тамирын дасгал сургууль болж ирснээс гадна хоол ундны дэглэм, гал тогооны зүйл нь элдэв өвчин халдвараас сэргийлэх шаардалгад зохицож байсан ажээ. Хоол ундны тухайд цагаан идээг толдож махан хоол-

той салаавчлан хэрэглэдэг, зун намрын тэнүүн цагт махан хоол бараг иддэггүй, өвөл хаврын хатуу цагт өөх тослог ихтэй, нүнжиг бүхий мах голдсон хоол иддэг, бас байн байн мацаг барьдаг байсан зэрэг нь хоол боловсруулах эрхтэний үйл ажиллагааг он удаан жил жигд сайн байлгах бололцоог бүрэлдүүлж байсан буй заа.

Монголчууд мөнгөн аяга, мөнгөн савх, мөнгөн савхан хувин болон зэс сав суулга, зэс тогоо шанага тэргүүтнийг хэрэглэсээр байсан нь эмнэлэг эрүүл ахуйн үүднээс цаанаа учир холбогдолтой байжээ хэмээн мэргэжлийн хүмүүсийн нэг бус удаа тэмдэглэсэн нь бий. Аж төрөхийн эрхээр заримдаа халдваргүй өвчнөөр үхсэн малын махнаас идэх, бас яһ бүрийн усаар унд хоол хийх зайлшгүй шаардлага гарах тохиолдолд хэрэглүүжин хэмээж аянчин жинчин, оторчин нүүдэлчин нар тусгай хэсэг зэс авч явдаг байсан бөгөөд түүнээ хоол унд болгохдоо хажууд нь хийж чанадаг ёсон монголчуудын дунд нийтлэг уламжлал болсон байж билээ. Ийм ч учраас мөнгө, зэс сав суулга, аяга савх зэрэг нь элдэв нян, халдварыг устгаж, хоол ундыг ариутгах, хүний биед нөлөөтэй сайн байдагийг монголчууд эрт цагаас ажиглалт туршлагаараа мэдэж, аж төрөлдөө хэрэглэсээр байжээ гэж хэлэх бололцоог бидэнд олгож байгаа юм.

Бас нэгэн зүйлийг дурдахад монголчууд бараг толгой дараалан тусгай аяга, тусгай хутга савх, тусгай аяганы алчууртай, түүнийгээ ямагт биедээ авч явдаг байсан зэрэг нь одоогийн эрүүл ахуйн шаардлагаар тавьдаг ёс зарчимтай яг тохирч байгаа зүйл ажээ.

Монголчуудын хүн эмнэлгийн уламжлалын талаар дээр өгүүлсэн зүйлийг ерөнхийд нь авч үзэхүл энэ уламжлал нь хэдийгээр зарим талаараа төвөдийнхтэй холбоотой байдаг боловч яг адилтгах аргагүйгээр үл барам монголын хүн эмнэлгийн уламжлал нь төвөдийн анагаах ухаанд багагүй нөлөөлсөн, бас тэр тухайн цагийнхаа өрнө дорнын анагаах ухааны ололт амжилттай зохих хэмжээгээр танилцаж чадсан; монгол эмч нарын тухайд гэвэл тэдний үйл ажиллагаа нь эш онолын хувьд өвөрмөц нэгдмэл байдалтай байжээ гэсэн хэдэн гол санааг хэлж болмоор санагдаж байна. Үүний зэргэцээ монгол *ардын эмнэлгийн* арга нь *уламжлалт хүн эмнэлгийн* ухаантай нягт холбоотойгоор бие биесээ харилцан баяжуулж, амьдралын ажиглалт туршлагаар шалгаран боловсорсон нэгдмэл өвөрмөц зүйл байсан юм гэдгийг тэмдэглэх хэрэгтэй буй заа.

ЛАВЛАРУУЛАН ҮЗҮҮЛТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Рашид-Ад Дин, **Сборник летописей**, Том I, книга I, М-Л, 1952, стр. 122.

Юан улсын судар, 1—210 дэвтэр, Дандаагийн орчуулга, гар бичмэл.

Гомбожав, **Монголчуудын төвөд хэлээр зохиосон зохиолын зүйл**, Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал, 1-р дэвтэр, Улаанбаатар, 1961, 18—49.

Олдсон зүйлийн эмийн нэр тодотгосон бичиг, төвөд монгол хадмал гар бичмэл, олон зүйл зурагтай.

Хайдав Ц., Алтанчимэг Б., Варламова Т. С, **Лекарственные растения в монгольской медицине**, УБ, 1985, стр. 32.

Chagdarsürüng Ts, **La médecine des Mongols nomades**, SM, T. IX (17), Fasc. II, UB, 1982, pp. 174—183.

Sagdarsüren C, **Die traditionelle mongolische Medezin**, -Die Mongolen, Pinguin, 1989, s. 272—273.

МОНГОЛЧУУДЫН ХЭРЭГЛЭЖ ИРСЭН МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ЗҮЙЛЭЭС

Монголчуудын түүх соёлд шууд холбогдох эд өлгийн зүйл хийгээд булш бунханаас олдсон олдворын дотор янз бүрийн мөнгөн зоос хэрэглэсээр байсны баримт өдий төдийгөөрөө байдаг. Мөн Юан улсын үед дэлдсэн монгол дөрвөлжин бичиг бүхий нэлээн хэдэн зүйлийн зоос, мөн монголын Ил хаадын үед Дундад Ази дахинаа гарсан араб бичигтэй монгол зоос цөөн бус гарсныг XIX зууны сүүлийн хагаст англичин эрдэмтэн Лэне Пууле, Францын эрдэмтэн Р. Бонапарт нар судалгааны номдоо тодорхойлон ар өвөр талынх нь гэрэл зургийг хавсарган үзүүлсэн билээ.

Бид энэ удаа зоосны талаар ярихаа түр хүлээгээж, монголчуудын хэрэглэж ирсэн цаасан мөнгөн тэмдэгтийн талаар ярилцвал илүү сонин болов уу гэж саналаа.

XIII зууны сүүл үеэс монгол газар зочлон ирж байсан алдарт жуулчин-элч Гильём де Рубрук, Марко Поло нарын тэмдэглэлээс тэр цагт монголчууд цаасан мөнгөн тэмдэгт хэрэглэн зарж байсан тухай европынхон үзээд ихэд гайхан итгэж ядаж байсан тухай эрдэмтэд тэмдэглэжээ. Гильём де Рубрукийн номын 39-р бөлөгт монголчууд цаасан тэмдэгтийг зоос мөнгөний оронд хэрэглэдэг тухай, мөн тэр цагт Орос газар янз бүрийн үнэт ангийн үс, үен хийгээд хэрэмний арьсыг зоос мөнгөний маягаар гүйлгээнд хэрэглэж байсан тухай дурдсан нь буй. Марко Поло номынхоо 96-р бөлөгт Их хааны ордоны хүү сангийн бархан цаасан мөнгөн тэмдэгтийг хэрхэн хэвлэдэг, түүнийг гүйлгээнд яаж зарцуулдаг талаар их л дэлгэрэнгүй бичсэн байдаг билээ. Энэ бүхэн бол харь газрын жуулчны гаднаас нь үзээд бичсэн тэмдэглэл! Харин түүхэнд хэрхэн тэмдэглэн үлдээж вэ? гэдэг бас л сонин. «Юан улсын судар» хэмээх 210 дэвтэр түүхийн хоёрдугаар дэвтэрт «...Дайжун хааны наймдугаар он-улаан бэчин жилийн цагаан сар... зарлиг цаасан бафию дармалж явуулав...» гэж тэмдэглэсэн байдаг нь аргын тооллын 1236 онтой тохирно. Үүнээс хойно Хубилай (1215-1294) хааны үед, тухайлбал, 1260 онд мөнгөний шинэтгэл хийж улсын олон мужид гарган хэрэглэж байсан янз бүрийн цаа-

сан дэвсгэртийг нэгттэн нэг мөр болгосон тухай баримт мөн байдаг. Хэрхэн тодорхойлсныг эшлэж танилцуулая:

«...Шизү Жүнтүнгийн анх онд сэйкэюү чүү хэмээх цаас хийв. Ширхэгээр өртөг болгожээ. Мөнгө бүр тавин лан. ширхэг цаас нэгэн мянган лангаар арилжимуй. Олон юмын үнийг цугаарыг ширхэгийн хуулийг дагана. Энэ жилийн арван сард бас Жүнтүнгийн ювамбүү цаас хийв. Жүнтүнгийн ювамбүү цаас: түүний бичиг нь араваар үйлдсэн нь дөрөв:

арван үсэг
хорин үсэг
гучин үсэг
тавин үсэг хэмээмүй. Зуугаар үйлдсэн нь гурав:
нэгэн зуун үсэг
хоёр зуун үсэг.
таван зуун үсэг. Хэлхээгээр үйлдсэн нь хоёр:
нэгэн хэлхээ үсэг
хоёр хэлхээ үсэг. Хэлхээ бүр цаас нэгэн ланлугаа адил. Хоёр хэлхээ цагаан мөнгө нэгэн лантай адил... Бас хээтэй лэнсээр нэхэж Жүнтүнгийн мөнгөний эд болговой. Түүний зэрэг нь тав буй.

нэгэн лан
хоёр лан
гурван лан
таван лан
арван лан хэмээмүй. Нэгэн лан бүр цагаан мөнгө нэгэн лантай адил...» гэжээ (Юан улсын судар, 93-р, Идэш эдийн тэмдэглэл, 42-р).

Сайхи эшлэлээс үзэхүл цаасан мөнгө тэмдэгтээс гадна бас лэнс хэмээх бөсөөр нэхэж үйлдсэн мөнгөн тэмдэгт байсан ажээ.

Үүнээс хойш 15 он болоод буюу 1275 онд хоёрдугаар шинэчлэл хийсэн тухай мөн түүхэнд тэмдэглэсэн нь:

«...Жи Юаны арванхоёрдугаар онд Ли чүү хэмээх цаас нэмж хийв. Түүний дүрэм нь гурав буй амуй:

хоёр үсэг
гурван үсэг
таван үсэг хэмээмүй...» гэжээ.

1309 онд гутгаар шинэчлэлийг хийсэн тухай дурдсан нь:

«...Жи да Үжүнгийн хоёрдугаар онд басхүү юм хүнд, цаас хөнгөн болсон учирт халж Жи да'гийн мөнгөн цаас хийв. Хоёр лангаас хорин ли хүртэл тогтоож гурван зэрэг болгожээ. Лан бүр Жи юаны цаас таван хэлхээ мөнгө нэгэн лан, алт нэгэн цэнгээр тогтоожээ. Юан улсын цаасны хууль үүнд хүрч ирээд лав гурав хувисчээ...» гэсэн байдаг.

Үүнээс үзвэл энэхүү гутгаар шинэчлэлтийг юмны үнэ өсч, цаасан мөнгөний ханш буурсан үед хийсэн болох нь тодорхой харагдаж байна.

Монголчууд энэ үед цаасан мөнгөн тэмдэгтээ хэрхэн хийдэг байсан тухай мэдээг мөшгөж үзвээс «...анх цаасны хэв нь мод хэрэглэж хэв болгожээ. (Жи Юаны Ц. Ш.) арван хоёрдугаар онд гуулиар цутгаж хайлжээ...» гэж байгааг бодохул цаасан мөнгөн тэмдэгтээ модон бараар хэвлэн олшруулж байснаа

1276 оноос гуулин бараар барласан цаасан дэвсгэрийг үйлдэх болжээ гэх бүрэн үндэс аяндаа гарч ирнэ.

Сая бид XIII зууны үед монголчууд цаасан мөнгөн тэмдэгт гаргаж байсан түүхэн мэдээг товч дурдлаа. Тэгэхээр тэр үед барлан гаргаж, хэрэглэж байсан тэрхүү дэвсгэртүүд бие бодоороо байна уу? гэдэг асуулт зүй ёсоор гарч ирнэ. Орос-Зөвлөлтийн эрдэмтэн П. К. Козловын удирдсан эртний судлалын шинжээний анги Хар хотоос тэр үеийн цаасан мөнгөн тэмдэгтээс арав шахуу зүйлийг олсон бөгөөд энэ чухаг ховор олдворыг польшийн нэрт монголч эрдэмтэн В. Котвич 1904 онд, зөвлөлтийн эрдэмтэн Е. И. Лубо-Лесниченко 1968 онд тус тус судалсан нь бусад судлагчдынхаас хамгийн нарийн бөгөөд дэлгэрэнгүй нь болой. Гэвч тэр цагийн цаасан дэвсгэрт дээрхи монгол дөрвөлжин бичгээр, хятад хэлээр буй бичвэрийн зүйлийг бараг уншаагүй, учир битүүлэг байсаар ирснийг 1955 онд академич Ринчен профессор тайлан уншиж нийтийн хүртээл болгосныг тэмдэглэлгүй орхих аргагүй юм.

Энд нэгэн зүйлийг онцлон тэмдэглүүштэй санагдлаа. Юун хэмээвээс, 1990 онд Н. В. Ивочкина авгай «Хятад орон дахь цаасан мөнгөний гүйлгээ буй болсон нь» гэдэг номдоо «...өдгөө шинжлэх ухаанд мэдэгдэж байгаагаар дундад зууны үеийн хятадын хамгийн эртний гэгдэж байгаа жинхэнэ цаасан дэвсгэрт нь Юаны үеийнх болж байна. Түүнээс түрүү үеийнх нь гэвэл зөвхөн цаасан мөнгөний барын төдийхнөөр хадгалагдаж иржээ...» гэж тэмдэглэжээ. Үүнээс үзэхүл Хар хотоос олдсон Юаны үеийн цаасан мөнгөн дэвсгэртүүд нь соёлын түүхнээ чухаг хэрэглэгдэхүүн болсоор байгаа билээ.

Ийнхүү дээр цагаас цаасан мөнгөн тэмдэгт үйлдэн арилжаа гүйлгээнд хэрэглэж байсан монголчуудын уламжлал тасралтгүй явсаар одоог хүрчээ. «Монгол Ард улсын угсаатны зүй, хэлшинжлэлийн атлас» хэмээх бүтээлийн «Цаасан мөнгөн тэмдэгт хэрэглэж байсан хүрээ хийдийн тархац» гэдэг зургаас үзэхүл, лавтайяа мэдээ баримтаар Төв халхын нутаг гэхэд л 9 газар хэрэглэж байсан ажээ. Гэхдээ тэр 9 газар хэрэглэж байсан цаасан дэвсгэртүүд нь өөр өөр нэртэй, өөр өөр нэгжтэй, тухайн хүрээ хийдийнхээ нутаг хязгаарын дотор гол төлөв арилжаа наймаа, зэд погийн зүйлд гүйдэг байсан байна.

Монголчууд цаасан мөнгөн тэмдэгтийг ерөнхийд нь *цаасан тийз буюу цаасан пиу* гэж нэрлэдэг боловч газар газрын хэрэглэж байсан дэвсгэртүүдийн оноосон нэр, нэгж нь өөр өөр байсан байдал харагддаг.

Ингээд хэдэн зүйл цаасан мөнгөн тэмдэгтийн талаар товч танилцуулсу. 1873 онд Хүрээний Их сангаас мууту цаасан дээр хар бэхээр барлаж, таван зүйл тэмдэгийг улаан шунхаар дарж хүчин төгөлдөр болгосон «Хүрээний их сангийн тэмдэг»


至元通行寶鈔
貳貫
字號
字料

Жи Юаны арванхоёрдугаар онд гаргасан цаасан мөнгөн тэмдэгтийн хуулбар зураг


нөртэй цаасан дэвсгэрт гарган хэрэглэж байжээ. Энэхүү «Хүрээний их сангийн тэмдэг» нь «зоос» гэдэг нэгжтэй байсан аж. 1955 онд академич Ринчен профессор «Хүрээний их сангийн тэмдэг»-ийг судлаад Унгарын Акта Ориенталиа сэтгүүлд франц



1873 онд гарсан «Хүрээний их сангийн тэмдэг»-ийн гэрэл зураг (хэмжээ 9x13 см)

хэлээр тусгай өгүүлэл бичиж эл цаасан тэмдэгтийг дэлхий нийтийн сонорт анх хүргэсэн билээ.

XVIII зууны тэргүүн хагаст Сайн ноён хан аймгийн Чин сүзэгт номун хан хутагтын шавьд «Их сангийн тийз» нэртэй цаасан мөнгөн тэмдэгтийг анх гаргаж, дараа нь сэлбэн хэдэнтээ барласан бөгөөд 1918 онд тавдахи удаа тархаасан тухай мөн хутагтын шавь Я. Цэвэл хэд хэдэн өгүүлэлдээ тодорхой тэмдэглэсэн нь буй. «Их сангийн тийз» нь шар цай гэдэг нэгжтэй байсан бөгөөд дотроо хоёр зүйл дэвсгэрт байжээ. Нэг нь «нэг шар цай»-ны, нөгөө нь «арван шар цай»-ны дэвсгэрт гэж ялгаатай байсан ажээ. Энэхүү цаасан мөнгөн тэмдэгт бараг 1935 он хүртэл нутаг усандаа хэрэглэгдэж байсан баримт буй.




Чин сүзэгт номун хан хутагтын шавьд хэрэглэж байсан «Их сангийн тийз»-ийн зураг (хэмжээ 8x11 см):
а. Арван шар цайны тийз
б. Нэг шар цайны тийз

Чин сүзэгт номун хан хутагтын хүрээнээс хурал номынхоо дэгийг авсан бусад хүрээ хийд, тухайлбал: Говь сангийн далайн хийд, Эхин загийн хийд буюу Долоон шар загийн хийдэд мөн жишээгээр тийз хэмээх цаасан мөнгөн тэмдэгтийг шавь дотроо гарган хэрэглэж байсан мэдээ баримт байдаг. «Их сангийн тийз»-ийг барлаж гаргахдаа дөрвөн махбод нөхцөн барилдаж баттахыг дүрсэлсэн тусгай суурь дүрсийг, элбэг баян бөгөөд хөгжин дэвжихийн бэлгэдэл гэж үздэг арслангийн будагаар дардаг зэрэг нарийн ширийн ёс жаяг байсныг Я. Цэвэл

болон миний бие үүнээс өмнө тусгайлан бичсэн тул энд дэмий олныг нуршсангүй.

1968 онд ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн ажилтан, эрдэмтэн Х. Лувсанбалдан Завхан аймгаар шинжилгээний ангиар явах зуураа Ялгусан хутагтын шавьд хэрэглэж байсан гурван янзын цаасан мөнгөн дэвсгэрийг олж, холбогдох мэдээг тэмдэглэн авсанаа надад үзүүлж «Монголчуудын цаасан мөнгөн тэмдэгт» гэдэг өгүүлэл бичихэд минь тусалсан билээ. Уул мэдээгээр, цаасан мөнгөн тэмдэгтийн нэгж нь *зэд* гэдэг нэртэй бөгөөд тэр шавийн дотор 1, 3, 5, 10, 50, 100 зэд гэсэн нийтдээ 6 янзын дэвсгэр байсан ажээ.



Гурван зэдийн дэвсгэрт (хэмжээ 8,5х15 см)



Арван зэдийн дэвсгэрт (хэмжээ 8,5 х 15 см)

Дээр дурдсан зүйлээс үзэхүл монголчууд харьцангуй эрт цагаас мөнгөн сангийн хувьд боловсронгуй тогтолцоог буй болгоснь үндсэн дээр арилжаа гүйлгээний хэрэгт нэн эрт цагаас сүхэс гэдэг нэгжээр цэвэр алт, мөнгө зардаг байсан уламжлалаа цаасан тэмдэгтээр төлөөлүүлэн сольж ирсэн нь хэдийгээр зарим үедээ нийт улс даяар түгээмэл бус байсан боловч мөнгөн сангийн сэтгэлгээний хүрээнд алс хэтийн хараатай, нарийн бодож боловсруулсан бодлоготой байсныг гэрчлээд зогсохгүй нийт хүн төрөлхтөний утга соёлын их санд зохих байр суурь

эзэлсээр ирсэний баримт бөлгөө. Үүнийг ч жинхэнэ эрдэмтэн нөхөд тэмдэглэсээр иржээ. Академич Б. Я. Владимирцов «Баруун монголын баатарлаг тууль» гэдэг номын удиртгалдаа XIII зууны үеийн монголчууд соёл боловсролынхоо хувьд тэр цагийнхаа Европ дахинаас давж гарсан байжээ гэдгийг үнэмшдэггүй байлаа гэж дурдаад энэхүү давуу байдлын баримт болгож «...монгол гүрэн нь засаг захиргааны цэгц зохион байгуулалттай, зам харилцааны нарийн журам дэгтэй, мөнгөн сангийн чанд нарийн тогтолцоотой, журамласан байнгын болон хэшигтэн, торгууд гэдэг тусгай торгон цэрэгтэй, дарь, их буу хэрэглэдэг, ном зохиол хийгээд *цаасан мөнгөн тэмдэгтээ хэвлэн гаргадаг*, өчигдрийн тал нутгийн нүүдэлчин малчны хөвүүд үрсийн тэргүүлсэн улс байсан юм...» гэж онцлон тэмдэглэснийг энд эшлэн дурдахад яав ч илүүдэхгүй буй заа.

ЛАВШРУУЛАН УЗҮҮШТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Юан улсын судар, 2-р дэвтэр, Уг тэмдэглэл, Дайзүн; 93-р дэвтэр, Идэш эдийн тэмдэглэл, 42-дугаар.

Lane-Poole S, **The Coins of the Mongols in the British Museum,** London, 1881.

Bonaparte R, **Documents de l'époque mongole des XII-e et XIV-e siécles,** Paris, 1895.

Котвич В, **Из находок П. К. Козлова в г. Харахото, Образцы ассигнации Юаньской династии в Китае.** Известия ИРГО, XLY, 1904, стр. 474—477.

Владимирцов Б. Я, **Монголо-Ойратский героический эпос,** М., 1923, стр. 8.

Козлов П. К, **Монголия и Амдо и мертвый город Хара-Хото,** М., 1948, стр. 86—87.

Rintchen, **A propos du papier-monnaie mongol,** АОН, Tom. IV, Fasc. 1—3, Budapest, 1955, pp. 157—164.

Книга Марко Поло, М. 1956, глава 96.

Гильом де Рубрук, **Путешествие в Восточные страны** -Путешествия в восточные страны Плано Карпини и Рубрука, М., 1957, глава 39.

Лубо-Лесниченко Е. И, **Ассигнации монгольского времени** (по материалам Хара-хото), НАА, М., 1963, № 3

Chagdarsuren Ts, **A propos de deux sortes de papier-monnaie mongol,** МУИС-ийн Эрдэм шинжилгээний сонсгол, № 30, UB., 1972, pp. 37—47.

Дамдинсүрэн А, **Монгол мөнгө,** УБ., 1975.

Цэвэл Я, **Чин сүзэгт номун хан хутагтын шавь,** -ТС, Том. XXV, 13-р дэвтэр, УБ, 1990, 123—152-р тал.

Ивочкина Н. В, **Возникновение бумажно-денежного обращения в Китае** (Эпохи Тан и Сун), М., 1990.

ТАВАН ХОШУУ МАЛ СҮРГЭЭ АДГУУЛАН ӨСГӨСӨН МОНГОЛ УХААНААС

ХЭМЭЭХ ХОЁРДУГААР БӨЛӨГ

МОНГОЛЧУУДЫН МАЛ МАЛЛАГААНЫ УЛАМЖЛАЛТ АРГА БАРИЛААС

Эртний судлалын эд өлгийн хэрэглэгдэхүүнээс үзэхүл шинэ чулуун зэвсгийн үеэс бидний өвөг дээдэс энэ уугуул нутаг газар дээрээ мал сүргээ адгуулан өсгөж малынхаа ая заңг дагаж нүүдэллэн аж төрж ирсэн нь монголчуудын амьдралын өвөрмөц хэв маягийг буй болгожээ. Мал нь ч гэсэн ус нутагтаа идээшин эзэнгүшиж яв явсаар нэгэн онцлог шинж төлөвийг олсон нь суурьшмал газрынханы мал сүргээс их ялгавартай болгох нөхцөл шалтгааныг үүдхэж бүрдүүлжээ. Чухам энэ л өвөрмөц ялгаа бол монголчуудын мал маллагааны уламжлалт мөнөөс мөн бөгөөд өргөн хүрээнд авч үзвэл дэлхий нийтийн аж ахуйн хүрээнд оруулсан монголчуудын хувь нэмэр юм гэж хэлэх бүрэн үндэстэй билээ. Дэлхий нийтийн аж ахуйн түүхийг судалдаг гадаадын олон эрдэмтэн үүнийг хүлээн зөвшөөрсөөр ирсэн, харин манай өөрийнхөн маань ингэж үзэх бүү хэл, хамгийн хоцрогдсон аж ахуйн хэлбэр гэж доодлосоор, түүнд нь олон хүний чих дасч, тийм буй заа хэмээн сэтгэсээр нэлээд удсан ажээ. Иймд монголчуудын мал маллагааны уламжлалт арга барилын талаар гол үндсэн онцлогий нь товч ярих нь зүйн доторхи хэрэг гэж одлооб.

Монгол малын бие чаң, сүү шим нь малынхаа хувьд ч, эзнийхээ хувьд ч, хээрлэн бэлчиж өсөж үрждэгтэй нь нарийн зохицсон байдаг байжээ. Үүний учир гэвэл, жилийн дөрвөн улирлын туршид бэлчээрлэж явах тул суурин газрын мал шиг шахаж бордсон мэт лагс том бие, хэрэгцээнээс хэтэрсэн илүү сүү шим тохиромжтой бус байжээ. Малчид ч олон зуун жилийн амьдрал, туршлагаараа энэ бүхнийг мэдэж өөр өөрсдийнхөө идэж уух, өмсөж зүүх, эдлэж хэрэглэх гол гол зүйлээ хангаж чадахуйц, бас нутаг усандаа зохицсон малын үүлдэр угсааг буй болгож чадсан ажээ. Иймээ ч учраас монгол нутгийн мал бол сүү шим, үс ноос, мах, арьс шир жигд өгдөгөөс гадна уналга, ачилга, тэрэг чарганд зүтгэх зэрэг нүүдэл аж төрлийн бүхий л шаардалгад тэгш зохицдог байлаа. Сүү шимийн хувьд гэхэд монголчууд их төлөв өтгөн тослогийн хувийг эрхэмлэхээс бишхэмжээ арвиныг тэдий л голлодоггүй байсан нь нүүдэллэн зөөхөд бага болович чанартай юм авч явахад хялбар, нөгөө талаас

айл бүр өөрийн гэсэн *мал малын захтай* байсан болохоор сүү цагаан идээг илүүчлэн борлуулна гэдгийг бараг мэддэггүй, хэн нэгэн хүн илүүчилж зар гэвэл томдог байсан жинхэнэ монгол сэтгэхүйтэй холбоотой буй заа гэж боддог. Гэтэл энэ чанарыг «хувиа аргацаасан» хамгийн адагийн зүйл гэж муучилсаар өнөөг хүрсэн боловч монголчуудын мал маллагааны өнөөгийн «шинэ» арга мал аж ахуйгаа зохих ёсоор хөгжүүлж чадаагүйг нийтээр хүлээн зөвшөөрч, зөвшөөрөхөөс ч өөр аргагүйд хүрээд байгаа билээ.

Нүүдэл амьдралын нөхцөлд хадлан тэжээлийн талаар одоогийнхоос их л өөр ойлголт монголчуудын дунд байсан нь мөнөөхи л жилийн дөрвөн улиралд «өвсний соргог, усны тунгалагыг хөөж» туж нүүдэллэн явахад өвс хадланг тээж явах гэдэг санахад ч бэрхтэйгээс гадна тэгэх ч хэрэггүй, монгол мал өнөд ч гэсэн цасан дооросс өвс тэжээлээ олж идэж чаддаг, малчин ээж нь ч гэсэн өвөл цагт цасан доорхи агь, багалзуур, боролзой, бор бударгана, бор шаваг, бутуул, бүднүүр, хамхаг, хургалж гэх зэрэг бэлчээрийн олон зүйл өвс ургамлын шимт чанар хадгалагдсаар байдгийг андахгүй мэддэг байсан болохоор хадлан гэдгийг бараг авдаггүй байжээ. Бараг гэдгийн учир бол нарим нутагт цагийн хатууд нялх төлийг эхийнхээ аяыг дагаж бэлчээрт хүрэх хүртэл нь буюу «өргөдөг мал» гаруужин гэж тус багахан өвс нөөдөг байсантай холбоотой юм.

Монгол нутгийн мал эхлээд нутгийнхаа байгаль, цаг уурын нөхцөлд шал[illegible]дараа нь эзэн хүний ухаан бодлын дагуухи ухамсарт ша[illegible]лыг давхар туулж бие бялдар, ашиг шимийн хувьд шил[illegible]гийн нь үлддэг байсан болохоор «өргөдөг мал» гэгч бара[illegible]даггүй байсан байна.

Эрт[illegible]с монголчууд *мал малын захтай байхыг* эрхэмлэдэг байс[illegible]нь мөн л аж төрөх шаардалгатай нэгэн талаас холбоотой, нөгөө талаас *сүргийн зохицол* гэдэг нарийн зүйлтэй холбоотой байсан юм. Тэр цагт сүү шим, унгас ноос ноолуур, арьс шир, мах өөх, түүнчлэн уналга ачилга зэрэг олон зүйл айл өрх бүрт, ер хэн хүн бүрт зайлшгүй хэрэгтэй байсан нь аж ахуйн шаардалга болой. Үүнээс гадна таван хошуу мал (нэлээн түрүү үеийн сурвалжид хонь ямаа хоёрыг нэгд тоолон дөрвөн хошуу мал гэж байсан явдал буйг энд тэмдэглэсэу) сүрэг бие биесийн хүчинд шүтэж өсөн үрждэг байсан ажгуу. Тухайлбал цас зудтай үед бод мал нь бог малдаа зам чийр гарган өгдөг, үхэр өөрөө бууц тарьдаггүй болохоор хонь ямааныхаа тарьсан бууцны хөлөөр шөнө тавтай хэвтдэг, хүйтэн хошуутай ямаа хонины хооц нөмөр нөөлөгт шөнийг дулаан өнгөрөөдөг гэх зэргээр харилцан бие биедээ дулдуйдаж өсөн үржиж мал малын захын нэгэн цогц болдог байжээ.

Нэхүү манай малчин ард түмэн маань нутаг орон, байгаль цаг уурттаа бүрнээ зохицсон, нүсэр их хөрөнгө, хүч шаарддаг-

гүй, дөрвөн цагийн туршид бэлчээрлэн тааваараа өсдөг нутгийн малыг буй болгож чадсан байна. Энэ байдал нь ч эрт дээр цагаас бусад улс орны мал ахуйтны анхаарлыг зүй ёсоор татаж монгол малчны туршилга зааврыг авч хэрэглэж байсан түүхэн баримт байдагийг дурдахад сонин ажтуу. Үүнд: 1296 оны нэгэн албан захидлаас үзэхүл, Юан улсаас Гуулин хэмээх Солонгос улсад малчин хүнийг мэргэжилтнээр илгээж байсан тухай түүхэн баримт дайралддаг болохыг энэ далимд сонордуулсу.

Ингэж мал сүргээ бэлчээрээр адгуулан өсгөж ирсэн аж амьдрал нь монголчуудын хувьд мал аж ахуйг тойрсон тал талын уламжлалт мэдлэг ухааныг хөгжүүлсний зэрэгцээ аж төрөх нэн өвөрмөц хэлбэр маягийг буй болгож өгсөн ажээ. Харин тэрхүү аж төрөх уламжлалт өвөрмөц арга маяг нь 1960 он гэхэд үндсэндээ үгүй болж мартагдахад хүрсэн байна.

Монголчууд малаа *бод мал, бог мал* гэж ангилдаг нэгэн ёс бий. Энэ нь их төлөв эдийн засгийн шинжтэй буюу үнэ таацуулан бодоход нэгжийн үүргээр гол төлөв хэрэглэгдэж байлаа. Мөн үүний хажуугаар *урт хөлийн мал, богино хөлийн мал* гэж хуваадаг. Урт хөлийн мал гэдэгт бод малаас адуу, тэмээ хоёр нь ордог. Мал сүргээ ийнхүү хуваах нь бэлчээрийн хол ойртой холбоотойгоос гадна өрхийн доторхи эрэгтэй, эмэгтэй хүний хөдөлмөрийн хуваарьтай яг тохирдог байжээ. Үүнд, урт хөлийн малд багтдаг адуу, тэмээ хоёр нь алсын бэлчээрт идээшлэдэг; хонь, ямаа, үхэр гурав нь гэрийн ойр зуур бэлчих тул даруй богино хөлийн малд тооцогддог ажээ. Энэ хуваарьт үндэслэж өрх гэрийн эрэгтэй, эмэгтэй хүний хийх ажил ялгармуй. Тухайлбал: гэрийн эр хүн урт хөлийн малаа адгуулж, бэлчээр буудалаа шилж сонгох, алдуул мал эрэх, малын өвчин эмгэг, гэмтэл согогийг анагаах, уналга ачилга бэлтгэж нүүх, гэр орноо барих гэх зэрэг хүч чадал, зориг тэсвэр шаардсан олон үзүүрт ажлыг нугалдаг байжээ. Гэрийн бүсгүй хүн бол хүүхэд багачуулынхаа хамт богино хөлийн малаа харж хандах, хурга тугалаа хариулах, сүү сааль авах, идээ цагаагаа боловсруулан бэлтгэх, гэр орноо цэвэрлэж үйл оёдол хийх, аргал түлш түүх, амны усаа авах гэх зэрэг түмэн эхтэй ажлыг эрхилэж ирснээс гадна хүүхэд багачуудаа хүмүүжүүлж ажил амьдралын дөртэй болгоход анхаардаг байжээ. Хүүхэд багачууд ч эцэг эх, ах эгч нараа дагаж ажил төрөлд нь тусласаар нэг л мэдэхэд аж төрөх ухааны зах зухтай болчихсон байдаг билээ.

Ер нь монгол айлын эзэгдэй болгон гэр орныхоо ажлыг эрхилэн мэдэж ирсэн бөгөөд сүүлийн үед олон судлагчийн (тэгэхдээ гол төлөв манайхны) амнаас гардагчлан дандаа эрийн боол гэрийн зарц болж яваагүй гэдгийг түүхэн баримт сэлт, ардын билигийн хэрэглэгдэхүүн, өвгөд дээдсээс үе улиран ир-

сэн амьи уламжлалын өдий төдий зүйл нутласаар байгааг хэлмээр санагддаг бөгөөд хожим энэ тухай нэг зүйл бичнэ гэж хэрэглэгдэхүүнээ цуглуулсаар байна.

Монгол айл өрхийн дотоодод, эрэгтэй эмэгтэй хүний хөдөлмөрийн хуваарь нэлээд чанд байсан бөгөөд аж амьдралын эрхээр ганц биеэрээ бүхий л ажлаа амжуулах тухайд *«гадаа гарч эр болох, гэрт орж эм болох»* гэдэг тогтсон хэллэг байдаг нь ч үүнтэй холбоотой буй заа.

Бэлчээрийн мал маллагааны ажил нь малчин монголчуудын дунд хүн хүчээ нэгтгэж, хамтран ажиллах өвөрмөц олон хэлбэрийг буй болгож тэр нь ч улмаар хувиа бодсон аминч бодлыг монгол хүний сэтгэл санаанаас зайлуулан холдуулж *«айл хүний* амь нэг, саахалт хүний санаа нэг» гэсэн нийтэч үзлийг хэвшихэд хөрс суурь нь болсоор ирснээс гадна бие биестээ туслах үндсэн дээр суурилсан хамтын баярын сэцлог үйл ажиллагаат нөхцөлдүүлэн үүсгэсэн байдал илэрхий харагддаг.

Ийнхүү хамтран ажиллах өвөрмөц арга нь *хот айл, саахалт, нэгэн голынхон* гэх зэрэг олон хэлбэрийг буй болгож, тэр хэлбэр бүр нь цөм л хүн хүч хэмнэх, хүчир хөдөлмөрийг хөнгөвчлөхөд л чиглэж байснаас гадна хамтын хөдөлмөрийн баяр болдог байжээ.

Хот айл буюу *хот* нь эртний монголын *цэрэг-аж ахуйн нэгж* болж байсан *хүрээ* задарсны дүнд буй болжээ. Хот айл буюу хотыг бүтэцээр нь авч үзвэл дотор нь хэдэн янги болгож болно. Үүнд:

1. *ганцаараа хот болж явдаг аж ахуйтан.* Ийм хот нь мал сүргээ өсгөж үржүүлэх, аж ахуйгаа хөтлөх хүн бүлтэй байдаг;
2. *Малын тоогоор ойролцоо хэдэн өрхөөс бүрдсэн хот айл;*
3. *Малын тоогоор адилгүй хэдэн өрхөөс бүрдсэн хот айл*

гэж ерөнхийд нь хувааж болохоос гадна бүр нарийсгавал сүүлийн хоёр дугаарт дурдсан хот айлыг дотор нь ураг төрлийн холбоотой эсэх, мөн жилийн дөрвөн улиралд тогтмол үргэлж хамт явдаг хот айл, эс бөгөөс түр нэгдэж явдаг хот гэж дөрөв дөрөв ангилж үздэг байна. 1932 оноос дотоод гадаадын олон судлагчид, тухайлбал: Я. Цэвээл, А. Д. Симуков, С. Беленьский, Н. В. Володин, Экгауз нар монголын хот айлыг судалж нэлээн олон бүтээлээ нийтлүүлж байсан ажээ. Гэсэн ч тэдний судлагааг дээд удирдлагаас алдаатай буруутгаж «монголчуудын адгуулан өсгөж ирсэн таван хошуу мал нь гадаадын ганц нэг гахай тахиатай адилгүй байсан» гэж бичсэнийг нь өөчлөж Зөвлөлт улсыг гахай тахианаас өөр малгүй байлаа гэж муучлав хэмээн олон жилийн турш шүүмжлэлийн бай болгож байсан жишээ үзэгддэг. Тэгээд ч 1959 он гэхэд тус улсын хэмжээгээр *хот айл* гэдэг аж ахуйн нэгж байх нөхцөл бүрмөсөн үгүй болж ганц нэг төрлийн мал бүхий суурь, бригад гэх зэрэг «шинэ» хэлбэр

гэгч зүйл буй болсон боловч манай мал аж ахуйд ч гэсэн, малчин ард түмэнд ч гэсэн хот айлаас илүү өгөөж нэмэр өгч ер чадсангүйгээр үл барам мал маллагааны уламжлалт арга, түүнтэй холбогдон гарч ирдэг байсан зан үйлийн олон зүйлийг мартуулахад хүргэсэн билээ.

Дээр дурдсан судалгаанаас үзэхүл хот айл гэдэг нь хэн хүний дураар нэгдэе гээд нэг хот болж болдоггүй, цаанаа нарийн учир начиртай, бас түүний дээр газар орны байдал төлөвтэй нягт уялдсан зүйл байсан нь тодорхой харагддаг юм. Жишээ татвваас, тухай тухайн аж ахуйтны малын тоо, цаг улирал хийгээд нутгийн байдал зэрэг нь хот айл бүрдэхэд шийдвэрлэхүйц үүрэгтэй ажээ. Үүнд: мал олонтой хэд хэдэн өрх нэг хот болно гэхэд бэлчээр хүрэлцэхгүйн зовлон гарна. Зун, намрын тавиун цагт, түр нэгдэж хот болоход 3—5 өрх байж болдог ба өвөл, хаврын тарчигдуу үед арай цөөн өрх нэг хот болдог нь бэлчээрийн даац болон нутаг бэлчээр сэлгэж нүүх тоотой харилцан уялддаг байсан ажээ. Бас хангай газрын нэг хот айлын өрхийг говийнхитой харьцуулахад тоогоор арай илүү байдаг нь нутгийн онцлог, бэлчээрийн даацтай шууд холбоотой. Ерөнхийд нь дундажаар бодож үзвэл нэг хотод 2—4 аж ахуйтан нэгддэг нь орон даяар нийтлэг байсан гэж хэлэх бүрэн үндэстэй байна. Үүнр иймд *хот буюу хот айл* гэдэг нь мал бүхий айл өрх нэг заримаар буюу хэд хэдээр хамтран буудаллаж ажил төрлөө хамтран бүтээдэг аж ахуйн нэгж хэмээн тодорхойлж болмоор санагдана.

Хот айлын байдлыг гаднаас нь авч үзвэл зохион байгуулалт нь тогтмол, *хотын их гэр* нь баруун өмнөд талдаа, хот нь айл гэрийн дунд талдаа байдаг зэрэг нь эртний монголчуудын цэрэг-аж ахуйн зохион байгуулалт-*хүрээний* задралаас хот айл буй болсныг давхар гэрчилдэг. Хотын *их гэр* гэдэг бол садан төрлөөрөө нэг хот айл болсон нөхцөлд эцгийн буюу нас ахмад хүний гэр, хар элгийн айл өрх нэг хот болсон нөхцөлд аж төрөх туршилга бүхий ахмад хүний буюу илүү олон малтай өрхийн гэр байдаг байсан билээ. Хотын их гэрийн эзэн бол тухайн хот айлын бүхий л үйл ажлыг эрхилэн зохицуулдаг байлаа. *Хот айл* гэдэг бол жилийн дөрвөн улирлын туршид мал сүргээ адгуулан өсгөх зорилго бүхий хамтын ажиллагааны хэлбэр ажгуу.

Саахалт айлуудын тухайд *саах тавина* гэдэг нэг сайхан ёс байсан нь саалийн үед хүн хүч хэмнэж хамтран ажиллах ажлын нэгэн өвөрмөц хэлбэр болж байлаа. *Саах тавих* гэдэг нь саахалт хоёр хот айлынхан хонь ямаа, хурга ишгээ саалийн үед тус тусдаа хариулах аваас даруй дөрвөн хүн хэрэгтэй болохыг хэмнэж нөгөө хотынхоо хурга ишгийг хонь ямаандаа нийлүүлэн эөрүүлэн авч хариулснаар хоёр хүн л уул ажлыг гүйцэтгэнэ гэсэн үг. Тийм ч учраас *саах тавих* гэдэг нэр томьёог *саах*

харуулах ч гэж хэлдэг ёсон бий. Тэгэхээр *саах зөрүүлнэ* гэдэг хамтын ажиллагаа нь зөвхөн саалийн үед л гарч ирдэг байсан тул улирлын чанартай байжээ гэж хэлэх бүрэн үндэстэй юм.

Цагийн хатууд мал оторлоно гэдэг нь мөн хот айл, саахалт, ойрынхныхоо *эр сувай малыг* нийлүүлэн авч оторлодог байсан нь нэг талаас хүн хүч хэмнэх, нөгөө талаас *хатуу цагийн бэлчээр* хомсдол нөөн хадгалж байсан алс цармын нутаг бэлчээрээ ашиглаж байгаа хэрэг мөн буюу.

Монголын малчин ард олны хамтын ажиллагааны бас нэгэн хэлбэр нь *нэгэн голынхон* буюу *нэгэн голын айлууд* юм. Үүнд гүү барих, хонь хяргах, эсгий хийх, хурга ишиг хөнгөлөх, мал агтлах зэрэг айл хот болгонд хонины ээлж мэт зайлшгүй нүүж тохиолдох ажлыг хот, саахалт, нэг голооров хамжин хийсэвч нэгэн нь монголчуудын хувьд чухамдаа хамтын хөдөлмөрийн баяр болж байсныг дурдваас зохилтой.

Энд монгол малчдын хамтын ажлын тухайд ярихдаа ардын баяр цэнгэл болдог байсан тухай хэдэнтээ дурдсаныг уншигч анзаарсан бол лав анзаараа биз ээ. Санамсаргүй нуршсан хэрэг биш гэж хэлэх гээд байгаа юм. Энэ үеийн хамтын хөдөлмөрийн баяр нь нэгдэлжих хөдөлгөөн ялсан гэгддэг 1960 хэдэн оноос хойшхи 30 гаруй жилийн шинээр буй болсон суурь, бригадын өдөрлөг гэх зэрэг социалист гэдэг тодотгол нэр өмнөө авсан «баяр» нас хэд хэдэн зүйлээр ор тас ялгаатай байсан ажээ. Үүнд, юу юуны өмнөхи ялгаа гэвэл монгол малчдын хамтын ажиллагааны үндэс нь бусдын хэргийг бүтээвэл, өөрийн хэрэг бүтнэ» гэдэг уужим сайхан сэтгэл байсан юм. Мөн тэрхүү хамтын ажиллагаанд үндэслэсэн ардын баяр цэнгэл маань олон зууны туршид бүрэлдэн буй болсон, бүх нийтээрээ дагаж зөвшөөрөн хүндэтгэдэг *«уламжлалт зан үйл-хөдөлмөр»* гэсэн салгахын аргагүй нэгдмэл *цогц* зүйл байсныг анхаарахгүй байх буюу мартахын арга огт байхгүй гэж бодогддог. Тийм ч учраас хот айлаараа, айл саахалтаараа, нэг голооров хийж байгаа хамтын хөдөлмөрийн баяр цэнгэл нь зөвхөн нэг «баяр» гэдэг өнөөгийн ойлголттой адилгүй, харин эдийн засагчдын хэлдэгчлэн «материал баялаг» гэдэг зүйлийг буй болгож, малчин түмэн маань хонины ээлж шиг, хэн хэндээ ашиг үлдэцтэйгээр харилцан туслалж идэж уух, эдлэх хэрэглэх зүйлээ улам арвижуулах тул чадлий хувьд ийм хамтын хөдөлмөр нь ч баяр, амралт чөлөө нь ч баяр байдаг байжээ. Түүний хажуугаар тэр давхар баяр нь аж төрөх зайлшгүй шаардлагаас үүдэн гарах тул яв явсаар наргийн журам, уламжлалт дэг ёстой болж тэрхүү зан үйл нь малчин хүн бүрийн саная сэтгэлд нийцсэн баяр цэнгэл болсоор олон он жилийн нүүрийг үзжээ. Үүнийг сүүлийн үеийн янз бүрийн «шинэ» зохиомол «баяр»-тай харьцуулан бодвол сонин зүйл санаанд ордог. Чухамдаа сүүлийн үед малчин ардуудын хамтын ажиллагаанаас үүдсэн баяр цэнгэлийн зүйл чухамдаа

үгүй болжээ. Үүнтэй уялдаад тухай тухайн зан үйл, уламжлал ч мартагдахад хүрчээ. Ганц жишээ дурдахад эсгий хийнэ гэдэг сайхан зүйл үгүй болсноор ноос савах ажил, ноос савж байгаа айл дээр очсод хэлдэг ерөөл, түүний хариу үг, эсгий хийх ёс заншил, холбогдох зан үйл, эсгийн ерөөл зэрэг зүйл цөм шаардалгагүй болж улмаар мартагдсаар нэг үеийг өнгөрчээ.

Сүүлийн үед гарч ирсэн зарим зохиомол баяр нь малчин ард олны амин хувьд ашиг нялзуур багатай хөдөлмөрөөс ганц ч өдөр болов холдохын мөн болсон, түрүүн буй болгосон «материал баялаг»-аа, бүтээлцээгүй бусад хүмүүстэй хамжин хомстогох, үндэсний үзэл гаруузай гэж ардын уламжлал, зан үйлийг мартагнуулахад чиглүүлж дарга даамал нарын сэтгэл сананд нийцүүлэн дэглэсэн «баяр» болж хувирсныг тэмдэглэлгүй орхиход сэтгэл түвдэхгүй байна.

Энэ бүхнээс үзэхүл аливаа ард түмний өвөрмөц уламжлал, зан заншил нь эрхэлдэг аж ахуй, тэрхүү аж ахуйгаа хөтлөх арга хэлбэр зэрэгтэй шүтэн барилдсан байдаг ажээ. Хэрэвзээ эрхлэдэг аж ахуй, түүнийг хөтөлдөг арга хэлбэрийг (ялангуяа огцом) өөрчлөхөд тухайн ард түмний аж төрөх уламжлалт ухаан, зан заншил арга буюу мартагдаж улмаар хүн ардын сананаа сэтгэлд ч үндэсний ухамсар бөхөн бүдгэрч ирдэгийг бидний монголчуудын туршилга бэлхэнээ харуулж өглөө.

Монголчуудын мал маллагааны арга барилын талаар ярихад нүүдлийн тухай товч боловч дурдалгүй орхивол зохисгүй хэрэг болно заа. Жилийн дөрвөн улирлын туршид, өвсний сортог, усны тунгалгыг хөөж таван хошуу малаа адгуулан өсгөх нь нүүдэл хийж аж төрөх хэлбэрийг шаардан нөхцөлдүүлжээ. Гэвч зарим нэг хүний үзэж тэмдэглэснээр нүүж аж төрөх нь цаанаа нарийн учир шалтгаангүй шахам, нүүхийн дон шүгэлсэн зүйл биш байсныг хэлэх хэрэгтэй юм. Үүнд: хангай говийн ялгаа, цаг улирал, нутаг бэлчээрийн хүрэлцээ, малын тоо толгой, ус ундны байдал, хүн малын өвчин зовлон, хужир давсны шаардлага гэх зэрэг өдий тодий хүчин зүйлтэй уялдаж нүүдлийн тоо олон цөөн байдаг билээ. Үүний зэргэцээ нүүдлийн хол ойр нь ямар байдаг вэ? гэдэг асуулт ч гарна. Малын тоо толгой, мөн сүргийн дотор ямар мал зонхилж байгаа хийгээд цаг агаар, улирлын байдал, хангайд уу, говьд уу гэх зэргээс нүүдлийн хол ойр нь шалтгаалдаг байлаа. Монголчуудын нүүх ёсыг судалсан дотоод гадаадын эрдэмтдийн бүтээл 1930-аад оноос 1940-өөд оны эх хүртэл тийм ч цөөнгүй гарсан гэдгийг дурдах нь зүйн доторхи хэрэг гэж үзэж байна. Судалгааны дүн хийгээд цуглуулсан хэрэглэгдэхүүн зэргээс үзвэл дундажаар, хангай газар 10 орчим, говь нутагт 10—14 удаа нүүдэллэдэг байна.

Дээр дурдсан зүйлийг нэгэн цогц болгон авч үзвээс монголчуудын мал маллагааны уламжлалт арга барил нь олон зууны өмнөөс монголчуудын нүүдлээр аж төрөх өвөрмөц ухааны

үндэс суурийт бүрэлдүүлснээс гадна дэлхийн олон улс үндэстний аж ахуйн түүхэнд нэмэр хандив болсон зүйл юм гэж тэмдэглэхэд одоо эргэлзэх хүнгүй байх гэж найднам. Харин бид өөрсөнөө аж төрөх энэ өвөрмөц зүйлээ огоот хэрэггүй гэж хоцрогдсонд тооцсоор, судлан сонирхолгүй өдгөөд хүрсэн нь даан ч харамсалтайяа!

ЛАВШРУУЛАН ҮЗҮҮШТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Цэбель Я, **Кочевки**, -СМ, УБ, 1933, № 1, стр. 27—31.

Симуков А, **Хотоны**, -СМ, УБ, 1933, № 3, стр. 19—32.

Трофимов Т, **Хангайские кочевья**, -СМ, УБ, 1934, № 1 (4), стр. 36—53.

Трофимов Т, **Кочевые скотоводские хозяйства**, -СМ, УБ, 1934, № 2.

Азаров С, **Кочевое животноводство гобийских аймаков МНР**, -СМ, УБ, 1934, №2, стр. 54—69.

Беленьский С, **К вопросу о хотонах**, -СМ, УБ, 1934, № 2, стр. 114—117.

Хэбэй вангийн аж төрөхийг заасан сургаал болай, -СМ. УБ, 1935, № 6 (13).

Симуков А, **Материалы по кочевому быту населения МНР**, -СМ, УБ, 1935, № 6 (13), 1936, № 2.

Тубянский М, **К вопросу о пастбищном зимовании скота в МНР**, -СМ УБ, 1936, № 4—5, стр. 151—169.

Володин Н. В, **К вопросу о хотонах**, -СМ, УБ, 1938, № 2, стр. 76—90.

Экгауз, **К вопросу о хотонах**, -СМ, УБ, 1939, № 1—2, стр. 119—121. 121.

Нацагдорж Ш, **То ван түүний сургаал**, -SH, Tom. V, Fasc. 2, UB, 1968.

Шагдарсүрэн О, **Байгалийн шалгарал ба билчээрийн мал аж ахуй**, УБ, 1969.

Төмөртогоо Д, **Нүүдэлч бөлгийн тухай**, -SH, Tom. X, Fasc. 17, UB, 1975, 69—82.

Chagdarsürüng Ts, **A propos de l'élevage des cinq espéses de bétail chez** les Mongols, -SM, Tom. V (13), Fasc. 16, 1977, pp. 144—167.

МОНГОЛЧУУДЫН МАЛ СҮРГЭЭ СОНГОН ҮРЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГ

БНМАУ-ын гурван боть түүхэнд тэмдэглэснээр 300 мянган жилийн өмнөөс монголчуудын энэ нутагт хүн нутагшиж болсон хэмээж байгаа боловч сүүлийн үеийн эртний судлалын олдворыг үндэслэж 500 мянган жилийн өмнө хүн аж төрдөг байжээ гэж хэлэх эрхтэй болж байна. Монгол нутгаас олдсон хадны сүг зургийн дотор мал аж ахуйг эрхлэх болсныг баталсан морьтой хүн, морин тэрэг, сүйхийн зураг цөөн бус тохиолдогийг мэргэжлийн эрдэмтэд судлаад наанадаж лавтайяа хүрлийн үед холбогдоно гэж үзжээ.

Ийнхүү монгол газар эрт цагаас буй болж улмаар монголчуудын гол амьжиргаа болсон мал аж ахуйг хөтлөх арга боловсрон боловсорсоор бидний үед хүрч ирсэн бөгөөд ийнхүү боловсроход эзэн хүний ухаалаг үйл ажиллагаа юу юунаас илүү чухаг үүрэгтэй байсан гэхэд эргэлзэх хүн хараахан гарахгүй буй заа гэж найднам.

Монголчууд мал сүргээ сонгон үржүүлэхдээ юуны өмнө *хээлтүүлэгч* буюу *эцэг малд* илүүтэй анхаарч, дараа нь *эх малын* тухайд өнгө зүсмийг айхавтар бодолцдог байсан нь ажиглагдана. Эх малын үр төл, сүү шим нь ч бас өнгө зүстэй нь холбоотой байсан болоолтой гэдэг итгэлийг үнэмшилтэйеэ төрүүлж байгааг тэмдэглэсэу. Энэ талаар доор товчхон ярья.

Монгол малчид «эцэг буюу хээлтүүлэгч мал бол бүх сүргийн тэн хагас хувь нь» хэмээж хэлэлцдэг нь нарийн учиртай бөгөөд аливаа хээлтүүлэгч малыг сонгодог нийтлэг хэмжүүр монголчуудын дунд уламжлагдан иржээ. Гэвч энэ нь газар газрын онцлог байсан гэдгийг үгүйсгэх баталгаа болж чадахгүй болгоо. Монгол малчин хүн аж ахуйдралынхаа шаардлага, нөхцөлийн улмаас хамгийн ашигтай гэсэн мал, тухайн малын доторхи чиглэлийг тулхүү анхаарч иржээ. Тухайлбал: морь гэхэд л дотроо *хөлөг морь*, *хурдан морь*, жороо, сайвар, арилжаа гэх зэрэг *явдалтай морь*, *хонины морь* гэх зэрэг ялгавартай бөгөөд тэд нь гадна шинж байдлаараа ч, хүч тэнхээгээрээ ч, ааш аранжингаараа ч өвөр зуураа ялгаатай байсан ажээ. Ухаан нь, *хөлөг морь* гэхэд л тэнхээ хурд тэгш, ааш аранжин нь эрмэг омголон боловч эзнийхээ л гарын аяар байж сэтгэл зори-

гий нь мэддэг, өвч хуягласан баатар идэрхэг эзнээ унуулж амь нас дүйсэн аюул бартаа бүхий урт замыг туулж чаддаг, гол төлөө цэрэг дайны үед хэрэглэгддэг морь байсан билээ. Энэ ташрамд нэгэн зүйлийг онцлон эс дурдваас сэтгэл үл төвдмүй. Үүнд: долхий дахины болон дундад зууны үеийн монгол цэргийн түүх хийгээд дайтах ухааны түүхийг тусгайлан судалдаг олон түүхчид XIII зууны монголын цэргийг тухайн цагтаа имагт *орчин үеийн цэрэг* байсан юм гэж санал нэгтэй дүгнээд монголчуудын цэргээ зохион байгуулсан өвөрмөц арга, монголын цэргийн сахилга бат, тэсвэр хатуужил, монгол жанжидын цэргэлэх эрдмийн нд хавыг үзүүлсэн дайтах ухаан, монголын цэрэг эрсийн хэрэглэж ирсэн зэвсгийн зүйлийг нарийвчлан судалсан нь долхийн том том дайны туршид өрсөлдөгч хоёр этгээдийн олон жанжины анхаарлыг татаж, цэрэг удирдах арга ухаан, жанжины нь эрдэм овсгоог нэмж өгдөг байсан гэж тэмдэглэсэн нэм зохиол тийм ч цөөнгүй бий. Жишээ дурдсу. Цэргийн түүхийн мэргэжилтэн Ж. Чембэрс 1979 онд хэвлүүлсэн, өөрөө дахинд хийсэн монголын байлдан дагуулалын тухай номдоо Чингис хааны цэргийн «галын хүч», «хөдөлгөөн» гэдэг хоёр гол зүйл нь цэрэг дайны түүхэнд хамгийн түрүүнд нөлөөлж өөдөлгөөн дундхи галын хүч» гэдэг ойлголтыг бүрдүүлсэн тухай, Наполеон болон Гюстав Адольф нар монголчуудын цэрэглэн уханыг судалж байсан тухай, XX зууны эхээр оросын монгол цэргийн дарга нар тийм цэрэглэх аргыг хэрэглэдэг байсан тухай, мөн дэлхийн хоёрдугаар дайны үеэр механикжсан хүчээ бодлоготон гэж нэрд гарч байсан жанжин Роммел, Паттон хоёр Сувэздэй жанжины дайтах арга эрдмийг судлаад Америкийнгтай нарийний нь хүлээн зөвшөөрч байсан тухай тоорхой бичсэн бөлгөө. Англиин цэргийн түүхч, зохиолч Базил Лидделл Харт (1895—1970) бичихдээ монголын морин цэргийн зүй ёсны удам хойч нь танк, онгоц болж байгаа юм хэмээжүхүй.

Энэ бүхнээс үүдэж нэг санааг нэмэрлэмээр санагддаг. Аль ч цэрэг дайны явдалд, орчин цагийн нэр томьёогоор хэлбэл «ургэн байрлах чадвар» онцгой үүрэгтэй байдаг бөгөөд XIII зуны үед морь, ялангуяа монгол морь эл шаардалгад онцгой тохирч байжээ. Үүний учир гэвэл монгол морь нь суурин газрын жүчээний мориноос их л ялгаатай, харахад бие нь жижиг хэвтэр боловч шандас шөрмөс сайтай, жилийн дөрвөн улирлын турш ял тэжээлээ өөрөө олж идэж чаддаг, өвөл цас зудтай үед ч тустай овьёос тэжээл шаардалгүй цас цавчиж идээшилдэг, вас цол, уул хад, гол усанд жигд сайн, авад эцдэггүй, өдөр бүтэн шөнө нь идээшлээд хүч тэнхээгээ сэлбээд авдаг самар амьтан билээ. Тэгээд ч монголын цэрэг эр бүр дайн тулаанд ганц хоёрхон хөлөг морьтой яав ч явдаггүй байсан нь

лавтай болой. Учир явдал ийм болохоор монгол цэрэг бүр морьтой, морь нь дээр дурдсан онцгой шинжтэй байсан болохоор цаг зав хожиж алс хол гэвч хүрэх гэсэн газраа харьцангуй үтэр очих боломжоо нэхцөлтэй байсан бөлгөө. Иймд хөлөг морь бол монголын цэргийн түүхэнд монгол цэрэг эрийн хатуужил сахилга, цэрэг дайны зохион байгуулалт, мөн нум сум, илд жад зэргээс гадна тусгай галт болон оньсон зэвсэгийн нэг адил онцгой үүрэгтэй, «түргэн байрлах» нэхцөлийг ханган байсан ажээ. Энгийн айван тайван цагт хөлөг морийг алсын аян зам, ан авд гол төлөв унамуй.

Хөлөг морьтой холбож цэрэг дайны асуудал руу хэлбийн орсноо орхиж энэ хэсэгт ярих ёстой үндсэн сэдэв рүүгээ орсу. Хурдан морь бол эрт цагаас одоо хүртэл монгол хүний дур хайрыг татдаг морь байсаар ирсэн бөгөөд монгол ардын үлгэр туульд ч цаг хугацаа, орон зайг хураан товчлохын бэлгэдэл болсоор ирсэн билээ л. Ахуй амьдралдаа монголчууд хурдан морийг шинжин шинжсээр чухамхүү ямар шинжтэй бол хурдан байдаг, хурд нь удам дамждаг зэргийг нарийн мэддэг болоод зогсохгүй тэрхүү нийтлэг шинж байдлыг судар номчлон тэмдэглэж ye дамжин хөтлөж арвижуулан баяжуулсаар байсан нь одоо бидний үед уламжлан иржээ. Тийм судраас нэлээд хэдийг эмхлэж эрдэмтэн Х. Лувсанбалдан нийтлүүлсэн бөгөөд уул ном одоо хэдэнтээ хэвлэгдээд байна.

Монгол хүний хувьд унаа хөлгийг нь барихад ямагт тусалдаг *уургын морь* бол адууны захтай айл бүрт заавал байдаг, байхгүй бол зайлшгүй үгүйлэгддэг морь болой.

Хонины морь гэдэг бол гэр бэлчээрийн хооронд өдөр тутмын ажлыг нугалж өтгөс хөгшдийн унаа болдогоос гадна хүүхэд багачуудыг морь унахад сургадаг номхон таатай морь байсан асан.

Явдалтай морь нь зөвхөн унаж явахад л чамин тохиромжтой байдаг амуй. Явдалтай морь нь дотроо жороо, арилжаа, хатир гэх зэрэг ялгаатайгаас гадна жороо гэхэд л унаган жороо, усан тэлмэн жороо, удган жороо, хатир гэхэд л гурван хөлний хатир буюу удган хатир, задгай хатир гэж ялгарах жишээтэй. Морины явдал нь гол төлөв унаган буюу төрөлхийн байдагаас гадна сүүлд сургасан явдалтай морь ч байдаг. Хэдийгээр явдалтай морь ховордуу, үнэ ханш ихтэй байдаг боловч тухайн нэг айлын адуунд жороо явдалтай морь олширвол тэдий л сайн гэж үздэггүй нэгэн сонин уламжлал байдагийг хэлэхэд илүүдэх нь юун.

Энэ мэтчилэнгээр эрт цагаас монголчууд таван хошуу малаа өөр өөрийнхөө санаа сэтгэлд нийцүүлэн сонгож үржүүлэхдээ унага, тугал, ботго, хурга, ишиг байхаас нь ажиглан шинжиж биеийн галбир дүрс, өнгө зүсэм, дэл сүүл, үс ноос, ааш араншин, арьс зэрэг олон зүйлийн шинж байдлыг онцгой анхаарч

азарга, бух, буур, хуц, ухна тавьдаг ёсон нийтлэг уламжлал болсон юм.

Хурдан морь бодон эцэг малын шинжээс олон нутагт нийтлэг байдаг зүйлийг нь товч тодий тоочсугай.

Хурдан морь: бие том, дөрвөн мөч нарийн, сэрвээ өндөр. хүзүү урт, нүд том бөгөд хүрэндүү, толгой багавтар, хоншоор шөвгөр, чих хурц бөгөөд урт, туурай цомбон бөгөөд гялалзсан хар, хавирганы матаас уужим, гол хавирга бүдүүн, сүвээний хавирга ташаандаа ойр, дэл сүүл шингэвтэр бөгөөд ширхэг нь нарийн урт, сүүлний хялгасын үзүүр салаалсан, хамрын нүх уужим, шүд цагаан бөгөөд бахим зузаан, шүдний цөгц гүнзгий, өвчүү гадагш овгор, сүвэргэдэс сайтай, уулзвар яс овгор, сүүлний угийн яс бүдүүн, сугандаа эргүүлгэтэй, гурван овоо, хүзүүний зураас тод, ташаа сайтай, салтаа уужим, бэрэвхий босоо, борви шулуун, эмгэн туруу дөрөвтэй, арьс нимгэн бөгөөд сул уужим, цавь суганы арьс элбэг, үс нимгэн тачир, умдаг бага, хошного цаана...

Азаргын шинж: бие бялдар том, дэл сүүл өтгөн, үс нягт, туруу цомбон, толгой том, хамар монхор, холбоо чихтэй, дух магнай тэнэгэр, хөх мах сайтай, дал мөр их, цээж өргөн, өвчүү урагшаа овгор, хавирга нь дүгрэг бөгөөд их, мах сайтай, бөгс цээж тэнцүүхэн, ташаа өргөн, салтаа уужим, босоо сагартай, засаа тэгш, сэлдий том, шөрмөс бүдүүн, хамрын нүх уужим, нуруугаараа бөгтөргөтэй, мундаа өндөр, булчин чанга, ахар сүүл урт, шүдний цөгц гүнзгий, борви тэнүүн, алхаа тэгш бөгөөд сариугүй, хошного цаана, бэлчээрт их төлөв адууны сүүлд явдаг...

Буурын шинж: бие том, толгой мөн том, магнай өндөр, нүд бүлтгэр бөгөөд том, харц зөөлөн, хоншоор хамар монхор, шүд сайн, бөх ширээ бөгөөд бөөрөнхий, нүүдэл аажим, цээж өргөн бөгөөд зузаан, ахар сүүл урт, хондлой яс урт, гуя том, түнх зэрцэгээр өргөн, цээждүү гэдэстэй, өвдөг зогдор ихтэй, урт өтгөн ноолууртай, нимгэн цомбогор тавагтай, алтан хумс нь урт бөгөөд их, хар ул зузаан, шилбэ богино бөгөөд бүдүүн, хомбогор урт хумстай, борви тэнүүн, засаа ил бөгөөд том, дуу хатан, зан аяа номхон...

Бухын шинж: бие бялдар том бөгөөд махлаг, толгой багавтар, хушуу шөвгөр, хүзүү бүдүүн, өргөн духтай, сэрвээ өндөр, ууц нуруугаараа хотгор гүдгэргүй тэгш бөгөөд уртлиг, цээж зузаан өргөн, гэдэс хэвэли ихтэй, бэлхүүс бүдүүн, хөл богино бөгөөд бахим, бөгс ба гуяараа бөөрөнхийдүү, зангирсан булчинтай, урд хөл эгц, хойд борви уужим, тахимаараа ойр бус, туруундаа улаан судалтай, үс сахлаг бөгөөд урт, эвэр нь холбоо бөгөөд бахим, дуу шингэн, төмс нь татуу, нүдний харц зөөлөн, биеийн байдал тэнцүүхэн, толгой дээр, гүймхий авьяастай...

Хуцын шинж: бие том, толгой бага шиг, хамар монхор, хүзүү богино бөгөөд бахим, цээж өргөн, дөрвөн хөл тэгш бөгөөд чанга, борви тэнүүн, бөгсөн бие зузаан бөгөөд тэгш, сүүл том бөгөөд дүгрэг, шүд нь бөх, арьс зөөлөн бөгөөд элбэг, үс ноос нь сахлаг урт бөгөөд нарийн, цээж бөгс тэнцүүхэн, харахад байдал нь аятайхан...

Ухны шинж: бие том бөгөөд тарган, хүзүү бахим бөгөөд тийм ч уртгүй, шүд бөх, сэрвээ өндөрдүү, цээж бөгс тэнцүүхэн бөгөөд өргөн, арьс зөөлөн, үс ноолуур сахлаг, махлаг...

Монголчуудын дунд «эх нь хээр алаг бол унага нь шийр алаг» гэх буюу «угт хүний үр, сүүт гүүний унага» гэж зүйрлэн ярилцдаг нь мал маллагааны арта барилд эхийн сайн муу шинж төлд нь уламжлан удам дагадагийг мэдэж мал сүргээ өсгөхдөө сүргийн бүтэцийг ямагт шилдэг сайн малаар бүрдүүлэхэд байгалийн шалгарлын хажуугаар малчин хүний жил бүр тогтмол хийдэг ухамсарт шалгаруулал онцгой үүрэгтэй байсныг гэрчлэж байгаа хэрэг буюу.

Монголчууд мал сүргээ адгуулан өсгөж үржүүлэхдээ малынхаа өнгө зүсэм бүрийг голчилдоггүй, мал малдаа зохистой гэсэн зүсмийг эрхэмлэн анхаардаг байсан нь нэг талаас биологийн шаардалга, нөгөө талаас монгол хүний гоозуйн таашаалтай нийцдэг байснаас гадна мал малын тухайд зарим өнгө зүс нь сүү шим, үр төл, тэсвэр хатуужилд нь сөрөг нөлөөтэй болохыг амьдрал туршилгаараа сайтар мэдсээр ирсэний нутлагаа ажгуу. Монгол ардын үгэнд «өсөх малын зүс нэг» гэдэг бөгөөд үүнээс үндэслэж «малын зүс нийлүүлэх» гэдэг тусгай ухамсарт үйл ажиллагаа байж, түүнийг сонгон үржүүлэхэд чухалчлан анхаардаг байдал бэлхэнээ харагддаг. Үүний дүнд ч зуны аагим халуун, ган гачиг, өвлийн тасхийм хүйтэн, цас зудыг давах, өвчин эмгэг даах, эрүүл чийрэг үр төл, шимт сайхан сүүтэй байх эсэх нь тухайн малын өнгө зүсэмтэй зохих ёсоор холбоотой байдагийг малчид амьдралаараа ажин мэдэж, мэдсэнээ туршин нарийсгасаар нэгэн цогц боловсронгуй мэдлэгийн санг буй болгожээ. Энэ уламжлал нь яв явсаар зөвхөн аж амьдралын хүрээнд төдийгүй ардын билигийн зүйлд, ялангуяа ерөөл, тууль, үлгэрийн дотор өргөн туссан байдаг билээ. Тухайлбал: монгол ардын баатарлагийн туульд сайн талын баатарын мал сүргийн тухайд, нарийн хар хээр азаргатай, ялан улаан үхэртэй, манхан хүрэн тэмээтэй, хөвөн цагаан хоньтой, өлөнгөр хөх ямаатай гэж байхад муу талын баатарын малын зүс нь гэхэд бар цоохор морь, үнэсэн хөх бух, хар бараан мал гэх зэргээр дүрслэн хэлсэн байдагийг «Эзэн улаан Бодон», «Эрийн сайн Ринчен мэргэн» зэрэг олон туулиас үзэж болно. Иймхүү малын өнгө зүсмийн талаар тууль, үлгэрт дурдсан зүйл нь монгол малчдаас мал сүргээ сонгон үржүүлэхдээ өнгө зүсмийн талаар үнэлэн үздэг уламжлалтай таардаг нь ерийн нэгэн тохиолдолын хэрэг яав ч биш ээ.

Монголчуудын хувьд мал аж ахуйтай холбоотой бараг бүх зан үйл нь нарийн дэг журам бүхий ардын баяр болдог байсан тухай түрүүн цухасхан дурдсан билээ. Үүнчилэн аливаа хээлтүүлэгчийг төл байхаас нь ажин шинжиж эцэг малд байвал зохих бүх онцлог цогцлон бүрдсэн төлийг танин сонгож хайрлан өсгөсөөр нас бие гүйцмэгц нь хээлтүүлэгч болгон тавихдаа бас нэгэн тусгай ёслол үйлддэг байжээ. Жишээлбэл, Барга мон-

голчууд хуц ухна эхлэн тавихдаа эхлээд нэгэн хэсэг тусад нь сойж байгаад товлосон өдөр болмогц саахалт голоороо цуглан цай идээ болж баярлалдан хөөрөлдөж бяцхан хүү охин хоёрыг зэргэцүүлэн мордуулаад тавихдаа үр тарианы зүйлийг гэдэс хэвэл доогуур нь цацаж «арвай шиг арвиж, үрэл шиг үрж!» гэж бэлгэдлийн сайхан үг хэлэхэд хүү нь буруу тал руу, охин нь зөв тийшээ аяархан унаж, хуц ухна нь ч сүрэгтээ очиж нийлдэг байсан ажээ. Энэ бүхэн бол арвай будаа лугаа адил эр охин олон төлтэй болохыг бэлгэдсэн ардын зан үйл ажгуу.

Ийнхүү таван хошуу малыг сонгож үржүүлэхтэй холбогдсон монгол ардын уламжлалт мэдлэг, түүнд үндэслэж гүйцэтгэсэн үйл ажиллагааны дүнд эрт дээр цагаас энэ орон нутаг, цаг уиралдаа бүрнээ зохицсон, тэсвэр хатуужилтай, нүүдэл амьдралын шаардалгад тэнцсэн монгол малын үүлдэр угсаа буй болсон ажээ.

ЛАВШРУУЛАН ҮЗҮҮШТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Цэвэл Я, **Малчны календари,** 1945 он, УБ, (монгол бичгээр).

Ринченсамбуу Г, **Монгол ардын баатарлагийн туульс,** УБ, 1960.

Халх ардын туульс, УБ, 1967.

Humphrey C, **A note on the Judgement of Race-Horse by Mongolian Nomads,** -SI, The Mongolian State University Press, UB, 1972, pp. 30—36.

Shagdarsürüng Ts, **Choix du bélier ou bouc chez les Barga-Mongols,** -EM, Cahier 4, Paris, 1973, pp. 141—145.

Chagdarsürüng Ts, **A propos de l'élevage des cinq espéces de bétail chez les Mongols,** -SM, Tom. V (13), Fasc. 16, UB, 1977, pp. 144—167; Production pastorale et Societe, № 5, Paris, 1979, pp. 19—24.

Chambers J, **Les cavalier du diable,** l'invasion mongole en Europe, Paris, 1988.

Лувсанбалдан Х, **Хүлгийн шинж,** УБ, 1989.

ТАВАН ХОШУУ МАЛЫН ААШ АРАНШИН, СЭТГЭЛЗҮЙТЭЙ ХОЛБООТОЙ МОНГОЛЧУУДЫН МЭДЛЭГЭЭС

Таван хошуу мал сүргээ адгуулан маллаж өнө удаан жил аж төрөх явцад монголчууд малынхаа ааш араншин, сэтгэлзүйг аажим аажмаар танин мэдсээр яваандаа нэгэн бүхэл бүтэн цогц мэдлэгийг хуримтлуулан бүрдүүлж, түүнийгээ зөвхөн танин мэдэхийн хүрээгээр хязгаарласангүй, мал аж ахуйг эрхлэн хөтлөх ухамсарт үйл ажиллагаандаа хэрэглэж малынхаа ухаан араншинг хөтлөн жолоодох шатанд хэдийнээ хүргэжээ.

Малын ухаан гэдгийг хэдийгээр хүнийхтэй зүйрлэхийн аргагүй боловч монгол хүлэг морь эзнээ хээр орхиж явгалдаггүй, уралдааны үед ямар ч зайгүй байлаа гэхэд унаж ойчсон хүүхэд дээр хэзээ ч гишгэдэггүй, монгол мал төрсөн хот хороо, ижил сүрэг, ус нутагаа санахын эрхээр хаа холоос ч хамаагүй гүйж ирдэг монгол ардын дуу хуурыг сонсоод уяран хайлж нулимс бөмбөрүүлэн уйлж элдэв атраг сэтгэл нь зөөлөрдөг, эмнэг догшин мал хайртай эзнийхээ дууг сонсож барааг хармагц номхрон гарынх нь аяар болдог тул монголчууд мал сүргээ ухаантай амьтан гэж ямагт хайрласаар ирсэн нь тийм ч учиргүй зүйл биш ээ. Өрнө дахины судалгааны ном зохиолд амьтны ухаан, психологи гэдэг нэр томьёог цөөнгүй хэрэглэсээр ирсэн бөгөөд одооноос бид нар тэр тухай ярьж, хэлэх бололцоотой болж байна. Энэхүү ойлголтыг монголчуудын ухаантай адгуус гэдэг үгтэй уттын хувьд дүйлгэж болмоор шиг санагддаг. Тэгээд ч манайхан өтүл бэртэгчин тэнэг хүнийг «малаас дор», «амьтны адаг, адгуусны жигшүүртэн» гэдэг байсан нь зүгээр нэг тохиолдлын хэрэг биш байжээ.

Энэ удаа бид дуу хуурын эгшиг ая дан хийгээд бас бусад аргаар таван хошуу малынхаа ааш араншинг хэрхэн эерүүлэн засдаг байсан талаар товч ярия гэж бодлоо.

Монголчууд хурдан мориныхоо сэтгэлий нь хөөрүүлж хөлий нь хөнгөрүүлэх, мөн төлөө голсон эх малд төлий нь хөхүүлэх, өнчин төлийг өөр эхэд авуулах зэрэгт дуу хуурыг голчлон хэрэглэж заншсан билээ л.

Хурдан моринд тухайд унаж яваа хүүхэд нь «Ай хөө», «Зээ хөөгийн гоо», «гийн гоо», «ум марзай» зэрэг тусгай аялгууг цээл нарийн хоолойгоор аялах нь хурдан моринд ааш араншинг эрмэгшүүлж хөлий нь хөнгөрүүлж өгдөг нөлөөтэй байсныг хэн бүхэн мэднэ заа.

Голдуу анх төллөж байгаа бага мал төлөө голж хажиглан хөхүүлэхгүй байх нь элбэг тохиолддог. Бас өнчин нялх төлийг харангадуузай хэмээж өөр эхэд хөхүүлэх, төл нь үхсэн эх малд өөр төл авахуулах зэрэг шаардалга мал маллагааны явцад аль олон гардаг билээ. Энэ шаардалга ч хэрхэн шийдвээс зохих зан үйл, түүндээ хэрэг болох ардын билигийн тусгай төрөл зүйлийг буй болгох нөхцлийг бүрдүүлж өгчээ.

Гологдсон буюу өнчин төл авахуулах зан үйл нийт монголчуудын дунд ерөнхийдөө нийтлэг байдалтай боловч монгол орон өргөн уудам болохоор нутаг нутгийн онцлог наад зах нь ая дан дээр ч байдагийг судлагчид тэмдэглэсэн нь бий.

Төл авахуулахад хэрэглэдэг дуу хөгжмийн зүйлийг дотор нь дан хөгжмийн зүйл, дан дууны зүйл, хоршмол зүйл гэж хуваж болмоор санагддаг. Хөгжмийн түхайд тэр бүр хөгжмийг хэрэглэдэггүй бөгөөд морин хуур, лимбэ, цоорыг эрхэмлэмүй. Дуу гэхэд тухайн эх малыг учирласан, гуйсан, айлгасан утга бүхий тусгай дуу байхаас гадна уртын дууг дуулахаас биш богино буюу шалиг завхай дууг дуулах ёсон гэж байгаагүй ажгуу.

Төл авахуулахад таван хошуу мал болгоны онцлогт нь тохирсон дуу дуулж хуурдана. Хонийг их төлөв тойгоо тойгоо гэж тойглохоос гадна зарим нутагт түшээ түшээ гэж түшиглэдэг, бас зарим газар тээгээ тээгээ хэмээн тээглэдэг нь буй. Ямааны тухайд голдуу чээгээ чээгээ гэж чээглэнэ. Барга монголчууд шүүгээ шүүгээ хэмээн шүүглэдэг ёсон бас бий. Хонь ямааны хувьд дээр дурдсан ая дуундаа тохирсон тусгай шүлгийн зүйлийг аялгуулан хослуулах явдал их өргөн байдаг. Үүний жишээ болгож энэ хэсгийн хавсралтад 1963 онд Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын малчин эмэгтэй, чивчин барга Нансалмаагаас тэмдэглэж авсан хоёр хэрэглэгдэхүүнийг оруулав. Гүүг ихэнхи газар гурийлна. Үнээн дээр халхад өөвлөнө; барга монголд өөг өөг хэмээж өөглөдөг явдал буй. Ингэний хувьд дуур дуур гэхээс гадна зарим нутагт хөөсөө хөөсөө гэж хөөслөж болго авахуулдаг билээ. Үүний хажуугаар гүүний хувьд морины тухай уртын сайхан дууг хуурдаж дуулах, ингэний хувьд «Өнчин цагаан ботго» хэмээх гунигт дууг хуурдан дуулах буюу салхин хуурыг хэрэглэх зэрэгт эхийн сэтгэл нэн уярч хоёр нүднээсээ нулимс мэлмэрүүлэн байж голсон төлөө авдаг явдал газар сайгүй байсан билээ. Энэ тухай судлагч Ж. Бадраа авгай «Ингэн эгшиг» хэмээх сайхан кино найруулан хийж олон улсын кино наадамд тэргүүн байрын шагнал хүртсэнийг үзсэн хүмүүс яав ч мартаагүй байх.

Бараг монгол малчин хүн бүр дуулж хуурдан гологдсон төлий нь эхэд нь авуулдаг байсан боловч ийм ажилд нарийн мэргэшсэн хүмүүс бусдаасаа ялгаран гарч, тэднийг нутаг орныхон нь урин залж гологдсон буюу өнчин төл авахуулах заншил, ёслол цөөн бус гүйцэтгэдэг байсныг хэлэх хэрэгтэй. Тийнхүү

мэргэшсэн хүмүүс ямар ч адармаатай малын аяыг олж аргандаа оруулах идтэй, эрдэмтэй байсан тухай үлгэр домог мэт сонин яриа хөөрөө малчдын дунд байдаг нь цөөнгүй билээ.

Монгол малчин ардын энэхүү сонин мэдлэг, зан үйлийг дотоод гадаадын олон эрдэмтэн судалсаар иржээ. Хөгжимсудлалын талаас нэлээд нарийн судалсан хүн бол монголч Б. Смирнов бөгөөд тэрээр ийм дуу хуур, хөгжим нь монголчуудын хувьд аязүйн талаар өндөр төвшинд хүрсний илрэл даруй мөн гэж дүгнэсэн байдаг билээ. Ардын билигзүйн үүднээс Ч. Содном, америкийн нэрт монголч эрдэмтэн Хенри Серроис нар ултай нь аргагүй судалж тусгай өгүүлэл бичсэн байдаг.

Дээр өгүүлснээс гадна гологдсон буюу өнчин төлийг өөр аргаар, тухайлбал: аливаа эх амьтанд байдаг, үр төлөө хайрладаг төрөлхийн зөн билгий нь сэдээх аргаар голсон эхэд нь буюу өөр эхэд авуулдаг явдал байсныг дурдалгүй орхиж хэрхэвч болохгүй буй заа. Үүнд: голсон төлд нь, эхийнх нь нүдэн дээр нохой ойртуулах, хөдөө хээр хоюулханы нь уяж дасгах зэрэг олон аргыг хэрэглэдэг байлаа. Бас төлөө үхүүлсэн эхэд өөр төл авуулж хөхүүлэхдээ үхсэн төлийнх нь арьсыг нөмрүүлэх, сүүгий нь түрхэх, эсбөгөөс мөнөөхи төлд нь хужир давс түрхэж долоолгон ойртуулсаар дасгадаг арга ч байсан билээ.

Энэ хэсэгт ярьсан зүйл хэдийгээр товч боловч таван хошуу малын ааш араншин, сэтгэлзүйтэй холбоо бүхий монголчуудын мэдлэгийн талаар зохих ойлголт өгөх байх гэж найдаж байна.

Хавсралт

Тэмдэглэх нь: Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын малчин эмэгтэй Нансалмаагаас 1963 оны зун тэмдэглэж авсан хэрэглэгдэхүүнээс 2 зүйлийг хавсралт болгон оруулаа. Нийтэд ойлгомжтойг бодолцож Чивчин баргын аялгуугаар байсныг энд халхын аялгуугаар болгосноо дурдсу.

ТОЙГОО, ТОЙГОО...

Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Мянган хонины дундаас
Майлаад юунд ирнэ вэ?
Мартаад юунд голно вэ?
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Гүмэн хонины дундаас
Түрүүлээд юунд ирнэ вэ?
Төөрөөд юунд голно вэ?
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Хөхөө шувуу донгодноо

Хөх ногоо урганаа
Сүүтэй дэлэн чинь чинэнэ дээ.
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Цагаан цас хаялнаа
Цаг эрин чинь хүрлээ
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Ургын ногоо урганаа
Улаан дэлэн чинь чинэнэ дээ.
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Тэрс зантай болсонд чинь
Тэрэгнээс барьж хүлнээ
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Санаа муутай болсонд чинь
Хананаа барьж хүлнээ
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Нар ортол уянаа
Ниран хээлий чинь татанаа
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Өдөр болгон уянаа
Өвс хээлий чинь татанаа
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Хаврын хар салхинд
Хажууд чинь хэн дагана вэ?
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Хавтгай улаан дэлэнг чинь
юу хөхөх вэ?
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Хургатай хонь хонгор галуу адил
Хургагүй хонь хувхай хожуул адил
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Үртэй хонь өндөгтэй шувуу адил
Үргүй хонь өмх хожуул адил
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Мойл хар нүдэнд чинь
Нялмас дүүртэл тойглоно
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Модон цагаан шүдий чинь
Шивэт болтол тойглоно
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Зуугандаа хургалсан хонь
Зурам халзан хургатай
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Зурам халзан хурга чинь
Зуураад үхэх боллоо
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Хатилдаа хургалсан хонь

Хамар халзан хуртатай
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Хамар халзан хурга чинь
Харангадаад үхэх боллоо
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Захидмал хурга биш
Зая хувийн чинь хурга
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Авуулаа хурга биш
Амин хувийн чинь хурга
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Өгүүлээ хурга биш
Өөрийн амины чинь хурга
Тойгоо, тойгоо, тойгоо, тойгоо
Тойгоолоо, тойгоолоо
Түм хүрнээ
Майлаараа майлаараа
Мянга хүрнээ
Тойгоо тойгоо, тойгоо, тойгоо

ЧӘӘГ, ЧӘӘГ...

Чәәг, чәәг
Уулын өндөрт гардаг
Чәәг, чәәг
Усны тунгалгыг уудаг
Чәәг, чәәг
Хаданд авирахад халихгүй
Чәәг, чәәг
Халгай идэхэд халахгүй
Чәәг, чәәг
Эмээл харвал иддэг
Чәәг, чәәг
Эрэг харвал тоглодог
Чәәг, чәәг
Тохой харвал тоглодог
Чәәг, чәәг
Тохом харвал иддэг
Чәәг, чәәг
Бөөгийн хэцэнд дуутай арьс чинь
Чәәг, чәәг
Бөөхийд худалдахад үнэтэй
Чәәг, чәәг
Дах хийхэд дулаан арьс чинь
Чәәг, чәәг
Дагуурт худалдахад үнэтэй
Чәәг, чәәг...

ЛАВЛАРУУЛЖ УЗҮҮШТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Содном Ч, **Малын тухайт үг,** Монголын судлалын зарим асуудал, SM, Tom. IV, Fasc. 14, UB, 1964, 15—31.

Смирнов Б, **Музыкальная культура Монголии,** М., 1963, стр. 69.

Chagdarsuren Ts, **Les chansons amadoyant la femelle qui refuse d'accepter son petit nouveau-né,** -RO, t. XXXIII, z. I, Warszawa, 1969, pp. 97—103.

Смирнов Б, **Монгольская народная музыка,** М., 1971, стр. 96—98.

МОНГОЛЧУУДЫН МАЛ ЭМНЭЛГИЙН УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГЭЭС

Монгол ардын хууч үгэнд «мал тэжээвэл ам тостоно, хүн тэжээвэл толгой цустана» гэдэг нь муу хүнтэй холбож үзвэл нэн ч зөв, мал ахуйтайгаа холбож үзвэл туйлын зөв ажээ. Таван хошуу мал маань монголчууд бидний аж төрөх өвөрмөц хэв маягийг буй болгоод зогссонгүй олоун ухааны хувьд ч өдий тэдий мэдлэг боловсрол үүсэн бүрдэхийн үндэс суурь болж өгсөн билээ гэдэгт маргах хүн одоо байхгүй буй заа. Иймэ мэдлэгийн нэгэн салбар нь монголчуудын уламжлалт мал эмнэлгийн ухаан даруй мөн бөлгөө.

Хэдэн мянган жилийн өмнөөс малыг гаршуулан өсгөх болсон тэр цагаас монголчуудын уламжлалт мал эмнэлгийн мэдлэг ухаан эх үүсгэлээ авч шилдэг сайн бүхэн нь үе дамжин нарийсан боловсорсоор ямар ч атугай бидний үе хүрч иржээ. Иймэ зүйл бол бусад олон улс үндэстний хувьд ч нийтлэг байсан бөгөөд тэдгээр улс оронд тэр уламжлал нь орчин цагийн шинжлэх ухааны үндэслэлтэй сүлэлдэн буй болсон мал эмнэлгийн суурь нь болсон байхад манай хувьд ардынхаа уламжлалт мал эмнэлгийн ухааныг тэр зэрэгт хүргэж чадаагүй нь бидний нь арчаагүй муугийнх билээ.


Гэтэл монгол ардынхаа мал эмнэлгийн уламжлалыг үзэхүл таван хошуу малын бие махбодын бүтэц, өвчин эмгэгийн шинж болон үүсэх шалтгаан нөхцөл зэргийг олон зуун жилийн туршид олж нутласан туршлага мэдлэгтээ суурилаж өвчин эмгэг бүрт тохирон зохицсон анагаан засах өдий тэдий аргыг боловсруулан хэрэглэж ирсэн тул шинжлэх ухааны үндэслэлгүй гэж батлахын арга огт үгүй ажээ.

Монголчууд мал малын өвчин эмгэг, согог гэмийг олон зүйл аргаар тухайлбал: ургамлын болон эрдэс зүйлийн ханд, эм уулгах, ханаж хатгах, цоргих, халуун хүйтэн жин тавих, гэмтэл согогийг барих, мэс засал хийх зэрэг эмчилгээний хийгээд бусад дом заслын хар бор аргыг дан дангаар буюу хослон хэрэглэдэг байж билээ. Мал маллан аж төрөхийн эрхээр малчин хүн бүр мал эмнэлгийн уламжлалт наад захын арга ухааныг сайтар мэддэг байсан гэхэд яав ч хэтрүүлэл болохгүй. Үүнд монгол хүн бүр малынхаа бие бүтэц, онцлогийг сайн мэддэг байсан нь монгол мал эмнэлгийн ухааны хөгжилд ихээхэн нөлөөлсөн гэдгийг тэмдэглэвэл зохино.

Үүний зэргэцээ малын өвчин эмгэгийг анагаахдаа нарийн мэргэшиж нутаг ус, хошуу айматтаа нэр цуу гарсан эмч, ханнуурч, бариач зэрэг хүмүүс газар бүр цөөнгүй байж айл аймаг, нутаг хошууныхандаа уригдан залуулж явдаг байсан бөлгөө.

Монголчуудын мал эмнэлгийн уламжлал нь зөвхөн амаар буюу нэгэн хүнээс нөгөөд дамжин үлдэж байсангүй монголын оюун билигт бичиг номын хүмүүсийн бүтээл туурвилд тэмдэглэгдэн ирсэн нь цөөнгүй. Одоо бидэнд мэдэгдэж байгаа баримтаар хамгийн дорвитой том нь Халхын Сайн ноён хан аймгийн Арвай хээр буюу Үйзэн вангийн хошууны Мэргэн бандида хувилгаан хэмээн нийтэд алдаршиж ирсэн арван таван боть номтой, соёлын их зүтгэлтэн Шагдарцэвээний *Цэвээлванчүгдорж* (1836—1894)-ийн «Малчин сүрэгчин тэргүүтэнд тус хүргэхэд үйлдэх учир мал сүргийг тэтгэх аргын дараалалнуугуудаас нийт хийгээд ялгал ямаа, хонь, тэмээ ба хайнаг, үхэр, морины өвчнийг засахын аймаг болай» гэдэг нэртэй зураг тайлбар бүхий төвөд хэлээр бичсэн зохиол юм. Харин өвчин эмгэг тэргүүтний монгол нэр томьёог төвөд үсгээр монгол хэлээр галиглан хадсан байдагийг хэлвэл зохино. Уг бүтээлийг үзвэл мал малын өвчинийг дотор нь нарийн ялган, үүсэх шалтгаан, илрэх шинж, анагаах арга тэргүүтнийг нарийвчлан өгүүлсэн байдаг. Иймд төвд ном болгон шашны ном байдаг гэж боддог байсан мөхөс оюунтны ойлголт мөчид болохын нэгэн баталгаа энэ зохиол буюу. Үүний дээр «шашны» хэмээж ад үзэх нь ч бас л мэдлэг боловсрол нимгэн, хэтэрхий «үзэл сурталжсаны» илрэл мөнөөс мөн буюу. Ингээд уншигч авгай нарт товч боловч танилцуулахын үүднээс уг номын «нийт хийгээд ялангуяа хонины өвчнийг засахын аймаг» хэмээх судраас өчүүхэн нэг хэсгийг Д. Цэдэвийн орчуулгаар эшлэсү.

...Хонины дэлэн айх өвчин
Хонины дэлэн хавдахыг заримдаа дэлэн айх буюу дочих гэнэ.
Засах арга
Ихэр хүүхдийн оймсоор дом тавих ч байдаг. Мөн тэнгэрийн сумаар домноход тустай гэдэг. Дэлэн хавдсан даруйд хасны судас буюу дэлэнгийн судас, өөрөөр хэлбэл гэдэсний судсыг ханахад тустай... гэж дурдсан нь буй.



Ш. Цэвэлванчүгбавуудоржийн зохиолын нэгэн хуудасны зураг

Үүнээс гадна монгол малчдын дунд малын өвчин эмгэгийн шинж тэмдэг, анагаах арга, засал, ханаж хатгах цэг, хэмжээ

дамжааг нарийн тэмдэглэсэн гар бичмэл-өврийн ном дэвтэр өдий тодийгээрөө байсныг дурдалгүй өнгөрч болохгүй.

Малчдын туршлагаас үзвэл монголчууд таван хошуу малынхаа хувьд өлонтаа элбэг тохиолддог 70 орчим өвчин эмгэгийг дээр дурдсан арга заслаар анагаан эдгээдэг байжээ.

Эмийн тухайд гэвэл өвчин өвчинд тустай уусмал, хандын зүйл гол зонхи нь болж иржээ. Үүнд: эмийн чанартай өвс ургамал, үр жимс болон эрдэсийн зүйлийг тусгай жорын дагуу найруулж их төлөв зэс буюу мөнгөн сав суулганд хандалдаг байсан зэрэг нь цаанаа нарийн учир начиртай байсан буй заа. Бас заримдаа өвс ургамал, эрдэсийн зүйлийг буцалган хандлахад эрдэм чанар нь үгүй болдог хэмээж өвс төжээлд нь хольж хуурайгаар нь өгдөг ёсон байсныг ч хэлэх хэрэгтэй юм.

Монголчуудын мал эмнэлгийн уламжлалд ханаж хатгах арга онцгой байр эзэлдэг нь малчин хүн малынхаа бие цогцосын бүтэцийг маш нарийн мэддэг байсантай учир шалтгааны холбоотой биз ээ. Ханаж хатгах аргыг их төлөв яаралтай эмчилгээ шаардсан өвчин эмгэгийг анагаахад хэрэглэж ирсэн бөгөөд үр дүн нь ч мөн л түргэн мэдэгддэг байсан асан. Ерөнхийд нь авч үзвээс адуунд хамгийн олон, тэмээ үхэрт арай цөөн, хонь ямаанд харьцангуй бага хэрэглэдэг байсан байдал харагддаг.

Ханаж хатгах эмчилгээг дотрын өвчин, доголын шинжээр мэдэгддэг хөл, үе мөч, туурайн эмгэг согог, түүнчлэн элдэв зүйлд хордсон малын хорыг тайлах зэрэгт их төлөв харьцангуй өнгөц байрладаг хураагуур судсын тодорхой нэг цэгийг ханаж монголчуудын хэлдэгээр «хэлбэчихсэн муу цус»-ыг гаргадаг байсан нь одоогийн ухаарлаар бол нүүрс хүчлийн хийгээр элбэг болсон цусыг гаргаж байсан хэрэг болой. Ийнхүү ханаж хатгаж ирсэн туршлагыг үзвэл ил нут болсон өвчин эмгэгээс гадна тарга тэвээргэ авдаггүй мал, мөн олон хоног сараар аян жинд явж харшсан тэмээ зэргийг ерөнхий заслын зорилгоор хавар хөх ногоонд цадсан үед нь ханаж эзэлсэн «муу цус»-ыг нь авдаг явдал заншил болсон байдаг.

Мал маллан аж төрөх явцад мал бэртэж гэмтэх явдал аль олон гардаг тул бэртэнг хугархайг барьж эвд нь оруулж чиг барьж боон эдгээх арга монголчуудын дунд өргөн дэлгэрсэн байдаг билээ.

Бас нэгэн зүйл гэвэл монголчуудын уламжлалт мал эмнэлгийн ухаанд тухайн нэг өвчнийг юугаар хөллөсөн байдлаар нь ялган салгаж эмнэдэгээс гадна нутаг нутгийн онцлогт тохирсон анги анги эмчилгээний аргыг нэг зүйл өвчинд хэрэглэдэг байдал бэлхэнээ харагдана. Үүнийг нарийн мэргэжлийн эмч нар судлан үзэж өдгөө цагийнхаа ухаарлын үүднээс тайлбарлаж гэмээ нь сонин дүгнэлт гарна буй заа гэж бодогддог.

Монгол малчид малынхаа өвчин эмгэг үүсэх шалтгаан нөхцлийг нарийн мэддэг байсан тул жилийн дөрвөн улирлын тур-

шид бууц буудал, өвс бэлчээр, ус унд, хужир шорвогийг тохируулах, элдэв засал хийх зэргээр өвчин эмгэгээс хамгаалан сэргийлэх тогтолцоотой ажлыг хийсээр ирдэг байсан нь яв явсаар уламжлал болж жил улирал бүрт заавал ч үгүй гүйцэтгэвээс зохих ажлын тоонд ордог болсон ажээ. Ерийн нэгэн жишээг дурдахад л, хавар ногооны цагаар адуу мал, хонь ямааг хужир шорвог бүхий газраар тоос таттал нь гүйлгэж хөөхөд ямар ч байсан тэр жилдээ тархины болон хамрын хатиар өвчнөөр өвддөггүй байсан байна.

ЛАВШРУУЛАН ҮЗҮҮШТЭЙ НОМ ЗОЖИӨЛЫН ЖАГСААЛТ

Цэвэл Я, **Малчны календарь-1945 он**, УБ (монгол бичгээр).

Равжир, **Малын өвчнийг эмчлэх ардын зарим арга**, УБ, 1962.

Шайрийбуу Д, **Малын хануур, зүү, төөнөлгийн засал**, Улаанбаатар. 1965

Chagdarsürüng Ts, **L'art vétérinaire des Mongols nomades**, -SM, Tom. VII (16), Fasc. 9, UB, 1980, pp. 125—137.

Цэвэлванчигдоржийн «Малчдад туслах таван хошуу малыг арчлах арга нийт ба ялангуяа хонины өвчнийг засахын аймаг» гэдэг **судар**, Орчуулсан Д. Цэдэв, -Mongol-Kenkyu, Journal of Mongolian Studies, № 12, Dec. 1989, Osaka, pp. 145—150.

ТЭНГЭР ХАНГАЙ, ОРОН ДЭЛХИЙГЭЭ ОЛЖ ТАНЬСАН МОНГОЛ УХААНААС

ХЭМЭЭХ
ГУТГААР БӨЛӨГ

МОНГОЛЧУУДЫН ГАЗАРЗҮЙН УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГ

Манай монголчууд нэн эрт цагаас, өвөг дээдсээсээ авуулан уугуул энэ ус, суугуул энэ нутагтаа гол амьжиргаа болсон таван хошуу малаа адгуулан өсгөж үржүүлсээр ирэхдээ хангай дэлхийнхээ өгөөж шимд шүтэж аж төрөн суухдаа зөвхөн газар нутгаа сайн мэддэг төдийгүй бас дэлхий ертөнцийнхөө байдлыг тандан судалж ирсэн баримт амаар дамжин ирээд зогсохгүй бичиг түүхнээ үлдэж бидний үед хүрэлцэн иржээ.

Бид энэ хэсэгт монголчуудын газарзүйн уламжлалт мэдлэгийн дотроос дэлхий ертөнцийн тухай хир мэдэж байсан тухай товчхон ярилцая гэж бодлоо. Үүнд: Бидний дээд өвөг хүн (нү) нар газрын зураг үйлдэн хэрэглэж байсан мэдээ тэмдэглэгдэн үлдсэн бөгөөд түүнээс наашлуулан нэхэн сурвалжлаж үзвээс «Италийн алдарт жуулчин Марко Пологийн тэмдэглэл болон «Юан улсын сударт»-т өрнө дорнын олон улс орноос одзүйч, зурхайч, тоозүйч өдий төдий эрдэмтэн мэргэд монголын хаан ордонд хуран цугларч номын мөр хөөн суудаг байсан тухай цөөнгүй мэдээ байдгаас гадна газарзүйг судлахдаа *газрын хөрсний дүрэмт сав* буюу *газрын ёсны тэмдэглэл*, *газрын хөрсний гулдын дүрэмт сав* буюу уртраг тогтоох багаж, *газрын хөрсний хөндлөн дүрэмт сав* буюу өргөрөг тогтоох багаж, *ерэн даруагийн дүрэмт сав* буюу газрын хол ойрыг хэмжих багаж гэх зэрэг арваад багаж төхөөрөмж хэрэглэж байсныг дурдсан ажээ. Энэ далимд тодруулан дурдахад *дүрэмт сав* гээд байгаа нэр бол одоогийн бидний ухаарлаар *хэмжих багаж* гэсэн үг болохыг тэмдэглэхэд илүүдэх нь юун билээ. Саяхи дурдсан багажийн дотроос *газрын хөрсний дүрэмт сав* буюу *газрын ёсны тэмдэглэл* гэдэг нь ямар багаж байсан юм бэ? гэдгийг мөн сударт тэмдэглэсэн нь бидний анхаарлыг зүй ёсоор татсаар байгаа юм.

Тэнд тайлбарлахдаа: «...**газрын ёсны тэмдэглэл буюу газрын хөрсний дүрэмт савыг** хийсэн байдал гэвэл модоор дүгриг бөмбөг үйлдэж долоон хувий нь ус болгожээ, түүний нь өнгө ногоон. Үлдэх гурван хувийг газар шороо болгожээ. Түүний өнгө цагаан бөгөөд мөрөн, гол, тэнгис, далайн судсыг түүний дотор хэлхэж тоолжээ. Өчүүхэн зохистой худаг зурж үйлдээд газар дэлхийн агуу ба газрын хол ойрыг тэмдэглэжүхүй...»

хэмээсэн байдаг. Энэ тайлбар ерөнхийдөө ойлгомжтой байгаа боловч эцсийн өгүүлбэрт буй «өчүүхэн зохистой худаг зурж» гэсэн нь одоогийн зураг дээр тавьж хол ойрын зайг үзүүлдэг хэмжээс даруй мөн ажгуу гэдгийг хэлмээр санагдлаа. «Юан улсын судар»-ын 48-р дэвтэрт байдаг эл тайлбарыг 1946 онд германий эрдэмтэн Вальтер Фүхс автай Бээжин хотноо нийтлүүлсэн «Хятадын газар нутгийн монгол зургийн цомог» гэдэг номдоо их л сонирхон тэмдэглэж эшлэн оруулсан байдгийг хэлэлгүй орхиж яав ч болохгүй.

Дээрхи тайлбараас үзэхүл лавтайяа тэр цагтаа монголчууд эх дэлхийгээ бөөрөнхий гэж мэддэг байсан төдийгүй дэлхийн арав хуваасны долоон хувь нь ус, үлдэх гурван хувь нь хуурай газар хэмээн бөмбөрцөгт тэмдэглэж байсан нь одоогийн бидний тооцоолдогчилон дэлхийн бөмбөрцөгийн 70,8 хувийг ус, 29,2 хувийг хуурай газар эзэлдэг гэж хуваадагтай бараг тохирч байгаа нь нэн сонирхолтой юм.

Учир иймээс наад зах нь Юан улсын үес гэхэд л бидний монголчууд дэлхийн «хуучин тив» гэж ном зохиолд нэрлэж заншсан Ази, Европ, Африкаас гадна 1492 онд нээж «шинэ тив» хэмээн алдарших болсон Америк тивийг ямар ч атугай газарзүйн үүднээс хэмжээ дамжаагий нь хүртэл мэддэг л байж гэдэг дүгнэлт эрхгүй гарч ирэх нь тодорхойёо болж байгаа юм. Бидний энэ дүгнэлтийг нутлахаар өөр ямар ямар баримт сэлт байна вэ? гэдэг асуулт гарч бүрэн болох юм.

Шинжлэл судлалын сүүлийн үеийн ололт, дүгнэлт, монгол хэлний хэрэглэгдэхүүн эшэ асуултад зохих хариуг өгөх болно. Үүнд: монгол нутагт олон жил ажилласан монгол-зөвлөлтийн түүх соёлын болон эртний амьтан судлалын хамтарсан шинжилгээний анги, мөн 1974 онд Аляска, Алеут арал дээр, 1975 онд Байгалын Ольхон арал дээр ажилласан зөвлөлт-америкийн эртний судлалын шинжилгээний ангийн судалгааны үр дүнг хэлвэл зохино. Цэрдийн галавын сүүл үе гэхэд Ази, Умард америк хоёрыг одоогийн Беринтийн хоолой хавиар хуурай газар холбож байсан гэдэг дүгнэлт гарч улам бат болсоор байна. Энэ нь ч цэрдийн галавын түрүү үед Ази хийгээд Умард америкийн матар, яст мэлхий мөн эвэрт хуягт болон махчин үлэг гүрвэлийн зүйл, сүүн идэштэн амьтад ойр төрөл байсны учир начрыг тодруулсан төдийгүй ялангуяа Умард америкийн үндсэн хүн ам нь хүнсудлалын үүднээс Сибирь, Төв азийнхантай адил байдгийн учир холбогдлыг тайлан өгч байгаа юм. Мөн монгол ангуучин нар Х зууны үест одоогийн Камчатка, Аляска руу явж ертөнцийн нөгөө хязгаарыг зорин оддог байсан тухай товтой баримтын талаар академич Ринчен доктор профессор Олон улсын нэгэн хуралд тавьсан илтгэлдээ дурдан нийтэд сонордуулж байсныг энэ ташрамд дурдсу.

Монголчуудын газарзүйн уламжлалт мэдлэгийн талаархи бас нэгэн сонин бөгөөд хэн бүхний мэдээж нэгэн зүйл бол ардын аман зохиолын хэрэглэгдэхүүн болой. Манай ардын дуунд:

...Орчлон гэдэг бөөрөнхий
Эргэж хөрвөж байдаг...

гэдэг үг буй билээ. Үүнийг хэлшинжлэлийн талаас задлан үзэхүл *орчлон* гэдэг нэрийн *орчи*-гэдэг үйл үндэс нь *хөдлөх, эргэх* гэсэн утгатай бөгөөд түүн дээр тухайн үйлийг үйлддэг юм гэсэн утга бүхий *-лан* дагавар залгаж нэр үг үүсгэсэн нь *хүсгэдэг* үйлээс *хүслэн* гэдэг нэр, *жарга*-гэдэг үйл үндэсээс *жаргалан* гэдэг нэр үг үүсдэг тогтолцоотой нэгэн адил бүтэж *эргэж хөдлөж байдаг юм* гэдэг утгыг зааж байгаа ажгуу. Энэ бол монголчууд эх дэлхийгээ бөөрөнхий бөгөөд үргэлж *орчиж, хөдлөж байдаг зүйл* гэдгийг их л эртнээс танин мэдэж, тэр мэдлэг нь ч монгол хэлэнд тусан үлджээ гэдгийн бие бодтой нотлагаа мөн буюу.

Үүнийг давхар батлах нэгэн зүйл гэвэл, монголын их бичгийн хүн, зохиолч түүхч Инжаннаши олон нийтэд зориулан «Бөмбөрцөгийн өгүүлэл» гэдэг нэгэн өгүүлэл бичсэнийг хэлбэл зохилтой. Инжаннаши уул бүтээлдээ:

> «...газар дэлхийн байдлыг хэлбээс бөмбөрцөг адил. Нарны өөдлөн эргэж орчих нь наран хөдлөхгүй, газар дэлхий хөдлөж орчих нь болой...»

гээд учир байдлыг хэн бүхэнд нэн ойлгомжтой энгийн жишээгээр тайлбарласан байдаг билээ.

Дээр өгүүлсэн зүйлээ нэгтгэн авч үзвэл бидний монголчууд эх дэлхийгээ бөөрөнхий бөгөөд эргэн орчиж байдаг гэдгийг их л эртнээс мэддэг байсан төдийгүй Европ дахинаа XV зууны эцсээр Америк тивийг нээхээс хэдэн зуун жилийн өмнө гэхэд Америкийг хэдийнээ нээчихсэн, газар нутгийн хэмжээ дамжаагий нь ч нарийн мэдчихсэн байсан ажээ. Энэ ташрамд бас нэгэн зүйлийг нэмж тэмдэглэхэд Америкийн үндсэн хүн ам-Индиана нарын дунд өөрсдийгөө Төв ази, бүр тодруулахдаа монголчуудтай гарал нэгтэй гэдэг үг байдаг нь, мөн түүнчлэн Индиана нарын хэл, аялгууг нарийвчлан шинжвээс монгол хэлнийхтэй хэлбэрийн хувьд ч төстэй, утгын талаар ч ойр цөөн бус үг байдаг нь бидний дээрхи ярьсан зүйлийг давхар батлаж байна уу даа гэж эрхгүй санагдуулдаг.

ЛАВШРУУЛАН ҮЗҮҮШТЭЙ НОМЫН ЖАГСААЛТ

Книги Марко Поло, глава CIV Б, М., 1956, стр. 124—125.
Юан улсын судар, 48-р дэвтэр, Дандаагийн орчуулга, гар бичмэл.
Гучинзургаат толь бичиг, Дүрэмт савын зүйл, 7-р дэвтэр, гарбичмэл

(тэмдэглэх нь: дүрэмт савын зүйл нь утга сурадгын хураангуйд багтмуй).

Walter Fuchs, **The «Mongol Atlas» of China,** Monumenta Serica, Monograph VIII, Peiping, 1946.

Инжаннаши, **Бөмбөрцөгийн өгүүлэл,** -Эрдэнэтогтох, Орчин үеийн монголын алдарт уран зохиолчид, Тэдний түүвэр зохиолыг дагалдуулав, Хөххот, 1981, 59-р тал.

Chagdarsürüng Ts, **La connaissance géographique et la carte des Mongols,** SM, Tom 3 (11), Fasc. 20, UB, 1976, pp. 343—370.

Каландадзе Н. Н, Раутиан А. С, **Место Центральной Азии в зоогеографической истории Мезозоя,** -Ископаемые рептилии Монголии, Труды СССМПЭ, Вып. 24, М, 1986 стр. 6—44.

МОНГОЛЧУУДЫН УЛАМЖЛАЛТ ГАЗРЫН ЗУРАГ

Түүхч Фан Е-гийн «Хожуу Хан улсын түүх»-нээ, манай тооллын 46-р онд Би гэгч түшмэл, хүмүүн зарж Сюннү (буюу Хүн) нарын газар нутгийн зургийг нууцаар Нангиадын эзэн хаанд явуулсан тухай тодорхой тэмдэглэсэн нь буй. Үүнээс үзэхэд манай өвөг дээдэс-Хүн нар тэр цагт газрынхаа зургийг үйлддэг байсан ажээ.

Ямар ч атугай энэ үеэс эх авсан газрын зургийн уламжлал яв явсаар, хөгжин хөгжсөөр бидний үед хүрч иржээ. Монголчуудын уламжлалт газрын зургийн талаар анх академич Б. Я. Владимирцов европ зүгийн эрдэмтдийн сонорт хүргэсэн бөгөөд дараа нь Вальтер Фүхс, Жозеф Клер зэрэг судлаачид түсгайлан ном өгүүлэл гаргасан байна. Үүнээс гадна японы хэд хэдэн судлагчид эх зургийг шинжлэн бичсэн зүйлээ нийтлүүлжээ. Германы монголч эрдэмтэн Вальтер Хайссиг, Магадбүрэн Халтод нар Ар, Өвөр монголын олон хошуу, аймгийн газрын зургийг нэгтгэж хоёр боть ном гаргасан нь дав дээр олж үзэхэд нэн ховор болсон монголчуудын газрын зургийн эхийг олон нийтийн хүртээл болгосон буянтай үйлс болсоор, монголчуудын утга соёлын судлалд хэрэглэгдэхүүн болсоор байгааг дурдалгүй орхиж яав ч болохгүй биз ээ.

Уламжлаж бидний үед хүрч ирсэн монгол газрын зургийг үзэхэд дотроо олон зүйл ялгавартай байжээ. Үүнд:

— улсын хэмжээний зураг,
— аймгийн зураг,
— хошууны зураг,
— хотын зураг,
— хүрээ хийдийн зураг,
— өртөө замын зураг,
— харуулын зураг

гэх зэрэг болно. Монгол газрын зургийг нягтлан үзвэл зураг зүйн хувьд тухайн цагтаа нэлээд нарийн, бусад улс үндэстнийхтэй жишихэд өвөрмөц онцлог шинжтэй байсан нь илэрхий харагддаг билээ.

Монголчуудын газрын зураг үйлддэг аргын талаар товч танилцуулсу. Үүнд, монголчууд газрынхаа зургийг үйлдэхдээ зургийн үндэс болгож тойрог татаад, тойргоо

— □ дөрвөн зүг,
— ○ найман өнгө,
— ⬡ найман өнцөг,
— ◇ дөрвөн зовхис

гэж 24 хуваагаад энэ 24 хуваарь тус бүрийн (●) завсар хэмээж бүгд 48 болгодог уламжлалтай байжээ. Иймд нэг хуваарь нь 7,5 хэмтэй тэнцэнэ гэсэн үг. Дээр дурдсан 24 хуваарь тус бүртээ тусгай нэртэй.

Дөрвөн зүг гэдэг нь: хулгана буюу умар (1),
туулай буюу дорно (7),
морин буюу өмнө (13),
тахиа буюу өрнө (19);

Найман өнгө гэдэг нь: харагчин (2),
хөх (6),
хөхөгчин (8),
улаан (12),
улаагчин (14),
цагаан (18),
цагаагчин (20),
хар (24);

Найман өнцөг гэдэг нь: үхэр (3),
барс (5),
луу (9),
могой (11),
хонь (15),
бэч (17),
нохой (21),
гахай (23);

Дөрвөн зовхис гэдэг нь: зогсолт (4)
ороло (10)
эвэргүү (16)
мөнх (22) гэсэн эдгээр

24 болой. Энд нэгэн зүйлийг тэмдэглэхэд, дөрвөн зовхис гэдэгт дорно зүгийн зурхайн ёснос нийтлэг хэрэглэгддэг найман хүлил хэмээх зүйлийн дөрвийг нь авч хэрэглэсэн байдаг бөгөөд чухамхүү ямар учраас тэр дөрвийг сонгон авсан нь одоогоор тодорхойгүй бөгөөд судлах эзнээ хүлээж буй асуудлын нэг тул дэмий нуршин тайлбарласангүй, харин үлдсэн дөрөв нь ямар хэлбэртэй болохыг уншигч авгай нарт сонирхуулахын үүднээс дор наймууланг нь үзүүлэв.

үүднээс дор наймууланг нь үзүүлэв. Найман хүлил гэдэг нь:

зогсолт (═══)


шавардал (═══)

мөнх (═══)

хөдлөл	( )
оролт буюу оролго	( )
гэрлүүл	( )
эсвэргүү	( )
баясал	( )

хэмээсэн найм бөлгөө.


Энэ бүхнээс үзэхүл монгол газрын зургийн суурь болсон тойрогт дээрхи 24 хуваарь, тэдгээрийн завсарын хамт нийт 48 хуваариа тогтсон дэс дараатайгаар нар зөв тойруулан байрлуулахдаа дөрвөн мөчлөг болгож мөчлөг бүр нь аль нэг зүгээр эхлэж, өнгө, өнцөг, зовхис, дахин өнцөг, өнгө гэдгээс бүрддэг байдал тодорхой харагдана (Монголчуудын газрын зураг үйлдэг суурийн байдлыг, сэргээн тайлбарласан бүдүүвч болон нэгэн хошууны гэрэл зургаас үзмүү).



Монголчуудын газрын зураг үйлдэхдээ хэрэглэдэг байсан суурийн бүдүүвч зураг

Ийнхүү зургийн сууриа бэлтгэсний дараа тухайн газрын зургийг үйлдэхдээ гол төлөв өмнө буюу морин зүгээс эхлэн нутгийн хил хязгаарын овоо дээс бүрийн хоорондын зайг нарийн хэмжиж 48 чиглэлдээ таацуулан эхний овооноос нар зөв эргүүлэн, үргэлжлүүлэн зурсаар дуусгадаг байжээ. Үүний үлгэр болгож Сэцэн хан аймгийн мэргэн гүн Цэрэнвандуйбавуудоржийн хошууны газрын зураг, түүний өгүүлэл цэсийг хавсралт маягаар энэ хэсгийн сүүлд бүрэн эхээр нь танилцах нь зүйтэй болов уу гэж саналаа.

Монгол газрын зургийн уламжлалыг үзэхэд хол ойрыг их төлөв *газар* буюу 576 м, *хувь* буюу 5,76 м, *алд* буюу 1,6 м, *ямх* буюу 0,32 м гэдэг нэгжээр хэмжиж, зурат дээрээ *нэг ямхад 20 газрыг* багтаадаг байсан ажээ. Гэхдээ монгол газрын зуратт хэрэглэж ирсэн *хэмжээс* (сүүлийн үед энэ нэр томьёог мартаж герман гаралтай, хэмжих мод гэсэн утга бүхий масштаб гэдэг



Түшээт хан аймгийн засаг, улст туслагч гүн Мандарваа агсаны хошууны нутгийн зураг


үгийг хэрэглэх болж иржээ) нь хэд хэдэн янз байсныг үгүйсгэх аргагүй бөгөөд зарим зураг дээр ам дөрвөлжин нүд (буюу түрүүчийн хэсэгт өгүүлсэнчлэн *өчүүхэн худаг*)-аар хэмжүүр хийдэг байсан байдал үзэгддэг.

Монголчуудын хийж ирсэн газрын зураг нь зөвхөн хил хязгаарханы татсан цулгай зураг байгаагүй нь мэдээж бөгөөд хаана хаана ямар уул ус, гол горхи, булаг шанд, сүм хийд, хүй гацаа, зам харгуй байдаг, уул гэхэд хэр өндөр, модтой эсэх, нуур гэхэд хэр гүн, шорвог эсэхийг, гол мөрөн гэхэд урсгалын чиг зэргийг нарийн заадаг уламжлалтай байжээ. Энэ бүхнийг нийт улс даяар нэгэн маягаар мөрддөг байсны баримт одоо Улсын түүхийн төв архивт хадгалагдаж байгааг дурдахад илүүдэх нь юун. Түүнийг *зургийн дүрэм* хэмээмүй.

Монголчууд газрын зургаа их төлөв чиг цагаан даавуу буюу муутуу цаасан дээр өнгө ялгаж үйлддэг байсан бөгөөд тийнхүү өнгө ялгахдаа хэн хүн дур дураараа өнгө будаг тавьдаггүй, тогтсон дүрмийн дагуу зурдаг байжээ. Тухайлбал: хилийн зааг шугам, харуул, өртөө зэргийг их төлөв улаан, хааяа хараар, замыг шараар, гол мөрөн, нуур далай, тэнгисийг хөх цэнхэрээр, элс манханы ягаавтар, бэлчээр, ой модыг ногооноор зурж заншчээ. Хот балгад, сүм хийд, хошуу тамга, худаг ус зэргийг байгаа байдлаар нь дүрслэхийг эрмэлзэнэ. Энэ нь монголын уламжлалт газрын зургаг одоогийн бидний ухаарлаар таних тэмдэг гэдгийг *зургийн илэдхэл* гэж нэрлэж, *монгол зургийн* өвөрмөц аргаар тэмдэглэж ирснийг гэрчлэж байгаа хэрэг юм.

Юуг үндэслэж *суурь* дээрээ зургаа зурдаг вэ? гэдэг асуулт аяндаа гарч ирэх нь мэдээж билээ. Зураг зурахдаа нэгэнт хүчин төгөлдөр болгож тамга дарж тусгайлан баталсан *зургийн өгүүлэл цэс* гэдэг хэрэглэгдэхүүнд үндэслэдэг ажээ. Зургийн өгүүлэл цэст хилийн овоо нэг бүрийг тодорхойлж, нэг овооноос нөгөө овоо хүртэл ямар чигээр, хэдий хэр хол зайтай зэргийг нар зөв тойруулан тодорхойлсон байдагаас гадна уулын өндөрийн хэмжээ, тухайн нутаг дэвсгэрийн хил хязгаарын нийт урт, хаагуураа ямар аймаг, хошуу, шавьтай хил нийлж нутаг савладаг, нутгийн өргөн болон уртын хэмжээ зэргийг нарийн дурдаад эцэст нь уул *өгүүлэл цэс*, газрын зургийг хэдэн оны хэдэн сард үйлдсэн гэдгээ огнодог байсан ажээ.


Тухайн нутаг дэвсгэрийг газрын зураг дээр ийнхүү тэмдэглэдэг байжээ. Харин жинхэнэ газар дээр нь ямар нэгэн тэмдэг тавьдаг байсан уу? гэж асууж болох билээ. Тэгвэл, хил хязгаарын зааг газар, уул даваан дээр овоо босгон тэмдэглэдэг, хад чулуун дээр тэр газрынхаа нэрийг сийлж тэмдэглэдэг, түүнийгээ *нутгийн дээс* хэмээж нэрлэдэг байсан гэж хариулбал зохилтой. Дээс гэж нэрлэдэгийн учир юун билээ хэмээвээс газрын хол ойрыг тусгай хэмжээгээр зангидсан дээсээр хэмждэг байсны улбаа мөр ажгуу.



Түшээт хан аймгийн Зоригт вангийн буюу Гүнцэл чивчид уулын хошууны нутгийн нэгэн дээс. Одоогийн Төв аймгийн Эрдэнэ-сант сумнаа бий. Хадан дээр «Гүнцэлийн Цүүгэл булаг энэ» хэмээж сийлжүхүй.

Энд нэгэн зүйлийг тэмдэглэхэд Ар, Өвөр монголын олон засаг хошуудын газрын зургийг үйлдэхдээ дандаа монгол хэл, бичгээр бичсэн байдал (Манжийн захиргаанд байсан үед ч гэсэн) нийтлэг үзэгддэг бөгөөд харин Манжийн хааны орднюос гарсан хошуу нутгийн монгол зургийн тухайд, уг зургийн монгол бичгээрхи тайлбар бүр дээр хятад орчуулга бүхий нэмэлт төдүүл хадсан байдаг билээ. Энэ нь монголчууд өөрснөө нутаг газрынхаа зургийг гардан үйлддэг байсны бас нэгэн батлагаа буюу.

Монголчуудын уламжлалт газрын зураг нийтлэг хэрэглэгдэж ирсэн **зургийн дүрэм буюу зургийн илэдхэлийг** жагсаан үзүүлвээс:



Монгол газрын зургийн илэдхэлийн жагсаалт

1. Хил хязгаарын шугам, хилийн овоо
2. Шинээр хошуу нутаг салгах зэрэгт татсан шинэ хязгаар
3. Уул нуруу
4. Модтой уул

5. Овоо
6. Ой мод; модтой газар
7. Дэрстэй газар
8. Элс манх
9. Гуу суваг
10. Гол ус, түүний урсгалын чиг
11. Булаг шанд, цөөрөм
12. Нуур тэнгис
13. Давстай нуур
14. Ухаа толгод
15. Суурин гацаа, айл гэр, хүй гацаа
16. Худаг ус
17. Сүм хийд
18. Суварга
19. Гүүр
20. Албаны гэр буюу засаг захиргаа түүний гэр нь
21. Засаг ноёны оргөө гэр
22. Харуул
23. Өртөө, өртөө зам
24. Тариалан
25. Төмөрзам
26. Төмөр утасны шугам буюу утсан холбоо
27. Усан онгоц явж болохуйц гол мөрөн
28. Зам

Ийх зөрөг болно.

Сайн хан аймгийн дөрвөн зөрөг нэмсэн зургаан зөрөг гэмдэглэсэн мөргөн засаг улст туслагч гүн Цэрэнвандуйбавуудоржийн хошууны нутгийн захын овооны зүг чиг нэр ба хоорондын газрын хэмжээ зах нийлсэн засаг хошууд зөргийг тодорхойлсон нь:

Нэгдүгээр Жаргалантын баруун хойд этгээд Цагаандэвсэгийн овооноос


Хоёрдугаар Бяцхан булагийн эхний Хар өндөрийн оройн овоо хүртэл оролго могойн завсраас гахай мөнхийн завсар зүг арван найман газар таван хувь хоёр алд энэ овооноос

Гуравдугаар Ханан уулын баруун этгээд Хөтөлийн овоо хүртэл оролго могойн завсраас гахай мөнхийн завсар зүг арван таван газар гурван хувь дөрвөн чи энэ овооноос

Дөрөвдүгээр Хар нуурын баруун дэвээс Цагаан хөвийн овоо хүртэл оролго могойн завсраас гахай мөнхийн завсар зүг зургаан газар таван хувь дөрвөн чи энэ овооноос

Тавдугаар Цагаанхөвийн адгийн овоо хүртэл луугаас нохой зүг долоон газар зургаан хувь таван алд энэ овооноос

СЭЦЭН ХАН АЙМГИЙН МЭРГЭН ГҮН ЦЭРЭНВАНДУЙБАВУУДОРЖИЙН ХОШУУ НУТГИЙН ЦЭС




Сэцэн хан аймгийн Цэрэнвандуйбавуудоржийн хошууны нутгийн цэсийн нугалбар бичгийн эхний гурван хуудас

Зургадугаар Улаанхудагийн баруун хойд ханан уулын овоо хүртэл хөхөгчин луугийн завсраас цагаагчин нохойн завсар зүг гурван газар долоон хувь гучин нэгэн алд нэг чи энэ овооноос

Долдугаар Цагааннуурын хойд этгээд талын эсэр толгойн овоо хүртэл луугаас нохой зүг арван нэгэн газар долоон хувь энэ овооноос

Наймдугаар Сонтуулын эхний бэлчир хошууны овоо хүртэл могой улааны завсраас гахай харын завсар зүг арван таван газар хоёр чи энэ овооноос

Есдүгээр Харгана уулын төв дундын оройн овоо хүртэл оролгоос Мөнхийн зүг есөн газар гучин алд хоёр чи энэ овооноос



Сэцэн хан аймгийн Цэрэнвандуйбавуудоржийн хошууны газрын зургийн эх. Одоогийн Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын хавь газар болой.

Аравдугаар Хорхой булагийн баруун өндөрийн оройн овоо хүртэл улааналс харын зүг хорин нэгэн газар найман хувь арван алд нэг чи энэ овооноос

Арван нэгдүгээр Баруун Сэвсүүлийн эхний өндөрийн овоо хүртэл бэчинээс барс зүг арван долоон газар энэ овооноос

Арван хоёрдугаар Зүүн Сэвсүүлийн эхний өндөрийн овоо хүртэл бэчинээс барс зүг арван гурван газар найман хувь энэ овооноос

Арван гуравдугаар Тэргилчийн зүүн модны баруун хар үзүүрийн овоо хүртэл хониноос үхэр зүг арван дөрвөн газар долоон хувь долоон алд энэ овооноос

Арван дөрөвдүгээр Баруун Зүртэйн хоргол уулын баруун өмнө адагийн овоо хүртэл хониноос үхэр зүг арван таван газар гурван хувь хорин нэгэн алд энэ овооноос

Арван тавдугаар Зүүн Зүртэйн Баяндэлгэр уулын зүүн үзүүрийн овоо хүртэл хониноос үхэр зүг арван найман газар долоон хувь арван зургаан алд энэ овооноос

Арван зургадугаар Дэлбэрэхийн ухаагийн оройн овоо хүртэл тахиагаас туулай зүг арван есөн газар нэгэн хувь хорин найман алд энэ овооноос

Арван долдугаар Алтан гадасын баруун этгээд Улаан чулууны зүүн хойд ар үзүүрийн овоо хүртэл тахиагаас туулай зүг арван есөн газар нэгэн хувь дөрвөн алд энэ овооноос

Арван наймдугаар Зүүн Хонгилчийн эхний өндөрийн оройн овоо хүртэл нохойноос луу зүг хорин хоёр газар хоёр хувь энэ овооноос

Арван есдүгээр мөн Хонгилчийн зүүн дэнжийн овоо хүртэл нохойгоос луу зүг арван гурван газар зургаан хувь дөрвөн алд энэ овооноос

Хорьдугаар Цагааннуурын зүүн хойд этгээд Сариг голын баруун дэнжийн овоо хүртэл нохойноос луу зүг хорин дөрвөн газар найман хувь гучин алд энэ овооноос

Хорин нэгдүгээр Сариг голын баруун дэнжийн овоо хүртэл нохойноос луу зүг нэгэн газар найман хувь энэ овооноос

Хорин хоёрдугаар Хуурай бүрдний овоо хүртэл хулганаас морин зүг арван зургаан газар долоон хувь нэг алд энэ овооноос

Хорин гуравдугаар Өвст нуурын баруун ухаагийн овоо хүртэл зогсолтоос эвэргүү зүг арван газар есөн хувь зургаан алд энэ овооноос

Хорин дөрөвдүгээр Хөтөл нуурын зүүн ухаагийн овоо хүртэл үхэр зогсолтын завсраас хонь эвэргүүгийн завсар зүг долоон газар есөн хувь гурван алд энэ овооноос

Хорин тавдугаар Талын худагийн хойт этгээдийн овоо хүртэл зогсолтоос эсвэргүү зүг арван дөрвөн газар зургаан хувь хорин есөн алд энэ овооноос

Хорин зургадугаар Хар магнай уулын овоо хүртэл барсаас бэчин зүг таван газар хорин нэгэн алд энэ овооноос

Хорин долдугаар Номгон уулын оройн овоо хүртэл барсаас бэчин зүг арван газар есөн хувь арван таван алд энэ овооноос

Хорин наймдугаар Вангийн худагийн овоо хүртэл зогсолт барсын завсраас эсвэргүү бэчиний завсар зүг наймаан газар долоон хувь арван алд энэ овооноос

Хорин есдүгээр Аманы худагийн овоо хүртэл үхэр зогсолтын завсраас хонь эсвэргүүгийн завсар зүг арван хоёр газар долоон хувь нэгэн алд энэ овооноос

Гучдугаар Талын овоо хүртэл үхэрээс хонин зүг арван газар зургаан хувь таван алд энэ овооноос


Гучин нэгдүгээр Давсан нуурын баруун хойд захын овоо хүртэл үхэр зогсолтын завсраас хонин эсвэргүүгийн завсар зүг долоон газар нэгэн хувь нэгэн алд гурван чи энэ овооноос

Гучин хоёрдугаар Доод Эргэцэгийн овоо хүртэл үхэр зогсолтын завсраас хонин эсвэргүүгийн завсар зүг арван зургаан газар хоёр хувь таван алд энэ овооноос

Нэгдүгээр Жаргалантын баруун этгээдийн Цагаандэвсэгийн овоо хүртэл үхэрээс хонин зүг найман газар зургаан хувь арван таван алд, эдгээр овоодын доторхи Нэгдүгээр Жаргалантын Цагаандэвсэгийн овооноос үүсгэн Аравдугаар Хорхойн холбоо баруун өндөрийн овоо хүртэл энэ арван овоонд Баатар вангийн хошуутай зах нийлмүй. Энэ овооноос үүсгэн Хорьдугаар Цагааннуурын хойт этгээдийн овоо хүртэл энэ арван овоонд

Шадар сайд Эрдэнэ дайчин жонон вангийн хошуутай зах нийлмүй. Энэ овооноос үүсгэн мөн Нэгдүгээр Жаргалантын Цагаандэвсэгийн овоонд хүртэл энэ арван хоёр овоонд Махасамади Далай сэцэн ханы хошуутай зах нийлмүй. Эдгээр тоорин гучин хоёр овооны хоорондохи газрын хэмжээ дөрвөн зуун арван есөн газар есөн хувь зургаан алд хоёр чи, харьяат хошуу нутгийн өмнө этгээд Жаргалантын Цагаандэвсэгийн овооноос хойд этгээд Дэлбэрэхийн ухаагийн оройн овоо хүртэл эрслэн нэг зуун хорин зургаан газар, зүүн этгээд Саригийн баруун дэнжийн овооноос баруун этгээд Баруун Сэвсүүлийн эхний өндөрийн овоонд хүртэл эрслэн нэгэн зуун хорин долоон газар болумуй.

Үүгээр уг хошууны газрын зургийн өгүүлэл үзэс дуусчээ. Тус хошууны хил хязгаарын дотоодод тэмдэглэсэн булаг шанд, нуур ус, худаг болон уул толгой бусад зүйлийг хэрхэн зурсан хийгээд ямар тайлбар хадсан гэдгийг арай торниун байдлаар үзүүлж бичвэрийн зүйлийг тусад нь жагсаан танилцуулсу.



Сэцэн хан аймгийн Цэрэнвандуйбавуудоржийн хошууны зургийг томсгон харуулсан байдал

Сэцэн хан аймгийн Мэргэн гүн Цэрэнвандуйбавуудоржийн хошууны зургийн тэг доторхи газар ус тэргүүтнийг тайлбарласны нь жагсаан үзүүлбэл:

Худаг усны зүйл:

1. Бяцхан булаг
2. Доод булаг
3. Чулуут булаг
4. Тэнхлиг булаг

5. Хорхой булаг
6. Баруун Сэвсүүл булаг
7. Дунд Сэвсүүл булаг
8. Зүүн Сэвсүүл булаг
9. Баруун Зүртэй булаг
10. Дунд Зүртэй булаг
11. Зүүн Зүртэй булаг
12. Баруун Бүрд
13. Зүүн Бүрд
14. Зүүн Хонгилч булаг
15. Дунд Хонгилч булаг
16. Баруун Хонгилч булаг
17. Зодлогийн булаг
18. Урд булаг
19. Шаварт булаг
20. Бүрд
21. Цагаан нуур
22. Өвст нуур
23. Хөтөл нуур
24. Вангийн худаг
25. Амны худаг
26. Хар нуур
27. Холбоо нуур

Уул толгодын зүйл:

28. Баяндэлгэр уулын өндөр нь хоёр газар
29. Ханан уулын өндөр нь нэгэн газар
30. Жаргалант уулын өндөр нь дөрвөн газар
31. Дэлгэр-обоо уулын өндөр нь таван газар
32. Харгана уулын өндөр нь хоёр газар таван хувь
33. Мутай уулын өндөр нь таван газар
34. Эрдэнэ хан уулын өндөр нь таван газар
35. Дэлгэр хан уулын өндөр нь таван газар
36. Өндөрцагаан уулын өндөр нь таван газар
37. Зодлог уулын өндөр нь дөрвөн газар
38. Зодлог уулын өндөр нь дөрвөн газар
39. Баянмөнх уулын өндөр нь дөрвөн газар
40. Баянцогт уулын өндөр нь дөрвөн газар
41. Билигт уулын өндөр нь хоёр газар

Бусад зүйл:

42. Гүн Цэрэнгомбын тус сахигч албаны гэр

ЛАВШРУУЛАН ҮЗҮҮШТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Фан Е, **История Поздней династии Хань,** глава 79, Повествование о южных Сюнну -Материалы по истории Сюнну (по китайским источникам) вып. II, Предисловие, перевод и примечания В. С. Таскина, М. 1973. стр. 70.

Владимирцов Б. Я, **Объяснения к карте Северо-Западной Монголии** ИИРТО, Том. XLVII, стр. 491—495.

Аоуma VIII, **On maps of the Yüan Dynasty,** -Toho gakuho VIII, Tokyo 1938, p. 103—152.

Walter Fuchs, **The «Mongol Atlas» of China,** MSer, Monograph VIII, Peiping, 1946.

Joseph Kler, **A propos de cartographie mongole,** -BSRBG, Fars I—II, 1956, p. 26—51.

Magadbürin Haltod, **Mongolische Ortsnamen,** Teil I, (Mongolische Manuskriptkarten in Faksimilia) -VOHD, Supplementband 5. I, Wiesbaden, 1966.

Гончигдорж Б, **Монголчуудын газар зүйн зургийн түүхийн зарим асуудалд,** ШҮАМ, 1969, № 1, 54—60 дахь тал

Chagdarsürüng Ts, **La connaissance géographique et la carte des Mongols,** SM, Tom. III (11), Fasc. 20, UB, 1975, pp. 345—370.

Walther Heissig, **Mongolische Ortsnamen, Teil II,** (Mongolische Manuskriptkarten in Faksililia) -VOHD, Supplementband 5. 2, Wiesbaden, 1978.

МОНГОЛЧУУДЫН ЦАГ УУРЫН УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГ

Бэлчээр хөөж мал сүргээ адгуулан аж төрж ирсэн нь бидний монголчуудыг олон зүйл ухаанд сургасан бөгөөд үүний нэг нь цаг уурын уламжлалт мэдлэг даруй мөнөөс мөн билээ. Тэгэхдээ эл мэдлэгийг байгаль цаг уурын хатуу ширүүнийг даван туулах явцад олж авсан зөвхөн туршилга ажиглалт гэж үзвэл учир дутагдалтай дүгнэлт болох буй заа. Учир юун хэмээвээс туршилга, ажиглалтын хажуугаар тухайн цагтаа одот тэнгэр, цаг уурыг судлах ухааны уламжлал зохих хэмжээгээр хөгжсөөр байсан тул нар, сар, од мичидийн тохиол зэргийг цаг уурын хувьсалтай харьцуулан тайлбарлах арга ухааныг тогтолцоотой буй болгосон явдлыг үгүйсгэхийн аргагүй. Лавтайяа мэдээ баримтаас үзэхүл Юан улсын үе гэхэд монголоор *Хасын шинжлэлийн оргил* гэдэг нэртэй одот ертөнцийг судлах тусгай газар байж, монгол, хятад, энэтхэг, араб, перс, итали зэрэг олон хэлийн эрдэмтэн нар тэнд хуран цугларч номын садан нөхөд болдог байсан тухай тэр цагийн жуулчны тэмдэглэлд нэг бус удаа дурдсан нь бий. Монголчуудын цаг тоолол, зурхайн тухай хэсэгт, сая ярьсан Хасын шинжлэлийн оргилд ямар ямар багаж хэрэглэж байсан тухай ярих тул энд дэмий олныг нуршсангүй.

«Цаг цагаараа байдаггүй» гэдэг үг монголчуудын дунд шууд болон шилжсэн утгаараа өргөн хэрэглэгддэг нь орой малаа хотлуулахдаа өглөө манагаар тэнгэр ямар болохыг харж, үүр цүүрээр босоод гарахдаа өдөр ямар болохыг ажиж заншсан малчдын аж төрлөөс үүдсэн нь маргаангүй хэрэг. Тэнгэр ямар болохыг монголчууд урьдчилаж хэрхэн мэддэг байсан тухай яриаг хэдэн гол хэсэг болгон авч ярьж болно. Монголчуудын цаг уурын мэдлэгт нар сар, од мичид, салхины аяс, манан буданы шинж байдлаар тэнгэр хангай ямар болохыг шинждэг арга гол байрыг эзэлдэг. Үүнд тэнгэрийн хаяа улайж нар шингэвээс маргааш сайхан өдөр болно; салхи урдаасаа уривал тэнгэр эвгүйтэнэ; цэлмэг байхад од үствэл бороо орно; нар сар хүрээлбэл хүйтэрнэ; наран хэт цоновоос шүрүүн бороо орно гэх мэт болой.

Мөн таван хошуу мал, араатан гөрөөс, жигүүртэн шувуу, хорхой шавьж зэрэг амьтны байр байдал зэргийг ажиглаж тэнгэр ямар болохыг шинжих явдал монголчуудын дунд дэлгэр бай-

жээ. Тухайлбал: тэнгэр муухай байхад унага тутал эрхлэн гүйвэл онгойхын тэмдэг; хараацай шувуу дээгүүр нисвээс тэнгэр сайхан байх, доогуур нисвээс эвгүйрхэхийн тэмдэг, чоныи от ороо эрт эхэлвэл ирэх хавар зөөлөн орохын шинж гэх зэрэг болно.

Үүнээс гадна эд юмс хийгээд утаа гарах байдал, мөн газар орны шинж төлөвөөр тэнгэр ямар болохыг зөгнөн мэддэг байсан билээ. Үүнд: салхигүй намуун үед утаа эгц дээшээ гарч байвал тэнгэр сайхан байх; тэрхэн хавьдаа хорголзоод байвал тэнгэр муудахын шинж; давс чийгтэх, намаг цөөрмөөс эвгүй үнэр гарах, гаанс бөглөрч бохь нь шаржигнах, гэрийн хялгасан бүслүүр, оосор бүч чангарч чивчрэх зэрэг нь цөм тэнгэр муудахын шинж, бороо орохын тэмдэг гэж монголчууд үздэг байсан асан.

Тэр ч байтугай амьдралын хатуу хүтүүг туулж насан өндөр болсон өтгөс хөгшид биеэрээ тэнгэр ямар болохыг зөгнөн мэдэж үр ач нартаа сануулан хэлж ажил төрлий нь заан зүрдаг уламжлал байсныг энд хэлэхэд илүүдэх нь юун билээ. Бие новоорон залхуу хүрэх, үе мөчөөр өвдөх, хэрэвзээ бэртэнгэтэй бөгөөд тэр нь өвдвөл тэнгэр муухайрахын шинж болдог ажээ.

Монголчуудын цаг уурын мэдлэгийн хувьд зайлшгүй нэмж хэлвээс зохилтой нэгэн зүйл бол монголчууд зөвхөн өнөө маргаашийн тэнгэрийн байдлыг мэдээд зогсдоггүй, зун намар бол өвс ургамлын байр байдал, самар жимсний гарц болцоор, өвөл гэхэд цас мөсний онцлогоор, бас ан амьтан, араатан жигүүртний ичих, буцах, хөөе тэжээлээ цуглуулах байдал зэрэг олон онцлогийг нарийн ажиглаад эсэргэн жил, улирал ямар болохыг зөгнөн мэдэж нүүдэл буудлаа тохируулан зохицуулдаг уламжлал үе дамжин буй болсон билээ л.

Энэ бүхний үндсэн дээр аж амьдралын их туршлагаар үнэн зөв нь шалгарсан мэдлэгийг үр удамдаа уламжлан үлдээхийн учир хэн бүхэнд ойлгомжтой. Цээжлэхэд хялбархан, өдөр тутмын аж төрөлд хэрэглэгдэх сургаалын чанартай зүйр сэцэн үгэнд шингээж хэлэлцдэг ёс заншил буй болжээ. Иймээс ч:

— Өглөөний нарыг наранд бүү бод
Өсөхийн жаргалыг жаргалд бүү бод,
— Ширүүн бороо уддаггүй
Шивэрэ бороо уддаг.
— Үүл зөрвөл бороо
Үг зөрвөл хэрүүл,
— Орох тэнгэрийн орой цоорхой
Орсон буурын шил цоорхой

гэх зэрэг олон зүйр сэцэн үгэнд цаг уурын мэдлэгийг ер хүний дагах ёстой зөргөцүүлэн сургасан нь цөөнгүй байдаг билээ.

Энд нэгэн зүйлийг дурдалгүй орхиж болохгүй гэж бодож байна. Монголчуудын дунд *тэнгэр задраах*, мөн *тэнгэр хангай хилэгнэх* гэх зэрэг сонин хэллэг байдаг. Тэнгэр задраана гэдэг нь цаг уриралдаа үл зохилдох зүйл үйлдсэнээс үүдэж тэнгэр хангай эвгүйрхэнэ гэсэн үг. Тэнгэр хангай хилэгнэнэ гэдэг нь аливаа ёсон бусын зүдэг хар үйл үйлдэх, орон дэлхийг зүй бусаар хөндөх зэргээс болж хариу цээрлэл үзнэ гэсэн санаа болой.

Дээр өгүүлсэн энэ бүх зүйл нь монголчууд нэн эрт цагаас байгаль дэлхийн явдал, цаг уурын үзэгдлийг зөв танин мэдэж аж төрөө түүнд зохицуулан тохируулж ирсэний нэгэн баталгаа буюу. Энэ бол нутаг ус, хангай дэлхийгээ хайрлан хамгаалж, уугуул унаган төрхөөр нь байлгах гэсэн эрхэм сайхан уламжлалт эрмэлзэл болохоос биш хүн төрөлхтөн байгалийн өмнө арчаагүй өчүүхэн амьтан байсны нутлагаа биш ажээ. Байгаль дэлхий маань хүний хайр хүндэтгэлийн хариуд өгөөж шимээ хүртээсээр байх өгөөмөр баян зүйл билээ л.

ЛАВШРУУЛАН ҮЗҮҮШТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Mostaert A, **Textes oraux ordos**, Monograph Series № 1, Peip'ing, 1937.

Цэвэл Я, **Малчны календарь, 1945 он**, УБ, (монгол бичгээр)

Chagdarsürüng Ts, **A propos de la météorologie populaire mongole**, EM, Cahier 2, Paris, 1971, pp. 129—134.

МОНГОЛЧУУДЫН УРГАМАЛСУДЛАЛЫН УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГ

Бэлчээрээр мал сүргээ адгуулан өсгөж нүүдэллэн аж төрдөг өвөрмөц амьдрал нэн дээр цагаас монголчуудын өвөг дээдсийг өвс ургамал шинжин таних арга ажиллагаанд эрхгүй сургаж, эхин үедээ идэж хэрэглэх жимс жимсгэний төдийхнөөр хязгаарлагдаж байснаа улмаар тэлж аж төрөх ухааны олон зүйл хэрэгцээнд өвс ургамал, үр жимс, тэдгээрийн үндэс тэргүүтнийг ашиглан хэрэглэх цогц мэдлэгийг бүрдүүлжээ.

Гэвч саяхан болтол дотоод гадаадын зарим судлагчид монголын нүүдэлчин ард түмний буй болгосон өвөрмөц соёл боловсролын өвийг мэдэхгүйн харгаагаар ч юм уу, эсбөгөөс монголыг зүсэн бүрээр муулж л байвал «дээдсийн» таалалд нийцнэ ч гэсэн юм уу зэрлэг буюу хагас зэрлэг байдлаар амь зууж ирсэн монголчууд мах сүүнээс өөр хоол гэдгийг мэддэггүй байсан хэмээж үнэнийг даваадуулсаар ирсэн явдал ч бий.

Дорно дахины түүхэн тэмдэглэлд монголчуудын өвөг-Ухуан нар тариа тарьж байсан тухай мэдээ үлджээ. Бас «Монголын нууц товчоон» хэмээх алдарт зохиолын 74 дүгээр зүйлд л гэхэд бэлэвсрэн үлдсэн Өөлүн Үжин хар нутаг дээрээ гээгдэн хоцорч «өлирсүн мойлсун түүж..., сөдүн гичигинэ ухаж... хөвүүдээ тэжээв... Эх Үжиний халцарсун мангирсунаар тэжээсэн хөвүүд хаад болура хүрэв...» гэж яруухан шүлэглэсэн байдаг билээ л. Бас 1221 онд Монголоос Гуулин хэмээх Солонгос улсад илгээсэн нэгэн албан захидалд эмийн болон будгийн бэрээмүг, гүргэм, шунх зэрэг ургамал хийгээд үрийн тос авдаг байсан тухай баримт байдагийг солонгос хэлээрхи орчуулгаас нь бид саяханаас мэдэх болж байна. Өөр нэгэн зүйлийг энд дурдмаар байна. Монголч эрдэмтэн В. С. Стариков монгол хэлнээ буй газар тариаланд холбогдох нэр томьёоны зүйлийг харьцуулан судлаад монголчууд хийгээд тэдний өвөг дээдсийн эрхлэж байсан газар тариалангийн уламжлал нь дорнодахиныхиас их л ялгаатай бөгөөд өвөрмөц болохыг олж гаргажээ. Сүүлийн үед ч олдож буй эртний судлалын хэрэглэгдэхүүн болон бусад зүйл энэ эрдэмтний дүгнэлтийг улам ч батлаасаар байна.

Энэ бүх баримт сэлтэд үндэслэн монголчуудын ургамалсудлалын уламжлалт мэдлэгийн талаархи нэгтгэсэн хэрэглэгдэхүүн

академич Ринчен профессорын эрхлэн хэвлүүлсэн «Монгол Ард Улсын угсаатны судлал, хэлшинжлэлийн атлас»-ын тэргүүн ботид орж 1980 онд нийтийн хүртээл болсон билээ.

Монголчуудын ургамалсудлалын уламжлалт мэдлэгийг ерөнхийд нь авч үзвэл иддэг ургамал болон үр жимсний зүйл, бэлчээрийн ургамлын зүйл, аж төрөлд хэрэглэх ургамлын зүйл, эмнэлэг эмд хэрэглэх ургамлын зүйл гэж хэдэн том бөлөгт хуваан үзэж болно. Тэгэхдээ бид энд таримал бус, байгалийн унаган төрхөөр нь авч хэрэглэдэг ургамал, үр жимсний талаар ярьж байгаа гэдгээ хэлэх нь зүйтэй юм.

Монголчуудаас *хүнс тэжээлдээ авч хэрэглэдэг ургамал, үр жимсний зүйлийг* дотор нь жимс жимсгэний зүйл, үр будааны зүйл, сонгины төрлийн ургамал, шанцайн ургамал, чихрийн ургамал, цайны ургамал, цардуулт ургамал, тосны ургамал, халуун болон ааг амтат ургамлын зүйл, мөөг гэх зэргээр ангилан хувааж болдог. Энэ бүхнийг нийтэд нь тоолж үзвэл наад зах нь 100 орчим болно. Тэдгээр олон зүйл ургамал, үр жимсийг хүнс хоолондоо дангаар нь буюу хольж, бас мойлтой тос, мэхээртэй тос гэх зэргээр хачир болгож хэрэглэдэг байдал харагдана.

Жилийн дөрвөн улирлын турш монголчууд таван хошуу мал сүргээ бэлчээрээр адгуулан өсгөж ирсэн нь *бэлчээрийн ургамлын* талаар арвин мэдлэгтэй болохын суурь болж өгчээ. Он жилийн саалтад энэ мэдлэг улам нарийссаар ямар ургамал аль улиралд ямар малд хамгийн шим тэжээлтэй болдогийг, мөн ямар ямар ургамал өвөл цагт цасан дор байхдаа ч шимт чанараа алддаггүй болохыг хэдийнээс олж мэдэн аж төрөлдөө хэрэглэсээр иржээ. Энэ нь ч малчин ардуудаас жилийн туршид шутаг ус шилж сонгохдоо газарзүйн тохиромжийн хажуугаар өвс бэлчээрийн өгөөж шимийг айхавтар бодолцдог байсны илрэл юм. Иймд нүүж аж төрнө гэдэг бол олон талын мэдлэгт суурилсан, нарийн бодлоор хөтөлдөг үйл ажиллагаа байснаас биш хэн хүн хаа хамаагүй нүүж бууж явдаг зүйл байгаагүй гэдгийн бас нэгэн нутлагаа нь энэ буюу.

Монголчууд эрт дээр цагаас аж амьдралдаа олон зүйл ургамлыг янз янзаар ашиглан хэрэглэж иржээ. Үүнд: гол өвс, дэрс ,жагма, зэгс, улалж зэргээр сав суулга, дэвсгэр сүлжиж; шүүр туужуу шаах, азуй, бамбай, зээргэнэ зэрэг ургамлаар хамрын тамхи хийх жишээний олон зүйлийг ярьж болно. Энд нэгэн сонирхолтой баримтыг дурдахад эрдэмтэн Ц. Шүгэр авгай «Монголчуудын ном хэвлэдэг арга» гэдэг зохиолдоо далантүрүүгээр цаас хэрхэн хийдэг байсан тухай сонин баримт өгүүлсэнийг анхааран үзмүү. Бас манай монголчууд 80 гаруй өвс ургамал, цэцэг навч, мод зэргээс үндсэн таван өнгийг ялган авч өөр хоороңд нь найрсуулан дуртай өнгөө гарган аж амьдралдаа хэрэглэсээр иржээ. Ургамлаас гарган авдаг будагийн зүйлийг

монголчууд бусад будгийн зүйлээс илүү эрхэмлэдэг байсан нэгэн ёс байжээ. Нэгэн жишээ дурдахад, монгол нутгийн олон газар хэрэглэж байсан цаасан мөнгийг барлахдаа хар бэх, улаан шунхын хажуугаар зарим газарт элбэг баян, дээшлэн хөгжихийн бэлгэдэл хэмээж ар-үрийн ногоон бэхийг эрхэм хэмээж хэрэглэдэг байсан баримт буй билээ.

Монголчуудын уламжлал хүн эмнэлэг, монгол ардын эмнэлэг хийгээд мал эмнэлэгт өвс ургамлаар хийсэн эмийн зүйл нэлээ олныг хэрэглэдэг. Ийм эм тангийн зүйлийг үйлдэж хэрэглэнэгдэг бол захын нэг л өвс ногоогоор хийдэггүй байсан нь мэдээж бөгөөд эмд ордог өвс ургамлын өвөрмөц шинж нь юу болох, ямар эрхтэний ямар өвчинд хэрэг тус болдог, өөр ямар зүйлтэй ямар хэмжээ тунгаар найруулбал тухайн эмийн ид чадал гүйцдэг зэрэг нарийн ширийн зүйлийг сайн мэдсэн байх хэрэгтэй болноо доо. Энэ нарийн ширийн зүйлийг судалсан, бичсэн олон монгол эрдэмтний ном зохиол өдий төдийгөөрөө буй бөгөөд тэр цагийнхаа эрхээр Төв Ази дахинаа ном бичтийн хэл болж байсан төвөд хэлээр үлдэж хоцорсон билээ. Үүнээс үүдэж зарим хүн монгол эмнэлгийн уламжлалыг төвдийнх мэт буруу ойлгож ирсэн явдал ч одоо болтол үргэлжилсээр байгааг хэлэхэд илүүдэхгүй. Монголчуудын уламжлалт анагаах ухааны ном зохиолын дотор зөвхөн Төв Азийн төдийгүй Европ зүгийн ард түмний анагаах ухааны тухайн цагийнхи нь ололт амжилттай танилцаж байсан баримт байдагаас гадна монголын эмч нарын бичиж зохиосон ном, монгол анагаах ухааны нөлөө ялангуяа Төв Азийн бусад улс оронд их байсан явдал бий. Энэ талаар холбогдох бөлөгт товч боловч дурдах болно.

Монгол *оточ* нарын зохиол бүтээлд эмийн ургамлын онцлог шинж чанар, үр нөлөөг тухайн цагт нь авч үзэхэд эмзүйн дээд төвшинд хүрсэн байдал аяндаа харагддаг. Сүмбэ ханба Ишбал жирын эмийн номд 200 гаруй, Найман тойн хэмээн алдаршсан Жамбалдоржийн бүтээлд 300 гаруй ургамлын гаралтай эмийг тодорхойлон бичсэн нь буй. Тухайн цагт нь авч үзэхэд тийм ч цөөдөх тоо биш ээ.

Мэргэжсэн эмч буюу оточ нараас гадна ардын эмнэлгийн хүрээнд манай малчин ардууд нүүдэл амьдралын эрхээр олон жилийн туршилгаар ашигтай хэрэгтэй болохы нь мэдсэн хэдэн зуун ургамлыг зохих зохих өвчин эмгэгт өөрсдийнхөө тогтоол буй болгосон арга, жороор хэрэглэсээр ирсэн билээ. Чухамдаа энэ нь ч үлэмж эртний уламжлалтай бөгөөд монголын гэгдэл өвөрмөц анагаах ухааны үндэс суурь болж өгсөн буй заа.

ЛАВШРУУЛАН ҮЗҮҮШТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Грубов В. И, **Конспект флоры Монгольской Народной Республики,** Труды Монгольской Комиссии, Вып. 67, М. -Л., 1955.

Стариков В. С, **Земледелие у Монголов и вопросы его происхожедния,** - Тезисы докладов научной сессии, посвященной итогам работы Института Этнографии им. Н. Н. Миклухо-Маклая АН СССР (Ленинградское отделение) за 1966 г., Л., 1967, стр. 54—56.

Цэвэл Я, **Монголчуудын хоол хүнсээ бэлтгэн боловсруулах арга барилын тухай,** -ЭС, IV боть, 4 дүгээр дэвтэр, УБ, 1969, 37—78 дахь тал.

Сумьяабаатар Б, **Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд,** УБ, 1975, 22 дахь тал.

Шүгэр Ц, **Монголчуудын ном хэвлэдэг арга,** УБ, 1976.

Ринчен Б, **Монгол Ард Улсын угсаатны судлал, хэлшинжлэлийн атлас,** Тэргүүн, дэд боть, УБ, 1980, 93—149 дүгээр зураг.

Цэвэл Я, **Чин сүзэгт номун хан хутагтын шавь,** -ТС, XXV боть, 13 дугаар дэвтэр, 123—152 дахь тал

МОНГОЛЧУУДЫН УЛАМЖЛАЛТ ЦАГ ТООЛОЛ

Монгол ардын үлгэр туулийн дотор аливаа нэгэн зан үйлийг үйлдэхдээ


«...сарын сайныг саатан хүлээж,
өдрийн сайныг өнжин хүлээж,
өлзий учрал бүрдсэн энэ өдрийг сонгож...»

гэж өгүүлсэн байх нь нэн олон. Үүнээс үзэхүл тухайн зан үйл хийгээд од мичидийн тохиолын шүтэлцээ холбоог айхавтар сайн мэддэг байсныг гэрчлэж байгаа хэрэг болой. Энэ уламжлалыг сүүлийн нэгэн хэсэг үед «шашны зүйл» гэж мартагнуулах бодолго явуулж, нас барж тэнгэрт хальсан хүнийг хүртэл мягмар, бямба, ням гарагт оршуулбал хэдэн төгрөг татуу болгоно гэж «тогтоол» гаргаад «эдийн засгийн арга»-аар шахаж эхлэсэн боловч олон нийтийн эсэргүүцэл дургүйг хүргэж уг тогтоол арга буюу хүчингүй болсон билээ. Ийм олон жишээ баримтын амьд гэрч бол настан хөгшид төдийгүй хүүхэд багачууд маань болсон гэдгийг хэлэхэд юу нь илүүдэх аж.

Бидэнд мэдэгдэж байгаа баттай баримтаар монгол газар гурвантаа шашин ном дэлгэрэхээс бүр өмнө тухайлбал: Хүн (нү) улсын үе буюу манай тооллын өмнөхи III—I зуун гэхэд сар сарын тодорхой хэдэн өдрийг эрхэмлэдэг байсан тухай түүхэнд тэмдэглэж үлдээсэн байдаг. Ингэж өдөр цагийг сонгон үздэг байсан нь нэг талаас одон зурхайн уламжлалт ухаантай, нөгөө талаас нүүдэллэн аж төрж, ажил төрлөө аль илүү зохистой, бүтэмжтэй цагт нь бүтээх гэсэн шаардалгатай холбоотойгоор үүссэн байдал үзэгддэг юм. Тэгээд ч тэр шаардалга нэн эрт цагаас эхлэн цаг тооллын уламжлалт ухааныг нарийсган боловсруулахад түлхэц болж өгсөн нь мэдээж юм.

Монголчуудын зурхайн ухаан буюу одот ертөнцийн шүтэн барилдалгыг судлах ухааны хөгжилд Юан улсын үе онцгой үүрэг гүйцэтгэж тэр цагийнхаа олон улс орны сонгодог мэдлэг ухааныг нэгэн цогц болгох боломцоо нөхцлийг бүрдүүлсэн гэж үзэх үндэстэй юм. Тэгээд ч Монголын их хааны ордноо тэр цагтаа нэр цууд гарсан тоозүйч, одзүйч, зурхайч зэрэг олон эрдэмтэн мэргэд Ази, Европын өдий төдий улс орноос уригдан ирж хуран чуулж ном эрдмийн мөр хөөж суудаг байсан тухай «Юан улсын судар» хийгээд Марко Поло зэрэг жуулчны тэмдэглэлд үлдэж бидэнтэй золгосон баримт тийм ч цөөнгүй.

Юан улсын үед хуучин байсан *Хасын шинжлэлийн оргил* буюу Одон орныг судлах оргилыг шинэчлэн тоноглосон нь тэр үедээ төдийгүй өнөөдөр ч гэсэн мэргэжлийн болон ер энгийн хүмүүсийн анхаарал сонирхлыг татсаар байна.



Юан улсын үед шинэчлэн өргөтгөж тоноглосон Хасын шинжлэлийн оргил

«Юан улсын судар» болон «Гучин зургаат тайлбар толь» зэргээс үзэхэд монголчууд зурхай хийгээд одот тэнгэрийг судлахдаа олон янзын, тэр цагийн төвшиндөө их нарийн багаж хэрэгсэл хэрэглэдэг байжээ. Юан улсын үед гэхэд л:

1. Бүхэл тэнгэрийн дугриг дүрэмт сав,
2. Бүхэл тэнгэрийн одон гарагийг бодож магадлах дүрэмт сав,
3. Хавар намрын хугас дундын нарны сүүдэрийн танхим,
4. Өвөл зуны туйлын нарны сүүдэрийн танхим,
5. Өдөр шөнийн цаг мөчийн дүрэмт сав зэргийг

хэрэглэж байсныг жагсаасан байдаг. Үүнээс өөр ямар ямар багаж байж вэ гэдгийг «Гучин зургаат тайлбар толь»-иос шүүн үзвэл

1. Хасын шинжлэл хэмээх их дуран,
2. Тэнгэрийн дүрэмт сав,
3. Шар замын дүрэмт сав,
4. Жаран даруагийн дүрэмт сав буюу даруа алслах дүрэмт сав,
5. Торин шинжлэлийн одыг тохиолдуулах дүрэмт сав,
6. Сувд эрхилгэ хэмээх тэнгэрийн бөмбөрцөг,
7. Наран хэмнүүр хэмээх нарны цаг,
8. Цагийн хэмнүүр буюу нэгэн зүйл цаг


зэрэг багаж хэрэгсэл лавтайяа байсан ажээ.

Монголчуудын одзүйн ухаан хийгээд зурхайг Уали, М. Тубянский, В. Котвич, А. Мостаерт зэрэг гадаадын олон эрдэмтэн XIX зуунаас эхлэн судалж ном зохиолоо энд тэндгүй нийтлүүлсэн боловч уул судлагдахууны эзэн нь болсон бид нар олж үзэлгүй, олж мэдэлгүй шахуу байсаар их л удсан билээ.

Монгол цаг тооллын тогтолцоог ерөнхийд нь авч үзэхэд Төв Азийн олон ард түмний тоололд байдагтай адил нийтлэг зүйл ч бий, бас бусад орныхоос ялгаатай зүйл ч багагүй гэдгийг тэмдэглээд гол сэдэв рүүгээ орсугай.

Монгол цаг тооллын тогтолцооны хамгийн их нэгж нь галав бөгөөд хамгийн бага нь дэнс буюу $9 \cdot 10^{-5}$ хором (буюу нарийн хувь, үүнийг оросоор секунд хэмээмүй) болно. Дурдсан хоёр туйлын хооронд шаталсан арав гаруй хуваарь байх бөлгөө. Үүнийг бүдүүвч зургаас үзэх ажаамуу. Ингээд цаг тооллын шатласан тогтолцоог товч товч тайлбарлаад, тодруулан үзүүлмээр зүйлийг хялбарчлахын үүднээс хавсралтад оруулав.

МОНГОЛ ЦАГ ТООЛЛЫН ТОГТОЛЦООНЫ БҮДҮҮВЧ



Галав нь дотроо толь галав, эвдэрэхүй галав, хоосон галав, тогтох галав, орших галав, их галав гэж хуваагдана.

1027 оноос Төв Азийн Энэдхэг, Төвөд, Монгол зэрэг олон орны цаг тоололд нийтлэг хэрэглэгдэх болсон, монголоор *ма-*

шид гарсан буюу *сайтар гарсан* гэдэг нэртэй их мөчилгө ч гэдэг, жаран жилийн тоолол ч гэдэг нэгж монгол хуанли буюу цаг тооны тогтолцоонд их үүрэгтэй байдаг билээ. Жаран 1027 оны гал туулай жилээс өдгөө хүртэл явсаар 1986 онд эхний арванзургаан жаран дуусч 1987 оноос XVII жарантай золгосон билээ бид. Нэг жаранд бага мөчилгө хэмээх 12 жил тавантаа тохиолдох тул зөвхөн жилийн махбодтой дурдсан ч өөр тодруулах баримтгүй бол яг төдөн он гэж онооход нэн бэрх байдаг билээ. Жишээлбэл: Ил хаан Авагаас олгосон зар бичгийг туулай жил бичсэн гэж байдаг. Энэ нь хэдэн он гэж тогтоохоод бэрхтэй тул Авага ханы байсан үеийг мэдэх хэрэгтэй болно. Авага хан 1262—1282 онд ширээнд суусан байсан тул энэ хугацаанд туулай жил хоёр удаа, 1267, 1279 онд тус тус тохиолдсон байна. Нэгэнт жилийн өнгө ялгал байхгүй тул уг бичгийг, өөр нутлагаа баримт олдохгүй болж гэм дурдсан хоёр оны аль нэг нь гэж үзэхээс өөр аргагүйд хүрдэг. Гэвч жилийг эш, өнгөтэй нь заасан байхул тийм жил нэг жаранд нэг л тохиолддог бөлгөө. Үүнээс гадна нэг жарны бүх жилд тусгайлан онооосон нэр байдаг нь Төв Азийн олон оронд нийтлэг хэрэглэгддэг. Эл жагсаалтыг хавсралтаас үзмүү.

Монголчуудын цаг тооллын тогтолцоонд бага мөчилгө хэмээх *арванхоёр жил* онцгой үүрэгтэй бөгөөд жаран, бага мөчилгө, жил, өдөр, цаг цөм л энэхүү арванхоёр эрхтэнээс бүрдэл болдог юм. Үүслийн хувьд арванхоёр жилийн тогтолцоо нь Төв Азийн бараг бүх улс оронд нийтлэг дэлгэрсэн байдал харагддаг. Арванхоёр жилийн үүслийн талаар их олон эрдэмтэн судласан бөгөөд лавшруулан нарийвчлаж үзвэл бас ялгаа зөрөө харагддаг. Жишээлбэл: бичгийн уламжлалыг ажиглахад, нангиадын соёлын хүрээнд хамаардаг ард түмэн хийгээд монголчуудын хэрэглэдэг арванхоёртын тооллын нэр: хулгана, үхэр, бар, туулай, луу, могой, морь, хонь, бич, тахиа, нохой, гахай гэдэг нь яг тохирдог боловч нангиад үсгээр өөр өөр ханзаар тэмдэглэдэг байна.

Монголчууд бага мөчилгийн арванхоёр жилээ мод, гал, шороо, төмөр, ус гэдэг таван махбод, мөн арга бэлгийн ялгалаар нийтдээ арван эш болгож нэг их мөчилгө буюу нэг жаранд таван удаа эргэхээр тохируулсан байдаг юм. Ингэхэд дурдсан арванхоёр жилийн хулгана, бар, луу, морь, бич, нохой гэдэг зургаа нь ямагт эр; үхэр, туулай, могой, хонь, тахиа, гахай гэдэг зургаа нь ямагт эм байдаг ажээ. Түүхэн баримт сэлтийг уламжлан үзэхэд Хүн (нү) нарын цаг тоололд арванхоёр жилийн тогтолцоо лав байсан тухай эрдэмтэд нутлан бичиж, түүнийг батлах биет баримт ч олдсон байдаг. Мөн орхоны түрэг бичээсийн дурсгалд лавтайяа 6 нь тэмдэглэгдэн үлдсэн байдаг зэргээс үзэхэд арванхоёр жилийн тоолол их л эрт цагаас Төв Азийн олон улс оронд нийтлэг байсан бололтой.

Хэдхэн мөрийн дээр таван махбодын тухай ярьсан билээ. Одоо түүний чанар, тэмдэг ямар болохыг эшлэн танилцуулваас:

«...Таван махбод нь: нэгдүгээр **усан** хэмээмүй, дорогш шимтэх нь усны чанар болой, тэмдэг нь хүйтэн, өнгө хар. Хоёрдугаар **гал**, дээш нөлүмүй хэмээмүй, тэмдэг насуд халуун, өнгө улаан. Гутгаарт **мод**, муруй шудургуу хэмээмүй, тэмдэг нь бороо орумуй, өнгө хөх. Дөтгөөрт, **төмөр** даамуй халамуй хэмээмүй, тэмдэг нь халуун, онгө цагаан. Тавдугаарт, **шороо** хэмээмүй, шороо төв дундад түмэн бодасыг төрүүлэх нь болой, тэмдэг үргэлж салхи салхиламуй, өнгө шар...»

хэмээж тодорхойлчухуй.

Монгол нутгийн байгаль цаг уурын онцлог зэргээс шалтгаалж *жилийг* хавар, зун, намар, өвөл гэж дөрөв хуваагаад тэрхүү дөрвөн улирлаа эхин, дунд, адаг сар гэж тус бүр гурван сар, нийтдээ арванхоёр сар болгон хуваадаг заншилтай. Сар гэж хуваадаг хуваарь европ дахины хуваарьтай таардаггүй. Үүний учир гэвэл монгол тооллын сар гэдэг хуваарь нь Сарыны явдлыг баримтлан тэргэл сартай өдрийг тухайн сарынхаа 15-ны өдөр болгож тоолдог номтой байсан тул үүндээ зохицуулан тохируулах зорилгоор монголын цаг тооны бичигт аль нэг өдөр тасрах, нэмэх буюу илүү сартай болох явдал зайлшгүй тохиолддогтой холбоотой болой. Монгол зурхайн уламжлалаар зурсан цаг тооны бичиг нь монгол нутгийн онцлогт, гол төлөв Их хүрээний хавийг төв гэж үзэн тохируулан зурдаг байсан тул дорно дахины цаг тоололтой заримдаа нэг хоёр хоногоор зөрөх явдал ч байдаг нь зүйн хэрэг юм.

Үүнээс гадна, бичгийн дурсгал болон аман уламжлалаас үзвэл XIII—XIV зуунд монголчууд сар бүрээ тусгай нэрээр нэрлэж байсныг бид «Монголын нууц товчоон» зэргээс мэдэж болохоос гадна тэрхүү уламжлал одоо болтол буриадад ул мөрөө үлдээснийг Банзарын Дорж бүтээлдээ тэмдэглэсэн бөлгөө.

Бас нэгэн зүйл гэвэл, монгол хэлний нутгийн олон аялгуунд буй сарын нэр, дэс дараах харьцуулан үзэхэд дээр үед монголчуудын цагаан сар намрын адаг, өвлийн эхин сарын заагаар болдог байсан бололтой гэмээр дүгнэлт гардаг бөгөөд улс төрийн шалтгаанаар монголчууд цагаан сараа өөрчилсөн гэдэг аман ярианы уламжлал ч үүнийг нутлаж байгаа юм шиг санагддагаа энэ ташрамд дурдъя.

Монголчуудын цаг тооллын тогтолцооны дараагийн нэгж нь *уур хэм* буюу *хориндөрвөн уур* ч гэдэг, *хориндөрвөн улирал* ч гэдэг тус бүр 15 хоногоос бүрдэл болдог тоолол юм. Жилийг ийнхүү хорин дөрвөн уур хэм болгож хуваасан нь монгол нутгийн цаг уур, аж амьдралын хэм онцлогтой дүйцэн тохирсон хуваарь болж байсан бөлгөө. Жишээлбэл: Ичигсэд хөдлөх улирлын үеэр өвөл ичсэн амьтад нүх ичээндээ хөдлөж, үүнтэй давхцан салхи гарч шороо хөдөлдөг байна. Энэ нь уг улирлын шинж тэмдэг нь болой. Хориндөрвөн уур хэмийн жагсаалт, шинжийг хавсралтаас үзмүү.

Монгол тооллын долоо хоног нь одоогийн нийтийн тоололтой дүйдэг бөгөөд долоон гарагийг даваа, мягмар, лхагва, пүрэв, баасан, бямба, ням гэж төвөдөөр нэрлэхээс гадна гол төлөв судар бичгийн зүйлд сумьяа, ангараг, буд, бархасбади, сугар, санчир, адьяа гэж самгардаар нэрлэдэг ёсон буй. Зарим цаг тооны бичигт долоон гарагаа монголчлож наран, саран, гал, усан, модон, алтан, шороон гараг хэмээн хэрэглэсэн нь ч дайралддаг.

Монгол цаг тооллын ёсоор *хоногт* мөн л 12 цаг буюу 12 эрхтэн байна. Энэ 12 цагийн нэр нь арванхоёр жилийн нэртэй яг дүйнэ, дэс дараа нь мөн адил. Хулгана цаг нь шөнийн 11 цаг буюу 23 цагаас эхлэн дараа өдрийн 1 цаг хүртэл үргэлжилдэг. Шөнө дунд гэдэг бол хулгана цагийн дунд гэсэн үг. Энэ мэтээр одоогийн хоёр цаг тутамд монголчуудын уламжлалт нэг цаг дүйдэг жишээтэй бөлгөө. Үүнд:

Хулгана цаг	— 23—1 цаг
Үхэр цаг	— 1—3 цаг
Бар цаг	— 3—5 цаг
Туулай цаг	— 5—7 цаг
Луу цаг	— 7—9 цаг
Могой цаг	— 9—11 цаг
Морин цаг	— 11—13 цаг
Хонин цаг	— 13—15 цаг
Бэчин цаг	— 15—17 цаг
Тахиа цаг	— 17—19 цаг
Нохой цаг	— 19—21 цаг
Гахай цаг	— 21—23 цаг

Монгол цаг тооллын тогтолцоогоор дараахи нэгжийн хуваарь нь хоёр салаалж *мөц* (буюу 15 минут), *мөч* (буюу 24 минут) болдог. *Мөц* нь цааш цаашаагаа *хувь* (буюу 1 минут), *нарийн хувь* (буюу 1 секунд) болж салбарлана.


Нөгөөхи *мөч* нь *чинлүүр* (буюу 0,4 минут эсвэгөөс 24 секунд), *амьсгал* (буюу 4 секунд), *эгшин* (буюу 0,06 секунд), дэнс (буюу $9 \cdot 10^{-5}$ секунд) гэж цааш цаашаа салбарлах бөгөөд энэхүү салааг зурхайн ухаанд голдуу хэрэглэж байжээ.

Монгол он тооллын тогтолцоо нь хэдийгээр сарны явдлыг баримтладаг боловч нарны явдлыг огт мэддэггүй байсан гэж хэлэх аргагүй. Жишээлэхэд Европ дахинаа ихэд дэлгэрсэн Зодиак хэмээх, нарны 12 гэрт оноосон монгол нэр байсныг монгол цаг тооны бичиг буюу хуанлигаас үзэж болно. Үүнд:

Хонины орд
Үхэрийн орд
Хамтадахын орд
Наймалжийн орд буюу Хархатаны гэр
Арслангийн орд
Охины орд
Хилэнцийн орд эсвэл хувилгааны гэр буюу Тиларийн орд
Жинлүүрийн орд

Нумны орд
Матарын орд
Хумхын орд
Загасны орд.

Монгол цаг тооллын тогтолцоон дээр үндэслэж манай зурхайч нар 1235 он гэхэд «Цаг улирлын тооны бичиг» зохиож байж, сүүлийн үед гол төлөв Их хүрээний хавь газрыг төв болгож жил бүрийн хуанли буюу цаг тооны бичгийг зохион бүрлаж тархаадаг байжээ.



Монгол улсын Олонаа Өргөгдсөний IV оны «Цаг улирлын тооны бичиг»-ийн нэгэн хуудасны гэрэл зураг

Монголын «Цаг улирлын тооны бичиг»-ийг үзэхэд тухайн жилийн сар, өдөр бүрийг өнгө, эш, махбодоор нь тодорхойлоод зогсохгүй наран ургах, шингэх цаг, өдөр болон шөнийн үргэлжлэх цаг хугацааг маш нарийн тоочин гаргасан байдаг.


Бас нэгэн зүйл гэвэл, орчин цагийн хуанлид байдагчлан тэмдэглэлт өдрийг жагсаан дурдсан байх нь монгол ардын уламжлалт ёс, шашин суртаалын жаяг дэгтэй нягт холбоотой байдаг билээ л. Ганц нэг жишээг татсугай.

> «...Монголын нэгдүгээр сарын...шинийн 1-ээс 15 хүртэл Бурхан-баар рид хувилгаан үзүүлсэн цаг... ...Монголын дөрөвдүгээр сар... шинийн 7-нд Бурхан мэндэлсэн хийгээд 15-нд илтэд тугуулсан ба гаслангаас нөгчигсөн цаг...»

гэх зэрэг болой.

Монгол зурхайн ухаанд энэдхэг төвөдийн эрдэмтэн мэргэдийн зохиол бүтээлээс гадна нангиадын зурхайн гол бүтээл «Хас хуурцаг нэрт бичиг», «Солбицон барих бодрол бичиг»

зэрэг номыг орчуулан монголчлож хэрэглээд зогсохгүй нарийвчлан боловсруулж, тусгай тайлбар бичиж байсан монголын зурхайч нар тийм ч цөөнгүй байжээ.



«Солбицон барих бодрол бичиг»-ийн монгол барын нэг хуудас

Монголын тоозүйч, зурхайч, эрдэмтдийн бүтээл, онол нь гол төлөв төвөд хэлээр байсан тул Төв Азийн олон ард түмний оюун билигийн их өв санд багагүй нөлөө үзүүлсэн гэдгийг франц, хятад, японы эрдэмтэд ном зохиолдоо тэмдэглэжээ. Монголын эрдэмтэн, их тоозүйч Мянгат (1685—1770) европ дахины их эрдэмтэн Н. Коперник, И. Ньютон, И. Кеплер, Ж. Кассини, Т. Браге нарын бүтээлийг судалж Дорно дахинд танилцуулах гүүр болсноос гадна тоозүйн салбарт «Тоозүйн хуулийн нарийн хуримтлал», «Тойргийг огтлож 2 дугаар тоог олох хялбар арга», одон орны судалгаагаар «Цаг улирлын үзэгдлийг шалгаж бүтээсний дараахи найруулал» гэдэг нөр их ажил, хүчин чармайлт, цаг хугацаа шаардсан зохиолоо хятад хэлээр бичсэн нь Дорно зүгийн тоо, одзүйн ухаан хөгжихөд их нөлөө болсон гэж судлагчид өндөр үнэлжээ.

Бас Сумбэ хамба Ишбалжир (1704—1788) монгол зурхайн уламжлалд шинэ онол үүсгэж гараг одны явдлыг шинжлэн зурах өвөрмөц аргыг нээсэн зохиолоо, зурхайч Өвгөнхүү (XIX-XX зуун) «Солбицон барих бодрол бичиг»-т тайлбар хийсэн зохиолоо, түүний нэг нутгийн зурхайч Түшээт ханы Жамбалшарав (XX зууны эх) наран, саран, одны явдлыг нарийвчлан

судалсан бүтээлээ төвөд хэлээр тус тус туурвисныг, ийм олон хүний зохиол дотроос сорлон дурдаж болно.

Сая бид нарийн мэргэжлийн эрдэмтэн, зурхайч нарын талаар ярилаа. Үүний хажуугаар монголчуудын иргэний мэдлэгийн дотор хэлбичиг, тоо бодолгын ухаан хоёр гол суурийг эзэлж ирсэн билээ. Тоо бодолгын хүрээнд гар хуруугаар тоолон сурахаас эхлээд цээжээр бодох, сампингаар бодох, зурж бодох, зурхайн самбар дээр бодох зэрэг арга багачуудыг сургадаг байжээ. Үүнд: «9 арилгах», «27 арилгах», «67 арилгах», «707 арилгах» зэрэг монгол зурхайн анхны дадалга олгох аргыг заадаг уламжлал тогтсон байсан гэдэг.

Монгол хэлний үгийн санд тоозүйн холбогдол бүхий *эх тоо, хүү тоо, төв хөвч* (буюу косинус), *өлгүү хөвч* (синус), *өлгүү шахах хямцаа* (тангенс), *төв шахах хямцаа* (котангенс) гэх зэрэг олон нарийн нэр томьёо уламжилсаар байсныг монголчуудын тоозүйн мэдлэгэтэй уялдсан баримт гэхээс өөр хэрхэх билээ. Монголчууд тооны нэрийг аравтын тогтолцоогоор нэг, арав, зуу, мянга, түм, бум, сая, живаа, дүнчүүр гэх зэргээр 10^{66} оронтой тоог нэрлэдэг тустай нэртэй байдаг нь бас л нэгэн хэлүүштэй зүйл болой.

Ингээд энэ бөлгийн эцэст монгол ардынхаа цээж бодолгын нэгэн жишээг бодуулсу:

> Хэсэг галуу нисч явтал нэг галуу дайралдаад «зуун галуу сайн явж байна уу? гэхэд тэдний нэг нь «бид зуу биш ээ. Бидэн дээр бидний нэмээд, түүний дээр бидний хагасыг нэмээд, бас хагасын хагасыг нэмж, дээр нь чамайг нэмбэл сая зуу болно» гэжээ. Хэдэн галуу нисч явсан бэ?
> (хариу буюу хүү тоо: 36)

Монгол жараны он дараалсан нэр, түүнийг нийтийн тоололтой дүйлгэсэн жагсаалт

01. Гал буюу улаагчин туулай жил.

Машид гарсан, сайтур гарсан,

1027, 1087, 1147, 1207, 1267, 1327, 1387, 1447, 1507, 1567,
1627, 1687, 1747, 1807, 1867, 1927, 1987, 2047, 2107, 2167,

02. Шороо буюу шар луу жил,
Тийн гарсан

1028, 1088, 1148, 1208, 1268, 1328, 1388, 1448, 1508, 1568,
1628, 1688, 1748, 1808, 1868, 1928, 1988, 2048, 2108, 2168,

03. Шороо буюу шарагчин могой жил.
Цагаан,

1029, 1089, 1149, 1209, 1269, 1329, 1389, 1449, 1509, 1569,
1629, 1689, 1749, 1809, 1869, 1929, 1989, 2049, 2109, 2169,

04. Төмөр буюу цагаан морин жил,
Маш соргонги.

1030, 1090, 1150, 1210, 1270, 1330, 1390, 1450, 1510, 1570,
1630, 1690, 1750, 1810, 1870, 1930, 1990, 2050, 2110, 2170,

05. Төмөр буюу цагаагчин хонин жил,
Төрлийн эзэн, төрөлхтөний эзэн,

1031, 1091, 1151, 1211, 1271, 1331, 1391, 1451, 1511, 1571,
1631, 1691, 1751, 1811, 1871, 1931, 1991, 2051, 2111, 2171,

06. Усан буюу хар бэчин жил.
Муу биет,

1032, 1092, 1152, 1212, 1272, 1332, 1392, 1452, 1512, 1572,
1632, 1692, 1752, 1812, 1872, 1932, 1992, 2052, 2112, 2172,

07 Усан буюу харагчин тахиа жил,
Цог нүүрт,

1033, 1093, 1153, 1213, 1273, 1333, 1393, 1453, 1513, 1573,
1633, 1693, 1753, 1813, 1873, 1933, 1993, 2053, 2113, 2173,

08 Модон буюу хөх нохой жил,
Хөх, бодь,

1034, 1094, 1154, 1214, 1274, 1334, 1394, 1454, 1514, 1574,
1634, 1694, 1754, 1814, 1874, 1934, 1994, 2054, 2114, 2174,

09 Модон буюу хөхөгчин гахай жил,
Идэр төгөлдөр, нас төгөлдөр,

1035, 1095, 1155, 1215, 1275, 1335, 1395, 1455, 1515, 1575,
1635, 1695, 1755, 1815, 1875, 1935, 1995, 2055, 2115, 2175,

10. Гал буюу улаан хулгана жил,
Баригч,

1036, 1096, 1156, 1216, 1276, 1336, 1396, 1456, 1516, 1576,
1636, 1696, 1756, 1816, 1876, 1936, 1996, 2056, 2116, 2176,

11. Гал буюу улагчин үхэр жил,
Эрхэт,

1037, 1097, 1157, 1217, 1277, 1337, 1397, 1457, 1517, 1577,
1637, 1697, 1757, 1817, 1877, 1937, 1997, 2057, 2117, 2177,

12. Шороо буюу шар барс жил,
Олон үет, олон үрт,

1038, 1098, 1158, 1218, 1278, 1338, 1398, 1458, 1518, 1578,
1638, 1698, 1758, 1818, 1878, 1838, 1998, 2058, 2118, 2178,

13. Шороо буюу шарагчин туулай жил,
Согтах төгөлдөр,

1939, 1099, 1159, 1219, 1279, 1339, 1399, 1459, 1519, 1579,
1639, 1699, 1759, 1819, 1879, 1939, 1999, 2059, 2119, 2179,

14. Төмөр буюу цагаан луу жил,
Баатар, тийн дарагч,

1040, 1100, 1160, 1220, 1280, 1340, 1400, 1460, 1520, 1580,
1640, 1700, 1760, 1820, 1880, 1940, 2000, 2060, 2120, 2180,

15. Төмөр буюу цагаагчин могой жил,
Сүргийн манлай,

1041, 1101, 1161, 1221, 1281, 1341, 1401, 1461, 1521, 1581,
1641, 1701, 1761, 1821, 1881, 1941, 2001, 2061, 2121, 2181,

16. Уеан буюу хар морин жил
Элдэв,

1042, 1102, 1162, 1222, 1282, 1342, 1402, 1402, 1522, 1582,
1642, 1702, 1762, 1822, 1882, 1942, 2002, 2062, 2122, 2182,

17. Усан буюу харагчин хонин жил,
Наран,

1043, 1103, 1163 1223, 1283, 1343, 1403, 1463, 1523, 1583,
1643, 1703, 1763, 1823, 1883, 1943, 2003, 2063, 2123, 2183,

18. Модон буюу хөх бэчин жил,
Нараан гэтэлгэгч

1044, 1104, 1164, 1224, 1284, 1344, 1404, 1464, 1524, 1584,
1644, 1704, 1764, 1824, 1884, 1944, 2004, 2064, 2124, 1284,

19. Модон буюу хөхөгчин тахиа жил,
Газар тэтгэгч,

1045, 1105, 1165, 1225, 1285, 1345, 1405, 1465, 1525, 1585,
1645, 1705, 1765, 1825, 1885, 1945, 2005, 2065, 2125, 2185,

20. Гал буюу улаан нохой жил,
Барашгүй, барагдахгүй,

1046, 1106, 1166, 1226, 1286, 1246, 1460, 1466, 1526, 1586,
1646, 1706, 1766, 1826, 1886, 1946, 2006, 2066, 2126, 2186,

21. **Гал буюу улагчин гахай жил,**
Хамгийн номхотгогч,

1047, 1107, 1167, 1227, 1287, 1347, 1407, 1467, 1527, 1587,
1647, 1707, 1767, 1827, 1887, 1947, 2007, 2067, 2127, 2187,

22. **Шороо буюу шар хулгана жил,**

Хотолыг баригч,

1048, 1108, 1168, 1228, 1288, 1348, 1408, 1468, 1528, 1588,
1648, 1708, 1768, 1828, 1888, 1948, 2008, 2068, 2128, 2188,

23. **Шороо буюу шарагчин үхэр жил,**
харшлалт,

1049, 1109, 1169, 1229, 1289, 1349, 1409, 1469, 1529, 1589,
1649, 1709, 1769, 1829, 1889, 1949, 2009, 2069, 2129, 2189,

24. **Төмөр буюу цагаан барс жил,**
Тийн урвагч,

1050, 1110, 1170, 1230, 1290, 1350, 1410, 1470, 1530, 1590,
1650, 1710, 1770, 1830, 1890, 1950, 2010, 2070, 2130, 2190,

25. **Төмөр буюу цагаагчин туулай жил,**

Эляжигэ,

1051, 1111, 1171, 1231, 1291, 1351, 1411, 1471, 1531, 1591,
1651, 1711, 1771, 1831, 1891, 1951, 2011, 2071, 2131, 2191,

26. **Усан буюу хар луу жил,**

Баясгалан

1052, 1112, 1172, 1232, 1292, 1352, 1412, 1472, 1532, 1592,
1652, 1712, 1772, 1832, 1892, 1952, 2012, 2072, 2132, 2192,

27. Усан буюу харагчин могой жил,

Тийн ялгуулагч, тийн ялгуусан,

1053,	1113,	1173,	1233,	1293,	1353,	1413,	1473,	1533,	1593,
1653,	1713,	1773,	1833,	1893,	1953,	2013,	2073,	2133,	2193,

28. Модон буюу хөх морин жил,

Ялгуусан,

1054,	1114,	1174,	1234,	1294,	1354,	1414,	1474,	1534,	1594,
1654,	1714,	1774,	1834,	1894,	1954,	2014,	2074,	2134,	2194,

29. Модон буюу хөхөгчин хонин жил,

Галзууруулагч,

1055,	1115,	1175,	1235,	1295,	1355,	1415,	1475,	1535,	1595,
1655,	1715,	1775,	1835,	1895,	1955,	2015,	2075,	2135,	2195,

30. Гал буюу улаан бэчин жил,

Муу нүүрт,

1056,	1116,	1176,	1236,	1296,	1356,	1416,	1476,	1536,	1596,
1656,	1716,	1776,	1836,	1896,	1956,	2016,	2076,	2136,	2196,

31. Гал буюу улагчин тахиа жил,

Алтан унжилгат,

1057,	1117,	1177,	1237,	1297,	1357,	1417,	1477,	1537,	1597,
1657,	1717,	1777,	1837,	1897,	1957,	2017,	2077,	2137,	2197,

32. Шороо буюу шар **нохой жил,**

Тийн унжилгат,

1058,	1118,	1178,	1238,	1298,	1358,	1418,	1478,	1538,	1598,
1658,	1718,	1778,	1838,	1898,	1958,	2018,	2078,	2138,	2198,

33. Шороо буюу шарагчин гахай **жил,**

Урвуулагч

1059,	1119,	1179,	1239,	1299,	1359,	1419,	1479,	1539,	1599,
1659,	1719,	1779,	1839,	1899,	1959,	2019,	2079,	2139,	2199,

34. Төмөр буюу цагаан хулгана жил,

Хотол төгс,

1060,	1120,	1180,	1240,	1300,	1360,	1420,	1480,	1540,	1600,
1660,	1720,	1780,	1840,	1900,	1960,	2020,	2080,	2140,	2200,

35. Төмөр буюу цагаагчин үхэр жил ,

Цөөвөр,

1061,	1121,	1181,	1241,	1301,	1361,	1421,	1481,	1541,	1601,
1661,	1721,	1781,	1841	1901,,	1961,	2021,	2081,	2141,	2201,

36. Усан буюу хар барс жил,

Буян үйлдэгч, сайжруулагч,

1062,	1122,	1182,	1242,	1302,	1362,	1422,	1482,	1542,	1602,
1662,	1722,	1782,	1842,	1902,	1962,	2022,	2082,	2142,	2202,

37. Усан буюу харагчин туулай жил,

Үзэсгэлэн болгогч,

1063, 1123, 1183, 1243, 1303, 1363, 1423, 1483, 1543, 1603,
1663, 1723, 1783, 1843, 1903, 1963, 2023, 2083, 2143, 2203,

38. Модон буюу хөх луу жил.
Хилинт эх, хилинт эм,

1064, 1124, 1184, 1244, 1304, 1364, 1424, 1484, 1544, 1604,
1664, 1724, 1784, 1844, 1904, 1964, 2024, 2084, 2144, 2204,

39. Модон буюу хөхөгчин могой жил,
Элдэв эрдэнэт,

1065, 1125, 1185, 1245, 1305, 1365, 1425, 1485, 1545, 1605,
1665, 1725, 1785, 1845, 1905, 1965, 2025, 2085, 2145, 2205,

40. Гал буюу улаан морин жил,
Сүрээр дарагч,

1066, 1126, 1186, 1246, 1306, 1366, 1426, 1486, 1546, 1606,
1666, 1726, 1786, 1846, 1906, 1966, 2026, 2086, 2146, 2206,

41. Гал буюу улагчин хонин жил,
Бэчин,

1067, 1127, 1187, 1247, 1307, 1367, 1427, 1487, 1547, 1607,
1667, 1727, 1787, 1847, 1907, 1967, 2027, 2087, 2147, 2207,

42. Шороо буюу шар бэчин жил,
Гадас

1068, 1128, 1188, 1248, 1308, 1368, 1428, 1488, 1548, 1608,
1668, 1728, 1788, 1848, 1908, 1968, 2028, 2088, 2148, 2208,

43. Шороо буюу шаргачин тахиа жил,
Амурлингуй,

1069, 1129, 1189, 1249, 1309, 1369, 1429, 1489, 1549, 1609,
1669, 1729, 1789, 1849, 1909, 1969, 2029, 2089, 2149, 2209,

44. Төмөр буюу цагаан нохой жил,
Ерд, ерөнхий

1070, 1130, 1190, 1250, 1310, 1370, 1430, 1490, 1550, 1610,
1670, 1730, 1790, 1850, 1910, 1970, 2030, 2090, 2150, 2210,

45. Төмөр буюу цагаагчин гахай жил,
ангижрагч, харшлагч,

1071, 1131, 1191, 1251, 1311, 1371, 1431, 1491, 1551, 1611,
1671, 1731, 1791, 1851, 1911, 1971, 2031, 2091, 2151, 2211,

46. Усан буюу хар хулгана жил,
Огоот баригч, бүхнийг баригч,

1072, 1132, 1192, 1252, 1312, 1372, 1432, 1492, 1552, 1612,
1672, 1732, 1792, 1852, 1912, 1972, 2032, 2092, 2152, 2212,

47. Усан буюу харагчин үхэр жил,
Сэрэмжгүй,

1073, 1133, 1193, 1253, 1313, 1373, 1433, 1493, 1553, 1613,
1673, 1733, 1793, 1853, 1913, 1973, 2033, 2093, 2153, 2213,

48. Модон буюу хөх барс жил,

Хотол баясгалан

1074, 1134, 1194, 1254, 1314, 1374, 1434, 1494, 1554, 1614,
1674, 1734, 1794, 1854, 1914, 1974, 2034, 2094, 2154, 2214,

49. Модон буюу хөхөгчин туулай жил,
Мангас.

1075, 1135, 1195, 1255, 1315, 1375, 1435, 1495, 1555, 1615,
1675, 1735, 1795, 1855, 1915, 1975, 2035, 2095, 2155, 2215,

---

50. Гал буюу улаан луу жил,
Гал,

1076, 1136, 1196, 1256, 1316, 1376, 1436, 1496, 1556, 1616,
1676, 1736, 1796, 1856, 1916, 1976, 2036, 2096, 2156, 2216,

51. Гал буюу улагчин могой жил,
Улбар шарт,

1077, 1137, 1197, 1257, 1317, 1377, 1437, 1497, 1557, 1617,
1677, 1737, 1797, 1857, 1917, 1677, 2037, 2097, 2157, 2217,

52. **Шороо буюу шар морин жил,**
Цагийн зардасун, цагийн элч,

1079, 1138, 1198, 1258, 1318, 1378, 1438, 1498, 1558, 1618,
1078, 1738, 1798, 1858, 1918, 1978, 2038, 2098, 2158, 2218,

53. **Шороо буюу шарагчин хонин жил,**
Тус бүтээгч,

1079, 1139, 1199, 1259, 1319, 1379, 1439, 1499, 1559, 1619,
1079, 1739, 1799, 1859, 1919, 1979, 2039, 2099, 2159, 2219,

54. **Төмөр буюу цагаан бэчин жил,**
Догшин,

1080, 1140, 1200, 1260, 1320, 1380, 1440, 1500, 1560, 1620,
1680, 1740, 1800, 1860, 1920, 1980, 2040, 2100, 2160, 2220,

55. **Төмөр буюу цагаагчин тахиа жил,**
Муу оюут

1081, 1141, 1201, 1261, 1321, 1381, 1441, 1501, 1561, 1621,
1681, 1741, 1801, 1861, 1921, 1981, 2041, 2101, 2161, 2221,

56. **Усан буюу хар нохой жил,**
Их хэнгэргэ, их хүүргэ,

1082, 1142, 1202, 1262, 1322, 1382, 1442, 1502, 1562, 1622,
1682, 1742, 1802, 1862, 1922, 1982, 2042, 2102, 2162, 2222,

57. **Усан буюу харагчин гахай жил,**
Цусан бөөлжигч,

1083, 1143, 1203, 1263, 1323, 1383, 1443, 1503, 1563, 1623,
1683, 1743, 1803, 1863, 1923, 1983, 2043, 2103, 2163, 2223,

58. **Модон буюу хөх хулгана жил,**
Улаан нүдэн,

1084,	1144,	1204,	1264,	1324,	1384,	1444,	1504,	1564,	1624,
1684,	1744,	1804,	1264,	1924,	1984,	2044,	2104,	2164,	2224,

59. Модон буюу хөхөгчин үхэр жил,
Хилэнт,

1085,	1145,	1205,	1265,	1325,	1385,	1445,	1505,	1565,	1625,
1685,	1745,	1805,	1865,	1925,	1985,	2045,	2105,	2165,	2225,

60. Гал буюу улаан барс жил,
Барагдах, барагдагч,

1086,	1146,	1206,	1266,	1326,	1386,	1446,	1506,	1566,	1626.
1686,	1746,	1806,	1866,	1926,	1986,	2046,	2106,	2166,	2226.

Жич: Жарангийн жил жилийн нэрийн тухайд заримдаа утга ойролцоо боловч өөр үгээр оноосон хэрэглэгдэхүүн дайралдаж болзошгүй бөгөөд бид энд голдуу барын ном зохиолоос авсан гэдгээ тэмдэглэсэү. Хошоод янзаар нэрлэдэг жилийн нэрийн дунд нь таслал талбив.

Монгол жарны таваи махбод хийгээд арга бэлгийн ялгал

№	Арванхоёр жил	I мөчилгө	II мөчилгө	III мөчилгө	IV мөчилгө	V мөчилгө
01	Туулай	улаагчин	шарагчин	цагаагчин	харагчин	хөхөгчин
02	Луу	шар	цагаан	хар	хөх	улаан
03	Могой	шарагчин	цагаагчин	харагчин	хөхөгчин	улагчин
04	Морь	цагаан	хар	хөх	улаан	шар
05	Хонь	цагаагчин	харагчин	хөхөгчин	улагчин	шарагчин
06	Бэч	хар	хөх	улаан	шар	цагаан
07	Тахиа	харагчин	хөхөгчин	улагчин	шарагчин	цагаагчин
08	Нохой	хөх	улаан	шар	цагаан	хар
09	Гахай	хөхөгчин	улагчин	шарагчин	цагаагчин	харагчин

10	Хулгана	улаан	шар	цагаан	хар	хөх
11	Үхэр	улагчин	шарагчин	цагаагчин	харагчин	хөхөгчин
12	Бар	шар	цагаан	хар	хөх	улаан

Жич: тэмдэглэх учир:

1. **Таван махбод:** Модон — **хөх**, хөхөгчин;
   гал — улаан, улаагчин;
   Шороо — шар, шарагчин;
   Төмөр — цагаан, цагаагчин;
   Усан — хар, харагчин.
2. **-чин дагавар** нь энд ямагт бэлгэ буюу эмийг заадаг болохыг анхаарму.

ХОРИНДӨРВӨН УУР ХЭМ БУЮУ ХОРИНДӨРВӨН УЛИРЛЫН ЖАГСААЛТ

1. **Хаврын уур** буюу хаврын тэргүүн сарын амьсгал.
   Аргын тооллын 2-р сарын 4—5-ны орчим.
   Шинж нь: Цас мөс хөлрөн **хайлж**, гол мөрний мөс ханзарна.
2. **Хур усны цаг, үндэсний үер** буюу хаврын тэргүүн сарын дунд.
   Аргын тооллын 2-р сарын 19—20-ны орчим.
   Өдрийн урт: 26 мөч, 40 чинлүүр,
   Шөнийн урт: 33 мөч, 20 чинлүүр.
   Наран ургах цаг: туулай цагийн V мөчийн 11 чинлүүр.
   Наран шингэх цаг: тахиа цагийн I мөчийн 50 чинлүүр.
3. **Ичигсэд хөдөлмүй** буюу хаврын дунд сарын амьсгал.
   Аргын тооллын 3-р сарын 5—6-ны орчим.
   Шинж нь: ичсэн амьтад үүр ичээндээ хөдлөж, салхи шороо гарна.
4. **Хаврын дундуур, хаврын хугас** буюу хаврын дунд сарын дунд.
   Аргын тооллын 3-р сарын 20—21-ний орчим.
   Өдөр шөнө тэнцэнэ.
   Өдрийн урт: 30 мөч.
   Шөнийн урт: 30 мөч.
   Наран ургах цаг: туулай цагийн III мөчийн 31 чинлүүр.
   Наран шингэх цаг: тахиа цагийн III мөчийн 30 чинлүүр.
5. **Нээсэн ханш** буюу хаврын сүүл сарын амьсгал.
   Аргын тооллын 4-р сарын 5—6-ны орчим.
   Шинж нь: мод бургас гөлөглөнө. Мод тарих цаг.
6. **Тариалангийн хур** буюу хаврын сүүл сарын дунд.
   Аргын тооллын 4-р сарын 20-21-ний орчим.
   Газар хагалж тариа тарих цаг.
   Өдрийн урт: 33 мөч 20 чинлүүр,
   Шөнийн урт: 26 мөч 40 чинлүүр.
   Наран ургах цаг: туулай цагийн I мөчийн 51 чинлүүр.
   Наран шингэх цаг: тахиа цагийн V мөчийн 10 чинлүүр.
7. **Зуны уур** буюу зуны тэргүүн сарын амьсгал.
   Аргын тооллын 5-р сарын 6—7-ны орчим.
   Шинж нь: Хөхөө донгодмуй.
8. **Өчүүхэн дүүрэн** буюу зуны тэргүүн сарын дунд.
   Аргын тооллын 5-р сарын 21—22-ын орчим.
   Нохойн хошуу цэцэглэмүй.
   Өдрийн урт: 36 мөч 40 чинлүүр,
   Шөнийн урт: 23 мөч 20 чинлүүр.
   Наран ургах цаг: бар цагийн V мөчийн 11 чинлүүр.
   Наран шингэх цаг: нохой цагийн I мөчийн 50 чинлүүр.
9. **Их дүүрэн** буюу зуны дунд сарын амьсгал.
   Аргын тооллын 6-р сарын 7—8-ны орчим.
   Шинж нь буудай боловсормуй.
10. **Зуны туйл** буюу зуны дунд сарын дунд.
    Аргын тооллын 6-р сарын 21—22-ын орчим.
    Нар буцна.
    Өдрийн урт: 40 мөч.
    Шөнийн урт: 20 мөч.
    Наран ургах цаг: бар цагийн III мөчийн 31 чинлүүр.
    Наран шингэх цаг: нохой цагийн III мөчийн 30 чинлүүр.

11. **Бага халуун, өчүүхэн халуун** буюу зуны сүүл сарын амьсгал.
Аргын тооллын 7-р сарын 7—8-ны орчим.
Эл 15 хоногт гол мөрний усанд орохыг тэвчих.

12. **Их халуун** буюу зуны сүүл сарын дунд.
Аргын тооллын 7-р сарын 23—24-ний орчим.
Өдрийн урт: 36 мөч 40 чинлүүр.
Шөнийн урт: 23 мөч 20 чинлүүр.
Наран ургах цаг: бар цагийн V мөчийн 11 чинлүүр.
Наран шингэх цаг: нохой цагийн I мөчийн 50 чинлүүр.

13. **Намрын уур** буюу намрын тэргүүн сарын амьсгал.
Аргын тооллын 8-р сарын 8—9-ний орчим.
Шинж нь: нүүдлийн шувууд ганганахаа болино.

14. **Сэрүүний цаг, халуун эгэмүй** буюу намрын тэргүүн сарын дунд.
Аргын тооллын 8-р сарын 23—24-ний орчим.
Өдрийн урт: 33 мөч 20 чинлүүр.
Шөнийн урт: 26 мөч 40 чинлүүр.
Наран ургах цаг: туулай цагийн I мөчийн 51 чинлүүр.
Наран шингэх цаг: тахиа цагийн V мөчийн 10 чинлүүр.

15. **Цагаан шүүдэр** буюу намрын дунд сарын амьсгал.
Аргын тооллын 9-р сарын 8—9-ний орчим.
Шинж нь: хяруу унаж, сэрүү амьсана.

16. **Намрын дундуур, намрын хугас** буюу намрын дунд сарын дунд.
Аргын тооллын 9-р сарын 23—24-ний орчим.
Шинж нь: өдөр шөнө тэнцэж, мод шарлана.
Өдрийн урт: 30 мөч.
Шөнийн урт: 30 мөч.
Наран ургах цаг: туулай цагийн III мөчийн 31 чинлүүр.
Наран шингэх цаг: тахиа цагийн III мөчийн 31 чинлүүр.

17. **Хүйтэн шүүдэр** буюу намрын сүүл сарын амьсгал.
Аргын тооллын 10-р сарын 8—9-ны орчим.
Шинж нь тэнгэрийн дуу хаяалдана.

18. **Хяруу унамуй** буюу намрын сүүл сарын дунд.
Аргын тооллын 10-р сарын 23—24-ний орчим.
Шинж нь: нүүдлийн шувуу буцна.
Өдрийн урт: 26 мөч 40 чинлүүр.
Шөнийн урт: 33 мөч 20 чинлүүр.
Наран ургах цаг: туулай цагийн V мөчийн 11 чинлүүр.
Наран шингэх цаг: тахиа цагийн I мөчийн 50 чинлүүр.

19. **Өвлийн уур** буюу өвлийн тэргүүн сарын амьсгал.
Аргын тооллын 11-р сарын 7—8-ны орчим.
Шинж нь: Хүйтэрнэ. Гол ус захаасаа хөлдөнө.

20. **Бага цас, өчүүхэн цас** буюу өвлийн тэргүүн сарын дунд.
Аргын тооллын 11-р сарын 22—23-ны орчим.
Өдрийн урт: 23 мөч 20 чинлүүр.
Шөнийн урт: 36 мөч 40 чинлүүр.
Наран ургах цаг: луу цагийн I мөчийн 51 чинлүүр.
Наран шингэх цаг: бэчин цагийн V мөчийн 10 чинлүүр.

21. **Их цас** буюу өвлийн дунд сарын амьсгал.
Аргын тооллын 12-р сарын 7—8-ны орчим.
Шинж нь: хүйт чангарна.

22. **Өвлийн туйл** буюу өвлийн дунд сарын дунд.
Аргын тооллын 12-р сарын 21—22-ны орчим.
Ес эхлэнэ. Ан амьтны сор гүйцэнэ.
Өдрийн урт: 20 мөч.

Шөнийн урт: 40 мөч.
Наран ургах цаг: луу цагийн III мөчийн 31 чинлүүр.
Наран шингэх цаг: бэчин цагийн III мөчийн 30 чинлүүр.

23. **Бага хүйтэн, өчүүхэн хүйтэн** буюу өвлийн сүүл сарын амьсгал.
Аргын тооллын 1-р сарын 6—7-ны орчим.

24. **Их хүйтэн** буюу өвлийн сүүл сарын дунд.
Аргын улирлын 1-р сарын 20—21-ний орчим.
Шинж нь: хүйтний эрч нугарна.
Өдрийн урт: 23 мөч 20 чинлүүр.
Шөнийн урт: 36 мөч 40 чинлүүр.
Наран ургах цаг: луу цагийн I мөчийн 51 чинлүүр.
Наран шингэх цаг: бэчин цагийн V мөчийн 10 чинлүүр.

Хавсралт 4.

ХОРИННАЙМАН ОДНЫ МОНГОЛ НЭРИЙН ЖАГСААЛТ

1. Хатгалдагч тэнгэрийн үүд одон буюу Хэртэг,
2. Баян хүнийг үгүйрүүлэгч одон буюу Рогини,
3. Шулуун өнгө зөөлөн одон буюу Маргишар,
4. Усанд алдсан шумнасын одон буюу Ардар,
5. Жуулчны мөр тэтгэгч одон буюу Бурнавасу,
6. Ганц өнчин улсын эзэн одон буюу Бус,
7. Өрнө умрын шижим одон буюу Аслиг,
8. Албины дээрэмч одон буюу Миг,
9. Хашгирахуй цөөвөр одон буюу Бурвабалгуни,
10. Үхээр хар зардасун одон буюу Ударибалгуни,
11. Галт торгон эргихүй модон одон буюу Хаст,
12. Бугын эврийн агуй одон буюу Цайитари,
13. Бүтэгч одон буюу Сувади,
14. Хүү санг баригч одон буюу Шушаг,
15. Нэгэн эм есөн эрийг дарах одон буюу Анурад,
16. Тэнгэрийн шижим одон буюу Чиста,
17. Хан хүмүүн төрж үхэх одон буюу Мул,
18. Долоон өлзийт баян одон буюу Бурвасад,
19. Дөрвөлжин хүр одон буюу Ударисад,
20. Дуулагч өнчин одон буюу Абичи,
21. Ялгуун дарагдагч одон буюу Ширван,
22. Гөрөөчин шумнасын одон буюу Таниста,
23. Махач цөөврийн одон буюу Садабиш,
24. Их Суна одон буюу Бурвадарибад,
25. Махач заан одон буюу Ударибадарибад,
26. Үр таслагч одон буюу Ривади,
27. Нэг хүмүүн хязгаар дайсан дарагч одон буюу Ашивани,
28. Авагч элээ одон буюу Бáрани.

Жич: Монгол хийгээд самгард нэрийн тухайд, янз бүрийн Цаг тооллын бичигт өөрөөр орчуулж, өөр дуудалгаар хадсан зүйл багагүй дайралддаг. Бид энд нэлээд дээр үеийн хуанлид бичсэн байдлыг сонгож оруулав.

ЛАВШРУУЛЖ УЗҮҮШТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Юан улсын сударь, 1—210 дэвтэр, Дандаагийн орчуулга, УБ, (гар бичмэл).

Гучин зургаат тайлбар толь, 1—36 дэвтэр, УБ, (гар бичмэл).

Wylie, **The mongol astronomical instruments in Peking**, Chinese Researches, Shanghai, 1897, «Section Scientific», pp. 1—27.

Kotwicz W. **O Chronologji mongolskiej**, RO, Tom. IV, Lwow, 1928, 108—166.

Тубянский М, **Монгольский календарь**, -СМ, 1933, № 3, УБ, 39—45.

Gronbech K, Krueger J. R, **An Introduction to Classical (Literery) Mongolian**, Wiesbaden, 1955.

Mostaert A, **Manuel of Mongolian Astrology and Divination**, Cambridge, 1968.

Батжаргал Б, **Эртний монголын математик**. УБ, 1976.

Дамдинсүрэн А, **Их эрдэмтэн Мянгат**, УБ, 1978.

Chagdarsürüng Ts, **La chronologie et l'almanach des Mongols nomades**, SM, Tom. VII (15), Fasc. 9, UB, 1982, pp. 170—208.

Sagdarsüren C, **Die mathematische Tradition der Mongolen**, -Die Mongolen, Haus der Kunst München, Pinguin, s. 266—267.

ЭХ ХЭЛ, ҮСЭГ БИЧИГ, НОМ СУДРАА БОЛОВСРУУЛСАН МОНГОЛ УХААНААС

ХЭМЭЭХ
ДӨТГӨӨР БӨЛӨГ

МОНГОЛ ХЭЛ

Эрдэмтдийн бичсэнээс үзэхүл одоо дэлхий дахинаа 3000 орчим хэлээр ярилцаж байгаа ажээ. Хэлшинжлэлийн ухаанд энэ олон хэлийг хоёр гол зарчмаар ангилж үздэг. Үүнд, нэгд үүсэл гарвалийн талаас, хоёрт, хэвшинжийн нь талаас хэлийг ангилдаг байна. Дэлхийн олон хэлийг гарвали үүслээр нь 20 гаруй *овогт* хуваадаг юм. Хэвшинжийн нь үүдэнээс *тусгайлиг*, *залгамал* (зарим ном зохиолд авалцмал, бас угсармал гэдэг нэр томьёог хэрэглэдэг), *нугархай* хэл гэж гурав ангилах бөгөөд анги тус бүр дотроо хэд хэд салбарладаг.

Хэлшинжлэлийн ангилалаар авч үзвэл монгол хэл маань үүсэл гарвалийн хувьд *Алтай овгийн хэлэнд* багтдаг. Үүнтэй холбогдуулан нэгэн зүйлийг дурдахад Алтайн онол гэдэг маргаантай асуудал хэлшинжлэлчдийн дунд байсаар байна. Үүнд нэгэн хэсэг нь Алтай овгийн хэлэнд багтдаг монгол, түрэг, хамниган хэлний салбар нь уттаа нэгэн зүйл хэлнээс салаалсан гэж, нөгөө нэгэн хэсэг нь нэн эрт язуур цагаас дээрхи гурван хэл нь ойр зэргэлдээ байсаар бие биесдээ нөлөөлсөн гэж үздэг юм. Сүүлийн үеийн судалгааны дүнд олон эрдэмтэн япон, солонгос хэлийг Алтай овгийн хэлэнд багтаан үзэж байгаа бөгөөд энэ нь ч шинжлэх ухааны үндэслэлтэй болох нь улам бүр батлагдсаар байна. Хэвшинжийн ангиллаар бол монгол хэл *залгамал хэлний* тоонд багтдаг. Гэвч монгол хэлний түүхэн хэрэглэгдэхүүнийг улариулан авч үзэхэд дотоод нугарлын ул мөр байдагийг манай болон гадаадын нэлээд эрдэмтэн гярхай ажиглаж тэмдэглэсэн зохиол буйг хэлэхэд илүүдэх нь юун.

Одоо дэлхий дахинаа дор дурдсан 8 монгол хэл байна гэж үзсээр ирсэн билээ. Үүнд:

Монгол хэл-монгол хэлээр БНМАУ-ын үндсэн хүн ам, БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орон хийгээд бас бусад мужийн монголчууд хэлэлцэнэ.

Буриад хэл-энэ хэлээр Зөвлөлт Социалист Автономит Бүгд Найрамдах Буриад улсын уугуул хүн ам хийгээд Эрхүү, Читийн буриадууд ярилцана.

Халимаг хэл-халимагаар Зөвлөлт Социалист Автономит Бүгд Найрамдах Халимаг Улсын халимагууд ярилцана.

Дунсян буюу *Санта хэл*-энэ хэлээр БНХАУ-ын Ганьсү мужийн монголчууд хэлэлцэнэ.

Дагуур хэл-дагуураар БНХАУ-ын Хэйлүнзян хэмээх Харморон муж хийгээд Өвөр монголын өөртөө засах орны дагуурууд ярилцана.

Монгор хэл-энэ хэлээр БНХАУ-ын Цинхай, Ганьсу мужийн монгорууд хэлэлцэнэ.

Баоани хэл-энэ хэлээр БНХАУ-ын Цинхай, Ганьсу мужид оршдог, өөрсдийгөө боунан гэж нэрлэдэг монголчууд ярилцана.

Могол хэл-моголоор БНАфгУ-ын Херат, Бадахшан, Майман мужийн могол нар ярилцана.

Дээр дурдсан 8 монгол хэл гэж хуваан үзэж байгаа хуваарийг сайтар эргэж бодохул улс төрийн шалтгаанаар бие даасан хэл хэмээж үзсэн юм уу даа гэж бодож болохоор зүйл байдагийг тэмдэглэвэл зохилтой. Гэвч ямар ч атугай монгол хэлээр нийтдээ 5 сая гаруй монголчууд ярилцдаг бөлгөө.

Одоогийн байдлаар дэлхий дахинаа дээр дурдсан газар нутагт тархан аж төрж байгаа монгол хэлтэн нарт таван зүйлийн *бичиг зохиолын хэл* үйлчлэж байна. Үүнд: энэ зууны дөчин хэдэн оноос БНМАУ, Зөвлөлтийн буриад, халимаг гуравт орос кирилл үсэгт суурилсан гурван янзын бичиг зохиолын хэл хэрэглэгдэх болжээ. БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах оронд уламжлалт монгол бичигт үндэслэсэн бичиг зохиолын хэл, мөн Шинзян-Уйгурын өөртөө засах оронд тод монгол бичигт суурилсан бичиг зохиолын хэл тус тус хэрэглэгдсээр байна.

Монгол хэл маань бусад олон хэлний нэг жишлэнгээр хөгжлийн урт удаан замыг туулж өнөөг хүрсэн бөгөөд монгол хэлний хөгжлийн түүхийг 3 гол үе болгож хуваан үздэг билээ.

Эртний монгол хэл. Монгол хэлний хөгжлийн энэ үе нь нэн эрт язуур цагаас аваад VII—VIII зууныг хүртэл үргэлжилмүй. Энэ үед монгол хэл хоёр гол аялгуутай байсан бололтой гэж эрдэмтэд үздэг. Эртний монгол хэлний гол дурсгал гэвэл хөрш зэргэлдээ нутаг савлаж суусан ард түмний түүхэн сурвалжид, нэн ялангуяа хятад үсгээр дуудлагы нь галиглан тэмдэглэсэн монгол хэлний хэрэглэгдэхүүн болж байна. Мөн монгол хэлний судлалд харьцангуй сүүл үед академич Л. Лигети авгайн хүчин зүтгэлээр нарийн тодорхой болсон сянби хэлний нэгэн аялгуу болох табгач хэлний дурсгал нь энэ үеийн нэгэн гол хэрэглэгдэхүүн болохынхоо хувьд олон эрдэмтний анхаарлыг зүй ёсоор татсаар байна.

Энэ үеийн монгол хэлний гол онцлогийг товч тоймлон өгүүлбэл: авиазүйн хувьд, бүх эгшиг авиа, түүний дотор одоо эрс саармаг болсон *и* эгшиг, мөн одоогийн *г*, *х* зэрэг гийгүүлэгч тэр үед бүтэх байдлаараа хоёр ангид хуваагдаж, одоо эгшгээр эхлэж байгаа бараг бүх үг өмнөө зохих зохих гийгүүлэгчтэйгээ байснаас гадна урт эгшиг үүсэн бүрэлдэх явц эхлээгүй байсан ажээ. Хэлзүйн хувьд, тоо хийгээд хүйсээр зохицох ёсон

сулраагүй, мөн бичгийн хэлний хажуугаар академич Б. Я. Владимирцов, Йөншөөбү Б. Ринчен нарын нэгэн сонин судлагдахуун болж байсан *аман бичгийн хэл* гэдэг нэн сонирхолтой өвөрмөц хэл бүрэлдэж бичгийн хэлний уртал нь болж ирсэн байна. Монгол хүдам бичигт суурилсан монгол бичгийн хэл нь энэ үеийн монгол хэлний онцлогтой их л ойр дөхүү байдаг билээ.

Дундад үеийн монгол хэл. Монгол хэлний хөгжлийн энэ үе VII—VIII зуунаас аваад XV—XVI зуун хүртэл үргэлжилдэг бөгөөд тэр цагтаа *өмнөд, дорнод, өрнөд* гэсэн гурван гол аялгуутай байсан ажээ. Дундад үеийн монгол хэлний дурсгалаас тоймтой томхоноос нь дурдвал, дорнод аялгууны тухайд, 1240 онд зохиож дуусгасан «Монголын нууц товчоон» хэмээх гайхамшигт зохиолын бидний гар дээр хүрч ирсэн эх, дөрвөлжин бичгээр үлдсэн монгол хэлний дурсгал, XIV зууны үеийн нангиад монгол толийн хэрэглэгдэхүүн, түүнчлэн дундад үеийн солонгос хэлнээ орж тэмдэглэгдсэн монгол үгийн зүйл, хятад үсгээр галигласан монгол хэлний баримт сэлт зэрэг болно. Өрнөд аялгууны тухайд, XIII—XIV зууны үед зохиосон араб-монгол, перс-монгол толь хийгээд араб үсгээр галигласан монгол хэлээрхи хэрэглэгдэхүүн ордог билээ. Харин өмнөд аялгууны гэхээр тоймтой томоохон бичгийн баримт одоо хир олдоогүй байна.

Энэ үеийн монгол хэлний ерөнхий онцлог гэвэл, авиазүйн хувьд эртний монгол хэлэнд хоёр зүйлийн *и* эгшиг утга ялгахаа больж нэгэн янзын *и* болсноос гадна өгүүлэх эрхтэний бүтэх байрлалаар тус тус ялгарч байсан *х, г* зэрэг гийгүүлэгчийн ялгараа алдарсхийж, хоёр эгшгийн дунд байсан *г, б, д* зэрэг гийгүүлэгч сугарч урт эгшиг үүсэх нөхцөл бүрэлдэж эхлэсэн байна. Одоо эгшгээр эхлэсэн олон үгийн эхинд шүргэх *х* гийгүүлэгч байсаар байжээ. Хэлзүйн хүрээнд гэвэл тоо, хүйсээр зохицдог байсан ёсон заримдаг байдалтай болсноос гадна монгол бичигт суурилсан бичгийн хэл бүрнээ тогтворжсон юм. Дундад үеийн монгол хэлний хөгжлийн сүүлийн шатанд монгол модон барын хэвлэл хөгжин дэлгэрсний үрээр монголын судлалын ном зохиолд сонгодог монгол хэл хэмээн нэрлэдэг, монгол хэлний хөгжлийн нэгэн чухал үе шат бүрэлдсэн билээ.

Орчин үеийн монгол хэл. Монгол хэлний хөгжлийн хамгийн сүүлийн үе нь XVI—XVII зуунаас өнөөдрийг хүртэл хамарч байгаа бөгөөд зарим судлагч дотор нь 1921 он хүртэл, 1921 оноос 1940 хэдэн он хүртэл гэх мэтээр 2—3 шат болгож үздэг явдал бий. Ийнхүү шат болгож хуваасан хуваарийг нарийвчлан хянаж үзэхүл монгол хэлний хөгжлийн онцлогийг огтхон ч харгалзаагүй, зөвхөн Ардын хувьсгалын үе шат болон монгол бичгийг сольж кирилл үсэг хүчээр авсан цаг үетэй тохируулах гэсэн оролдолго мөн тул монгол хэлний хөгжлийн онц-

логтой холбоогүй, харин бичиг зохиолын хэлний өөрчлөлтийг хэлний хөгжилтэй хуттаи будилсан хувааръ болсон юм.

Монгол хэлний хөгжлийн энэ үеийн баримт хэрэглэгдэхүүн асар их. Орчин үеийн монгол хэлний гол онцлог гэвэл, авиазүйн хувьд, урт эгшиг буй болох үйл явц бүрнээ бүрэлдэн тогтож, одоогийн эгшгээр эхлэсэн олон үгийн эхинд байсан шүргэх *х* үгүй болжээ. Хэлзүйн хүрээнээ тоо, хүйсээр зохицдог байсан ёсон бас арилжээ. XVII—XVIII зуунд монгол модон барын ном зохиолын хэвлэл хөгжсөний хирээр үүсч бүрэлдсэн, монгол бичигт суурилсан сонгодог монгол бичгийн хэл нарийсан хөгжсөөр тус улсад энэ зууны 40-өөд он хүрсэн бөлгөө. Иингээд монгол хэлний талаар товчхон танилцуулсу.

Одоо монгол хэл халх, буриад, ойрд, цахар, харчин, хорчин, ордос зэрэг аялгуутай; олон монгол хэлний хөгжил хувьсалд гол цөм нь, гол хэмжигдэхүүн нь болж өгсөөр байна. Өнөөдрийн байдлаар монгол хэлнээ 3 зүйлийн бичиг зохиолын хэл үйлчлэж байна. БНМАУ-ын хэмжээнд мянга есөн зуун дөчин хэдэн оноос орос кирилл үсэгт суурилсан бичиг зохиолын хэл хэрэглэгдэх болжээ. БНХАУ-ын хэмжээнд худам монгол хийгээд тод монгол бичигт суурилсан 2 зүйл бичиг зохиолын хэл үйлчилж байна.

Тус улсад бичиг зохиолын хэл нь халхын аялгуунд үндэслэдэг бөгөөд монгол хэл академич Ш. Лувсанванданы судалгаагаар 22 эгшиг, 24 гийгүүлэгч нийтдээ 46 авиалбартай. Монгол бичгийн хэлнээс ялгарах гол ялгаа гэвэл дээр дурдсан ерөнхий онцлогоос гадна авиазүйн хувьд хамжин шүргэх *з*, *ц* буй болсон явдал юм. Хэлзүй болон найруулгазүйн талаар ярьж анхаарах зүйл багагүй байгааг энд цухас боловч хэлмээр санагдлаа. Үүнд: Шашин суртаалын нөлөөгөөр монголчилсон зохиолын дотор, бурханы номын үг үсгийг хамаагүй өөрчлөж болохгүй гэдэг үзлийн үүдээс уг эхийн үг бүрт нэг үг оноох, хэлзүйн хэлбэрий нь хэвээр хадгалах ёстой гэсэн зорилгоор төвөд, самгард хэлний хэлзүй хийгээд найруулах ёсны нөлөө айхавтар их туссан явдал сонгодог монгол хэлний найруулгад гүнээ шингэж бараг нэгэн бие даасан дэгийн хэмжээнд хүрсэн нь бий. Ийм байдал үүгээр дуусвар болсонгүй. Ардын хувьсгалын дараа, шашин шүтлэг намжаасны хойно ч, өөр маягаар үргэлжилсэн ажээ. Ялангуяа монгол бичгээ халж, хэдэн үеийн туршдаа европ зүгийн, тэр дундаа орос хэлний нөлөө хүчтэй болж ирснээс үүдэж монгол хэлний үгсийн сан, хэлзүй, найруулгазүйд харь хэлний гаж өөрчлөлт газар авсан билээ л.

Одоо эргэцүүлэн бодоход, биеэ даасан бүрэн эрхэт хэмээх улсын хувьд манайхиас өөр, эх хэлээ гаргуунд нь гаргасан улс орон байхгүй биз ээ. Удаа дараа үе залгамжилсан зор эзэрхэгчийн балгаар үсэг бичиг, эх хэл, зан заншил, үүх түүхээсээ хүнийрхэх болсон улс үндэстэн монголчууд биднээс өөр бий л

болов уу даа. 1930-аад оноос хэл ангийн чанартай хэмээн сурталдаж *зарлиг, шарил, айлтгал* зэрэг өдий төдий үгийг хэрэглэхийг хорьж, феодалын үг гэж зарлан айлгасан зүйл хэвлэгдсэн билээ. Уламжлалаасаа хөндийрөн холдсоны харгаагаар хуучин ном зохиолд *Кунз, Ром, Герман, Парис* гэх зэргээр уг хэлний дуудалгад нь ойр бөгөөд зөв байсан олон үгээ мартаж Конфуци, Рим, Немц, Париж гэх боллоо. *Наймдугаар богд, тавдугаар далай лам* гэдэг байтлаа Петр первый гэдгийг яг махачлаж Петр нэгдүгээр гэх боллоо. Дээд найруулгын үгийг өөр дээрээ буюу 1 дүгээр биед хэрэглэдэггүй ёсыг зөрчиж миний алдар, би зооглоно, надад таалагдаж байна гэх зэргээр ярьж бичих болжээ. Тэр ч бүү хэл зандалчны шарил гэж хэнэггүй бичсэн өгүүлэл нийтлэгдэн гарсныг бид баримттай хэлж чадна. Сүүлийн үест хэт үзэл сурталжаад Чингис уулыг Ингэс болгож билээ. *Хир чинээ* гэдгийн хирийг хир буртагийн хиртэй адил хэлбэртэй байгаа тул зохист үл нийцнэ гэж тайлбарлаад хэр гэж бичих нь эүйтэй гэж монгол хэлний хууль зүйг эвдсэн энэ мэт жишээ олон гарлаа. Захуй зарамын говь гэдэг нэрийн тухайд, захуй гэдэг үгийг орос хүн сонсоход муухай үг тул солих хэрэгтэй гэж ч санал тавьж байсныг ч олон хүн лав мартаагүй буй заа. Банзал цамц гэдэгт ордог *банзал* гэдэг үгийг бараг янхан гэдэг утгатай адил байна гээд орос хэлний юбка гэдэг үгээр сольсон нь нэн инээдэмтэй. Инээдэмтэй нь юу вэ? гэвэл орос хэлний юбка гэдэг үгийн нэг салаа утга нь мөнөөхи цээрлээд байсан үгтэй яг дүйж, олноор явдаг бүсгүй хүнийг хэлдэг гэдгийг тийнхүү сольсон хүмүүс маань ухаараагүйд л байгаа хэрэг. Зуд гэдэг үг тун саяхан хэлмэгдсэн үгийн нэг даруй мөн билээ.

Нэр томьёоны тухайд ердөө орчуулж болдоггүй үг гэх буюу дэлхий нийтийн үг, олон улсын үг тул орчуулах шаардалгагүй гэж олон хүн маргадаг. Чухамдаа хэлний мэргэжлийн хүнээс асуувал дэлхий нийтийн үг гэж байдаггүй гэж хариулна. Олон улсын үг гэдэг тухайд бодолцох юм бий. Үүнд: гарал үүсэл нэг буюу нэг овгийн олон хэлнээ ойр төстэй хэлдэг үг байх нь эүйн хэрэг. Ийм нэр англи, франц, герман зэрэг хэлэнд түгээмэл байх явдал бий. Гэвч энэ дурдсан хэлнээ ялгаатай нэр томьёогоор нэг зүйлийг нэрлэсэн жишээ багагүй. Жишээлбэл: орос хэлээр *вычислительная машина* гэдгийг францаар *ординатор, машина калькулятрис, калькулятор* гэж байхад англиар *компьютор* гэнэ хэмээж 1987 онд Парис хотноо гарсан толь бичигт бичжээ. Манай зарим хүмүүсийн хэлдэгчлэн орчуулж болохгүй гээд байгаа калькуляц, компьютор гэдэг хоёр үг бол *тоолох, тооцох* гэсэн л утгатай үгнээс үүсэлтэй тул монголоор *тооцоолуур* хэмээж ноосон нь яг дүйсэн нэр гэж үзэх бүрэн үндэстэй. Учир нь: энэ нэрийн *тооцоол* гэдэг хэсэг нь орос хэл-

ний вычислительная, франц хэлний *ордина* буюу *калькуляц*, англи хэлний *компью* гэдэгтэй нь; монгол хэлний үйлээс нэр үүсгэх *-уур* дагавар нь тухайн үйлийг бүтээх багаж, хэрэгсэл гэсэн утгатай бөгөөд энэ техиолдолд орос хэлний *машина*, франц хийгээд англи хэлний мөн тийм утга бүхий *-тор* дагавартай тус тус дүйж байгаа юм. Ер нь бид зөв оноож чадахгүй байгаа буюу уугуул утга болон тухайн нөхцөлд зааж байгаа санаагий нь мэдэхгүй байгаагаас эх хэлээрээ буулгаж чадаагүй болохоос биш утга санаагий нь орчуулж огт болдоггүй үг гэж байдаггүй билээ. Саяхан болтол орчуулж болдоггүй гээд л байсан олон үг, тухайлбал *лимит* гэдэг нь *хязгаар* гэсэн утгатай, *фонд* гэдэг нь *сан* юм уу *хөмрөг* гэсэн утгатай болохыг англи, франц, герман, япон зэрэг гадаад хэл үзэн сурч, билигийн нүд нь улам нээгдэж байгаа хөгшин залуу олон хүн лавтайяа ухан ойлгож байгаа буй заа. Шинэчлэлтээс өмнө, зор эзэрхэгчдийн үед нэг нэр томьёог монголоор онооно гэдэг мөн ч хүчир ажил байсан асан. Орос хэлний *недра* гэдэг үгийг монголоор оноох гэж бүхэл 9 жил яриа маргаан болсон гэхэд одоо бараг итгэмээргүй санагдах биз ээ.

Аливаа улс үндэстний хэлэнд нийгмийн үүрэг гэдэг том ойлголт дагаж явдаг. Монгол хэлний тухайд, 90-ээд оноос өмнө 30-аад жилийн турш нийгмийн үүрэг нь улам бүр хязгаарлагдмал болж их дээд сургуулийн олон хичээл орос хэлээр орж, томоохон хурлын илтгэл, хэлэх үгийг эхлээд оросоор бичээд дараа нь махачлаж монгол болгодог, эрдмийн зэрэг хамгаалах бүх зохиолыг хураангуйнхи нь хамт заавал оросоор бичих тогтоолтой, орос хэлний мэдлэг бол хүн бүрийн хувьд үндсэн хэмжүүр болсоор ирсэн тул монгол хэлээ нарийн үзэж сурая гэсэн эрмэлзэл унтарч, харин ч зүсэн зүйлээр монгол хэлээ муучлаж арга буюу тулга тойрсон хүрээнд л хэрэглэх болж билээ. Хэл сэтгэхүй хоёр шүтэн барилдсан зүйл гэдгийг бид гүн ухааны хичээлээр хэдийгээр их ярьж шалгуулсаар ирсэн боловч эх хэлэндээ тэр мэдлэгээ зориулж чадаагүй билээ. Ингээд... их багагүй тулга тойрсон хэдэн үгтэй, хялбарчлах, бэлэнчлэхийн балгаар бодол шаардаж, толгой зовоохгүй богино богинохон өгүүлбэр арай гэж найруулдаг, тэгээд түүнийгээ хэнд ч болов ойлгомжтой сайхан найруулгатай гэж бие биесээ хоосон магтаж, хэн нэгэн хүн монгол хэлний уламжлалт маягаар бичихвээс эвэртэй туулай үзсэн мэт гайхан «үндэсний үзлийн илрэл» болгосоор байгаад эх хэлээрээ сэтгэх, бодох, бичихдээ нэг л мэдэхэд арга буюу ядуурахад хүрчээ. Эрүүл чийрэг хүний идэх хоол нь дотрын гэмтэй хүнд яав ч таардаггүй шиг монгол хэлий маань чухамдаа дотрын гэмтэй хүнд тохируулан хийсэн шим шүлтгүй хоол шиг болгосон зүдэг хар цагийг гэгээрүүлэх эрин айсаж байна.

ЛАВШРУУЛАН ҮЗҮҮШТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Владимирцов Б. Я, **Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия,** Введение и фонетика, Л., 1929.

Санжеев Г. Д, **Сравнительная грамматика монгольских языков,** I, М., 1953.

Poppe N, **Grammar of Written Mongolian,** SA (PLO) I, Wiesbaden, 1954.

Ринчен, **Монгол бичгийн хэлний зүй,** Удиртгал, авиан зүй, өгүүлбэр зүй, УБ., 1964—1967.

Poppe N, **Introduction to Altaic Linguistics,** UAB, XIV, Wiesbaden, 1965.

Лувсанвандан Ш, **Орчин цагийн монгол хэлний зүй,** Авианы бүтэц, Тэргүүн дэвтэр, УБ., 1967.

Лувсанвандан Ш, **Орчин цагийн монгол хэлний бүтэц,** монгол хэлний үг нөхцөл хоёр нь, УБ, 1968.

Кара Д, **Книга монгольских кочевников,** М., 1972.

МОНГОЛЧУУДЫН ҮСЭГ БИЧИГ

Аливаа улс үндэстний үсэг бичгийн хуланц дээд өвгийг эрдэмтэд *санаа бичиг* гэж нэгэн дуугаар хүлээн зөвшөөрч, тэрхүү санаа бичгийг хөгжлийн нь хувьд хоёр шат болгон хуваж, эхлээд эртний *болзмол тэмдэг* гэдэг хэлбэр буй болоод, дараа нь *зураг бичиг* гарсан хэмээж үздэг. Дэлхий дахины хэмжээнд санаа бичгийн сонгодог дурсгал гэвэл Франц, Итали, Испани нутгаас олдсон, эртний хүмүүсийн орон бууц нь болж байсан Ла Ферраси, Касильо, Дордони, Пэш мерль, Ляско, Фон де гом зэрэг чулуун зэвсгийн үеийн агуйн ханын хөшиг зураг зэрэг болно. Монгол-Зөвлөлтийн хамтарсан эртний судлалын шинжээнийн анги тус улсын нутгаас, тухайлбал, Ховд аймгийн Манхан сумын Хойд Цэнхэрийн агуйгаас дээр дурдсан олон газрын дурсгалтай нэгэн цаг үеийн нэн сонин судлагдахууныг олсон билээ. Академич А. П. Окладников зөвхөн Төв Азид төдийгүй дэлхий нийтийн эртний судладд шинэ чухаг нээлт болсон эл дурсгалыг үнэлж «...Франц, Испанийн агуйн зурагтай яг таг дүйх туургын хөшиг зургийг баруун монголын Хойд Цэнхэрийн агуйгаас олоход хялбархан юм...» хэмээн дурджээ. Энэ жишлэнгээр эртний чулуун зэвсгийн үеэс аваад хүрэл, төмрийн үед хамаарах нүсэр том хөшиг зургийг монголын аль ч газраас олоход төдий л төвөггүй билээ.

Монголчууд хийгээд монголын өвөг дээдсийн хэрэглэж ирсэн бичиг үсгийг авч үзэхүл эх үүсгэл нь нэн эрт цагт тулж очих бөгөөд тооны хувьд лавтайяа арав гаруйд хүрнэ. Үсэг бичгийн хувьд ийм дэлгэр түүхтэй улс орон яав ч олонгүй. Ийнхүү олон зүйл үсэг бичиг хэрэглэж ирсэний учир холбогдлын талаар товч ярьсу.

Хүн (нү) нар бичиг үсэгтэй байсан эсэх талаар эрдэмтдийн дунд хоёр зүйл санал бий бөгөөд нэгэн хэсэг нь үсэг бичиггүй байсан гэж нөгөө хэсэг нь үсэг бичигтэй байсан бөгөөд ямархуу янзын бичиг байв аа? гэвэл тамга-үсэг маягтай байсан гэж үздэг. Ийм бичгийн биет баримт гэвэл Говь-Алтай аймгийн Цагаан голын хадны бичээс бөгөөд энэхүү бичээсийн талаар академич Ринчен профессор анх судалгаа хийсэн билээ л. Өөр биет баримт гэвэл Хүн нарын булш бунханаас гарсан эд өлгийн зүйл дээрхи тамга-үсэг нь нийтдээ 60—70-д хүрсэн гэдгийг яав ч дурдалгүй орхих аргагүй. Энэ бүх хэрэглэгдэхүүнийг

түүхч эрдэмтэн Г. Сүхбаатар, А. Дамдинсүрэн нар нарийсгаж судалсаар байна. Бас 1983 онд манай эртний судлаач эрдэмтэд Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт хүн улсын үеийн булш малтаад бичээс бүхий «Алтан хүн» олсон нь Хүн нар бичиг үсэгтэй байсан гэдэг саналыг улам ч бататгасан биет хэрэглэгдэхүүн болсон билээ. Энэ нандин олдворыг түүхийн талаас нь эрдэмтэн Д. Наваан, хэлний талаас нь эрдэмтэн Б. Сумьяабаатар нар судалж «Өвөг монгол хэл, бичгийн чухаг дурсгал» гэдэг ном бичсэн нь 1987 онд Улаанбаатар хотноо хэвлэгдсэнийг чухас дурдсу.

Нангиадын түүхнээ манай өвөг дээдэс-Ухуани нарын тухайд «...Ахлагч нар нь хэн нэгнийг дуудах болоход модон дээр хэрчлээ тавьдаг. Тэр хэрчлээ нь үсэг бичгийн үүрэг гүйцэтгэмүй...» гэж тэмдэглэсэн нь буй. Үүнээс үзэхүл тэрхүү хэрчлээ гэдэг нь ямар ч атугай дуудах гэсэн хүнээ бусдаас ялгаад зогсохгүй хэрхэх яах тухай тодорхой мэдээ өгч чаддаг байсныг гэрчлэж байгаа хэрэг болой. Түүгээр үл барам, лавшруулан бодохул модон дээр хэрчлээ гаргана гэдэг нь дээр дурдсан тамга-үсэг маягтай болохыг давхар нутлаж байгаа явдал билээ. Эртний түрэгийн «рун» хэмээж нэрлээд байгаа үсэг бичиг нь хэлбэр байдлаараа тамга-үсгийг эрхгүй санагдуулдаг гэдгийг ч хэлмээр байна. Бас нэгэн зүйл гэвэл Польшийн түрэгч эрдэмтэн, профессор Э. Трыярски авгай 1985 онд эртний түрэгийн рун бичгийн гарал үүслийн талаар судалгааны томоохон өгүүлэл нийтлүүлж, түүндээ эртний түрэг бичгийн үүсэлд *тамга-үсэг* холбогдох учир шалтгааныг тайлбарласан нь бидний хувьд бүр ч сонирхол татсаар байна.

Мөн «Вей шү», «Сүй шү» гэдэг нангиадын түүхийн дотор Тоба нар *шинэ* бичиг зохиосон тухай дурдсанаас гадна Сянби хэлний нэг аялгуу-табгач хэлээр хэвлэсэн ном, үүнд хэлний сурах бичиг, дууны түүвэр, толь бичиг зэрэг 13 ном байсан гэж жагсаан товьёглосон баримт байдгийг энэ ташрамд сонордуулахад яав ч илүү зүйл болохгүй. Гагцхүү харамсалтай нь тэдгээр номоос бидний үед хүрч ирээгүй ажээ.

Хятаны Ляо улс (916—1125) байгуулагдсаны дараахан хятан эрдэмтэд 920 онд *их бичиг*, 925 онд *бага бичгээ* зохиосон бөгөөд бага бичгээр тэмдэглэсэн хөшөө дурсгал нэлээд олон үлдсэн боловч одоо болтол гүйцэд тайлан уншиж чадаагүй байгаа тул монгол, зөвлөлт, хятад, мажар зэрэг улсын олон эрдэмтэн хятан бичгийг тайлан унших бэрхтэй ажилд мэдлэг хүчээ шавхан зарсаар байгааг хэлэх нь зүйн хэрэг бөлгөө.

Хятан бичгийн дараа монголчуудын хэрэглэж өдгөөг хүргэсэн, монголын соёлын хөгжилд онцгой үүрэг гүйцэтгэсэн бичиг бол олон нийтийн дунд хуучин монгол бичиг, хуучин бичиг, зарим хүний уйгуржин монгол бичиг гэж янз бүрээр зөв буруу нэр ус зүүж ирсэн *монгол бичиг* мөн бөлгөө. Дээр цухас

дурдсанчлан монгол туургатны соёл боловсролын их санд үлэмж үүрэг гүйцэтгэсэн тул монгол бичгийн талаар тусгай нэгэн хэсэг болгон танилцуулах нь зүйтэй гэж үзээд энд ярихаа түр хүлээлзсүгэй.

Дундад зууны үед монголчуудын хэрэглэж байсан *дөрвөлжин бичгийг* Хубилай хааны зарлигаар 1269 онд Пагва лам Лодойжалцан (1234—1298) төвөд үсэгт дулдуйдаж зохиосон бөгөөд төрийн бичиг болж албан ёсоор 1368 он хүртэл хэрэглэгдсэн билээ. Европ дахины судалгааны ном зохиолд зохиосон хүний нь нэрээр *Пагвагийн үсэг* гэж тэмдэглэсэн байдагийг энэ ташрамд дурдсу.


Энэ бичиг 44 үсэгтэй бөгөөд бидний гарт хүрч ирсэн баримт, дурсгалаас үзэхүл монгол, төвөд, самгард, түрэг зэрэг олон хэлний үгийг тэмдэглэн бичих бүрэн боломжоотой байсан нь харагддаг. Дөрвөлжин бичгийг хэдийгээр төвөд үсэгт дулдуйдаж зохиосон боловч монгол бичгийн жишлэнгээр дээрээс нь доош бичдэг. Үсгийн махбодыг холбох байдал хийгээд бичих чигийг үзэхэд монгол бичгийн нөлөө айхавтар сүрхий туссан нь тодорхой байна гэж судлагчид ажиглан тэмдэглэсэн байдаг. Үгийг дөрвөлжин бичгээр үе үеэр нь тусгай бичдэг тул зарим хүн үет бичиг хэмээж ташаарсан явдал байсан боловч чухамдаа бол үет бичиг огт биш, авианы цагаан толгойт бичиг юм гэдгийг хэлбэл зохино.

Дөрвөлжин бичгээр бичсэн зарлиг, зоос, тамга, цаасан мөнгөн тэмдэгт, хад чулууны бичээс, пайз болон модон барын «Субашид» хэмээх номын тасархай зэрэг олон дурсгал бидний үед хүрч ирсэн бөгөөд америкийн нэрт монголч эрдэмтэн Н. Поппе, Ж. Крюгер, польшийн монголч эрдэмтэн М. Левицки зэрэг олон эрдэмтэн дээр дурдсан дурсгалыг нарийвчлан судалж олон ном гаргасан билээ. Сүүлийн үед БНХАУ-ын олон эрдэмтэн, түүний дотроос нөхөр Зуунаст авгайн шинжилгээний бүтээл монголын дөрвөлжин бичгийн судлалд хувь нэмэрээ оруулсаар байна.

Монголын дөрвөлжин бичгийн дурсгалыг нэгтгэн дүгнэж үзээд академич Б. Я. Владимирцов «...XIII зууны үеийн олон улсын цагаан толгой» байсан юм гэж үнэлснийг энд дурдалгүй өнгөрвөөс лавтайяа нүгэл болно заа.

Дээр дурдсан бүх зүйлээс үүдэн бодохул Юан улсын үед монголын дөрвөлжин бичгийг улс төрийн шалтгаанаар зохиож улс төр, шашин суртаалын хүрээнд нийтлэг нэг бичиг үсэгтэй болохыг эрмэлзсэн байдал илэрхийеэ мэдэгдэнэ. Дөрвөлжин бичгээр үлдсэн дурсгал нь дундад үеийн монгол хэлний хөгжлийн нэгэн гол судлагдахуун болоод зогсохгүй түүхийн үүднээс сурвалж бичиг, биет хэрэглэгдэхүүн болдог ач холбогдолтой билээ. Дөрвөлжин бичиг бол дундад зууны үед монголчууд хэлшинжлэлийн талаар зөвхөн монгол хэлний хувьд төдийгүй

хятад, төвөд, самгард, түрэг зэрэг олон хэлний зүй тогтоолыг айхавтар нарийн мэддэг, тэр мэдлэгээ аж амьдралынхаа хүрээнд зохистой хэрэглэж байсны бас нэгэн биет баримт болсоор байна.



Дөрвөлжин бичгээрхи бичээс бүхий хоёр зоосны гэрэл зураг

1648 онд Ойродын Зая Бандида Огторгуйн далай хэмээх Намхайжамц (1599—1662) *тод бичиг* зохиожээ. Энэ бичиг нь монгол бичгийн дүрс ижил, дуудалга өөр авиаг салган тэмдэглэсэн, цэг тэмдэг нэмж ялгасан байдал аяндаа мэдэгдэхээс гадна зөвхөн Ойродуудад төдийгүй нийт монголчуудад зориулан зохиосон байдал илэрхий харагддаг.

Тод бичиг нь 7 эгшиг, 19 гийгүүлэгчтэйгээс гадна урт эгшгийг хэдэн зүйл аргаар тэмдэглэсэн тусгай тэмдэгтэй, төвөд, самгард зэрэг гадаад хэлний үгийг бичих тусгай галиг үсэгтэй.

Энэ бичгээр бичсэн гар бичмэл хийгээд барын ном нь нэр төрлөөрөө хэдэн мянгад хүрнэ. Дэлхийн олон орны номын санд тод ном буй боловч ахмад эрдэмтэн Х. Лувсанбалданы хичээл зүтгэлээр цуглуулж ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд буй болгосон тод номын хөмрөг дэлхий дахинаа тэргүүн байранд ордог.

Тод бичгийг Ойрод, Халимаг, Торгуудууд нийтээр хэрэглэсээр энэ зууны 30—40-өөд оныг хүргэсэн билээ. Одоо БНХАУ-ын Шинжаанд ном зохиол, сонин бичгээ тод үсгээр хэвлэн нийтлэж хэрэглэсээр байна

Тод бичгийн хэлийг үзэхэд монгол бичгийн хэлийг тэр цагийнхаа аман хэлнээ ойртуулах гэсэн эрмэлзлийн үүднээс зохиосон байдал илэрхий үзэгдэх боловч хэтэрхий «тод» болгосны шалтгаанаар нийт монголчуудын хувьд хүртээмжтэй болж чадалгүй зөвхөн ойрдуудын дунд л үлдсэн ажээ. Хэтэрхий «тод» болсон гэдгийн талаар монгол бичгийн хэсэгт товч тайлбарлах болно.

Өндөр гэгээн Занабазар (1635—1723) монголын *соёмбо бичгийг* 1686 онд ланз буюу ранза үсэгт дулдуйдаж зохиожээ. Соёмбо гэдэг нь самгард буюу эртний энэдхэгийн судрын боловсорсон хэлээр «өөрөө буй болсон гэгээн үсэг» гэсэн утгатай бөгөөд энэ нь тэнгэр огторгуйд ийм үсэг дурайн буй болж харагдсан гэдэг домогтой холбоотой ажгуу. Монголын соёл урлагийн гарамгай зүтгэлтэн Занабазар эл бичгээ зохиосон учраа тайлбарлахдаа түрүү түрүү үед орчуулсан ном зохиолын ор-



Манж эвхмэл, тод, араб, хятад дөрвөн зүйлийн үсэг хадмал тамгын дардас

чуулгыг шүүтгэн засч энэ бичгээрээ хэвлэх, төвөд, самгард хэлний үгийг нарийн тэмдэглэх боломжийг улам боловсронгуй болгох санаа агуулснаа дурдсан байдаг. Гэвч бас тэр цагт манжийн түрэмгийлэгчид Монголын тусгаар тогтнолд заналхийлж Монголыг талаас нь таслаж, үзүүрээс нь умхэж эхлэхийг илт санаарҳаж байсан үед ил хэлж болохгүй нэг санаа байсан хэмээдэг өтгөсийн аман яриа дам дамаа уламжилсаар бидний үед хүрч ирсэн билээ. Тэр нь юун хэмээвээс соёмбо бичгийг үндэсний тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг болгож зохиосон гэдэг яриа бөлгөө. Үүний ул үндэстэй болохыг баталсан, хэн бүхний сайн мэдэх нэгэн зүйл бол манжийн түрэмгийллийн эсрэг тэмцсэн Лигдэн хааны үеэс өнөөдрийг хүртэл монгол улсын туг далбаан дээр тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг болсоор байгаа алтан соёмбо тэмдэг болой. Энэ тэмдэг бол Өндөр гэгээний зохиосон соёмбо бичгийн эхний бярга буюу эгчим хэмээх тэмдэг тасралтгүй уламжилсаар өнөөдрийг хүрсэн хэрэг ээ.

Соёмбо бичгийг эртний энэдхэгийн ланз үсэгт шүтэж 90-ээд үсэгтэй зохиосон бөгөөд энэ бичгээр монголоос гадна төвөд, самгард хэлний үгийг бүрнээ бичих бололцоотой, их төлөв зүүнээс баруунш хөндлөн бичдэг боловч хаяа заримдаа зарим тэмдэг, махбодыг нь хурааж дээрээс доош нь бичсэн явдал дайралддаг


Соёмбо бичиг хийгээд үүний дараа бидний ярих гэж байгаа Хэвтээ дөрвөлжин үсгийн талаар хэлшинжлэлийн анхны судалгааг хийж Европ дахинаа танилцуулсан эрдэмтэн бол академич Йөншөөбү Бямбын Ринчен билээ. Одоо бидний мэдэж байгаа хирээр соёмбо бичгээр бичсэн дурсгалын зүйл нь их төлөв шашны агуулгатай байна. Хэдий тийм боловч академич Л. Лигетийн тэмдэглэсэнчлэн соёмбо бичгийн дурсгал нь монгол хэлний түүхийг судлахад, ялангуяа тэр үеийн халхын аялгууны түүхэн судлалд чухаг хэрэглэгдэхүүн болж байгаа юм.





Соёмбо бичгийн цагаан толгой

Соёмбо үсгээр «тэмдэг» гэдэг үгийг хэвтээ хийгээд босоо маягаар бичсэн байдал

Монголын *хэвтээ дөрвөлжин бичгийг* Өндөр гэгээн Зана-[illegible] соёмбо бичигтэйгээ бараг нэгэн зэрэг зохиосон гэдэг. 66 [illegible] Монголоос гадна төвөд, самгард хэлний үгийг тэмдэг-







[illegible] дөрвөлжин үсгийн барын цагаан толгойн гэрэл зураг




Хэвтээ дөрвөлжин үсгээр бичсэн «Амгалант тамга» гэсэн үг бүхий тамгын дардас


лэх боломжтой. Соёмбо бичгийн нэгэн адил зүүнээс баруун мөн л үгийг үе үеэр нь бичдэг, авианы бичиг болой. 1801 о эрдэмтэн П. С. Паллас Санктпетербургт хотноо хэвлүүлсэн но доо энэ бичгийн талаар ямар нэгэн тайлбаргүйгээр цагаан то гойгий нь хавсаргаж европ дахинаа анх түрүүн мэдээлсэн б лээ. Уул бичгийн учир начрыг анх түрүүн академич Ринчен пр фессор нарийвчлан судлаад тайлбар сэлтийн хамт 1952 онд М жарт нийтлүүлсэн байна. Энэ бичгээр бичсэн дурсгал гэв сүм дуганын ханын чимэг, хэдэн зүйл барын цагаан толго проф. Д. Карагийн олж нийтлүүлсэн «Амгалант» хэмээх там зэрэг нэлээд хэрэглэгдэхүүн бидэнд олдоод байна.

Хэдий тийм боловч эл бичгийг хэрхэн, чухам ямар зори гоор зохиосон тухай тодорхой мэдээ сэлт энэ хир үгүй тул тийм гэж хэлэх бололцоо хараахан бүрдээгүй байна.

Буриадын лам Агваандорж (1850—1938) хэмээгч 1905 о *Вагиндрагийн үсгийг* зохиожээ. Вагиндра гэдэг нь түүний н



Вагиндрагийн үсгээр чулуун бараар хэвлэсэн «Зүрхэн толти» гэдэг хэлзүйн номын эхний хуудасны гэрэл зураг



1911 онд Монгол улс тусгаар тогтнолоо олж Олнаа өргөгдсөн хааны барьсан тамгын үсэг

рийн Агваан гэдэг хэсгийнхи нь самгард орчуулга болой. Зохиогч эл бичгээ монгол бичигт дулдуйдан зохиож авиа бүрийн дүрсийг ялгахдаа тод монгол бичгийн хэлбэрийг ашигласан байдал бэлхэнээ үзэгддэг. Гэхдээ энэ бичигт монгол бичгийнхитэй адил эхин дунд адагт ордог ялгаа гэж үгүй. Гол онцлог нь гэвэл орос хэлний *ф*, *щ* болон буриадын шүргэх *х* авиаг тэмдэглэх тусгай үсэг хийгээд урт эгшиг, тагнайшсан байдлыг тэмдэглэх тэмдэг зохиож, цэг цэглэлийн зүйлийг европын жишлэнгээр нэмжээ. Үүнээс үзэхүл буриад аялгууны байдлыг тусгаснаас гадна орос хэлний үгийг тэмдэглэхэд илүү зохиомжтой болгох гэсэн зорилго бэлхэнээ харагдана.

Энэ бичиг нь үндсэн үсэг 36, үүнээс 8 нь эгшиг, бас цэг цэглэлийн тэмдэг 7-той бөлгөө. Вагиндрагийн үсгээр байгаа дурсгал гэвэл 1905—1910 оны хооронд чулуун бараар хэвлэсэн хэлзүйн бичиг, ардын билигийн зүйлийн товхисон эмхэтгэл арав гаруй дэвтэр зэрэг болой. Мөнгө зардлын бололцооноос болоод цаашдаа энэ бичгээр ном хэвлэх ажил хязгаарлагдсаар яваандаа уул бичиг бараг мартагдахад хүрчээ. Харин монгол

бичиг хуучин хэвээрээ буриадуудын дунд хэрэглэгдсээр 1940-өөд оныг хүргэсэн юм.

Тус улсад 1940 хэдэн он хүртэл бүх хэвлэл, улсын албан хэргийг монгол бичгээр явуулж байсан боловч 1930 оны үеэс монгол бичгийг өөрчлөх бэлтгэл эхэлсэн байна. МАХН-ын VIII их хурлын төвч тогтоолд (1930 оны 4-р сарын 3-ны өдрийн):

> «...хуучин хүнд суртлын үлдэгдлийн нэгэн салбар бөгөөд шинэ соёл боловсролын хөгжилтөд дөхөмгүй болох монгол үсгийг халж боловсон соёлыг дэлгэрүүлэхэд дөхөмтэйг нийт дээр дэлгэрэх туршлагыг олсон латин үсгийг өөрийн монголын хэлэн дээр зохилдуулан үндсэн хэлний үсэг болгон хэрэглэх явдлыг богино хугацааны дотор гүйцэтгүүлж нийт соёл боловсролын ба санхүүд боогдол саатал бүхий байдлыг устгахыг чухалчлах...»

гэж заасан байдаг.

Энэ заалтын дагуу латин үсгийн багш бэлтгэх түр сургууль байгуулж латин үсгийн ном дэвтрийг хэвлэж, латин үсгийг заах, сонинд булан гаргах зэрэг ажлыг гүйцэтгэсний хажуугаар шинээр хэрэглэх латин үсгийг боловсруулах комисс байгуулан ажиллуулж 1941 оны 2-р сарын 21-ний өдрийн МАХН-ын Төв Хороо ба Сайд нарын Зөвлөлийн хамтарсан 17/13 дугаар хурлын тогтоолын 1 дүгээр заалтад

> «...Латин үсгийн комиссоос төлөвлөн ирүүлсэн 29 үсэг нь манай дуут тэмдэглэхэд хүрэлцэх ба тохирох тул хэвээр баталсугай...»

гэж дурдаад уул тогтоолыг хүчин төгөлдөр болгож МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Ардын сайд нарын Зөвлөлийн Ерөнхий сайд Улсын Маршал хоёр нарын үсгээ зурсан байдаг.

Гэтэл энэхүү хамтарсан тогтоол арай гэж ганцхан сарын настай байж; 1941 оны 3-р сарын 25-ны өдрийн МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчид ба Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлаас гаргасан 22/18 дугаар тогтоолын 5-р заалтаар хүчингүй болгосон ажээ. Үүнээс үзвэл нэгэн сар хүрэхтэй үгүйтэйн өмнө манай хоёр эрхтэн дархтаны нарын үсэг зурсан тогтоолыг түүнээс үлэмж хүчтэн өөрчлүүлж, арван жилийн турш хийж үлэмжхэн хөрөнгө мөнгө үрж, хүч хөдөлмөр тарамдуулсан их ажил ёстой хоосоор өнгөрчээ.

Хэдхэн мөрийн дээр дурдсан 22/18 дугаар тогтоолын тэмдэглэл хэсэгт:

> «...монгол үсгийг латчилахад мөнхүү латин үсэгт монгол хэлэнд хэрэглэгдэх тэмдэг дутагдалтай ба мөн хэвлэлийн талаар дутагдах зэрэг техникийн бэрхшээл тохиолдож байна. Мөн түс орны соёл боловсролын цаашдийн хөгжилт нь гагцхүү ЗХУ-ын ард түмэнтэй ах дүүгийн холбоог бэхжүүлэх түүний баялаг соёлыг эзэмших замаар явах болно...» гээд тог-

тоолын **заалтад:** «...Монгол бичгийг шинэ орос үсэг дээр шилжүүлэн авах явдал чухал хэмээн үзмүй...»

«...шинээр төлөвлөсөн монгол үсгийн төлөвлөгөөг зөвшөөрч нийтэд хэлэлцүүлэхээр зарласугай...»

«...Орос үсэг дээр үндэслэсэн Монголын шинэ үсгийн эцсийн төлөвлөгөөг нийтэд зарлаж хэлэлцүүлсэн саналыг харгалзан нэг сарын дотор МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчид ба Засгийн газраар оруулан батлуулах явдлыг н. Цэдэнбал даргатай улсын комисст даалгасугай...» гэж заасан байдаг юм.

Үүний үндсэн дээр Ардын Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1941 оны 5-р сарын 9-ний өдрийн хамтарсан 25/27-р хурлын тогтоолын 1 заалтаар «...Орос үсгээр үндэслэсэн монголын үсгийг бүгд 35 үсгээр...» баталжээ. Сүүлийн энэхүү тогтоолын заалтын дагуу шинэ үсэгт сургах ажлыг зохион байгуулж, «Монголын шинэ үсгийн товч дүрэм»-ийг зохиож, бүх сонинд булан гаргаж олон нийтэд ажиж ажиллаар сурган танилцуулсаар хэдэн жилийн нүүрийг үзээд 1945 оны 5-р сарын 18-ны өдөр дээр хэдэнтээ дурдсан хоёр том байгууллагын хамтарсан 31/27-р хурлын тогтоолын 1 заалтаар «...Бүх хэвлэл ба улсын албан хэргийг 1946 оны 1-р сарын 1-нээс эхлэн шинэ үсгээр явуулсугай...» гэж тогтоожээ.

Харин Баян-Өлгий аймгийн тухайд 1942 оны 9-р сарын 3-ны өдрийн, мөнөөхи 2 байгууллагын хамтарсан хурлын 40/63 дугаар хурлын тогтоолоор

«...Казах аймагт хэрэглэн буй латин үсгийн оронд шинэ орос үсгийг тогтоон явуулсугай...»

«...СССР-ын Казах улсад хэрэглэж буй орос үсгийг бүрэн хэрэглэж явуулсугай...» гэж заасан байдаг.

Монголын шинэ үсгийн зөв бичихзүйн талаархи судалгаанаас үзэхүл, дээр дурдсан тогтоолд заасанчлан олон нийтийн, нэн ялангуяа монгол хэлний нарийн мэргэжлийн хүмүүсийн санал бодлыг тусгаагүй, зөвхөн Цэдэнбал даргатай улсын комиссынханы хэмжээгээр эз дийлэн шийдвэрлэсэн байдал тодорхой харагддаг бөгөөд иймэ байсан нь ч уул комисст оролцож явсан зарим нөхдийн бичсэн зүйлд санамсаргүй батлагддаг юм.

Шинэ үсгийн талаар одоо олон нийтээрээ сайн мэдэж байгаа тул дэмий олныг нурших нь илүүц гэж бодоод авч хэрэглэсэн түүхэн байдлыг албан ёсны баримтад түшиглэж, дээр дурдсан байдлаар товч танилцуулах нь уншигч авгай нарт илүү сонин болов уу гэж бодлоо.

Дээр дурдсан үсэг бичгийн тухайт хэсгийг ерөнхийд нь авч үзвэл, бусдын шахалтаар арга буюу авсан бичгийн тухайд биш, харин монголчууд өөрснөө ямар учраас үсэг бичгээ олонтаа солих болов? гэдэг асуулт аяндаа гарах нь мэдээж билээ. Үүнийг хоёр гол зүйлээр тайлбарлаж болно. Нэгд, улс төрийн шалтгаанаар үсэг бичгээ сольж өөрчлөж байсан талаар тухай

тухайн бичиг дээр цухас боловч өгүүлснийг эргэж санахад илүүдэхгүй буй заа. Хоёрт гэвэл, монгол бичгийн хэлийг тухайн үеийн аман аялгуундаа ойртуулж, монгол бичгийн дүрс ижил боловч дуудалга өөр өөр байсныг нутаг нутгийнхаа яриандаа ойртуулах гэсэн эрмэлзэлтэй холбоотойгоор «тодчилох» гэсэн бас нэгэн зорилго байжээ. Гэвч энэхүү хоёрдугаар зорилго нь нийт монгол туургатны хэл аялгууны байдлыг тэгш тусгасан монгол бичгийн онцлог чанарыг давж, илүү гарч чадсангүй тул шинээр зохиосон тэр олон бичиг нь тухайн тодорхой нэгэн хэсэг үед буюу тухайнхаа нэгэн хэсэг газар нутагт хязгаарлагдмал байдалтай хэрэглэгдсэнээс биш нийт монгол туургатны хэл аялгуунд жигд тохирч чадахгүйд хүрчээ. Энэ тухай дараагийн Монгол бичиг гэдэг хэсэгт илүү тодорхой өгүүлэх болно. Гэвч монголчуудын үсэг бичгийн шинэчлэл хийх гэсэн оролдолгоос хоёр гол дүгнэлт хийж болно.

Түүхэн хөгжлийнхөө явцад монголчуудын хэрэглэж ирсэн үсэг бичиг нь үүсэл гарлын хувьд хүмүүн төрөлхитөний бүтээн буй болгосон бичиг үсгийн өнө эртний гурван уламжлалд, тухайлбал: Арамей гаралтай согд бичиг, брахми гаралтай төвөд-нагарын бичиг, кирилл гаралтай орос-слав бичигт тус тус холбогдон очих бөгөөд цөм авианы бичигт хамаармуй. Тэгэхдээ монголчууд бэлэн бичгийг хэвээр нь авч хэрэглэж байсангүй, цөмий нь боловсруулан засч эх монгол хэлнийхээ зүйд нийцүүлэн тэнхцүүлж иржээ.

Бас нэгэн зүйл, монголчуудын хэрэглэж ирсэн олон зүйл үсэг бичигт буй нийтлэг нэгэн онцлог бол тэдгээр бичгийн цагаан толгойн бүрэлдэхүүнд төвөд, самгард, хятад, түрэг мөн орос зэрэг европ дахины олон хэлний үг, бичвэрийг тухай тухайн хэлээр нь тэмдэглэн бичдэг галиг үсгийн тогтолцоо заавал ордог явдал юм. Энэ нь монголчуудын хэрэглэж ирсэн зүйл зүйл бичиг үсэг бүр нь олон ард түмний бие биесээ харилцан баяжуулах соёл боловсролын өвөрмөц гүүр болж, бидний монголчууд эрт цагаас эхлэн бусад ард түмний дэвшилтэт соёл боловсролыг эрх тэгш хүндэтгэж байсны бас нэгэн баталгаа буюу заа.

Rintchen B, **Zwei unbekannte mongolische Alphabete aus dem XVIII Jahrhundert,** AOH, Tom. II, Fasc. I, Budapest, 1952, s. 62—71.

Poppe N, Krueger J. R, **The Mongolian monuments in hPhags-pa script,** GAF, Band 8, Wiesbaden, 1957.

Ринчен, **Монгол бичгийн хэлний зүй,** Удиртгал, 1964.

Истрин В, **Возникновение и развитие пиеьма,** М., 1965.

Hans Jensen, **Die Schrift,** Berlin, 1969.

Сүхбаатар Г, **Сянби,** УБ, 1971.

Кара Д, **Книги монгольских кочезников,** М., 1972.

Окладников А. П, **Центрально-азиатский очаг первобытного искусства,** Новосибирск, 1972.

Фридрих И, **История письма,** М., 1979.

Сүхбаатар Г, **Монголчуудын эртний өвөг,** УБ, 1980.

Шагдарсүрэн Ц, **Монгол үсэг зүй,** Тэргүүн дэвтэр, УБ, 1981.

Булаг Б, **Монгол үсэг бичгийн товч түүх,** Хөххот, 1983 (монгол бичгээр)

Боошиан, **Монгол үсэг бичгийн ухаан,** Хөххот, 1984. (Монгол бичгээр).

Наваан Д, Сумьяабаатар Б, **Өвөг монгол хэлний чухаг дурсгал,** УБ, 1987.

МОНГОЛ БИЧИГ ТҮҮНИЙГ ҮЗЭЖ СУРАХЫН УЧИР ХОЛБОГДОЛ

Монгол туургатан нар өвөг дээдсийнхээ үеэс түүхэн хөгжлийнхөө туршид арав гаруй үсэг бичгийн тогтолцоог хэрэглэж ирсэн тухай өмнөхи хэсэгт ярьсан билээ. Энэ олон бичгийн дотроос анх буй болсон цагаасаа өнөөдрийг хүртэл хамгийн өнө удаан бөгөөд тасралтгүй, бас дээр нь нийт монгол туургатанд нийтлэг хэрэглэгдсээр ирсэн нь гагцхүү *монгол бичиг* билээ.

Энэ бичиг яагаад ийнхүү он цагийн саалтад хоцролгүй явсаар өнөөдрийг хүрэв? гэдэг асуулт гарах нь зүйн хэрэг бөгөөд эх хэл, монгол бичгээ шамдан сурах их эрмэлзэл нийтээр өрнөж байгаа өнөө үед орчин цагийн хэлшинжлэлийн үүднээс үнэн мөнөөр нь хариулах явдал хэрэгтэй байна. Монгол бичгийн талаар бид 40—50 жилийн турш үнэн мөний нь нууж, гүтгэж гүжирдсэн, улстөржсөн тайлбар соноссоор түүнд итгэмэр болсоор, зарим үзэл сурталжсан хүний сэтгэлд тэр нь итгэл үнэмшил болсоор буй тул үргэлжлүүлэн гүтгэж муучлах явдал байсаар байгааг анхаарахгүй, анзаарахгүй байхын арга алга байна.

Одоо энэ бичгийг олон нийтийн дунд *монгол бичиг, хуучин монгол бичиг, уйгуржин монгол бичиг*, баруун монгол болон халимагт *худма монгол* бичиг гэх зэргээр олон янзаар нэрлэсээр байна. Иймд нэрийн талаар цухас ярих хэрэгтэй буй заа гэж эрхгүй бодогдоно. Хуучин гэдэг нэрийн тухайд монголчууд олон үсэг бичиг боловсруулан хэрэглэж ирсэн тул түрүүчийн бичиг болгон хуучин нэрийг авч цагийн урсгалд шинэ байсан бичиг ч хуучин болдог байсантай холбоотой ажээ. Харин 1940 хэдэн оноос кирилл бичгийг авсан үеэс монгол бичгийг хуучирсан баларсан гэдэг утгаар хуучин бичиг гэж нэрлэх явдал айхавтар их газар авсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм. Уйгуржин монгол бичиг гэгддэгийн учрыг нэг домогтой холбож үзэх хэрэгтэй юм. Уул домогоор бол Монголчууд найманыг дайлахад Тататунга хэмээх бичгийн сайдыг олзлоход өврөөс нь уйгур үсэгтэй тамга гарснаас үүдэж уул бичгийг авах болсон гэж өгүүлсэн байдаг. Гэвч түүхэн баримт сэлтээс үзэхэд уг домог төдий л үндэс муутай болох нь мэдэгдэх бөгөөд энэ талаар хойно арай дэлгэрэнгүй ярьсу. Бас монгол бичгийг хэдэргийн

хэлбэрт дулдуйдаж зохиосон гэдэг өөр нэгэн домог ч байдагийг хэлэхэд сонин байх болов уу!

Монгол бичгийн үүсэл, он цагийн талаар эрдэмтдийн дунд хэдэн санал бий. Харин сүүлийн үеийн судалгааны шинэ баримт хэрэглэгдэхүүнд тулгуурлан олон эрдэмтэн монголчууд монгол бичгээ XIII зуунаас нэлээд өмнө авсан гэж санал нэгтэй үзэх боллоо. Гэхдээ Финикээс гаралтай Арамей бичгийг Согд нараас Уйгур, Монгол хоёр нэгэн зэрэг авсан уу? эсвэгөөс Согдоос Уйгурууд аваад дараа нь монголчууд уйгураас дам авсан уу? гэдэг талаар арай санал нэгтэй болоогүй байна. Энэ хоёр саналын аль хагалахад олон талын баталгаа баримт хэрэгтэй болой.

Монгол бичгийн хэл нь чухам хэдий үеийн монгол хэл буюу аялгууны онцлогийг тусгасан бэ? гэдэг асуулт юу юуны өмнө уг бичгийг авсан он цагийг тодорхойлох гол зүйл болох нь хэн бүхнээ ойлгомжтой билээ. Монгол бичгийн хэлний байдлыг монгол хэлний түүхийн баримт сэлт, тухайлбал, нангиад галигаар тэмдэглэгдэн үлдсэн эртний монгол хэлний жишээ, сянби хэлний аялгуу болох табгач хэлний дурсгал, хятан хэлний хийгээд дундад үеийн монгол хэлний хэрэглэгдэхүүн, бас нутгийн аялгууны баримт сэлттэй харьцуулан үзэхүл их л сонин зураг гарна. Үүнд: монгол бичгийн хэл нь дундад үеийн монгол хэлний хэрэглэгдэхүүнээс хамаагүй түрүү үеийн онцлогийг тусгаж харин ч табгач хэлний үгийн дуудалгыг сэргээсэн байдалд илүү ойртож очдог. Энэ бол сонин дүгнэлт гаргах бололцоо гаргаж байгаа хэрэг.

Нэлээд олон судлагчийн үзэж байгаагаар Уйгурууд X—XI зуунд Согдоос бичгээ авсан гэж байна. Гэтэл түүхийг нарийвчлан үзэхэд VIII зуун гэхэд Согдууд араб нарт эзлэгдээд согд бичгээ орхин араб бичигт орсон гэдэг баримт байдагийг яав ч мартах аргагүй билээ. Тэгэхээр Согд нар хэдийнэ орхиод хэдэн зуун жил болсон бичгий нь тэднээс Уйгурууд авсан гэхэд учир шалтгааны үүднээс их эргэлзээ төрүүлэхэд хүрнэ. Ингэж бодвол Уйгурууд Согдоос яав ч X—XI зуунд бичиг авсан байж таарахгүй, наанадаж VIII зуунд авсан болохоос зайлахгүй.

Бас нэгэн зүйл: монголын түүхийн төвөд хэлээр бичсэн «Хор чойнжунг» буюу «Монгол газар шашин ном дэлгэрсэн түүх»-нээ:

> «...(Согдын) мэргэн багш нар уйгур хийгээд монголчуудад үсэг бичих унших ба бурханы дээд ном зарлиг, шаштар, сайн зарлигуудыг өөр өөрийн хэлээр орчуулах ёсыг үзүүлж сургавай... Тэр цагт тэднар сайн зарлигийг уншихад согдаг бичгийн дээрээс эндэхэг хийгээд өөр өөрийн хэлнүүдэд холимогоор орчуулснаас, номлон унших амны уншилгыг үйлдсээр буй ажгуу. Тэр шалтгаанаар одоо манагаар ч номын хэл нь энэдхэг, уйгур, монгол холимогоор оршсон болой...»

хэмээж дурдсан нь бий. Энэ эшлэлд дурдсаныг батлах баримт бас байна. Тухайлбал: нийтлэг нэлээд нэр томьёоны бичсэн байдлыг үзвэл уйгур, монгол хэлээр ялгаатай бичсэн баримт цөөнгүй байдаг явдал ч үүний нэгэн баталгаа буюу хэмээж санамуй. Энэ бүхнээс үүдэж дээр дурдсан «Хор чойнжун»-д товлосон он цагаар бодвол, VII—VIII зууны үест уйгур, монгол хоёр эшлэлд өгүүлсэнчлэн нэгэн зэрэг Согдоос бичиг үсэг авсан байж бүрэн болох таамаглал аяндаа гарч ирнэ.

«Хор чойнжунг»-д дурдсан зүйлийг батлахаар нааштай баримт юу байна вэ? гэвэл бас бий. Монголч эрдэмтэн Б. Лауфер, академич Б. Я. Владимирцов, Г. И. Рамстедт нарын судалгаанд уйгур хийгээд монгол хэлнээ байгаа самгард нэр томьёоны зүйл Согдоор дамжиж орсон хэмээсэн нэгдмэл дүгнэлт гаргасан байдаг бөлгөө.

Энэчлэн Согдууд Монголчуудтай холбоо хэлхээтэй байсан гэсэн өөр нутлагааг гаргаж болно. Тус улсын нутаг дэвсгэр дээр Согдуудын үлдээсэн гүнзгий ул мөр багагүй байдаг. Үүнд: согд бичээс бүхий хөшөө дурсгал хэд хэд олдсон нь судлагчдын анхаарал сонирхлыг хэдийнээс татаж монгол нутгаас олдсон «Сэврэйн согд бичээс», «Бугатын согд бичээс» гэх зэргээр тодорхой нэр ус авч эрдэм шинжилгээний гүйлгээнд орсон билээ. Бас түрэгийн Моюнчүрийн хөшөөний бичигт

> «...Ишгээд би Согд, Табгач (энд хятад гэсэн утгаар байгаа!) нарт Сэлэнгийн эрэг дээр Байбалык хот цогцлохыг тушаав...»

гэсэн үг байдаг бөгөөд иймхүү цогцлуулсан хотын туурь нь одоо Булган аймгийн Хутаг сумын нутагт Бийбулаг нэртэй байсаар байгааг бид нар сайн мэдэх билээ. Энэ хотыг цогцлоход Согд нар оролцсоноос гадна тэнд арилжаа наймааны ажлаар аж төрдөг асан согд хүмүүс олон байсныг түүхэн баримтад нэг бус удаа тэмдэглэсэн нь бидний үед хүрч иржээ.

Монголчуудаас Согдод хариу нөлөөлсөн зүйл байна уу? гэдгийг бид бас сонирхохгүй байхын аргагүй. Одоохондоо бидэнд ном бичгээс өөр тус болчих зүйл хараахан олдохгүй байна. Уг нь манай залуу судлагчдаас монголчуудын соёл боловсрол гадагшаа ямар улс үндэстэнд, яаж нөлөөлсөн зэргийг судлах цаг хэдийнээ болоод байгааг анхаарч үзээсэй билээ гэж энэ далимд хүсэн гуюнам. Бид өөрснөө л ийм судалгааг шамдан хийх нь монголчуудын утга соёл, эдийн боловсролын түүхийн судлалд буянтай сайхан ажил болох нь ямар ч маргаангүй бөлгөө. Согд улс мандан бадарч байсан үеийн зоос мөнгөний нь цуглуулгаас саявтархан тэр нутаг газар байгаагүй хоёр бөхтэй (монгол) тэмээний дүрс бүхий хоёр янзын зоос олдсоныг эрдэмтэд нэн сонирхож, согдоч эрдэмтэн О. Смирнова авгай энэ хоёр зүйл зоосыг одоо тайлбарлана гэхэд учир битүүлгэ бай-

на гэж тэмдэглэжээ. Бухаарын баянбүрдийн Варахши балгас орчмоос олдсон, дурдсан зоосыг дэлдэх үест Төв Азийн нүүдэлчдийн, магадгүй тэр дундаа монголчуудын өвөг дээдсийн нөлөө байсан байж бүрэн болох боловч хөдлөшгүй баримтаар л нутлах хэрэгтэй юм. Энэ мэт соёл боловсролын хэлхээ холбооны асуудлыг ялангуяа гадна тийш нь хандуулан судлах буй заа гэж залуу эрдэмтэн нөхдөд гүнээ найдна.

Бас нэгэн зүйл, халимаг, баруун монголчуудын дунд монгол бичгийг *худма үзүг* гэж нэрлэдэг тухай дээр зөвхөн дурдаад өнгөрсөн. Энэхүү худма гэдэг үгийн талаар судлагчид янз янзын санал дэвшүүлсээр байгаа бөгөөд зарим нь тод үсэг гэдэгтэй эсэргүүцэлдүүлэн хуудам гэсэн үг гэж үздэг боловч авиазүй гэдэг ухааны үүднээс тэгж тайлах боломжгүй болох нь хэдийнэ мэдэгдсэн байна. Мөн уугуул, уг гэсэн утга санаа бүхий удам гэдэг үгийн эртний хэлбэртэй холбож үзэж байгаа эрдэмтэн байна. Энэ бол монгол хэлний авиазүйн хувьсал хөгжлийн үүднээс тайлбарлах бүрэн үндэстэй санал гэдгийг хэлэх хэрэгтэй юм.

Энэ номыг бичигчийн хувьд бол худма гэдэг үгийн учир холбогдлыг нэхэн үзсээр согдоор «ном, уншилга, эш, зарлиг» гэсэн утгатай үг байсан байж тун ч болзошгүй байна гэдэг санал дэвшүүлсэн бөлгөө. Ийнхүү согдын *хутба* гэдэг үгтэй холбож үзсэн саналыг маань зарим эрдэмтэн зөвшөөн тэжээж дэлхий дахинаа түгэн дэлгэрсэн анхны авианы үсгийн түүхэнд шууд холбогддог, *Кадма* гэдэг нэртэй учир шалтгааны холбоотой байж бүрэн болно гэж үздэг. Кадма бол эртний финикийн хаан хөвгүүн бөгөөд тэр цагийн домгоор анхны авианы үсгийн зохиогч мөн тул үсэг бичгийн түүхнээ тийнхүү зохиосон бичгий нь Кадма'гийн үсэг гэж нэрлэж заншсан явдал байдаг. Энэ жишлэнгээр европ дахинаа монгол дөрвөлжин үсгийг зохиосон хүнээр нь Пагвагийн үсэг гэж нэрлэдэг ёсон тэр бөлгөө. Монгол бичгийн ч гэсэн, согд бичгийн ч гэсэн дээд өвөг нь даруй Арамейгаар дамжиж Финик үсэгт холбогдон очдог тул худма, хутба, кадма гэдэг нэрийн хэлхээ холбоо энд дурдсанчлан байж болохыг үгүйсгэх аргагүй юм.

Монголчууд ийнхүү нэлээд эрт цагаас монгол бичгээ хэрэглэсээр соёлын харилцаа хэлхээ хөгжихийн хирээр гадаад үг, нэр усыг монгол бичгээр тэмдэглэх шаардлага улам ихсэж ирэхэд 1587 онд Аюуш гүүш гэдэг бичгийн хүн *Али-гали* гэдэг тусгай үсгийг нэмж зохиосон нь монгол бичгээр самгард (буюу эртний энэдхэгийн ном судрын боловсорсон хэл), төвөд, хятад зэрэг гадаад хэлний үгийг зөвлөнгүй бичих тэмдэглэх боломжоог бүрэлдүүлжээ. Нэгэнт самгард хэлний үг, авиаг тэмдэглэж болно гэдэг нь авиазүйн хувьд энэдхэг-европын овог хэлний үг, авиаг тэмдэглэж чадна гэсэн үг. Гэтэл монгол бичгээр гадаад үгийг тэмдэглэх ямар ч болоцоо байдаггүй гэж

нэгэн хэсэг хүн монгол бичгээ гүтгэн доодлож хэлж бичсээр, сурталдсаар, тэр нь одоо болтол нарийн учир мэдэхгүй бас нэгэн хэсэг хүний тархи толгойд эргэлдсээр байгаа боловч монгол цагаан толгойн бүрэлдэхүүнд Али-гали үсэг ордогоороо орсоор, тийм цагаан толгой дотоод гадаадгүй нийтлэгдсээр, монгол бичгээр төвөд, самгард зэрэг гадаад хэлээр бичсэн өдий тэдий ном судар хувь хүний гар дээр болон энд тэндхийн номын сангийн хөмрөгт хадгалагдсаар байгаа бие бодтой баримт нутлагааг үгүйсгэж чадахгүй бөлгөө.

Монгол бичгийн хажуугаар олон зүйл шинэ бичиг гарсан боловч монгол бичиг нь бичих, сурч сургахад хялбар, монгол хэл аялгуу, нийт монгол туургатны хэлний зүй тогтолд жигд таацан тохирч байсан тул хамгийн удаан, лавтайяа 1000 хол илүү жил нийт монгол туургатанд тогтвортой хэрэглэгдсээр өнөөдрийг хүрчээ. Энэ тухай арай дэлгэрүүлэн, энгийн жишээгээр тайлбарлан өгүүлсүгэй.

Монгол бичигт *о, у* болон *ө, ү* эгшгийг нэгэн ижил хэлбэрээр, *ха, га* болон *хэ, гэ* мөн *д, т* хийгээд *ж (з), й* гийгүүлэгчийг нэгэн хэлбэртэй тэмдэглэдэг нь одоогийн зарим «судлаач»-ийн үздэгээр мэдэлгүй буюу ялгаж чадалгүй будилсан хэрэг огт биш, цаанаа нарийн шалтгаантай, тухайлбал монгол хэл, монгол хэлний олон аялгууны авиазүйн онцлог хуулийг нарийн судлаад, тэр судалгаагаа үсэгзүйн зарчимтай нарийн хослуулж одоо манайхны хэлэх дуртай үгээр бол онолоо амьдрал практикт ёстой гайхамшигтай хэрэглэсний жишээ юм. Тийм ч учраас өндөр гэдэг үгийг буриад аялгуутан үндэр гэж яг дууддагаараа уншихад огт саад байхгүй. Халхын ихэнхи нутагт соёл, ташуур, хоршоо, халзан гэж байхад өвөрхангайн зарим газар суюл, халхын нэлээд хэсэг нь дашуур, горшоо, дариганга хавиар галзан гэх зэргээр нутаг орныхоо дууддаг дууддаг жишлэнгээрээ уншихад бүрэн тохирно. Монголын төв нутгаар засах гэж байхад баруун монголд ясах гэж дуудах жишээтэй байдаг.

Учир иймээс монгол бичиг маань нийт монгол туургатныг үсэг бичгийн хувьд нэг талаас нэгтгэж, нөгөө талаас монголын олон аймаг үндэстэн ястны хэл аялгууг эрх тэгш хөгжих боломцоог гаргаж өгдөг онцлогтой байсан ажээ. Гүн ухааны хуулиар үзвэл нэг талаас монгол хэл маань байж, нөгөө талаас монгол хэлний олон аялгуу оршин байж сая эх хэл маань тогтнож байхын үндэс болох ёстой. Харилцан бие биесээ нөхцөлдүүлсэн, бие биеэ баяжуулсан, харилцан шүтэн барилдсан ийм хоёр тал байхгүйгээр ямар ч хэл оршин тогтнож, хөгжиж чаддаггүй ажээ. Иймээс бид олон монгол хэл, монгол хэлний нутгийн олон аялгууг эрх тэгш жигд хөгжүүлбэл эх монгол хэл маань улам ч нарийсан хөгжих үндэс болно гэдгийг ургэлж санаж явбал зохилтой.

Монгол бичиг нь түргэн бичгийн үүрэг давхар гүйцэтгэж, бичиж дадсан хэн боловч хүний ярьсан зүйлийг аан уунгүй тэмдэглэж чаддаг байсныг хэлэх хэрэгтэй. Бусад хэл, бичгийн тухайд түргэн бичгийн тусгай зохиомол тогтолцоо байдаг, түүнийг тухайн хэл бичиг мэддэг хүн бүр үзэж сураагүй л бол бичиж хэрэглэж чаддаггүй гэдгийг энд цухасхан дурдсу.

Энэхүү дурдсан бүх чанар нь монгол бичгийг бусад монгол бичгээс давуутай болгож нийт монгол туургатны дунд жигд бөгөөд тэгш, тогтвортой бөгөөд өнө удаан хэрэглэх бололцоог буй болгосон гэж баттай хэлэх бүрэн үндэстэй юм.

Үүнтэй уялдуулан нэгэн зүйлийг онцлон дурдуушгай санагдаж байна. Юу хэмээвээс Финикээс үүсэлтэй Арамейгаар дамжиж салбарласан бичгийг хэрэглэж байсан Согдууд VIII зуунд, мөн Уйгарууд XI зуунд арабын буюу лалын соёлын хүрээнд орж араб бичиг авсаны учир түрүүчийн хэрэглэж байсан үсэг бичгээ орхисон билээ. Харин монголчууд бид согдоос дам авсан худма монгол бичгээ орхиж мартсангүй харин ч монгол хэлэндээ таацуулан боловсруулж өнөөдрийг хүртэл хэрэглэсээр байгаа нь монголын ард түмнээс дэлхий дахины үсэг бичгийн түүхэнд гүйцэтгэсэн нэгэн чухаг хувь нэмэр даруй мөн бөлгөө. Хэрэвээ монголчууд энэ бичгийг орхиж мартсан аваас дэлхийн анхны авианы үсэг-Финикээс гарч Арамейгаар дамжиж салдарласан, хүн төрөлхтөний буй болгосон нэгэн том соёлын хэсэг үгүй болох байсан аймээ гэж эрхгүй санагддаг.

Өөрчлөлтийн ач буянаар монгол бичгээ сэргээж, үзэе, сурая гэснэ эрмэлзэл зүйн дагуу өрнөсөөр байна. Иймд одоо монгол бичгээ сурч судлахын учир холбогдол юунд орших тухай тайлбарлах хэрэгтэй гэж бодож байна.

Аливаа зүйлийн тухайд, онгөрсөн үегүй одоо ба ирээдүй үе гэж байдаггүй, онгөрсөн үеийг мэдэхгүйгээр ирээдүйг төсөөлөх аргагүй гэж хэлдэг, бичдэгийг мэдэхгүй хүн байхгүй буй заа. Үүнчлэн хэн хүн боловч эх хэлээ үндэстэй сайн мэдэе гэвэл хөгжиж ирсэн зам мөрий нь өөрийн эрхгүй анхааран үзэх шаардалга гарч ирнэ. Монгол хүн юм чинь монгол хэлээ мэдэхгүй яах юм бэ? гэж хялбарчлан ойлгодог байсан хандалга бараг 2—3 үеийн турш газар авсаар, ийм хандалгатан нар улс орны хэлний бодолгыг залсаар ирсэн тул эх хэлээ нарийн үндэслэлтэй сурах, сургах шаардалга үгүй болж, монголоор ярих, бичих нийгмийн шаардалга үндсэндээ үгүй ирсэнээс, Монголын зохиолчдын эвлэлийн их хурал дээр олон нэрт зохиолчийн хэлсэнчлэн монгол хэл ядуурч, доройтохын шалтгаан гарсан билээ.

Монгол хэлээ үндэстэй сайн ойлгож мэдэхэд харьцангуй түрүү үеийн монгол хэлний хөгжлийн онцлогийг тусгасан монгол бичгийн хэл одоо бидний маргалдан цэцэрхэж байгаа буюу учир начраа олж ядан байгаа олон асуудалд үнэн зөв хариуг

өгч чаддаг, маргааны буруу зөвийг ялган салгах гол хэмжүүр болсоор байдаг бөлгөө. Үүнийг зарим нэгхэн хялбар жишээгээр тайлбарлая. Шинэ үсгээр *хил, хязгаар, хөрөө, хялгас, шүд, хярган, хядах, шивэх* гэж бичдэг олон үгийн гарлыг энэ янзаар нь олж тайлбарлах арга байхгүй, харин эл үгийг монгол бичгээр хэрхэн бичдэг байдлаас нь үзвэл цөм нэг язгууртаас салбарласан болох нь амархан харагддаг. Бас *нүүр, нүүц* гэдэг хоёр үгийг нэг язгууртай, *сэглэх тэслэх хийгээд туших шүтэх*, мөн *хаших шахах* гэдэг үг угтаа нэг үг байснаа үе тонгорохын хуулиар салбарлаж тус тус хошоод үг болсон гэдгийг монгол бичгийн баримт л бидэнд хэлж өгнө.

Бас нэгэн зүйл гэвэл, орчин цагийн монгол хэлнээ шинэ үсгээр нэг үгийг олон янзаар бичиж байгаа явдал өдий төдий бөгөөд зөв хэлбэрээр нь бичих хэрэгтэй нь мэдээж байлаа шүү дээ. Ганц жишээ гэхэд *дууриал, цуурай* гэдэг үгийг аль алий нь хэдэн янз бичдэг байлаа. Жигдлэнэ гэхэд зарим хүн-*иа*гаж нэг тогтолцоотой байх ёстой тул дууриал, цууриа гэх ёстой хэмээн тайлбарлаж өдгөөчлөх хандалга ч гардаг л байлаа. Гэтэл эл хоёр үгийг монгол бичгээр дагурийал, цуурай гэж бичдэг тул «нэг тогтолцоотой» гэж хэлэхийн аргагүй юм. Энэ мэтээр сүүлийн үед монгол бичгийн зөв бичихзүйн утга салгадаг нарийн ялгарааг мэдэлгүй, ерөнхийлөх буюу аль нэгэн хэлбэрий нь таамгаар баримтлах болсноос утга санааны нарийн ялгамжаа алдрах явдал багагүй гарсаар байна. Одоо *бохирдох, бохиртох* гэдэг хоёр хэлбэрийг ялгахаа больж бохирдох гэдэг ганц хэлбэрийг хэрэглэсээр байна. Уг нь *бохирдох* гэвэл хэтэрхий бохирын учир тухайн хэрэгцээнд үл тохирно гэсэн утга, *бохиртох* гэвэл уул юм уламаар бохир болох гэсэн утга заадаг билээ. Тэгээд ч *хувцас бохирдоод өмсөх аргагүй болжээ, нүүрын ус бохиртож байна* гэж утгын нарийн ялгамжаа гардаг байсан бөлгөө. Гэтэл монгол бичгээ сайн мэдэхгүй зарим нь монгол бичигт *д, т* хоёр адил хэлбэртэй байдаг болохоор яаж ялгадаг байсан юм бэ? гэж маргасаар үгүйсгэсээр байгаа баримт ч дайралдаж л байна. Хэлшинжлэлд аливаа хэлийг давхарласан тогтолцоо гэж үздэг. Бас бичиг бол хэл биш. Тийм ч учраас хэлбэрсудлал буюу үгзүйн аргаар дээрхи ялгааг илтгэж монгол бичгээр *бохирдох* гэвэл *бокирдаку, бохиртох* гэвэл *бокиртуку* гэж ялгадаг байсан билээ. Хэл бол тогтолцоо мөн учраас үүнийг энэ жишлэнгийн олон үгээр тухайлбал: усдах, устах, үсдэх, үстэх гэхэд өөр өөр утга гаргадаг баримтаар батлахад нэн хялбар. Утгын нарийн ялгаа ийнхүү дагаварын тухайд тодийгүй биеэ даасан үгийн хувьд ч гарч хамбичвэргүй нөхцөлд ялгахын аргагүй болсон жишээ цөөнгүй байна. Монгол бичигт *эркилэку* гэвэл ямар нэг ажил үйлийг хариуцан эрхлэх, *эркэлэку* гэвэл эцэг эхдээ эрхлэх гэсэн утга илтгэдэг байсан бөгөөд ганцаараа уул үг байхад л ялгарч харагддаг байсан бол

одоо хоюулаа эрхлэх гэдэг ганцхан хэлбэртэй болсон байна. Энэ мэтээр монгол хэлний олон үг хэлзүйн хувьд зүй тогтлоосоо гажсан явдал их гарсан юм.

Монгол хэлний ийм гажуудлыг нарийн мэргэжлийн эрдэмтэд хэлсээр бичсээр, засч залруулах гэж тэмцсээр ирсэн боловч зүдэг хар цагийн эрхээр ажил амьдрал, амь насаараа хохирсоор ирсэн болохоор хэлний мэргэжилтэн нарын дунд

«үйл нь ирсэн хүн
үсгийн дүрмээр оролдож
үндэсний үзэлтэн болно» гэдэг

яриа гарсан юм. 1940 оны III сард Ю. Цэдэнбал даргатай шинэ үсгийн комиссын илтгэлийг хэлэлцсэн хурал дээр Х. Чойбалсан:

«...шинэ үсгийг эсэргүүцэгч аливаа нэгэн үндэсний үзэлтэн, бүтцохигдсон феодал, лам нарын үлдэгдлийн эсэргүүчүүдэд хамгийн эрс хатуу цохилт өгч тэмцэх хэрэгтэй...»

гэж хэлжээ. Ингээд л монгол хэл бичгээ гэсэн хүн болгон үндэсний үзэлтэн бөгөөд эсэргүү болсоор бараг 1990 оныг хүрсэн ажээ.

Авиазүй, сонсолзүйн үүднээс авч үзвэл монгол хэлний эгшиглэх чанар их л онцлогтой бөгөөд энэ онцлог нь үеийн бүтэцтэй холбоотой юм гэж судлагчид бичсэн нь ганц биш ээ. Монгол хэл нь эгшиг гийгүүлэгч салаавчилсан дөрөвхөн зүйл үетэй бөгөөд үүнийг орчин цагийн туршилт авиазүйн судалгаа ч нутласаар байна. Тэгээд ч аман зохиолын зүйлийг аялгуулан унших, дуулах зэрэгт улам ч тодорхой мэдэгддэг. Ийм ч учраас шүлгийн хэмжээ тохируулан хайрцаглах, хөгжмийн зохиол бичихэд тухайн үгийг ая дэнд нь тохируулан хуваарилая гэхэд одоо бидний бичиж байгаа хэлбэр тэр бүр сайн тохирдоггүй гэж нэрт хөгжмийн зохиолчид маань ярьж байгаа нь монгол хэлний үеийн бүтцийг шинэ бичигт яг нарийн тусгаж чадаагүйтэй холбоотой хэрэг.

Монгол бичигт суурилсан монгол бичгийн хэлний найруулга нь хөгж хөгжсөөр тогтсон тансаг найруулгынхаа шатанд хүрсэн бөгөөд найруулгын онцлогийг бичгээс нь салгахын аргагүй шүтэн барилдаж нөхцөлдсөн байдаг билээ. Тэгээд ч Төрийн шагналт зохиолч Б. Явуухулан, Ч. Лодойдамба, С. Дашдоров нарын олон хүн монгол бичгээр бичсэн буюу байгаа зохиол бүтээлийг шинэ бичгээр болгоход найруулга нь эрс мууддаг тухай, мөн шинэ үсгээр байгаа хэлбэрээр монгол шүлэг гийг хайрцагласныг уянгалуулан уншихад үеийн тоо, бүтэцтэйгээ тохирч өгдөггүй гэж зохиол бүтээлдээ тэмдэглэсэн, хэлсэн нь яг үнэтэй холбоотой юм.

Монгол бичгийг сурахад түмэн төвөгтэй гэдэг бодлыг хүмүүсийн санаа сэтгэлд шингээж сурахад хэцүү бичиг үсэгтэй байх нь улс орны хөгжилд саад болно гэж албаны тогтоолд

зааж, сурталдсаар дөч гаруй жил болсон билээ. Чухамдаа монгол бичгийн дүрэм маань үгийн үндсээ мэдэж л байвал зөв бичихийн тухайд хувилах, хувилгах үсгийн цөөн хэдхэн дүрэмтэй. Тэгээд ч монгол хүн төдийгүй гадаадынхан ч сурахад төдий л хэцүү бус байгааг олон орны монголч эрдэмтэн нөхөд, оюутан сурагчдын монгол бичгийг гаргууд сайн сурсан биебодтой жишээ бэлхэнээ харуулж, монгол бичиг сурахад хэцүү бэрх гэж хий хоосон зүрхшээсээр үндэсний бичиг үсгээ сураагүй монгол хүнийг ичээсээр байгаа билээ. Олон улсын бичиг үсгийг авч үзэхүл хятад, япон бичиг нь үзэж сурахын тухайд яав ч монгол бичгээс хялбаргүй нь хэн бүхэнд мэдээж. Хэрвээ сурахад хэцүү бичиг үсэг улс орныхоо хөгжилд садаа тотгор болдог байсансан бол япон, хятад орны хөгжил манайхаас доогуур байх байж дээ гэдэг бодол төрмөөрсөн дөө.

Монгол бичгийг муулан доодлогч нар монгол бичиг нь ярианы хэлнээс хэт холдсон тул хоцрогдсон бичиг юм, ийм хоцрогдсон үсэг бичиг улс орны цаашдийн хөгжилд дохөмгүй, саад болно гэж 1930 оноос өөлж ирсэн тухай бид дээр эшлэл авч байгаад ярьсан асан. Англи хэлний бичилгэ дуудалга хоёр бас л ихээхэн зөрөөтэйг англи хэл мэддэг буюу сурч судалж байгаа хүмүүс лавтайяа сайн мэднэ ээ. Олон жилийн өмнө англи бичгийг засч ярианыхаа хэлэнд ойртуулах тухай санал гарч англи хэлээр ярилцдаг бүх орны хэлшинжлэлч нар хуран цугларч хэлэлцээд англи бичгийн дүрмийг засч өдгөөчлөх аваас англи хэлний уянгалаг аялуун байдал яваандаа алдрах болно гэж нэгэн дуугаар хүлээн зөвшөөрч англи бичгийн зөв бичихзүйг хөндөөгүй үлдээсэн билээ. Тэглээ гээд Англи улсын хөгжил ер саарсангүй, хэл нь ч дэлхий нийтэд улам түгэн тарсхаар байна.

Одоо цагт улс орны бүх салбарыг цахим тооцоолуургүйгээр хөгжүүлнэ гэж санах бүү хэл зүүдлэхийн ч аргагүйг саяханаас арга буюу ойлгох болж ирлээ. Иймд аж амьдралын шахалт шаардалгаар бичгээ тооцоолон бодох янз бүрийн хэрэгсэлд дуртай ч дургүй ч оруулахаас өөр арга байхгүй. Ингэхэд монгол бичгийн дүрэмд үгийн язгуур, үндэс, дагавар цөм тогтмол хөдөлгөөнгүй, өөрөөр хэлбэл монгол бичигт гээгдэх эгшиг, шилжих эгшиг гэх мэтийн хэлбэр урвуулах зүйл байдаггүй тул ямар нэг гажилтгүй шууд орж чаддаг.

Монгол бичгийн дээр дурдсан олон онцлог, боловсронгуй чанар нь сүүлд удаа дараа зохиосон олон зүйл монгол бичгээс давамгай хэвээрээ байсан тул монгол бичиг маань анх буй болсон цагаасаа өнөөдрийг хүртэл нийт монгол туургатны дунд бараг тасралтгүй тогтвортой хэрэглэгдсээр ирсэн бөлгөө.

Одоогоор бидэнд мэдэгдэж байгаагаар монгол бичгээрхи хамгийн түрүүний гэгдэж буй дурсгал бол Чингисийн чулууны бичиг гэж олон нийтэд алдаршсан таван мөр бичээс бөгөөд

үүнээс хойш тасралтгүй уламжлаасаар бидний үе хүртэл арвин их хэрэглэгдэхүүн монгол бичгээр хуримтлагдан иржээ. Үүнд их баға таван ухаан хийгээд бас бус бүх салбарыг хамарсан нүсэр их дурсгал багтаж байна. Бид тэр их сангаас ядахдаа мэргэжил мэргэжлийнхээ салбараар уншиж танилцахгүйгээр улс орон, ард түмэн, өвөг дээдсийнхээ үүх түүх, соёл боловсрол, аж төрөх ухаан, өв уламжлалаа мэдэх боломжгүй бөгөөд тэр бүрийг хөрвүүлж шинэ үсэгт буулгана гэвэл асар их хөрөнгө хүч, цаг хугацаа суйтгэсэн ажил болно. Монгол бичгээ сурч гэмээ нь хамгийн наад зах нь нэг байгаа юмаа дахин хэвлэлд бэлтгэх, хэвлэх гэж мөнгө хөрөнгө, цаг зав, хүн хүчийг хоосоор үрэхийн оронд өөр шинэ зүйлд зарцуулах боломж чгарах болно.

Уламжлалт өв соёл, эх хэл бичгээсээ хүнийрхэн хөндийрсөөр ямар байдалд хүрснийг бидний монголчууд өнөөдөр яс махаараа мэдрэх боллоо. Цаашид тийм маягаар явж болохгүй нь нүдний өмнө ил боллоо. Хэл сэтгэхүй хоёр салгахын аргагүй шүтэн барилдсан зүйл тул эх хэлнийхээ мэдлэг боловсролыг ахиулахгүйгээр сэтгэх бодох чадлаа нарийсган хөгжүүлэхэд бэрхтэйг мэдэж эхэллээ. Эх хэлээ үндэстэй нарийн зөв сурч судлахад монгол бичиг маань үндсэн суурь нь ч, зөв бурууг ялган шийтгэх хэмжүүр нь ч мөнөөс мөн болдог тул монгол хүний соёл боловсролын бахархал болсон монгол бичгээ шимтэн сурч судлах сайхан улирал тавин жил завсарлаад сая нэг ирлээ

ЛАВШРУУЛЖ ҮЗҮҮШТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Тэмдэглэх учир: Монгол бичиг хэмээх энэхүү хэсэг бол үүний өмнөхи **Монголчуудын үсэг бичиг** гэдэг бөлгийн дотроос арай түлхүүхэн **тайлбарлууштай** гэж бодоод сугалан авч ярьж буй зүйл тул лавшруулан үзүүштэй ном зохиолын зүйлийг дурдсан бөлгөөс шүүн танилцах ажаамуу.

МОНГОЛЧУУДЫН ҮСЭГ БИЧГИЙН ЭВХМЭЛ ХЭЛБЭР

Монголчуудын хэрэглэсээр ирсэн олон зүйл тогтолцоо бүхий үсэг бичгийн дурсгалыг үзэхүл бичих журмын хувьд

хичээнгүй,
таталган,
эвхмэл

бичиг гэсэн гурван гол ялгавартай байсан нь үзэгдэх бөгөөд *хичээнгүй маягаар* **өргөх** бичиг, албан бичиг зэрэг үнэ хүндтэй зүйлийг бичдэг, *таталган бичгээр* яаруу сандруухан тэмдэглэл хийх, эх зохиох, хувийн тэмдэглэл хөтлөх, навтарга ноорог зэрэг албан бус зүйлийг бичиж тэмдэглэдэг, *эвхмэл* янзы нь тамга, тэмдэг, захиралга хийгээд номын тэмдэг буюу тийз, мөн түүнчлэн гоёл чимэглэлийн зүйлд хэрэглэдэг байсан нь бусад олон улсын үсэг бичгийн уламжлалтай эгээ л адилхан ажгуу. Бичих журмыг ерөнхийлөн тайлбарлах эл боломжийг ташрамдуулан нэгэн зүйлийг дурдсу. Яав ч илүүц зүйл болохгүй буй заа. Монголын олон алдарт бичгийн хүмүүс, бичээч нар таталгаан хэлбэрийг төдий л ойшоон үздэггүй байсан бөгөөд «сайн бичээчийн гурван чаддаггүй юм» гэдэг тусгай нэр бүхий зүйл тэдний дунд уламжлагдсаар яваандаа дагаж мөрдөх хэв хууль мэт болсон байлаа. Тэр чаддаггүй гурван зүйл нь юу вэ? гэвэл, нэгд, ацаг шүдгүй бичиж чаддаггүй, хоёрт, буруу бичиж чаддаггүй, гуравт, удаан бичиж чаддаггүй гэсэн гурван зүйл болой.


Монголчуудын үсэг бичгийн эвхмэл хэлбэрийн тухайд бид эвхэж бичих гол журмын тогтолцоог гаргахын хамт бусад гадаадын үсэг бичигт хэрэглэдэг энэ мэт ёсноос ялгарах зарим онцлогийг цухас боловч гаргахыг хичээсүгэй. Ямар ч атугай монголчуудын үсэг бичиг эвхэн хэрэглэдэг байдал нь дундад зууны үеэс л Христус, Лалын шашны хүрээнд багтдаг Европ, Азийн улс орныхоос өвөрмөц байдаг гэдгийг хэлмээр байна.

Өнөөдөр, бидний мэдлэгийн хирээр эвхмэл бичгээр бичсэн хамгийн эртний гэгдэж байгаа дурсгал бол 1240 оны Өгөөдэй хааны зарлигийн хөшөөн дээрхи тамга, мөн 1267 он юм уу 1279 оны туулай жил Ил хан Абага'ас католик шашны элчид олгосон зар бичигт дарсан тамга болон Францын ван Гоо Филиппэд 1295 онд Ил хан Аргунаас, 1305 онд ил хаан Өлзийтөөс

илгээсэн захидал дээр (үүнд захидлын эцэст болон цаашид залгаа бүр дээр) дарсан тамгын дардас зэрэг болно.

Эвхмэл бичгийн дурсгалаас үзэхэд худма монгол, дөрвөлжин, соёмбо бичиг, түүнчлэн монгол бичигт дулдуйдан зохиосон, зарим нутагт хар худма гэж нэрлэдэг манж үсгийг эвхэж хэрэглэсэн зүйл арвин дайралддаг. Харин одоогоор тод бичгийн эвхмэл хараахан олдоогүй байна. Гэхдээ олдоогүй байгаа нь байхгүй байсан гэдгийн батлагаа болохгүй нь мэдээж буй заа.

Үүнээс гадна монголчуудын соёл боловсролын хүрээнд нөлөө тусгал их байсан энэдхэг, төвөд үсгийг эвхэж шашин сүм хийдийн хэрэгт, мөн уран барилгын чимэглэлд өргөн хэрэглэж байсан баримт бидний үед хүрэлцэн иржээ.




Дундговь аймгийн Эрдэнэдалай суманд байгаа уран барилгын чимэглэлд эртний энэдхэг үсгийг эвхэж хэрэглэсэн байдал

Монголын шашин суртаалын хүрээнд төвөд, самгард хэл их л үүрэгтэй, Европ дахинаа латин хэл ном бичгийн хэл болж байсантай адил, монголын эрдэмтэн, лам нарын хувьд номын хэл болж зохиол бүтээлээ төвдөөр бичих нэгэн уламжлал тогтсон байлаа. 1920 онд акад. Б. Я. Владимирцов «Монгол утга зохиол» гэдэг бүтээлдээ «...сүүлийн хоёр зуун жилд Төвөд газартаа хүртэл нэр цуу нь алдаршсан, төвөд хэлээр зохиол бүтээлээ туурвидаг нэрт зохиолч, утга боловсролын зүтгэлтэн олон хүн монголчуудын дотроос гарсан юм...» гэж тэмдэглэсэн байдаг билээ. Энэ бол «хоцоргдсон харанхуй бүдүүлэг» гэдэг тодотгол авсаар ирсэн монгол оронд чухамдаа гадаад хэл нэвтэрхий мэддэг эрдэм боловсролтон олон байсны гэрч болой. Учир иймээс монголчууд маань төвөд үсэгт дулдуйдаж зохиосон монгол дөрвөлжин бичигтээ суурилаж төвөд үсгийг эвхэж бичих тэгийг буй болгосон бөгөөд үүнийг нь төвдийн ном бичигт, тухайлбал V Далай лам Агваанлувсантүвдэнжамц (1617-1682) «Үсгийн аймаг элдэв зүйл цэцгийн эрхис» гэдэг номдоо

«*хор йиг*» буюу үгчлэн орчуулбал 'монгол үсэг' хэмээн нэрлэсэн нь бий. Тэгээд тэр зохиосон тэгээрээ самгард буюу төвөд хэлээр эвхэж тамга, гарын тэмдэг, номын нэр, чимэг зэрэгт оргон хэрэглэж иржээ. Жишээ нь гэхэд 1577 онд Алтан хаан (1507—1583) Монгол газар III Далай лам Содномжамц (1543—1588)-ыг залж авчраад Очир Дар Далай лам цол өргөмжлөж алтан тамга, бэлэг сэлтийн хамт барьсан тухай III Далай ламын намтарт өгүүлэхдээ:

> «...зуун лангийн алтан тамга өргөсөн. Эл тамга нь таван луугийн дүрстэй, хор-йиг бичгээр «Дорже чан Далай-и лама-и тамга жал» гэсэн бичигтэй. Тамгын гэр нь мөнгө...»

гэжээ. Энд тэмдэглэх нь: тамгын бичгийг монгол уншилгын дуудах маягаар тэмдэглэснээ хэлэх нь зүйтэй болов уу гэж үзлээ. Бас нэмж хэлэхэд төвөдөөр *хор йиг* гэдэг нэр томьёо нь монгол дөрвөлжин бичгийг заадаг гэдгийг сануулахад илүүдэхгүй биз ээ.



1577 **онд Алтан хаанаас III Далай лам Содномжамцад барьсан** алтан тамгийн дардас (хэмжээ 10,8 смх10,8 см)

Монголчуудын үсэг бичгийн эвхмэл бичгийн хэв маягийг үзвэл хэдэн зүйл ялгаа хялбарханаа мэдэгдэнэ. Үүнд:

1. Дөрвөлжлөн эвхсэн бичиг,
2. Угалзлан эвхсэн бичиг гэдэг хоёр зүйл ялгаа байна. Энэ хоёр нь хэв маягаасаа гадна хэрэглэгдэх хүрээгээрээ ч ялгаатай ажээ.


Дөрвөлжлөн эвхсэн бичгийг гол төлөв албаны тамга, захиралга, гарын тийз, номын тэмдэг зэрэг бичиг хэргийн зүйлд түлхүү хэрэглэж иржээ. Угалзлан эвхсэн хэлбэрийг албан ёсны хийгээд бичиг хэргийн зүйлд төдий л их хэрэглэдэггүй, голдуу гоёл чимэглэлд хэрэглэдэг бөгөөд зэрвэсхэн харахад хээ угалз мэт боловч лавшруулан сайн харвал бэлэг дэмбэрэлтэй, ерөөлийн сайхан үгийг зураач хүний ухаанаар угалзлуулан бичиж заншсан байна.

Дөрвөлжлөн эвхэх тухайд нарийн баримталдаг хоёр зарчим байжээ. Энэ нь *хэм тэгшийн зарчим, тэнцүү харьцааны зарчим* болой. Товч танилцуулсугай. *Хэм тэгшийн зарчим* гэ-

дэг нь гол төлөв тамга, тэмдгийн эвхмэл бичигт тодорхой харагдах бөгөөд уг бичих зүйлээ ам дөрвөлжин зайд яг таарууулан бичдэг номтой байж. Тэгээд ч уг зүйлээ үзэхүйеэ гоо сайхан болгож, илүү дутуу гарсан сондгой шугам зураасгүй, цалгардсан их зайгүй, хэм тэгш бичих шаардалга эрхгүй гарсан ажээ. Тухайлбал ганц үгийг бичнэ гэхэд үеэр нь хувааж хоёр эгнээ болгож болохоос гадна ам дөрвөлжин зайдаа таарууулан өргөөш нь сунгаж бичиж болно.




Монгол бичгээр баяр гэдэг үгийг ам дөрвөлжин зайд өргөөш нь сунгаж бичих байдал



Дөрвөлжин үсгээр бат гэдэг үгийг хоёр үе болгож ам дөрвөлжин зайд таарууулсан байдал


Бичих зүйл маань хэд хэдэн үгнээс бүтсэн буюу олон үетэй үг байваас хэдэн ч эгнээ болгон эвхэж болно. Тэгэхдээ ам дөрвөлжин зайндаа л таарууулах ёстойг мартаж болохгүй. Бас эгнээ бүрт байгаа зураасны тоог сондгойруулах ёсгүйг доорхи жишээнээс ажигламу.




Монгол улс гэдэг хоёр үгийг ам зайд дөрвөлжлөн эвхэхдээ эгнээ бүрийн зураасны тоог хэрхэн тэнцүүлсний жишээ

Хэм тэгшийн зарчмыг баримтлан зураасны тоо, зайг таарууулахад монгол бичгийн хувьд гэдэс, сүүл, орхиц, цэг тэмдэг их үүрэгтэй байдаг бөгөөд эгнээ бүрийн зураасны тоог таарууулахад гэдэс, сүүл, орхицыг хэдэн ч удаа нугасхийн сунгаж болох боловч тухайн гэдэс сүүл, орхицын ерөнхий дүрс хэлбэрийг алдагдуулж огт болохгүй. *Монгол улс* гэсэн дээрхи жишээнд зураасны тоог тэнцүүлэх гэж *улс* гэдэг үгийн хоёр гэдсийг сунган бичиж таарууулсан байгааг анхаарму.

Монгол дөрвөлжин бичгийн тухайд хэм тэгшийн зарчмаар зураасны тоог тэнцүүлэхэд тухайн эгшиг үсгийн гол махбод, мөн гэдэс бүхий гийгүүлэгч үсэг гол хэрэглэгдэхүүн нь болж өгдөг байна.



Монгол бичгийн гэдэс, сүүлийг сунгаж эвхэх маягийг үзүүлсэн байдал



Монгол дөрвөлжин үсгийн эвхмэлд хэм тэгшийн зарчмаар зураасны тоо, зай хэмжээг тохируулах байдал

Саяын бидний ярьсан зүйл нь зай хэмжээг **тэнцүүлэх шаардалгатай** зүйл дээр л гол төлөв хэрэглэтддэг. Эвхмэл **бичгээр** ерийн цувуулан бичих тухайд заавал ингэж сунгаад **байх шаардалга** байхгүйг хэлэх хэрэгтэй.


Энэхүү хэм тэгшийн зарчим нь монгол бичгийн **эвхмэл дээр** хэд хэдэн үг, дөрвөлжин бичиг дээр бол хэд хэдэн **үе бүюу** үгийн харьцаан дээр илэрдэг юм.



Монгол үсгийн эвхмэл хэлбэрээр ерийн цувуулан бичсэн номын нэг хуудас

Тэнцүү харьцааны зарчим бол дөрвөлжлөн эвхсэн бичигт зайлшгүй байх ёстой зүйл. Хэм тэгшийн зарчим нь доод зах нь хоёр эгнээний харьцаанд, монгол бичгийн тухайд үг дээр, дөрвөлжин бичгийн эвхмэл дээр бол үеийн хооронд зураасны тоог тэнцүүлдэг бол одоо ярьж байгаа тэнцүү харьцааны зарчим нь монгол бичгийн эвхмэл дээр нэг үгийн дотор, дөрвөлжин үсгийн эвхмэлийн хувьд нэгэн үеийн дотор зураас бүрийн хоорондын зай хэмжээний тэнцүү хэмнэлийг буй болгож үзэмж, харьцаагий нь төгөлдөржүүлдэг ажээ.

Би гэдэг үгийг эвхсэн жишээ. Эхний эвхмэлд тэнцүү харьцааны зарчим алдарсан тул хоорондын зай жигд болсонгүй байна. Дараагийн эвхмэл нь ном зүйгээрээ болжээ.



Угалзлан эвхсэн бичгээр бэлгэ дэмбэрэлтэй ерөөлийн сайхан үг бичиж, бэлэг дурсгал болгох, гэр орноо чимэх зэргээр хэрэглэдэг уламжлал монголчуудын дунд их байжээ. Үүнд, уран бүтээлийн чимэг, хивсний хээ, хос уянга зэрэгт хэрэглэхээс гадна тамхины сав, аяганы алчуур дээр «баяр», «давхар баяр», «хос баяр», «хүсэл мөрөөдөл биелэх цагт гал голомт бадарна» гэх зэрэг өлзий дэмбэрэлтэй сайхан үгийг угалзлан

эвхээд зүү ороон шаглаж дотно найртай нөхөд, хайр сэтгэлтэй хүндээ дурсган өгдөг сайхан заншил монголчуудын дунд их л дэлгэр байсан асан. Ийнхүү угалзлан эвхэж бичихэд заавал чандлан дагах ёстой гэсэн тусгай зарчим байхгүй, зохицоо, үзэмж, уран гоёыг л эрхэм болгодог байжээ.







Тамхины савын дөрвөн өнцөгт зүү ороон хатгаж оёсон **баяр хээний** зураг




Монгол бичгээр угалзлан эвхсэн хос уянгын зураг. 9 эрдэнийн тоогоор ес, есөн үгийг бичжээ. Үг нь: **Өлзий хийгээд хутаг-ину Сүмбэр уул адил баттах болтугай, Насан ба буян-ану Сүн далай мэт арвитах болтугай.**

Манж бичгээр угалзлан эвхсэн хос уянгын нэг талын зураг. Манжаар: **Доло гунингала эйитэн байита мүтэмби** гэсэн бүюу монголчилвоос **Дотор санасан бүх явдал бүтэмүй** гэсэн үг

Монгол бичгийн хувьд ч гэсэн, дөрвөлжин бичгийн хувьд ч гэсэн үсгийн махбод бүрт тогтсон ерөнхий эвхэх хэлбэр байдаг боловч бичиж байгаа хүний ур ухаан, бичих зүйлийн зо-


рилго, хэмжээ дамжаа зэргээс шалтгаалан тухайн үсгийнхээ гол дүрс хэлбэрийг алдагдуулахгүйгээр санаачлан яаж ч бичиж болдог байжээ.



Эрдэм гэдэг үгийг гурван янзаар, үүнд, д үсэг хийгээд эцэст орсон м үсгийг янз янзаар бичжээ. Бусад үсгийг ч энэ жишлэнгээр өөр өөр маягаар эвхэж болно.

Түрүүхэн үеийн монгол бичгийн эвхмэл дурсгалыг үзвэл *н, г, ш*-ийн цэгийг тавьдаггүй ёстой байсан байдал харагддаг. Харин XIX зууны дунд үеэс эвхэхдээ цэг тавих болсон бололтой байдаг.


Дөрвөлжин бичигт үндэслэж төвөд үсгийн эвхэх ёсыг буй болгосон тухай дээр өгүүлсэн билээ. Үүнээс гадна монгол үсэгт дулдуйдан зохиосон манж бичигт эвхэж бичих уламжлал нэн өргөн байсан бөгөөд журам горимы нь үзвэл монгол бичгийнхитэй яг адил бөгөөд ялгарах гол ялгаа нь цэг тэмдэг, биндийг орхидоггүй байсан ажээ. Энэ нь ч манж хэлний хувьд яав ч орхиж болохгүй нь мэдээж юм. Манжийн уламжлалаас үзвэл эвхмэл үсгээ ерөнхийд нь *фүгжинга хэргэн* гэж нэрлэдэг бө-



Манжийн **Фодохо абдаха-и фүгжинга хэргэн** буюу **Удын навчны тулгарын үсгээр** эвхэж бичсэн номын нэгэн хуудасны зураг

гөөд үүнийг монголоор *тулгарын үсэг* гэж орчуулан заншсан байна. Манж эвхмэл нь дотроо олон янз нэртэй, тухайлбал: тасха ошохонго фүгжинга хэргэн буюу барс хумст тулгарын үсэг, фэргүвэчүкэ сабинга фүгжинга хэргэн буюу гайхамшигт сэцэгт тулгарын үсэг, мүдүри ошохонго фүгжинга хэргэн буюу луу хумст тулгарын үсэг гэх зэрэг 41 зүйл тулгарын үсэг байдаг байна. Гэвч энэхүү 41 янз гэдэг нь бичих хувьд нэг л журамтай, зөвхөн үгийн төгсгөл, үсгийн үзүүр зэрэгт тухайн нэртээ ойртуулсан хэлбэр оруулдаг байжээ. Хэлбэр зурам талаасаа манж эвхмэл нь дөрвөлжин эгц өнцөгүй, өнцөг нь мөлгөрдүү байдагаараа монгол бичгийн дөрвөлжлөн эвхэх байдлаас ялгардаг.

Монголчууд эвхмэл үсгээр бичсэн зүйлийг ном бичгийн хэргээс гадна сүм хийд, номын гэр, орон байшиндаа чимэг болгодог заншил ялангуяа судар номын хүмүүст өргөн байжээ. Үүнд голдуу хос уянга, тусгай захиалж хийлгэсэн хивс тэргүүтнийг хэрэглэдэг ажээ.



Есөн эрдэнийн тоогоор бэлгэ дэмбэрэлтэй есөн үгээр зохиосон үгийн сүлжээ бүхий хивсний зургийн хэсэг

Энд хавсарган байгаа хивсний зураг дээр эвхэж бичсэн есөн үгийг хэрхэн сүлжилдүүлэн унших байдлыг сонирхуулсугай. Үүнд:


1. нас	4. цог	7. заяа
2. буян	5. маш	8. арвин
3. дэлгэр	6. бадар	9. урт

гэсэн есөн үг байгаа бөгөөд үүнийг доорхи маягаар уншиж болно.


1. 1—2—3: нас буян дэлгэр
2. 4—5—6: цог маш бадар
3. 7—8—9: заяа арвин урт
4. 1—5—9: нас маш урт
5. 7—5—3: заяа маш дэлгэр
6. 2—5—8: буян маш арвин
7. 1—5—3: нас маш дэлгэр
8. 7—5—9: заяа маш урт
9. 4—2—6: цог буян бадар
10. 4—8—6: цог арвин бадар
11. 4—2—3: цог буян дэлгэр
12. 4—8—9: цог арвин урт

гэх мэтээр лавтайяа арав гаруй маягаар сүлжин уншиж болдог ажээ.


Монголчуудын эвхмэл үсгийн уламжлалыг бусад гадаад улсын гоёлын бичигтэй харьцуулахад үүргийн хувьд адил төстэй зүйл байх авач үсгийн махбод бүрт тохирсон, тогтсон эвхэх журам бүхий онцлог хэлбэртэй бие даасан тогтолцоо болж чадсан ажээ. Дөрвөлжлөн эвхэх ёс нь монгол үсэгзүйд бүрэлдэн буй болсон, зонхилох нэгэн зарчим даруй мөн бөгөөд ийм уламжлал бусад улсын гоёл чимэгийн үсэгзүйд төдий л элбэг тохиолддоггүй билээ. Харин угалзлан эвхэх ёсон гадаад олон улсын үсэгзүйд элбэг тохиолддог боловч зурах маяг, хэрэглэх хүрээний хувьд нэлээд ялгаатай байдаг. Энэ ташрамд кирилл хийгээд араб үсгээр угалзлан бичсэн, энд тэнд олонтаа дайралддаг хэдэн жишээг хавсарган үзүүлэв. Харшуулан үзэж ялгаа зөрүүг анхааран үзэх ажаамуу.



Номын нэг бадаг буюу бөлөг эхлэхэд хэрэглэдэг гоёлын кирилл үсэг. 1. XIV зуунд Новгородод хэрэглэж байсан К, 2. XVII зуунд Москвад хэрэглэж байсан С, 3. XIV зуунд Новгородод хэрэглэж байсан П, 4. XVI зуунд Москвад хэрэглэж байсан М.



Уран барилгын чимэглэлд хэрэглэж байсан араб бичиг



Орос үсгээр угалзлан эвхэж бичсэн дурсгал. Дээд талд буй нь XV зууныхи, доод талд байгаа нь XIX зууныхи болой.

ЛАВШРУУЛЖ ҮЗҮҮШТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Бат-Очир, **Монгол үсгийн мөрдөн дууриах үлгэр**, МХБСБӨ, IV дэвтэр, УБ, 1934,

Ринчен, **Мөнгол бичгийн хэлний зүй**, дэд дэвтэр, авиазүй, УБ, 1966.

Щепкин В. Н, **Русская палеография**, М, 1967.

Кара Д, **Книги монгольских кочевников**, М, 1972.

Шагдарсүрэн Ц, **Монгол үсэг бичгийн эвхмэл хэлбэр**, -SM, Tom. IV (12), Fasc. 15, UB, 1976, 339—360.

Шагдарсүрэн Ц, **Монгол үсэг зүй**, УБ, 1981.

ТӨВ АЗИЙН АРД ТҮМНИЙ СОЁЛЫН ТҮҮХНЭЭ МОНГОЛ ҮСЭГ БИЧГИЙН ЭЗЛЭХ БАЙР

Дэлхий дахинаа олон улс үндэстэн өдий тэдий үсэг бичиг хэрэглэсээр байгаа боловч тэр олон бичгийн тогтолцоо нь цөм хүн төрөлхтөний түүхийн өнө эрт үед буй болсон тоотой хэдэн бичгийн уламжлалд хамаардаг билээ. Өөрөөр хэлбэл урдхи уламжлалаас ор тас салангид, бусад үсэг бичгийн нөлөө тусгал огт аваагүй буюу цоо шинээр зохион хэрэглэсэн бичиг гэж байдаггүйг дэлхийн олон улс үндэстний үсэг бичгийн түүх бэлхэнээ нутлан харуулж байна.

Монголчуудын түүхийнхээ туршид авч болловсруулан хэрэглэж ирсэн үсэг бичгийн түүх ч энэ нийтлэг уламжлалаас салангид байсангүй. Иймхүү монголчууд соёлын хувьд нэгэн хүрээнд багтаж байсан бусад ард түмнээс үсэг бичгийг уламжлан авч мэдлэг ухааныхаа хүчээр монгол хэлнийхээ хөгжлийн онцлог, зүй тогтолд таацуулан боловсруулж ирсэн нь зөвхөн нэгэн талын асуудал бөгөөд энэ тухай нэлээд судалгаа гадаад дотоодгүй гарсан тухай бид дээр ярьсан билээ. Нөгөө талаас нь үзэхүл монголчууд үсэг бичиг авч хэлэндээ тохируулан боловсруулж хэрэглээд зогссонгүй хөрш зэргэлдээ оршиж нутаг савлан аж төрдөг, соёл боловсрол, улс төрийн хувьд хэлхээ холбоотой, Төв Азийн бусад ард түмний үсэг бичгийн хөгжилд түнзгий нөлөөлж байсан нь ер нэгэн тохиолдлын чанартай буюу ганц нэгийн тэдий байгаагүй тул эрдэмтэн судлаачийн анхаарлыг эртнээс зохих ёсоор татсаар ирсэн боловч ерөнхийд нь нэгтгэн дүгнэж үзсэн ном бүтээл хараахан гараагүй байна. Иймээ нэгтгэсэн судалгаа гарах нь монголын судлалд тэдийгүй Төв Азийн соёл иргэншлийн түүхэнд чухаг хувь нэмэр болох нь мартаангүй билээ.

«Монголчуудын үсэг бичиг» гэдэг бөлөгт Хүн (нү) нарын тамга-үсгийн тухайд бид эртний түрэгийн *рун* хэмээх бичигтэй ямар ч атугай холбоо хэлхээ буйг хөндөн ярьсан билээ. Унгарын ШУА-ийн гишүүн профессор Янош Харматта Аваруудын булш бунханаас олдсон зүүний хайрцаг дээрхи бичгийн дурсгалыг судалж 1983 онд «Аваруудын хэлэнд холбогдох асуудлаас» гэдэг томоохон өгүүлэл нийтлүүлснээс үзвэл Хүн улсын хэрэглэж байсан тамга-үсгийн олон тэмдэгтэй дүйх

баримт байгааг үзэж болно. Мөн 1983 онд профессор Янош Харматта авгайн бичсэн «Дорнод европ дахи түрэгийн рун бичээс» гэдэг томхон өгүүллийн баримт бидний дээр өгүүлсэн таамаглалыг улам ч үнэмшилтэй болгож байна уу даа гэж хэлэх боломжийг олгодог билээ. Гэвч өнө эртний ийм хэлхээ холбооны асуудлыг нарийсган гүнзгийрүүлж судлах шаардалгатай нь мэдээж бөгөөд Хүн нарын тамга-үсэгтэй харьцуулан үзэх судалгаа эзнээ хүлээсээр байгааг энд өгүүлэхэд илүүдэх нь юун билээ.

Үүнээс хойш ярих гэж байгаа хэдэн зүйл бол монголчууд хийгээд өвөг дээдсийнхи нь хэрэглэж байсан бичиг үсэг Төв Ази дахины бусад улс үндэстэнд хэрхэн нөлөөлсөн тухай түүхэн сурвалж тулгар бичгийн нутлагаа хийгээд бие бодтой баримт, бас олон эрдэмтний судалгааны дүнд батлагдсан асуудал гэдгийг юуны өмнө цухас дурдсугай.

Эртний хятадын сурвалж бичигт Илоу, уцзи, мохэ, нюйжин буюу нюйжи гэж олон янзаар тэмдэглэгдэн ирсэн хамниган угсааны Зөрчид гэдэг улсын бичиг үсгийн түүх монголчуудын өвөг Хятан нарын үсэг бичигтэй гүнзий холбоотой байсан ажээ. Түүхийн тавцанд Алтан улс (1115—1234)-аа байгуулсан Зөрчидүүдийн түүхийг сөхөж үзэхүл тэдний аж амьдралын хүрээнд төдийгүй соёл боловсролынхи нь салбарт Хятан нар ихээхэн нөлөөтэй байжээ. Бидний сонирхон ярилцаж буй сэдэвт шууд холбоотой баримт «Алтан улсын судар»-т олон бий.

Нэгэн хэсгийг эшлэсүгэй: «...Алтан улст язгуураас бичиг үгүй. Улс улмаар түрэмгий (хүчирхэг Ц. Ш) болох тулд, ойрхи улс зохицож хойш урагшид цөм Дайляо (Хятан нарын байгуулсан Ляо улс Ц. Ш.) улсын бичгийг хэрэглэх бөлгөө. Тайзү хаан түүний Си-ин нэрт түшмэлд өөрийн улсын бичгийг үүсгэн бичигтүн! Хэв хэмжээ байгуул! хэмээн тушаавай. Си-ин хятад бичгийг дууриан Дайляо улсын бичгийг дагаж, улсын үгэнд нийлүүлж Нюйжи'-гийн бичгийг эхлэн бичиж Тайзү хаанд хүргэж ирсэний хойно хаан их л баярлаж олонд тархааж, Си-ин'д нэг морь, нэгэн зэрэг хувцас шагнавай...»

гэж өгүүлжээ Энэхүү бичгийг зохиосон он цагийн талаар эрдэмтэд хэд хэдэн ац саналтай байдаг боловч Тайзү хэмээх хааны уг нэр нь Агуда бөгөөд 1113 онд зөрчидүүдийн удирдагч болоод хоёр жилийн дараа Алтан улсыг байгуулж анхны хаан ширээнд залраад асар удалгүй 1123 онд тэнгэрт хальсан зэрэг түүхэн нөхцөл байдлыг таацуулан бодвол, Зөрчидүүд энэхүү «их» бичгээ 1119 онд хятаны «их» бичигт үндэслэж зохиосон гэж дүгнэсэн эрдэмтэн М. В. Воробьевын саналыг нарийвчлан хянан тохиолдуулсан судалгаа гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Гэвч энэ бичиг нь төдий л сайтар боловсроогүй байсан ажээ. Тэгээд ч Алтан улсын гутгаар хаан (1135—1149), уг нэр нь Хула хэмээх Си-зүн'гийн үед зөрчидийн бага бичгийг зохио-

сон байна. Ингээд 1119 онд зохиосон бичгийг «их» хэмээн нэрлэх болж 1145 оноос хойшлаа зэрэг хэрэглэгдэж байснаа 1191 оноос түрүүчийн «их» бичиг шахагдаж хэрэглэгдэхээ больсон байна. Сүүл зохиосон «бага» бичгийг 1138 онд Си-зүн хаан зохиосон гэдэг домог маягийн мэдээ байдаг боловч «Алтан улсын судар»-т буй өөр баримт сэлтээс үзэхүл Си-зүн хаан бичиг номд идэр залуугаасаа дөргүй байж, архи өнгөнд унаж, шударгуу сайн эрдэмтдийг хөнөөж улмаар төрийн хэргийг огоорч эцэстээ хорлогдон үхсэн тухай байдаг тул «бага» бичгийг өөр хүн зохиосон буй заа.

Зөрчидүүд ийнхүү өөрийн гэсэн бичигтэй болсон боловч «Алтан улсын судар»-ыг бүхэлд нь авч үзэхэд соёл боловсролын хүрээнд хятан хэл, бичгийн нөлөө түрүүчийн адил байсаар байсан, хятан орчуулгаар дамжуулан хятадын сонгодог олон ном бичигтэй танилцаж, зөрчид бичгийнхээ зэргэцээ хятан хэл, бичгийг эзэн хаанаасаа эхлэн цэргийн жанжин, бичгийн түшмэд цөм шамдан сурдаг байсан, бичгийн түшмэл болох хүнээс тусгайлан хятан хэл, бичгийн боловсрол шаарддаг тухай өдий төдий баримт сэлт тэмдэглэгдэн үлдсэн билээ.

Зөрчидүүд хүчирхэгжиж, хятаны Ляо улстай илэрхий дайсагналцаж эхлэснээсээ хойш хятан бичигт үндэслэсэн үсэг бичгээ зохиож, хятаны хэл, бичгийн боловсролыг ихэд хэрэгсэн үзэж байсан нь одоогийн ухаарлын үүднээс сонин юм шиг санагддаг. Үүний учир гэвэл тэр цагтаа хятан нарын соёл боловсрол илт илүү нөлөөтэй байсан, хоёрт зөрчид үсэг бичиг нь хятаны бичигтэй харьцуулахад илүү боловсорч чадаагүйтэй холбоотойгоос гадна хэлний хувьд хятан зөрчид хоёр хоёулаа Алтай овгийн хэлтэнд багтдаг байсан зэрэгтэй лав уялдаатай буй заа. Алтан улсын Үлү хэмээх нэртэй Ши-зүн хаан (1161—1189) 1180 онд хятан бичгийг их л алсын хараатай, төгс төгөлдөр зохиосон бичиг гэж үнэлээд «...зөрчидийн шинэ бичиг түүнээс давж чадсангүй...» хэмээж харамсан өгүүлсэн гэдэг мэдээ «Алтан улсын судар»-т байдаг нь үүний нэгэн нутлагаа болно заа.

Энэ ташрамд тэмдэглэхэд тус улсын нутаг дэвсгэр дээр зөрчид бичгийн дурсгал үлдэж хоцорсон бөгөөд хамгийн тоймтой том нь Хэнтий аймгийн Баянхутаг сумын Сэрвэн хаалганы бичээс бөгөөд энэ нь одоогоор дэлхийн хэмжээнд нэн ховор гэж үздэг дан зөрчид хэл, бичгээр бичсэн гурав, дөрөвхөн дурсгалын нэг нь болж байна. Харин Зөрчидийн үед холбогдох хоёр хэлний хадмал дурсгал, мөн зөвхөн хятад хэл бичгээр бичсэн дурсгал гэвэл гуч гаруйхан юм. Энэ дурсгал нь хэмжээний хувьд чамлахааргүй том, 9 мөр, 150 орчим тэмдэгттэй бөгөөд зүүн урагш харсан хөмөг хаднаа цохиж сийлсэн тул бороо салхинаас харьцангуй хамгаалагдаж одоо болтол тийм их элэгдэж холтроогүй ажээ.

Солонгосын түүхийн сурвалжид монгол солонгосын харилцаа холбооны талаар өдий тэдий баримт сэлт байдаг бөгөөд түүнийг судлаж анх монгол түмэндээ ном болгож танилцуулсан эрдэмтэн бол Б. Сумьяабаатар юм.

Монгол түүхийн ном зохиолд Гуулин улс гэж гардаг Солонгос улсын үүх түүхийг судалсан нэлээд эрдэмтэн солонгосуудын гарал үүслийг монголчуудын дээд өвөгтэй холбож тодорхой баримт сэлтээр батлан бичсэн зүйл ч байдагийг цухасхан дурдаад гол сонирхож буй сэдэв рүүгээ орсу. «Гуулин улсын судар»-ын гутгаар дэвтэрт 995 онд Гуулин улсаас хятан хэл бичиг үзүүлэхээр арван хүүхэд явуулсан гэдэг мэдээ байдаг байна. Юан улсын үед гэхэд

> «...Чүнрйөл вангийн 21-р он, хөхөгчин хонин жилийн хаврын тэргүүн сарын хар тахиа өдөр Юан улсаас монгол бичгийн багш Ли Мангодэй ирэв...»

гэсэн мэдээ байдаг ажээ. Энэхүү 21-р он гэдэг нь аргын толлын 1295 он болой.

Бас 1393 онд монгол хэл бичиг сургаж судлах зорилго бүхий Сайөгвөн хэмээх тусгай байгууллага буй болгосон, монгол хэлний ангид нийслэл хотоос сурагч сонгон авч байсан хийгээд сургаж шалгах тусгай журам тогтоосон, монгол хэл бичигт сургах ном, толь бичиг гарган хэрэглэж байсан нь XV зуун гэхэд лавтайяа 20 орчимд хүрсэн гэх зэрэг мэдээ хар байдагийг хэлэхэд бидний сэдвээс хазайсан зүйл яав ч болохгүй биз ээ.

Солонгосын үсэг бичгийн уламжлал, түүхийг үзвээс Христусын тооллын эхин үеэс шахуу хятад үсгийг хэрэглэж иржээ. Ер нь ч тэр цагаас Япон, Аннамд мөн л хятад үсгийг хэрэглэсээр байсан бөгөөд үүний учрыг японы эрдэмтэн Онуки Масао:

> «...Зүүн Азийн ихэнхи үндэстэн дээр үеэс эхлэн хятад бичиг соёлын хүчтэй нөлөөн дор байсаар ирсэн ба гагцхүү монгол үндэстэн л уг нөлөөг үл зөвшөөрснөөрөө бусдаас ялгарах өөрийн хувь шинжээ илэрхийлсээр иржээ...»

гэж тайлбарласан байдаг билээ.

Солонгосын Ли улс (1392—1910)-ын Сэжон вангийн 25-р он буюу нийтийн тооллын 1444 онд солонгосууд эх хэлэндээ илүү зохицсон *хунминчен-им* буюу утгачлан орчуулвал «иргэнийг сургах төв аялгуу» хэмээх *авианы бичгээ* зохиосон нь өдгөө хүртэл хэрэглэгдсээр байгаа билээ.

Солонгосын энэхүү авианы үсгийн гарал үүслийн талаар монгол, япон, солонгос, америк, хятад, зөвлөлт, герман зэрэг орны үсэгзүйч олон эрдэмтэн судлаж монгол бичгийн нөлөө тусгал байгааг нийтээр хүлээн зөвшөөрч ирсэн бөлгөө. Гэхдээ худма монгол бичгийн нөлөө юу, монгол дөрвөлжин бичгийн тусгал уу гэдэг дээр санал зөрөх явдал байгааг хэлэх хэрэгтэй.

Олон эрдэмтний судалгаа дүгнэлт хийгээд түүхэн нөхцөл байдал, учир шалтгааны холбоог харгалзаж монгол үсэгзүйн судалгаанд үндэслэж өөрийн гэсэн саналаа дурдахад 1444 онд зохиосон солонгосын авианы үсэг нь гадна хэлбэр дүрсээрээ нангиад бичгийн хажуугаар монголын дөрвөлжин бичгийн хэлбэрийг зохих хэмжээгээр анхааран хэрэгссэний зэргэцээ үсэг бүрдүүлж байгаа үндсэн махбодын үүсэл нь монгол бичгийн махбодын гол хэлбэртэй нарийн тогтолцоотой нь аргагүй холбоотой байна гэдэг дүгнэлтийг хийж бүрэн болмоор санагддаг.

Хамниган үгсааны Манж нарын соёлын судалгаанаас үзэхэд XIII зуунаас өмнө хятадын дүрс бичгийг хэрэглэж байсан гэж олон эрдэмтэний бичиж тэмдэглэсэн нь бий. Тэгээд монголчууд түүхийн тавцанаа хүчирхэгжин гарч ирсэн цагаас манжууд монгол бичгийг хэрэглэх болж бас нэгэн хэсэгтээ монгол хэлийг ч гадаад харилцааны албан хэрэгтээ ашиглаж байсны баримт нутлагаа гарч ирсээр байгааг судлагчид тэмдэглэж байна.

Яв явсаар XIV зуунаас Манж нар хүчирхэг болж ирэхийн хамт албан хэргээ манжаараа явуулах, өөрийн гэсэн үсэг бичигтэй болох хэрэгцээ гарч ирсэн нь мэдээж бөлгөө. Ингээд манжийн Нурхац хааны үед Эрдэнэ багш, Гагай заргач гэдэг хоёр түшмэлд монгол үсэгт түшиж манж бичиг зохиохыг даалгасан баримт бидний үед хүрэлцэн ирсэн билээ. Тэр хоёр бичгийн их түшмэл хуучин уламжлалынхаа дагуу монгол хэл, бичгийг улсын гадаад харилцаанд хэрэглэвэл ямар гэж хүссэнд Нурхац эс зөвшөөрсөн гэдэг мэдээ ч бас бий. Одоогоор учир үл мэдэгдэх шалтгаанаар мөн онд Гагай заргач өзэн төрийн өмнө нүүргүй болж үхэх ял олсон гэдэг. Энэ бүх мэдээ сэлт хийгээд тэр хоёр түшмэлийн нэр, цол зэргээс үүдэж Эрдэнэ багш, Гагай заргач нарыг монгол хүн байсан гэж судлагчид үздэг юм.

Ингээд манж үсэг боловсруулан зохиох ажилд Эрдэнэ багш махран зүтгэж монгол бичгийг манж хэлнээ таацуулахдаа үсгийн дүрс хэлбэрийг яльгүй яльгүй өөрчлөснөөс гадна дусал, бинд гэдэг тусгай тэмдэг нэмж 1632 онд дуусгасан байна. Харин энэ ажилд нь Дахай гэдэг бичгийн түшмэл гар бие оролцсон баримт мэдээ байдаг билээ.

Манж бичгийг зохиох ажил 30 гаруй жил үргэлжилсэн тул тэр хугацаанд монгол бичгийг бараг тэр хэвээр нь шахуу хэрэглэж манж хэлийг тэмдэглэж байсан бөгөөд энэ үеийн бичгийн дурсгалыг манж нар сүүлд *тонки фука аку хэргэн-и бидхэ* буюу *дусал, бинд үгүй бичиг* хэмээн нэрлэх болжээ.

Зөрчид, солонгос, манж нар яагаад ийнхүү монголчуудын үсэг бичгийг илүүтэй анхаарч, монгол үсэг бичигт үндэслэж өөр өөрсдийнхөө «шинэ» бичгийг зохиох болов? гэдэг нь бидний бодлоор хоёр гол хүчин зүйлтэй холбоотой гэж үзүүштэй

байна. Үүнд, нэгд, нийгэм-улс төрийн хувьд тэр цагтаа монголчуудын нэр хүнд, нөлөө тусгал илүү байсантай, хоёрт, монгол хэл нь Алтай овгийн хэлний нэгэн салаа мөн бөгөөд гарвалийн хувьд залгамал хэл тул Алтай овгийн хэлтэнд багтдаг зөрчид, солонгос, манж нарын хэлэнд нангиад дүрс бичгийг бодоход монгол хэлэнд зориулсан авианы бичиг илүү тохиромжтой байсантай тус тус холбоотой гэж үзэж байна.

ЛАВШРУУЛЖ ҮЗҮҮШТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Алтан улсын судар, нийт 9 дэвтэр, Манж хэлнээс Бат-Очир орчуулав, УБ., 1930, (гар бичмэл).

Ринчен, **Монгол бичгийн хэлний зүй,** Удиртгал, УБ., 1964.

Hans Jensen, **Die Schrift,** Berlin, 1979.

Сумьяабаатар Б, **Монгол солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд,** УБ., 1975.

Воробьев М. В, **Чжурчжэни и государство Цзинь,** М., 1975.

Сумьяабаатар Б, **XIII—XIV зууны монгол солонгос харилцааны бичгүүд,** тэргүүн дэвтэр, УБ., 1978.

Иоганнес Фридрих, **История письма,** М., 1979.

Е Лун-ли, **История государства Киданей,** М., 1979.

Шагдарсүрэн Ц, **Монгол үсэг зүй,** тэргүүн дэвтэр, УБ, 1981.

Воробьев М. В, **Культура чжурчжэней и государства Цзинь,** М., 1983.

Шагдарсүрэн Ц, **БНМАУ-аас олдсон хятан, зөрчид бичгийн дурсгалын тухай,** (1987 онд Улаанбаатар хотноо болсон Олон улсын монголч эрдэмтний V их хурлын III салбарт тавьж хэлэлцүүлсэн илтгэл), хэвлэлд буй.

МОНГОЛЧУУДЫН НОМ БИЧИГ

Монгол хэлний *«ном»* гэдэг үгийн гарлыг хөөж үзвэл эртний герег хэлний 'сургаал ёс' гэсэн утга бүхий *номос* хэмээх үгтэй холбоотой ажээ. Герег хэлний энэ үг зөвхөн монгол хэлэнд нөлөөлсөн төдийгүй европ дахины олон хэлнээ *агроном, астроном, гастроном, метроном* зэрэг өдий төдий үгэнд одоо болтол хэрэглэгдсээр байгаа билээ. Орчин цагийн монгол хэлнээ *ном* гэдэг үг шууд утгынхаа хажуугаар *«номын дагуу», номоороо болж байна»* гэх зэрэг хэллэгт уугуул герег хэлэндээ байсан «ёс, зүй» гэсэн утгаа хадгалсаар байгаа нь бас л сонин үзэгдэл болой. Эртний монгол хэлнээ *«дэвтэр»* гэдэг үг ном гэсэн утгаар хэрэглэгдэж байсан баримт байдаг бөгөөд одоо ч түүний ул мөр байсаар байгааг тэмдэглэн хэлэхэд илүүдэхгүй буй заа.

Энэ бүхнээс эргэцүүлэн бодохул монголчууд эрт цагаас герегүүдтэй харилцаа холбоотой байж, герег хэлийг ч сайн мэддэг эрдэмтэн мэргэдтэй байжээ гэж баттай хэлэх бололцоог олгож байна. Үүнд: дээр цагт монголчуудтай нутаг газар ойр буюу эрдэм ухааны хувьд нягт хэлхээ холбоотой байсан бусад улс орны тухайд «ном» гэдэг үгийг төдий л хэрэглэж байгаагүй байдал үзэгдэхээс гадна герег хэлнээ *«номос»* гэдэг үгийн эцсийн *-ос* дагавар нь нэр үгийн эр хүйсийг заадаг дагавар тул уул үгийг авахдаа монгол хэлний үүднээс онц шаардалгагүй тэрхүү дагаварыг орхисон зэрэг сонин ажиглагдахуун бэлхэнээ харагддаг билээ.

Монгол номын үүх түүхийг улариулан хөөвөл, бидний өнөөдрийн мэдлэгийн хирээр нэлээн дээр үед хүрч очдог. Академич Л. Лигети «Суй шу» буюу «Суй улсын он дараалсан бичиг» хэмээх түүхийн сурвалжийн номзүйд монголчуудын өвөг-Сянби нарын хэлээр толь бичиг, унших бичиг, хэлний сурах бичиг зэргийн 13 номын жагсаалт байгаа тухай мэдээг олон нийтэд сонордуулсан билээ. Мөн Хятан нарын байгуулсан улс «Ляо улсын судар»-т хятан нар ном хэвлэдэг байсан тухай тодорхой мэдээ гардаг. Энэ үе бол IX—X зуун болой. Бас «Юан улсын судар»-т Хубилай хааны 19 дүгээр он буюу аргын 1282 онд *нэвтэрхий толь* барлан тараасан тухай тодорхой тэмдэглэгдэхүүн бидний үед золгон иржээ.

Монголчуудын ном хэвлэлийн түүхийг дотоод гадаадын эрдэмтэд сонирхон шимтэж судалсаар ирсний дотор хамгийн иж бүрэн судалгааг Мажарын нэрт монголч эрдэмтэн Д. Кара хийж 1972 онд Москва хотноо «Нүүдэлчин монголчуудын ном дэвтэр» хэмээх нарийн судалгаа бүхий тусгай ном болгож нийтлүүлсэн билээ.

Судалгаанаас үзэхүл монголчуудын номын өвөг нь хад чулуун дээр сийлж, зурж бичсэн «чулуун ном» байсан ажгуу. Иймд монгол нутаг дээр газар сайгүй тохиолддог хад чулууны зураг, бичээс зэрэг нь цөм энэхүү чулуун номын л нэгэн хэсэг нь болой. Одоо бидний мэдэж байгаагаар монгол бичгээр байгаа хамгийн эртний гэгдэж буй чулуун ном бол 1224—1225 оны «Чингисийн чулууны бичиг» хэмээж нийтэд алдаршсан дурсгал юм. Эл дурсгал нь одоо хамгийн эртнийхи гэгдэж байгоо боловч хэлний хувьд үлэмж цэгцэрсэн, бичсэн байдлын хувьд гэхэд л хүндэтгэвээс зохилтой хүний нэр усыг мөр тэтгэн онцлож байрлуулсан зэрэг нарийн дүрэм журамтай байгаа нь яав ч монгол хэл, бичгийн анхны дурсгал биш болохыг давхар давхар гэрчлэж байгаа хэрэг. Өөрөөр хэлбэл үүнээс өмнөхи үеийн монгол бичгээр бичсэн дурсгал зайлшгүй байх ёстой гэсэн үг бөгөөд харамсалтай нь одоо болтол олдоогүй байгаад л байгаа юм. Монголын чулуун номын дотроос дэлхийн олон монголч эрдэмтний анхаарал, сонирхлыг татсан бас нэгэн чулуун ном бол 1620 онд монголын халуун эх оронч, яруу найрагч Цогт хунтайжийн шууд зохион өгүүлсэн гүн утга бүхий тансаг сайхан шүлгийг дөрвөн жилийн дараа Дуутын хар чулуунд Дайчин хиа, Гүен баатар нарын сийлсэн, ном зохиолд «Цогтын их бичээс» хэмээн алдаршсан нандин дурсгал мөнөөс мөн билээ.

Монголчуудын ном бичгийн түүхээс үзэхүл чулуунаас гадна монгол номын хэрэглэгдэхүүнд үйс, торго бөс хийгээд янз бүрийн цаас, навч тэргүүтнийг хэрэглэсээр ирсэн байдал харагддаг.

Үйсэн номын тухайд, монголын уран зохиолын түүхэнд «Алтан ордоны үйсэн дээрхи бичээс» хэмээн нэрлэгддэг, дайн дажны хүчир зовлонд бэрхдэн зүдэрч салсан эх хүү хоёрын харилцан дуулсан зохиол болон цааз хуулийн зүйл бидний үед хүрэлцэн ирснийг дурдаж болно.

Монголчуудын цаасан номыг дотор нь гар бичмэл, барын ном гэж хуваан үзэж болно. Гэвч монголчууд аль алий нь адилхан эрхэмд үзэж нандигнан хадгалж хайрладаг сайхан уламжлал хүн бүрийн яс маханд шингэсэн байж билээ.

Хувьсгалын өмнө монгол нутагт байсан хэдэн зуун сум хийдийн дотор, хэмжээний хувьд дундаас дээшхи бараг бүх хүрээ хийдэд *бархан* хэмээх тусгай хэвлэлийн газартай, тэндээ төвөд, монгол, самгард хэлээр өдий тэдий ном барлаж хэвлэдэг байсан ажээ. Шашин сүм хийдийн хүрээнд төвөд хэл зон-

хилон номын хэл болсоор байсан боловч монголоор хурал номоо уншдаг хүрээ хийд цөөн боловч байснаас гадна монгол хэл бичгээр ном дэвтэр хэвлэдэг бархантай газар цөөнгүй байсныг дурдваас зохино. Тус улсын одоогийн нутаг дэвсгэр дээр гэхэд л лавтайяа мэдээгээр монголоор хэвлэдэг бархан 60 орчим байсан гэж «Монгол Ард Улсын угсаатны зүй, хэлшинжлэлийн атлас»-т тэмдэглэсэн нь буй. Энэ бол сүм хийдийн хүрээнд гол төлөв шашин суртаалын ном хэвлэдэг байсан тухай мэдээ баримт болой.

Үүнээс гадна улс төр, засаг захиргааны хувиар иргэний агуулга бүхий ном зохиолыг монгол, манж, нангиад хэлээр хэвлэх, мөн хоёроос таван хэлний орчуулгын тайлбар толь, мөнгөн тэмдэгт, газрын зураг хийгээд бичиг хэргийн наад захын хэрэгцээний хэрэглэгдэхүүн, албан бичгийн нэгдмэл журмыг тогтоосон шугамт цаас тэргүүтнийг хэвлэн тархаах үүрэг бүхий барын хэвлэлийн газар байсныг мартахын арга байхгүй.

Барын номын зэргэцээгээр амин хувийнхаа хэрэгцээнд, эсбөгөөс ном буян арвижуулах сэтгэлийн үүднээс ном зохиолыг хуулж авах, хувилан тараах ажлыг ямар нэгэн олз ашиг бодолгүй ёстой «ухамсар», үнэн сэтгэлээсээ хийнэ гэдэг монгол хүний нэгэн сайхан заншил уламжилсаар байсныг хэлэлгүй орхивоос нүгэл болох биз ээ. Тийм ч учраас барын ном, гар бичмэл хоёр аль аль нь эрх тэгш, эрхэм нандин зүйл болсоор ирсэн юм.

Ер нь монголчуудын хувьд аливаа ном, номын үсгийг эрхэм нандин зүйл хэмээж үзсээр ирсэн тул харь гадаад улсын болон шашин суртаал ангид ном зохиолыг ч өөрийнхтэйгээ адил хүндэтгэж, дорд гэж огт үздэггүй байсан нь чанд уламжлал болон тогтсон байж билээ.

Тэгээд ч монгол хүний хувьд ном бүтээнэ гэдэг ажлыг хамгийн буянтай үйл гэж үздэг үзэл хүн бүрийн мах ясанд шингэсэн байсан тул хэвлэлийн нүсэр их бөгөөд олон үзүүрт ажил олны сэтгэл сүзгээр аяндаа бүтдэг байсан ажээ. Тухайлбал: барын ном гэхэд л номын эхийг бичих, бар сийлэх, алдаа мадагийг засч арилтгах, цаас болгох, хэвлэж барлах, ном болгох гэх мэтийн өдий тодий ажил байх бөгөөд энэ бүхэнд бичиг мэддэг, мэддэггүй хэн боловч буянтай үйлсэд гар оролцох гэсэн өгөөмөр уужуу сэтгэлийн угаас аливаа нэгэн албадалгагүй туслалцдаг байсан тул хэдэн зуун боть ном бүтээлийг хэдхэн жилийн дотор гаргаж чадаад байсан билээ. Үүний жишээ хэмээвээс, Бурханы шашны сургаал номын хажуугаар ардын билигзүйн өдий тодий дээж, Калидасын «Үүлэн зардасан» зэрэг иргэний агуулга бүхий яруу сайхан зохиол, мөн эртний энэдхэг, төвөдийн олон эрдэмтэн мэргэдийн дотоод ухаан буюу гүн ухаан, дуун ухаан буюу хэлшинжлэл, нутлах ухаан буюу учир шалтгааны ухаан, тэжээх ухаан буюу анагаах ухаан, урлахуй

ухаан хэмээх *их таван ухааны* хэдэн зуун бүтээлийг багтаасан 108 боть Ганжуур, 226 боть Данжуур зэрэг барын өдий төдий ном дэвтрийг дурдаж болно.

Монголчуудын ном бүтээдэг аргыг тусгайлан судласан эрдэмтэн, мэргэжилтний бүтээлээс үзэхэд ном хэвлэх буюу бүтээхэд зайлшгүй шаардлагатай далан түрүүний цаас болон есөн эрдэнээр бичихэд зориулсан гялгар хар цаас, болгосон цаас, будаг, бэх, цавуу, үдээс, багаж зэмсэг тэргүүтнийг өөрснөө бэлтгэдэг байсан байна. Бас нэгэн зүйлийг тэмдэглэхэд Солонгосын түүхийн зохиолд 1221 он гэхэд Монголоос Гуулин улс хэмээх Солонгост илгээсэн албан захидалд цаас, бэх, бийр, будаг зэрэг ном хэвлэлийн хэрэглэгдэхүүнийг авдаг байсан тухай баримт байгаа нь монголчуудын ном хэвлэлийн түүхэнд бас л сонин мэдээ юм.

Монгол номыг хэлбэрийнхи нь талаас үзэхүл *сударчилсан, товхисон* буюу *дэвтэрлэсэн, нугалбар, хуйлмал* гэж лавтайяа дөрвөн зүйл ялгаатай байсан нь илэрхий мэдэгдэх бөгөөд *сударчилсан* ном нь их төлөв шашин суртаалын хүрээнд, *дэвтэрлэсэн* ном нь голдуу улс төр, иргэний салбарт зонхилон хэрэглэгдэж байж уу даа гэж санагддаг.

Мөн монгол номын дотор, монголчуудын хэрэглэж ирсэн олон зүйл үсэг бичгээс гадна гадаад хэл, бичгээр хэвлэсэн буюу бичсэн ном багагүй хувь эзэлдэг байсныг дээр нэг бус удаа дурдсан билээ.

Монгол хэлээрхи ном зохиолын дотор худма монголоос гадна монголчуудын хэрэглэж ирсэн дөрвөлжин, тод, соёмбо, хэвтээ дөрвөлжин, Вагиндрагийн үсэг зэрэг олон зүйл монгол бичгээр бичсэн хэвлэсэн, тэр ч байтугай төвөд, самгард, хятад, манж хэлээр давхар хадсан ном бичгийн зүйл арвин байсныг хэлэлгүй горьгүй.

Монгол ном нь чимэг сэлтийн хувьд бусад улс үндэстнийхээс яав ч дорд орохооргүй бүтээсэн, үүнд мод, зэс, чулуун барын аргаар нэг өнгийн, олон өнгийн, зураг чимэгтэй, зүмбэртэй ном цөөнгүй байгааг бид нар мэднэ заа. Бичмэл ном гэхэд л тусгай хар цаасан дээр алт, мөнгө хийгээд есөн эрдэнээр маш урлагтай бүтээсэн нандин ном аль олон байсныг огт үгүйсгэх аргагүй.

Ийнхүү олон зуун жилийн турш хөгжин боловсорч ирсэн монгол ном улс орны дотооддоо айл гэрийн хамгийн хүндтэй байранд хөймор залярч, бас Ази, Европ, Америк, Австрали дөрвөн тивийн нэр цуутай номын санд залагдан очиж зохих хүндэтгэл бүхий байраа эзлэн, орон орны монголч эрдэмтнийг шимтэн сонирхуулж, судлагаа шинжилгээний нь чухаг эрхэм хэрэглэгдэхүүн болсоор байгааг хэлэхэд сэтгэлд нэн таатай байна.

Ligeti L, **Le Tabghach, un dialecte de la langue Sien-pi,** -Mongolian Studies, Budapest, 1970, pp. 265—308.

Кара Д, **Книги монгольских кочевников,** М., 1972.

Шүгэр Ц, **Монголчуудын ном хэвлэдэг арга,** УБ., 1976.

Монгол Ард Улсын үгсаатны судлал, хэлшинжлэлийн атлас, тэргүүн, дэд боть, Ерөнхийлөн эрхэлсэн академич Ринчен, УБ, 1980, 43-р зураг.

Альманах библиофилов, М., 1988.

МОНГОЛ АЛБАН БИЧИГ, ЗАХИДЛЫН УЛАМЖЛАЛ

Монголчуудын албан захидал бичгийн үүсэл түүхийг ярихад өвөг дээдсийнхи нь уламжлалтай холбохгүйгээр яагаад болохгүй нь мэдээж. Гэвч он цагийн эрхээр тэр бүх уламжлал нь жинхэнэ эхээрээ буюу бие бодтойгоороо бидний үед хүрэлцэж ирсэн нь харьцангуй хожуу үед хамаардаг боловч бас бидний азаар уугуул эхээрээ бус боловч харь хэлний орчуулгаар утга санаа нь үлдсэн баримт цөөнгүй байна. Ийм дурсгалын хамгийн эртнийхи нь манай тооллын өмнөхи 192 дугаар онд Хүн (нү) улсын хаан Модунгаас Дундад улсын хатан хаан Гао-хэү'д илгээсэн, нангиад орчуулгаар бидэнд мэдэгдэж байгаа нэгэн албан захидал болой.

Уг эхээрээ хадгалагдаж ирсэн, одоогоор хамгийн эртний гэгдэж байгаа албан захидал бол 1289 онд Ил хан Аргунаас Францын ван Гоо Филиппэд илгээсэн 34 мөр бүхий, өдгөө Францын Улсын Архивт нандигнуулан хадгалагдаж байна. Мөн захидалтай хамт 1305 онд Ил хан Өлзийтээс Францын Гоо Филипп ванд явуулсан захидлын эх хамт байгааг хэлэх хэрэгтэй юм.

Ийнхүү нэн эрт цагаас эх үүсгэлээ авсан монгол албан бичиг захидлын зүйлийг дэлхийн монголч эрдэмтэд анхааран судалж монголын ард түмний туулж ирсэн түүхэн их замыг тал талаас нь нарийсган тодруулахдаа нэгэн чухаг судлагдахуун нь гэж үзсээр ирлээ шүү. Ганц жишээ татсугай. Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнгийн жинхэнэ гишүүн, польш эрдэмтэн Котвич Владислав авгай 1305 онд Ил хан Өлзийтөөс Францын Гоо Филипп вантанд илгээсэн албан захидлыг нарийвчлан судлаад 1933 онд Польшид хуралдсан Олон улсын түүхийн шинжлэх ухааны VI их хуралд тавьж хэлэлцүүлсэн илтгэлдээ Монголчууд энэ захидлаараа XIII зуунд дэлхий нийтийн эрх тайвангийн санааг сэдэж үүсгэсэн юм хэмээж дэлхийн олон эрдэмтнээ сонордуулсан бөгөөд үүнээс үүдэж олон улсын харилцааны түүхэнд латинаар «Пакс монголика» буюу монголчилвоос «монголчуудын үүсгэсэн эрх тайван» гэсэн утга бүхий тусгай нэр томьёо хэрэглэгдэх болж, 1970 онд Францад «Монголын эрх төр» гэдэг тусгай ном ч хэвлэгдэн гарч, тэр цагт Монголчуудын үүсгэсэн төр улс дэлхий нийтэд эрх амгалан тогтоохоод ихээхэн үүрэгтэй байсныг дурдан бичсэн байдаг. Ха-

рин бид өөрснөө болохоор өнгөрсөн түүх, уламжлалынхаа талаар ёстой буяндаа бузар оруулахаар юм хийсэн улс даа. Одоо харин дээр нь муу юм нэмэхгүй шиг л байж, соёл түүхээ зөв гольдрилд нь оруулахад нь бас бүр ч хожигдоогүй байна.

Монголчуудын албан захидал бичгийн уламжлалыг үзвэл, захидлын дугтуй, бичих маяг, бичиг захидлаа эвхэн дугтуйлах байдал, үг найруулгын ялгаа, бэхийн өнгө зэрэг цөм тусгай утга учир, бэлгэдэлтэй байсан ажээ.


1289 онд Аргун ханаас Гоо Филиппэд илгээсэн захидлын дотор *жигүр-э агулган* гэсэн үг байдаг бөгөөд зөвхөн энэ хэллэгийг л гэхэд германы Шмидт, Э. Хайниш, польшийн В. Котвич, зөвлөлтийн М. Пучковский, С. А. Козин, А. Богданов, бельгийн А. Мостаэрт, Америкийн Ф. В. Кливез, японы Ш. Мураяама, монголын Я. Цэвэл зэрэг эрдэмтэд судлаад цөм яаралтай захидлын тухайд холбогдсон үг байна гэж үзсэн бөгөөд Я. Цэвэл улам тодруулж монголчууд хамгийн яаралтай захидлынхаа дугтуй дээр шувууны өд наан бусад захидлаас ялгадаг байсан уламжлалыг энэ хэллэг зааж байгаа юм хэмээн тэмдэглэсэн байдаг. Үүнийг энд дурдаж байгаагийн учир гэвэл лавтайяа XIII зуун гэхэд монголчууд яаралтай захидлаа ерийн захидлаас ялгадаг нарийн тэмдэгтэй байжээ гэдгийг л батлах гэсэн зорилго болой. Үүнээс үүдэн нарийвчлаж үзэхүл монгол захидал бичгийг дотор нь яаралтай, ерийн гэж хувааж байснаар барахгүй яаралтай захидал бичгийг дотор нь бас зэрэглэн ангилаж байсан ажээ. Үүнд: дээр дурдсанчлан, шувууны өд наах, хошуундаа бичиг зуусан шувуу зураад хажууд нь буюу эсвөгөөс зууллтай захидал дээр нь «энэ мэт нис нис» хэмээн бичих, дугтуйн дөрвөн булан дээр нь морин туурайн дүрс зураад дотор нь «морин», «дээгүүр», «довтолгон», «явуул» гэсэн үгийг нижгээдээр нь бичих, мөн дугтуйн зах хөвөөгөөр улаан шунхаар ташуу ташуу ирмэглэж, орчин үеийн агаарын шуудангийн дугтуй адил ялгах тэмдэг тавьдаг байсан уламжлалыг улсын архив, номын сан хөмрөгт хадгалагдаж буй баримт хэрэглэгдэхүүнээс төвөггүй олж үзэж болно.

Яаралтай захидлын дугтуй дээр өд наадаг уламжлал нийтлэг байсан ажээ. Үүний нэг баталгаа гэвэл «Өдтэй бичиг нь өртөөгөөр дамжина» гэж эхлэдэг ардын дуу болой. Энэ далимд нэгэн зүйлийг дурдахад Польш улсын агаарын шуудангийн зарим дугтуй дээр шувууны өд зурсан байдаг нь 1289 оны монгол захидалд өгүүлсэн *«жигүр-э агулган»* гэдэг хэллэгийг эрхгүй санагдуулдаг билээ.

Ерийн захидлын тухайд монголчууд тусгай тэмдэг тавьдаггүй байжээ. Монгол дугтуйны талаар товчхон танилцуулваас ийм буюу.

Захидал бичихэд ямар ямар ялгаатай, хэрхэн найруулдаг тухай дурдсу. Монголчууд албан захидал, бичгийг ерөнхийд

нь дээш өргөх бичиг, зэргэмжээ хүнд илгээх бичиг, доош нь явуулах бичиг гэж хуваадаг, цөм нарийн журам горимтой байсан нь тодорхой харагддаг. Аливаа захидал нь «тогтсон үг» хэмээх хандсан хэсэг, учир шалтгааныг тодорхойлсон хэсэг, төгсгөл гэсэн гурван хэсэгтэй бөгөөд уг бичгийн хэнд бичиж байгаагаас болж үг найруулга нь цөм ялгавартай байжээ. Захидал бичиж байгаа хүн юуны өмнө гуншин, нэр усаа дурдсаны дараа дээш өргөх бичиг бол тухайн газар, хүний нэр хаяг, гуншинг бүрэн бичиж «...танаа өргөв...», «...өргөн толилуулах учир...» гэх ба зэргэмжээ хүн, газарт бол «...илгээх учир...», «...явуулах учир...» гэж доош хандсан бичигт очих газар, хүний хаяг гиншинг товчдуухан тавиад «...тушаан илгээв», «...тушаан явуулах учир...» хэмээн захидлаа эхлэж ярьж мэдэгдэх зүйлийнхээ үүсэл, учир холбогдол, явц байдал, санал бодлоо товч тодорхой бичдэг байжээ. Тухайн захидал хэнд очихоос шалтгаалан төгсгөлийн үгийг ялгамжаатай бичдэг журамтай байлаа.



1305 онд Ил хан Өлзийтөөс Францын Гоо Филиппэд илгээсөн захидлын эхний хэсгийн гэрэл зураг.

Аливаа бичиг захидлын илгээх хувь нь үг үсэг, утгын алдаа мадаггүй, баллаж сохлосон зүйлгүй, мөр тэтгэх, мөр дарах ёсыг чанд баримталсан нямбай сайхан эх байхаас гадна нутаг газар сайгүй нэг л утгаар ойлгодог, толь бичигт орсон, бичгийн найруулгын өнгө аяст тэнцэх тансаг хүндтэй үгийг хэрэглэхээс бишь, салаа утга санаатай буюу нийт даяарт ойлгомжгүй, эс-

хүл тухайн нэг нутагт хэрэглэдэг үгийг оруулдаг ёсон байгаагүй. Захидал албан бичигт хэрэглэдэг тогтмол үгийн толь монголчуудын бичгийн хүмүүсийн дунд гар бичмэл болон бараар нэлээд тархсан байжээ. Үүнээс тоймтой том нь гэвэл Засаг вангийн хошууны захирагч, занги Баянбилигийн зохиосон «Албан хэргийн тогтмол үг» гэдэг дөрвөн дэвтэр нэг дугтуй чулуун барын толь бичиг болой.






Монгол яаралтай захидлын гурван зүйл дугтуйны зураг
а. Шувууны од наасан онц яаралтай захидлын дугтуй,
б. Дөрвөн өнцөгтөө морин туурайн дүрс, амандаа захидал зууссан шувууны зураг бүхий дугтуй.

Захидлын бичгийн хэлбэр нь ацаг шүдтэй, тогтуухан бичиг байхаас биш хамаа намаагүй бичсэн буюу татласан, заргын буюу жад сүүл татсан байх ёсонгүй байжээ. Харин заргын бичигт үгийн сүүл хаялга дээр заргын бичиг болох нь мэдэгдэхүйц бичсэн буюу жад сүүл, мөн арцалдсан сүүл хэрэглэх ёсон байсныг дурдахад сонин буй даа.

Захидлаа дугтуйлахад бас тусгай ёс заншил байсан бөгөөд ерийн алба, амины захидлыг нугалбар маягаар эвхдэг байжээ. Харин эрхэм хүндтэй хүнд баяр талархал илэрхийлсэн захидлын дээд доод хоёр этгээдийг хоёр тийш нь нугасхийж дуг-



в. Улаан шунхаар ирмэглэн хажиж, захидал зуусан шувууны зураг бүхий дүгтуй.

туйлдаг заншилтай байлаа. Энэ нь захидал бичиж байгаа хүн толгой мэхийж, өвдөг сөгдөсний бэлгэдэл ажгуу

Захидлын их багаас болж заримдаа урт нугалбар хийхдээ цаас залгадаг байсан тул санаа муу хүн тэр залгаасыг ашиглаж өөр зүйл бичүүжин хэмээж залгаас дээр нь албаны тамга дардаг нарийн ёс бас байжээ.

Үүнээс гадна захидлыг их төлөв улаан шугамтай цаасаа хар бэхээр, баяр ёслолын захидлыг улаан шугамтай цаасан дээр бичиж мөн хөх бэхээр тамга тэмдэг дардаг нарийн ёсон уламжлал болсон байж билээ. Захдилын эцэст гарын үсгийн дэргэд, бичиж байгаа хүний хэргэм зэргээс хамаарч тамга, захиралга, тэмдэг, гарын тийзийн аль нэгийг дардаг ёсон байжээ. Иймч учраас монголын бичгийн хүн бүр өөрийн гэсэн гарын тэмдэг-тийзтэй, тэр тийз нь гол төлөв эвхмэл үсгээр нэрээ бичсэн байдаг байлаа. Энэ нь европ дахины бичгийн хүмүүсийн хэрэглэдэг экслибоис хэмээх тийзтэй адил ажгуу.

1959 онд Улаанбаатар хотноо болсон Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хуралд ахмад эрдэмтэн Я. Цэвэл «Монгол албан бичгийн уламжлал» гэдэг илтгэл та-

вин хэлэлцүүлж түүндээ монгол албан захидал бичгийн нарийн ёс, дэг журмыг тодорхой дурдсан гэдгийг энэ ташрамд дурдсу.

Бас нэгэн зүйл, Монголчуудын захидал, албан бичгийн уламжлалыг сөхөн үзэхэд, цаг төр үймээнтэй, дайн самууны үед элдэв нууцыг чандлан хадгалахын үүднээс ам захиаг бичмэл захидлаас илүүд үздэг байсан нэгэн сонин онцлог байжээ. Үүнийг монголчууд *«дуу бариулах»* хэмээмүй. Бас түүхэн тэмдэглэл, ном зохиол зэргээс үзвэл өөрийн элч мөн гэдгээ батласан зурвас, пайз, тусгай таних тэмдэг өгч явуулдаг, зурвастаа бол «хэлэх үг элчийн аманд» гэсэн үг бичдэг байжээ. Томоохон захиа байдаг байсан нь мэдээж. Ийм үед хэлэх санаагаа ал даншгий нь тааруулсан шүлэг болгоод итгэл бүхий хүндээ цээжлүүлэн элч болгон илгээдэг байж. Тийнхүү шүлэг болгодогийн учир юун хэмээвээс үг зүйлийг яг хэвээр нь цээжлэхэд хялбар болгож байгаа арга ажээ. Хэрэвээ ийм элч хүн дайсанд баригдваас нэг биеэрээ дуусч нууцыг чандлах андгай тавьдаг байсан гэлцдэг. XIII зууны үед монгол газар ирсэн жуулчдын тэмдэглэлээс үзэхэд төрийн элчээр захидал буюу дуу бариулан илгээхдээ монголоор *гэрэгэ* гэдэг нэртэй алтан юм уу мөнгөн пайз тэмдгийг өгч «энэ хүн даруй миний элч мөн» гэж мэдүүлдэг заншилтай байсан ажээ. Гэрэгэ гэдэг үгийн учрыг хөөн үзвэл гэрчлэх, гэрч гэдэг үгтэй нэгэн язгууртай буй заа гэж сананам.

ЛАВШРУУЛАН ҮЗҮҮШТЭЙ НОМ ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ

Bonaparte R, **Documents de l'époque mongole XII et XIIIe siécles**, Paris, 1895.

Kotwicz W, **Les Mongols, promoteurs de l'idée de paix universelle au début du XIII siécle**, -La Pologne au VI Congrés International des Sciences historiques, I, Warszawa, 1933, pp. 199—204; -RO, t. XVI, Warszawa, 1950.

Цэвэл Я, **Монгол албан бичгийн уламжлал**, SM, tom, I, Fasc. 22, UB., 1959.

Mostaert A, Cleaves F. W, **Les lettres de 1289 et 1305 des ilkhan Aryun et Öljeïtü à Philippe le Bel**, Cambridge, 1962.

Chagdarsuren Ts, **A propos des enveloppes des «lettres urgentes» mongoles**, -RO, T. XXXV, z. I, Warszawa, 1971, pp. 111—116.

Норовсамбуу Г, **Монголын архив-албан хэрэг, түүний бичгийн хэв**, УБ., 1975.

ТОВЧИЛЖ ХУРААСАН ҮГИЙН ЖАГСААЛТ

Известия ИРГО	— Известия Императорскаго Русскаго Географическаго Общества, С.-Петербургъ.
ИИРГО	— Известия ИРГО
Л.	— Ленинград
М.	— Москва
М—Л	— Москва—Ленинград
МХБСБӨ	— Монгол хэл бичгийг сайжруулах бодолгын өгүүлэл, Улаанбаатар, (монгол бичгээр)
СМ	— Современная Монголия, Улан-Батор
Труды ССМПЭ	— Труды совместной Советско-Монгольской палеонтологической экспедиции, Москва
ТС	— Түүхийн судлал, Улаанбаатар
УБ	— Улаанбаатар
ХЗС	— Хэл зохиол судлал
ШУАМ	— Шинжлэх ухааны академийн мэдээ, Улаанбаатар
AOH	— Acta Orientalia Hungaricae, Budapest
BSRBG	— Bulletin de la Societe Royale Belge de Geographie
EM	— Etudes mongoles, Paris
Fasc.	— (дэвтэр гэсэн латин үгийн товч хэлбэр)
MSer	— Monumenta serica, Peiping
RO	— Rocznik Orientalistyczny, Krakow (Lwow) Warszawa
SA (PLO)	— Studies on Asia (Porta Linguarum Orientalium), Wiesbaden
SH	— Studia Historica, Ulan Bator
SM	— Studia Mongolica, Ulan Bator
Tom.	— (боть гэсэн латин үгийн товч хэлбэр)
UAB	— Ural-Altaische Bibliothek, Wiesbaden,
UB	— Ulan Bator
VOHD	— Verzeichnis der Orientalischen Handschriften in Deutschland, Wiesbaden
z.	— (дэвтэр гэсэн үгийн товч хэлбэр, Польшид хэрэглэдэг)